



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-123
1.Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох	8-113
2.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа	113-123

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 17-ны өдөр /Мягмар гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Г.Ганбаатар, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, П.Мөнхтулга, Р.Сэддорж;

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Д.Ганмаа, Л.Оюун-Эрдэнэ, М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Энхтүвшин;

Тасалсан: Н.Алтанхуяг, Х.Болормаа, Ш.Бямбасүрэн, С.Ганбаатар, Д.Жаргалсайхан, С.Лүндэг, Н.Номтойбаяр, Д.Пүрэвдаваа, М.Сарнай, Х.Тэмүүжин, А.Ундраа, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-2 цаг 00 минут, С.Амарсайхан-08 минут, Б.Батбаатар-08 минут, Р.Батболд-04 минут, Д.Ганбат-18 минут, Л.Гантөмөр-19 минут, Т.Доржханд-05 минут, Ц.Мөнхтуяа-02 минут, П.Наранбаяр-02 минут, Ц.Туваан-2 цаг 30 минут, Г.Тэмүүлэн-3 цаг 06 минут, Д.Цогтбаатар-2 цаг 29 минут.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн хуралдаан дууссаны дараа үргэлжлүүлэн хуралдахыг мэдэгдэж, чуулганы нэгдсэн хуралдаан 17 цаг 07 минутаас 17 цаг 48 минутад завсарлав.

Нэг.Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Н.Учрал, Т.Доржханд, С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Батцэцэг, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, Г.Дамдинням, Д.Батлут, Б.Батбаатар, П.Наранбаяр, Т.Аубакир, Б.Дэлгэрсайхан, Ч.Ундрэм, Э.Бат-Амгалан, Ж.Энхбаяр, Э.Батшугар, Б.Чойжилсүрэн, Ж.Чинбүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын асуудал хариуцсан

хэлтсийн дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад нэр дэвшигч Ням-Осорын Учрал, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигч Тогмидын Доржханд, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдад нэр дэвшигч Сайнбуянгийн Амарсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад нэр дэвшигч Сандагийн Бямбацогт, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдад нэр дэвшигч Болдын Жавхлан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдад нэр дэвшигч Лхагвын Мөнхбаатар, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад нэр дэвшигч Гонгорын Дамдинням, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдад нэр дэвшигч Дамбын Батлут, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад нэр дэвшигч Батын Батбаатар, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайдад нэр дэвшигч Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад нэр дэвшигч Тилеуханы Аубакир, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдад нэр дэвшигч Борхүүгийн Дэлгэрсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад нэр дэвшигч Чинбатын Ундрэм, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад нэр дэвшигч Энхтайваны Бат-Амгалан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад нэр дэвшигч Жадамбын Энхбаяр, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад нэр дэвшигч Энхбаярын Батшугар, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдад нэр дэвшигч Баттогтохын Чойжилсүрэн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдад нэр дэвшигч Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарыг томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар нэр дэвшигч тус бүрээр танилцуулав.

Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл танилцуулав.

Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулга болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, нэр дэвшигч Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдад нэр дэвшигч Батмөнхийн Батцэцэгийн танилцуулгыг танилцуулав./18:46/

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 19 цаг 57 минутаас 20 цаг 45 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 20 цаг 45 минутад хуралдааныг даргалав.

Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулга болон нэр дэвшигчдээс Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ө.Шижир, П.Сайнзориг, У.Отгонбаяр, Да.Цогтбаатар, С.Эрдэнэболд, Ц.Идэрбат, Н.Наранбаатар, Т.Мөнхсайхан, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, Н.Алтаншагай, М.Мандхай, Б.Уянга, М.Ганхүлэг, Д.Үүрийнтуяа, Г.Лувсанжамц, Х.Баасанжаргал, Ж.Галбадрах, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа, С.Замира, Ц.Мөнхбат, Ж.Баярмаа, С.Цэнгүүн, П.Батчимэг, Г.Хосбаяр, Ц.Мөнхтуяа, Д.Ганбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, нэр дэвшигч Б.Жавхлан, Ж.Чинбүрэн, Н.Учрал, Г.Дамдинням, С.Бямбацогт, Э.Бат-Амгалан, Л.Мөнхбаатар, Б.Батбаатар, Т.Аубакир, П.Наранбаяр, С.Амарсайхан, Б.Чойжилсүрэн, Б.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Ч.Номин, О.Номинчимэг, С.Эрдэнэбат, Д.Үүрийнтуяа, М.Нарантуяа-Нара, Ц.Баатархүү нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын гишүүдийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонслоо.

Уг асуудлыг 23 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаан Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийн дараа үргэлжлүүлэн хуралдахаар 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 23 цаг 39 минутаас 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 00 цаг 15 минутад завсарлав.

Хоёр.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа

Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнд нэр дэвшигч Н.Учрал, Т.Доржханд, С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Батцэцэг, Б.Жавхлан, Л.Мөнхбаатар, Г.Дамдинням, Д.Батлут, Б.Батбаатар, П.Наранбаяр, Т.Аубакир, Б.Дэлгэрсайхан, Ч.Ундрэм, Э.Бат-Амгалан, Ж.Энхбаяр, Э.Батшугар, Б.Чойжилсүрэн, Ж.Чинбүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Менежментийн газрын дарга Т.Нармандах нар байлцав.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар танилцуулав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын газрын дарга Э.Одмөнх, мөн газрын референт Ц.Уранчимэг, шинжээч Б.Мөнхтүшиг, мэргэжилтэн Б.Билгүүндалай, Ч.Цолмон, ажилтан Г.Анар, Б.Анхцэцэг, Э.Рагчаадорж нар зохион байгуулав.

Танхимын баруун хойд, зүүн хойд болон урд дэлгэцэн дээр “МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН БИ УЛСЫН АШИГ СОНИРХЛЫГ ЭРХЭМЛЭН, ТӨРТ ЁС, ТҮҮХ, СОЁЛЫНХОО УЛАМЖЛАЛЫГ ХҮНДЭТГЭЖ, МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН САХИЖ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН

ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙЖ, ТӨРИЙН ХУУЛЬ БИЕЛҮҮЛЭХ АЖЛЫГ ТӨР, АРД ТҮМЭН, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ӨМНӨ БИЕЧЛЭН ХАРИУЦАЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙ ҮҮРГЭЭ ЧИН ШУДАРГААР БИЕЛҮҮЛЭХЭЭ ТАНГАРАГЛАЯ. МИНИЙ БИЕ ЭНЭ ТАНГАРГААСАА НЯЦВАЛ ХУУЛИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭНЭ.” гэсэн Засгийн газрын гишүүний тангаргийн үг гарч байв.

“Их хуралдай” танхимын индрийн баруун талд Төрийн далбаа, танхимын голд Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэн байрлуулж, Төрийн сүлдний баруун талд хүндэт харуул зогссон байлаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 10-т “Засгийн газрын гишүүд танхимын голд Монгол Улсын Төрийн сүлд рүү харан эгнэн зогсон тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдад нэр дэвшигч Борхүүгийн Дэлгэрсайхан тангаргийг уншиж, бусад гишүүн давтан хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах дарааллаар Засгийн газрын гишүүдийн нэрийг дуудав.

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд Болдын Жавхлан;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайд Лхагвын Мөнхбаатар;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатар;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Тилеуханы Аубакир;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан;

14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Чинбатын Ундрам;

15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан;

16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр;

17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Энхбаярын Батшугар;

18/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн;

19/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд Жигжидсүрэнгийн Чинбүрэн.

Тангараг өргөсний дараа нэр дуудагдсан Засгийн газрын гишүүн суудлаасаа босож Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Засгийн газрын 19 гишүүнд үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсод суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд амжилт хүсэж, үг хэлэв.

Тангараг өргөх ёслолын ажиллагаа 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 00 цаг 53 минутад өндөрлөв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 30 минут үргэлжилж, 126 гишүүнээс 103 гишүүн хүрэлцэн ирж, 81.7 хувийн ирцтэйгээр 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 00 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
17 цаг 06 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

65 гишүүн бүртгэгдэж, ирц 51.6 хувьтай болсон байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 17-ны өдрийн үдээс хойших хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар

Нэгдүгээрт, “Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.

Хоёрдугаарт, Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Ингээд “Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг яг Ардчилсан намын бүлэг дээр бас танилцуулга хийгдэж байгаа учраас чуулганы хуралдааныг 30 минутын хугацаатай завсарлуулъя. 17 цаг 40 минутаас чуулганы хуралдаан үргэлжилнэ. Түр завсарлалаа.

Мягмар гараг 17 Зургаадугаар сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 17 цаг 48 минут.

Д.Амарбаясгалан: Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье. Хэлэлцэх асуудалд оръё.

Засгийн газрын гишүүнийг томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно.

Засгийн газрын гишүүдийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хүн нэг бүрээр уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Засгийн газрын гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж байна.

Төрийн гадаад, дотоод бодлогын тогтвортой байдал, бодлогын залгамж чанарыг хадгалж, Засгийн газрын үйл ажиллагаа шуурхай, тасралтгүй байх зарчимд үндэслэн шинэ Засгийн газрыг 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр баталсан Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нийцүүлэн байгуулж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тууштай үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Засгийн газрын бүтцийг хадгалах нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан мега төсөл, суурь реформ болон аялал жуулчлал, цахим засаглал, эрчим хүчний салбарын либералчлал, дэд бүтцийн бүтээн байгуулалт, төрөлжсөн бүсүүдийн хөгжил, Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, тус сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх хөшүүрэг нь байх болно гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан улсын эрх ашгийг эн тэргүүнд тавих, улс орны хөгжлийн өмнө тулгамдсан томоохон сорилт, бэрхшээлийг харилцан ойлголцолд тулгуурлан зөвшилцлийн үндсэн дээр шийдүүлэх нь чухал байна.

Өөрөөр хэлбэл, олон улсын харилцаа, геополитикийн эгзэгтэй нөхцөл байдал цаашид ч үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд худалдааны тарифын зөрчилдөөн, уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн уналтаас үүдэлтэй эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төрийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалж, үндэсний эв нэгдлийг хангаж ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Ойрх Дорнодод гадаад гео стратегийн нөхцөл байдал нэн хүндэрч байна. Үүнээс шалтгаалсан тарифын дайн, олон улсын нөхцөл байдал улам бүүр ээдрээтэй болж байна. Энэ цаг үед эмхлэн байгуулагдах Засгийн газар шууд ажилдаа орох, төрийн бодлогын тогтвортой залгамж чанарыг хадгалах нь хамгийн зүйтэй гэж үзлээ.

Ийм учраас улс өмнө нь ажиллаж байсан Засгийн газрын гишүүдийн гуравны нэгийг, нэн ялангуяа мега төслүүд хэрэгжүүлж байгаа томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа энэ төслүүдийг үргэлжлүүлж ажиллуулахын тулд Засгийн газрын бүрэлдэхүүний гуравны нэгийг хэвээр нь хүлээж ажиллуулж байна.

Мөн энэ шинээр байгуулах Засгийн газрын бүрэлдэхүүнд Улсын Их Хуралд суудал бүхий намуудын төлөөллийг оролцуулах нь хамгийн оновчтой шийдэл гэж үзлээ.

Яагаад гэвэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бол сонгогчдын саналыг хаяхгүй байх зорилгоор улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрөөс эмхлэн ийм хамтарсан мөрийн хөтөлбөрийг боловсруулсан. Энэ мөрийн хөтөлбөрийг үргэлжлүүлж ажиллуулахын тулд Улсын Их Хуралд суудал бүхий намуудын төлөөллийг оролцуулах ийм зарчмыг баримталлаа.

Энэ хүрээнд дээрх зарчмуудыг баримтлан Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны даргаас бусад Засгийн газрын гишүүдийг томилохоор Улсын Их Хуралд танилцуулж байна.

Ням-Осорын Учралыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

Ням-Осорын Учрал 1986 онд Улаанбаатар хотод төрсөн. 39 настай, эрэгтэй, эхнэр хүүхдийн хамт амьдардаг.

2007 онд Их засаг сургууль, 2010 онд Лимкоквинг технологийн их сургуулийн Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Лондон хотын салбар сургууль, Их Британийн Букингхамийн их сургуулийг тус тус төгссөн. 2013 онд ОХУ-ын ШУА-аас Сибирийн салбарын Монгол төвд Будда судлалын хүрээлэнд түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй. Бизнесийн удирдлага, түүхийн ухаан, олон улсын менежментийн магистрын зэрэгтэй.

Ням-Осорын Учрал нь 2010-16 онд Роял академийн Ерөнхий захирал, Удирдах зөвлөлийн дарга, 2012-14 онд Нийслэлийн Монгол Ардын намын хорооны Улс төрийн хэлтсийн дарга, 2012-16 онд БЗД-ийн ИТХ-ын төлөөлөгч, 2015 онд Монгол Улсын Шадар сайдын Олон нийттэй харилцах бодлогын зөвлөх, 2019-2024 онд Монгол Ардын намын дэргэдэх Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбооны Ерөнхийлөгч, 2016-2020, 2020-24, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. 2020-2022 онд Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, 2022-2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, 2024 оноос Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ажилласан туршлагатай.

Иймд Засгийн газраас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чадвар, тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд хуримтлуулсан туршлага, мэдлэг, удирдан зохион байгуулах авьяас чадвар, ажил хэрэгч чанарыг үндэслэн Ням-Осорын Учралыг энэхүү албан тушаалд томилохоор танилцуулж байна.

Сайнбуянгийн Амарсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1973 онд Улаанбаатар хотод төрсөн. 52 настай. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

1991 онд Налайх дүүргийн “Эрдмийн оргил” 10 жилийн дунд сургууль, 1996 онд АНУ-ын Калифорни мужийн Фресно институт, 2000 онд АНУ-ын Саут Уест их сургуулийг тус тус төгссөн. Хэл судлал, эрх зүйч мэргэжилтэй, Хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй.

1992-94 онд Шинжлэх ухаан, мэдээлэл, технологийн төвд ажилтан, 2004 онд Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны консулын ажилтан, атташе, 2004-2007

онд “Американ трейд энд девелопмент” ХХК-д Хөрөнгө оруулалт гадаад худалдааны менежер, 2007-2017 онд “Оюуны ундраа” группийн Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгч, ТУЗ-ийн дарга, 2012-2020 онд НИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, 2016-2017 онд НИТХ-ын Төсөв, санхүү, эдийн засгийн хорооны дарга, 2017-2019 онд НИТХ-ын дарга, 2019-2020 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга, 2021-2025 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын даргаар ажиллаж байна.

Тогмидын Доржхандыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1977 онд Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

95 онд Нийслэлийн 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 99 онд МУИС-ийг Төрийн санхүүч, бакалавраар, 2004 онд Япон Улсын Хитосубаши их сургуулийг Төрийн эдийн засгийн бодлогын магистраар тус тус суралцаж төгссөн. 2010 онд АНУ-ын Харвардын их сургууль Дэд бүтэц дэх төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чиглэлээр, 2012 онд Их Британи Улсын Оксфордын их сургуульд Санхүүгийн онол чиглэлээр суралцаж, мэргэжил дээшлүүлсэн. Төрийн санхүүч мэргэжилтэй. Төрийн эдийн засгийн бодлогын магистр зэрэгтэй.

1999-2002 онд Сангийн яамны Төсвийн бодлогын газарт мэргэжилтэн, 2003-2004 онд Япон Улсын Сангийн яаманд дадлагын ажилтан, 2005-12 онд Сангийн яамны Зээл, тусламжийн бодлогын газрын орлогч дарга, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн зохицуулагч, 2012-13 онд Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга, 2016-2020 онд ХҮН намын Удирдах зөвлөлийн дарга, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2024-25 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар ажилласан. Улсад 26 жил, төрийн албанд 16 жил ажиллаж байгаа туршлагатай байна.

Сандагийн Бямбацогтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1974 онд Ховд аймгийн Жаргалант сумд төрсөн. 51 настай. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

1992 онд Ховд аймгийн Жаргалант сумын 2 дугаар дунд сургууль, 1999 онд СЭЗДС, 2005 онд Нидерланд Улсын Маастрихтын их сургууль, 2014 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч, эрх зүйч, Бизнесийн удирдлага болон хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй.

2000-2008 онд “Нью прогресс” группийн захирал, ТУЗ-ийн дарга, 2008-16 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2010-16 онд Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга, 2016-2020 онд Улсын Их Хурлын гишүүн, 2016-17 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд, 2019-2020 онд Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, 2020-24 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020-22 онд Монгол

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна. 2022-24 онд Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, 2024-25 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар ажилласан ийм туршлагатай.

Болдын Жавхланг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

75 онд Дархан-Уул хотод, Дархан-Уул аймгийн Дархан сумд төрсөн. 50 настай. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг. 90 онд Дархан-Уулын 17 дугаар сургууль, 92 онд Сүхбаатар аймгийн 1 дүгээр дунд сургууль, 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургууль, 2009 онд АНУ-ын Индианагийн их сургуульд тус тус суралцсан. Банкны эдийн засагч мэргэжилтэй.

1997-2004 онд Монголбанканд Хянан шалгагч, 2004-2007 онд Худалдаа хөгжлийн банкны Дэд захирал, 2010-16 онд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, 2016-2025 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020-21 онд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 21 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар ажилласан. Улсад нийт 20 жил, 28 жил, төрийн албанд 25 жил ажилласан туршлагатай байна.

Лхагвын Мөнхбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1977 онд Хөвсгөл аймагт төрсөн. Гэр бүл, эхнэр хүүхдийн хамт амьдардаг.

1995 онд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын 10 жилийн сургууль, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль, 2008 онд Отгонтэнгэр Их сургуулийг тус тус төгссөн. Хуульч, эрх зүйч мэргэжилтэй, магистрын зэрэгтэй.

1999-2000 онд Хууль зүйн яамны Эрх зүйн шинэтгэлийн стратегийн нэгдсэн төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, 2000-2006 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, 2006-2008 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, 2008-2009 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн дарга, Улсын Ерөнхий байцаагч, 2009-2011 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий бүртгэгч, 2013 онд, 2012 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2013 онд Монгол Ардын намын даргын зөвлөх, 2014-2016 онд Хөвсгөл хөгжил сангийн тэргүүн, 2016 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2022-23 онд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга, 2023-24 онд Монгол Улсын Их Хурлын Дэд дарга, 2024 оноос Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн даргаар тус тус ажиллаж байна. Улсад 26 жил ажилласан туршлагатай.

Гонгорын Дамдиннямыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1982 онд Дархан-Уул аймагт төрсөн. 43 настай. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

99 онд Дархан-Уул аймгийн 7 дугаар дунд сургууль, 2004 онд МУБИС, 2007 онд МУБИС-ийг Улс төр судлалын магистр, 2016 онд Канад Улсын Бритиш Колумбийн их сургуулийг Уул уурхайн менежментийн мэргэжлээр тус тус төгссөн. Нийгэм судлал, эрх зүйн багш, Уул уурхайн засаглал судлаач мэргэжилтэй. Улс төр судлал болон Уул уурхайн засаглал, бодлого судлалын магистр зэрэг тус тус эзэмшсэн.

2005-8 онд Монгол Ардын намын дэргэдэх Монголын Ардчилсан Социалист оюутны холбооны Ерөнхийлөгч, 2007-2008 онд Монгол Ардын намын дэргэдэх Ардчилсан социалист залуучуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүн, 2008-2009 онд Монголд Байгаль орчны сайдын зөвлөх, 2009-2010 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын зөвлөх, 2010-13 онд ШУТИС-ийн Нийгмийн хөгжил, эдийн засгийн проректор, 2015 онд Канад Улсын Бритиш Колумбын их сургуулийн Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнд судлаач, 2017 онд “Прокон Майнинг Монголиа” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, захирал, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2021-22 онд Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, 24 оноос Монгол Ардын намын бүлгийн Дэд даргаар ажиллаж байна.

Дамбын Батлутыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна. 1974 онд Архангай аймгийн Хашаат суманд төрсөн. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

82 онд Архангай аймгийн Ерөнхий боловсролын дунд сургууль, 1992 онд Орхон аймгийн Ерөнхий боловсролын 5 дугаар дунд сургууль, 2004 онд ШУТИС-ийн харьяа Отгонбилигийн нэрэмжит Технологийн сургуулийг Цахилгааны инженерээр, 2007 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын менежерээр тус тус төгссөн.

1991-93 онд Дорноговь аймгийн Зүүнбаян дахь 149 дүгээр цэргийн ангид 2 жил цэргийн алба хаасан. 94-2000 онд “Эрдэнэт хивс” ХХК-д туслах ажилтан, 2003-2006 онд “Дэлхийн Зөн Монгол” олон улсын байгууллагуудад гүйцэтгэх захирал, 2006-2013 онд Орхон аймгийн Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбооны тэргүүн, 2006-2007 онд Орхон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын мэргэжилтэн, 2008-2012 онд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын орлогч, 2006-2013 онд Нийгмийн Ардчилал Монголын Залуучуудын Холбооны дарга, 2010-12 онд Баян-Өндөр сумын намын анхан шатын байгууллагын дарга, 2013 оноос Орхон аймгийн Монгол Ардын намын дарга, 2008-2020 онд Орхон аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, бүлгийн дарга, 2016-2020 онд Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч, 2020-24 онд, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Батын Батбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1973 онд Улаанбаатар хотод төрсөн. 52 настай, эрэгтэй. Гэр бүл, эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

91 онд Улаанбаатар хотын 10 жилийн 47 дугаар дунд сургуулийг төгссөн. 99 онд Монгол Улсын Эдийн засгийн сургууль, эдийн засагч бакалавр, 2000 онд Монгол Улсын Эдийн засгийн сургууль магистр, 2002 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль Эрх зүйч, бакалавр, Эдийн засагч, Эрх зүйч мэргэжилтэй. 2003-2013 онд Нийслэлийн ЧД-ийн Ардчилсан намын дарга, 2004-2008 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлого, боловсрол, шинжлэх ухааны байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүн, Аюулгүй байдлын байнгын хороо, Хүний эрхийн дэд хорооны дарга, гишүүн, 2012-2016 онд Нийслэлийн ЧД-ийн ИТХ-ын Төсвийн хяналтын хорооны дарга, 2015-2016 онд Ерөнхий сайдын орон тооны зөвлөх, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр тус тус ажиллаж байна.

Пүрэвсүрэнгийн Наранбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсролын сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1976 онд Улаанбаатар хотод төрсөн. 49 настай. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

94 онд Ерөнхий боловсролын 13 дугаар дунд сургууль, 2002 онд МУИС-ийг Олон улсын харилцааны бакалавр, 2007 онд Япон Улсын Киотогийн их сургуулийг Эрх зүйн магистрын зэрэгтэй төгссөн. 2015 онд МУИС-д Олон улс судлалын докторын зэрэг хамгаалсан.

2000-2004 онд Байгаль орчны яамны Хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, сайдын туслах, 2004 онд Японы экологийн сан Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга, 2009-2011 онд Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороонд мэргэжилтэн, 2011 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын газрын орлогч дарга, 2011-2012 онд Токиогийн Гадаад судлалын их сургуульд судлаач, 2012-2020 онд Ерөнхий боловсролын “Шинэ Монгол” сургуулийн захирал, 2019 оноос ХҮН намын Удирдах зөвлөлийн гишүүн, 2020-23 онд ХҮН намын Нийслэлийн намын хорооны дарга, 2020-2024 онд НИТХ-ын төлөөлөгч, Хүний хөгжлийн хорооны дарга, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсролын сайдаар ажилласан.

Тилеуханы Аубакирыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1976 онд Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумд төрсөн. 49 настай. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

1992 онд Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын 10 жилийн дунд сургууль, 2000 онд Отгонтэнгэр дээд сургууль Олон улсын эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2000-2005 онд “Сэлэнгэ тариа” ХХК-ийн Дэд захирал, 2006-2015 онд “Тариа цацал” ХХК-ийн захирал, 2008-2015 онд Баян-Өлгий аймгийн НАМЗХ-ны дарга, 2015-2016 онд Гаалийн ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын дарга, 2017-2019 онд Гаалийн ерөнхий газрын харьяа Буянт-Ухаа дахь Гаалийн газрын орлогч дарга, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Борхүүгийн Дэлгэрсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1964 онд Дорноговь аймгийн Сайншанд суманд төрсөн. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

1982 онд Дорноговь аймгийн Сайншанд сумын 1 дүгээр дунд сургууль, 1987 онд Нийгмийг аюулаас хамгаалах яамны дэргэдэх Цэргийн дээд сургууль буюу одоогийн Хууль сахиулахын их сургуулийг хуульч мэргэжлээр тус тус төгссөн.

1982-83 онд Хилийн цэргийн 01129 дүгээр анги, Улаан-Уул дахь отрядын Рашаантын 6 дугаар заставд Цэргийн алба, 1987-1989 онд Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн газрын дарга, 1989-1992 онд Дорнод аймгийн Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн дарга, 2016-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2023-24 онд Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга, 2024 оноос Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдаар ажилласан.

Чинбатын Ундрамыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1982 онд Улаанбаатар хотод төрсөн. 43 настай. Үр хүүхдүүдийн хамт амьдардаг.

1998 онд Нийслэлийн 23 дугаар дунд сургууль, 1999 онд АНУ-ын Терри Санфорд ахлах сургуулийг төгссөн. 2003 онд Лондон хотын Олон улсын Америкийн их сургуулийн Бизнес сургуульд бакалавр, 2004 онд Лондон хотын Олон улсын Америкийн их сургуулийн Бизнесийн сургуульд магистрын зэрэг хамгаалсан. 2010 онд Япон Улсын Нагояагийн их сургуулийн Эдийн засгийн сургуульд “Ил уурхай болон төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн төслийн менежмент ба симуляц дүн шинжилгээ хийх зарим аргууд” сэдвээр докторын зэрэг хамгаалсан. Эдийн засагч мэргэжилтэй.

2007-2008 онд Япон Улсын Нагояагийн их сургуулийн Эдийн засгийн сургуульд зочин судлаач, 2010-2020 онд Харвардын их сургуулийн Бизнесийн сургуулийн дэргэдэх Өрсөлдөөний макро экономикийн институтын Монгол Улс дахь координатор, 2010-2013 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн менежментийн тэнхим Тэнхимийн эрхлэгч, профессор, 2013-2014 онд МУИС-ийн Бакалаврын сургалтын албаны дарга, Байгаль эх лицей ахлах сургуулийн удирдах зөвлөлийн дарга, 2014-2017 онд МУИС-ийн сургалтын нэгдсэн албаны дарга, Бизнес менежментийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, 2017-2018 онд МУИС-ийн Захиргаа, дотоод хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал, 2017-2020 онд Монгол Улсын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөлийн гишүүн, 2020-24 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны даргаар ажиллаж байна.

Энхтайваны Бат-Амгаланг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1977 онд Улаанбаатар хотод төрсөн. 48 настай. Эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг.

1994 онд Нийслэлийн 1 дүгээр дунд сургууль, 1998 онд МУИС-ийн ОУХДС, 2004 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг тус тус төгссөн. Олон улсын дипломатч, эрх зүйч мэргэжилтэй.

2002-2008 онд “Баян хадат тур” ХХК-ийн гүйцэтгэх захирал, 2008-2010 онд Нийслэлийн БЗД-ийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга, 2008-2012 онд Нийслэлийн БЗД-ийн ИТХ-ын төлөөлөгч, 2010-2012 онд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын орлогч дарга, 2015-2020 онд Иргэний нисэхийн ерөнхий газрын “Чингис Хаан” ОУНБ-ын Гадаад харилцааны хэлтсийн дарга, 2016-2020 онд НИТХ-ын төлөөлөгч, 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Жадамбын Энхбаярыг Монгол Улсын сайд, Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1973 онд Улаанбаатар хотод төрсөн. 52 настай. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

1990 онд 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 1999 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль, 2003-2005 онд Маастрихтын их сургуулийг тус тус төгссөн. Хуульч мэргэжилтэй.

2000-2006 онд Гаалийн ерөнхий газарт зөвлөх, газрын дарга, 2006-2008 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Тамгын газрын дарга, Дэд дарга, 2008-2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, 2020-21 онд Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, 2021-24 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдал, улс төрийн бодлогын зөвлөх, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар ажиллаж байна.

Энхбаярын Батшугарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1987 онд Улаанбаатар хотод төрсөн. 38 настай. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.

2000 онд Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр дунд сургууль, 2004 онд АНУ-д бүрэн дунд боловсрол эзэмшсэн. 2008 онд АНУ-ын Бентлигийн их сургуулийг тус тус төгссөн. Эдийн засагч, санхүүч мэргэжилтэй.

2008-2011 онд Жи.Пи.Морган хөрөнгө оруулалтын банкир, 2011-2012 онд Монгол Ардын Хувьсгалт намын Гадаад харилцаа хариуцсан Нарийн бичгийн дарга, 2012-16 онд Монголбанкны Дэд ерөнхийлөгч, 2016-2021 онд “Медиа холдинг” ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, 2021-2024 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2022-24 онд Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Баттогтохын Чойжилсүрэнг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1970 онд Увс аймгийн Тэс сумд төрсөн. 55 настай. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг.

1988 онд Увс аймгийн Улаангом сумын 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 1993 онд ОХУ-ын Екатеринбург хотын Уралын политехникийн их дээд сургуулийг тус тус төгссөн. Автоматикч, телемеханикч мэргэжилтэй.

1993-95 онд ОХУ-ын Екатеринбург хотын “Эс Пи Команд” ХХК-ийн захирал, 95-99 онд “Хурд Ч” Хувиараа эрхлэх аж ахуйн захирал, 99-2005 онд “Хурд хүнс” ХХК-ийн захирал, 2005-2008 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Дэд дарга, 2008 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2016-27 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, 2017-2020 онд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2020-22 онд Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга, 2022-2025 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдаар ажилласан.

Жигжидсүрэнгийн Чинбүрэнг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

1972 онд Улаанбаатар хотод төрсөн. 53 настай. Эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг. 1990 онд Нийслэлийн 23 дугаар дунд сургууль, 1997 онд АУИС, 2001 онд Халдвар судлалын төв, хавдар судлаач эмч, 2002 онд Швейцар улсын Лозанын их сургууль мэс заслын эмчийн резентур, 2015 онд Япон улсын Токиогийн Анагаахын анагаах ухааны эмэгтэйчүүдийн их сургуулийг тус тус төгссөн. Хүний их эмч мэргэжилтэй, Анагаах ухааны докторын зэрэгтэй.

1997-1998 онд Анагаах ухааны хүрээлэнд Шинжлэх ухааны туслах ажилтан, 1998-2008 онд ХСҮТ-д Ерөнхий мэс заслын тасгийн мэс заслын эмч, 2008-2016 онд ХСҮТ-д Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасгийн хэрэглэгч, Бүгд Найрамдах Казакстан Улсын Шымкент хотын Хавдрын төвд сургагч багш, 2014-2016 онд АШУҮИС-д Хавдар судлалын багш, 2015 оноос Монголын элэг, цөс, нойр булчирхайн нийгэмлэгийн тэргүүн, 2016 онд Эрүүл мэндийн яамны Хавдрын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, 2016-2019 онд ХСҮТ-д Ерөнхий захирал, 2020 онд ХСҮТ-д Зөвлөх эмч, 2020-24 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Засгийн газрын гишүүнд нэр дэвшүүлэхдээ Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилт арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, зохион байгуулах чадавх, танхимын зарчмаар

ажиллах чадвар, хариуцсан салбар, ажил үүргийг гүйцэтгэх чиглэлээр хуримтлуулсан туршлага, мэргэжил, ёс зүйн болон хариуцлагатай байдал зэргийг харгалзан үзсэн болно.

Харин Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д Засгийн газрын гишүүдийн эрхлэх ажлыг тодруулан хуваарилж, түүнийг гүйцэтгэлд хяналт тавина гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газар дотоод зохион байгуулалтын хүрээнд Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, 20 минут Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд нарын эрхлэх асуудлыг давхар хариуцуулан гүйцэтгэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Засгийн газрыг богино хугацаанд шуурхай эмхлэн байгуулах нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан тогтвортой засаглал, оновчтой бүтэц, зохион байгуулалт бүхий төрийн албыг төлөвшүүлэх хүрээнд төрийн үрэлгэн зардлыг багасгаж, төсвийн сахилга батыг сахих чадварлаг, бүтээмжтэй төрийн алба бий болгох, олон нийтийн хяналтад оруулах, татвар, нийгмийн даатгалын цогц реформыг цаг алдалгүй хэрэгжүүлж, төсвийн тодотголыг барьж, төсвийн томоохон хэмнэлтийн төсвийн тодотгол хийх боломжийг олгож, хууль зүйн нөхцөлийг бүрдүүлэх юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны зохих журмын дагуу шуурхай зохион байгуулж, Засгийн газрыг шинээр байгуулах, Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ цаг алдалгүй хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэхийг дэмжлэг үзүүлж байгаа Улсын Их Хурлын дарга болон Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд Ерөнхий сайдын хувьд талархал илэрхийлье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай асуудлаар хуралдаж, Монгол Улсын Ерөнхий сайдад тодорхой бодлогын шаардлага хүргүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, бизнесийн орчныг сайжруулж, үндэсний аж ахуйн нэгжүүдээ дэмжих, ардчилал сайн засаглалыг бэхжүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдаас дараах бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг шаардаж байна.

Нэгдүгээрт нь, Монгол Улс авлигын төсөөллийн индексийн эрэмбээр сүүлийн 10 жилд 42 байраар ухарсан нь авлига, улс төр, эдийн засгийн тогтолцооны асуудал болсныг илтгэж байна. Тиймээс авлигын эх үндэс болсон

эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, шударга ёсыг бэхжүүлэх хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Яам болон сайд нарын тоог 50 хувиар цөөлж, төрийн захиргааны болон тусгай албан хаагчдын тоог 20 хувиар бууруулах, төрийн албаны мэргэшсэн улс төрөөс ангид байдлыг хангаж, ашиг сонирхлын зөрчлийг таслан зохицуулах шаардлагатай. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгох, орон тоог нь 2 дахин бууруулж, үр өгөөж, бүтээмжийг эрс дээшлүүлэх шаардлагатай байна.

Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тууштай тэмцэх, хуулийн байгууллагуудын хараат бус байдлыг хангах хүрээнд бодлого, боловсон хүчний шинэчлэлийг хийх шаардлагатай байна. Сонгуулийн санхүүжилтийг ил тод болгож, мөнгөний хамааралгүй шударга сонгууль явуулах эрх зүйн орчин дээр бид анхаарах шаардлагатай байна.

Хоёрдугаарт нь, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш өсөн нэмэгдэж, төсвийн алдагдал гүнзгийрч, эдийн засгийн хямралтай нүүр тулах бодит эрсдэл бодитой боллоо. Иймд иргэд, аж ахуйн нэгжүүдээ хямралаас хамгаалж, эдийн засгийн тодорхой өсөлтийг хангах шаардлагатай байна.

Үнийн өсөлтийг сааруулж, ханшийн тогтвортой байдлыг хангах замаар айл өрхийн бодит орлогыг хамгаалах, төрийн хүнд суртал, хяналт шалгалт, татварын дарамтаас бизнес эрхлэгчдээ чөлөөлж, хувийн өмч болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хувийн хэвшилд ноогдох татварын дарамтыг 20-оос доошгүй хувиар бууруулах шаардлагатай байна.

2025 оны улсын нэгдсэн төсвийг тодотгож, төсвийн урсгал зардлыг 20 хувиар танах, төсвийн худалдан авалт, хөрөнгө оруулалтыг бодлогоор үндэсний аж ахуйн нэгжүүдээ дэмжих мега гэдэг төслүүдийг эдийн засгийн үр өгөөжийн хувьд эрэмбэлэн үр ашиггүй төслүүдийг зохиох шаардлагатай байна.

Гуравдугаарт нь, Монгол хүний амьд явах эрхийг хангаж, амьдрах орчинд тулгарч буй эрсдэлийг арилгах нь Монгол төрийн нэн тэргүүний үр мөн гэдгийг ухамсарлан бас дараах чиглэлд тодорхой бодлого хэрэгжүүлэх шаардлагатай.

ДЦС-3 дугаар станцад гарсан ослын улмаас 2025-26 оны өвөл цахилгаан, дулаан хангамж дутагдах эрсдэлээс сэргийлэх, эрчим хүчний хараат байдлыг бүрэн алхах замаар салбарын эрх реформыг бодитойгоор хэрэгжүүлэх шаардлагатай.

Агаар орчны бохирдолтой тууштай тэмцэж ирэх жилүүдэд утаанаас бүрэн ангижрах зэрэг ийм бодлогын шаардлагуудыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зүгээс Ерөнхий сайдад бас танилцуулж, шаардлагыг хүргүүлж байгааг мэдэгдье.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье.

35, 36 гишүүнээр тасаллаа. Нэр нь ороогүй гишүүн байна уу?

Пүрэвийн Батчимэг гишүүн, Жудгийн Баярмаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн. Болсон уу? Тасаллаа. Отгонбаяр гишүүн. Ингээд 38 гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Пүрэвдорж: Улс төрийн ач холбогдлын хувьд Ардын намын ардчиллын төлөөх саналуудыг хуваадаг төслүүд МАН-тайгаа 1 уутанд орсонд болж байна. Тэгээд бас энийг нь ард түмэн мэдэх ёстой байсан. Эдийн засгийн хувьд өнгөрсөн оны төсөв батлахдаа нийтдээ 83 сая тонн нүүрс гаргана, 105 доллароор экспортолно, түүнээсээ ер нь гол экспорт нүүрс учраас 19 тэрбум долларын орлого олно, ДНБ-ийг 93 их наяд төгрөг хүргэнэ, эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэнэ гэж амласан. Гэвч өнгөрсөн онуудын мөн үеийнхтэй харьцуулахад 3 сарынхтай харьцуулахад 23 онд 8 хувьтай байсан эдийн засгийн өсөлт 24 онд 7.9 хувь болсон. Энэ оны 3 дугаар сарын байдлаар, эхний улирлын байдлаар 2.4 хувиар өсөж хэд дахин багассан байгаа.

Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 3 сард 373 сая долларын ашигтай байсан бол 25 оны эхний 3 сард 614 сая долларын алдагдалтай болж 1 тэрбум доллароор багассан байж байгаа. 3.6 тэрбум их наяд төгрөгөөр. Тэгээд энэ улам цаашаа өснө.

Өөрөөр хэлбэл, эхний хагас жилийн байдлаар миний ойлгож байгаагаар 2.5 тэрбум долларын алдагдалтай төлбөрийн тэнцэл гарна. Тэгээд өнгөрсөн долоо хоногт болсон Хятадын нүүрс тээврийн ассоциаци хурал хийгээд ерөөсөө гадаадаас авдаг нүүрсээ 100 сая доллароор багасгана. Дээрээс нь 50 юаниар сайн коксожсон нүүрсний үнийг унагаасан байж байгаа. Энэ та нарт маш том эрсдэл авчирна. Тийм учраас энэ гадаад худалдаагаа либералчлах илүү олон төрөлт болох тэр ажлыг сайн хийгээрэй гэж хэлмээр байна.

Төсөв бол өнгөрсөн хэдхэн жилийн дотор дэлхийн ДНБ-ий 27 хувиас шууд 37 хувь руу өсөөд явчихсан. Тэгээд нийт 64 их наяд төгрөгийн хөрөнгөтэй 123 компани байгаа. Тэрний орлого нь 23 их наяд, зарлага нь 16 их наяд, тэгээд өр нь 22 их наяд. ДНБ-д эзлэх төрийн оролцоо 70 хувьд хүрчихсэн. Нөгөө сонгууль болгоноор амлаад л энэ хувийн хэвшлээ л дэмжинэ гээд байдаг. Бүүр тэрний эсрэг бүүр яаж л хувийн хэвшлийнхнийг хөөж зайлуулах вэ гэдэг бизнесийг нь булаах вэ гэдэг ийм л юм явж байгаа.

Гуравдугаарт нь гадаад нөхцөл байдлын асуудал байна. БНХАУ-ын эдийн засгийн хүндрэл, ОХУ, Украины асуудал, Иран, Израилын асуудал, 1 минутаа авчихъя дарга.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Б.Пүрэвдорж: Тэгээд энэ бүх зүйлээс шалтгаалаад жишээ нь Ираны Ерөнхий сайд энэ газрын тосны энэ 1 барайль газрын тосны үнэ 300 долларт хүрнэ гээд мэдэгдчихсэн байгаа шүү дээ. Тийм учраас оны эцсээр энэ шатахууны хангалт энэ тэр чинь маш их хүндэрнэ. Тийм учраас энэ 2 хөрштэйгөө эвтэйхэн байхгүй, өөрөөр хэлбэл урагшаа хэдхэн бараа гаргаж байгаа. Хойноос ганцхан

бараа, бүтээгдэхүүн оруулж ирж байна. Нефть. Тэгэхээр энэ хөрштэйгөө бас асуудлаа ярилцаад аятайхан урагшаа явах тэр зүйлийг хийх хэрэгтэй.

Хамгийн ганц, сүүлд нь ганцхан хүсэлт байна. 4 компани манай нүүрсийг худалдаж авч байгаа. Гашуунсухайтаар гаргаж байгаа. Тэрний 3 нь оффтейкийн гэрээгээр огт төлбөр төлөхгүй авч байгаа. 1 нь төлбөр төлж байгаа. Тэр 3 оффтейкийн гэрээг заавал ил болгоорой гэж би та нарт ард түмний өмнө ил болго гэж би танаас хүсэж байна. Та энийг нээлттэй болгоно гэдэгт эргэлзэхгүй байна.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн. Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Пүрэвдорж гишүүн бас төрийн оролцоог багасгах талаар, төсвийн хэмнэлтийг бий болгох талаар чухал саналууд дэвшүүллээ. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргын хувьд бас тодорхой саналуудаа өгч хамтарч ажиллахыг хүсье.

ДНБ-д эзлэх төрийн оролцоо 70 хувь гэдэг болон төлбөрийн тэнцлийн алдагдал тийм их байгаа бол зөрүүтэй мэдээлэл байж магадгүй. Төлбөрийн тэнцэл 4 дүгээр сарын эцсийн байдлаар 491 сая долларын алдагдалтай байгаа. Оны эхний 5 сарын байдлаар 31.8 сая тонн нүүрс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээр бол бараг ойролцоо 1 сая хүрэхгүй тонноор бага тоо байгаа. Гэхдээ яах вэ нүүрсний тонн тутамд нүүрсний үнэ 71.9 ам.доллар байсан бол 118 доллароос 39 хувиар буурсан нь гол энэ төсвийн тодотголд нөлөөлөх хүчин зүйл үзүүлэлт болж байна. Бүүр тодруулж ярих юм бол 5 дугаар сард нүүрсний үнэ бараг 2 дахин уналаа.

Алтны үнэ 3429 доллар өнөөдрийн байдлаар хүрч түүхэн рекорддоо хүрсэн. Гэвч алтны ... Монголбанканд тушаасан тушаалт ноднингийнх нь мөн үеийнхээс бараг 2 дахин бага буюу 4 тонн орчим байна. 5 дугаар сарын эцсээр 3.4 тонн байсан сая 4 тоннд хүрч байна. Ноднин мөн үед 7 тонн хүрч байсан. Жилдээ 20 тонн алт авч байсан энэ улс. Ийм учраас Алт 3 хөтөлбөр, бусад хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд таны хэлж байгаа шиг Алт 3 хөтөлбөр болон бусад томоохон төсөл хөтөлбөрүүдээ хэрэгжүүлж төсвийн тодотгол хийхэд таны хэлж байгаа шиг тэр төлбөрийн тэнцлийн алдагдал 2.5 тэрбум долларт хүрэхгүй. Бас эдийн засагт шок үүсгэж, буруу хүлээлт үүсгэхгүйн тулд бас мэдээллийг үнэн бодитой өгөх нь зүйтэй гэж үзсэн үүднээс тодрууллаа.

Гэхдээ бид төсвийн тодотголыг хийгээд төсвийн зардлаа хумьж чадах юм бол инфляцад үзүүлэх төсвийн эффект болон төлбөрийн тэнцэлд учруулах дарамт буурч ер нь бид хямралаас урьдчилан сэргийлээд зогсохгүй, хямралыг боломж болгох хувилбар байгаа. Энэ зорилгоор бид төсвийн тодотгол оруулж ирэх үедээ дэлгэрэнгүй танилцуулах учраас таныг хамтарч ажиллахыг хүсэж байна.

Оффтейкийн гэрээнүүдийн талаар би сайн мэдэхгүй байна. Төсвийн тодотголын үеэр бид нар сайн судлаад танилцуулъя. Болдын Жавхлан сайд дэлгэрүүлж хариулна. Сангийн сайд.

Д.Амарбаясгалан: Нэр дэвшигч, томилогдох этгээд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүний асуултад нэмж хариулъя. Оффтекийн хувьд нэмж хийгдсэн зүйлүүд байхгүй байгаа. Өмнөх онуудад хийгдсэн гэрээнүүд хүчин төгөлдөр үргэлжилж байгаа цөөхөн гэрээнүүд байгаа. Харин сая өмнөх Засгийн газрын үед хууль дээр бид нар дагаж оруулж Биржийн тухай хууль дээр оруулж ирж байсан ба баялаг солилцооны ийм шинэ эрх зүйн орчны асуудал яригдаад ингээд Их Хурал дээрээс Засгийн газар руу буцаасан байгаа. Энэ асуудал буцаасан хэдий ч бүрэн зогссон асуудал биш. Энийг дахиж сайжруулах, судлах, Их Хуралтай мөн хамтарч энэ дээр ажиллах, сайжруулах ийм шатдаа явж байгаа гэсэн үг.

Ер нь сая Пүрэвдорж ер гишүүн макро эдийн засгийн чиг хандлага том тоонуудыг зөв ярилаа. Зарим тоонууд дээр зөрүүтэй мэдээлэлтэй байх шиг байна. Ерөнхий хандлагатай санал нийлж байна. Тэгэхээр одоо хагас жилээр бид нэлээн дүнгүүдээ харлаа. Дараагийн хагас жил дараагийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Цогтгэрэл: Шинэ Засгийн газрын бүрэлдэхүүн шууд сайд нарын асуудал орж ирж байна л даа. Эндээс л бас ингээд асуулт гарч байна. Ер нь аливаа бүтэц, бүрэлдэхүүн систем шинээр ингээд эхлэхдээ уг нь ажлынхаа зорилгыг тавиад, тэрэндээ таарсан бүтцээ зураад, бүтцэдээ таарсан бүрэлдэхүүнээ хүний нөөцөө тавиад, энэндээ таарсан төсөв мөнгөө тавьдаг. Гэтэл ингээд төгсгөлөөс нь шууд хүнээсээ эхлээд ингээд явчих юм байна л даа. Тэгэхээр өмнөх бүтэц, бүрэлдэхүүн, бүтэц, тогтолцоо маш сайн байсан. Ийм учраас үргэлжилж байна. Тэр тусмаа Засгийн газрын сайд нарын 50 хувь нь буцаж улирч байх шиг байна. Тэгэхлээр маш сайн байсан гэсэн дүгнэлт гарч байх шиг байгаа юм. Тэгэхлээр яг өнөөдөр нөхцөл байдал ямар байгааг би бас та нарт цөөн тоогоор бас хэлье.

Өнөөдөр төсвийн орлого үлэмж хэмжээгээр тасарчихсан байна. Төсвийн орлого тасарна гэдэг чинь аж ахуйн нэгжүүд чинь татвараа төлж чадахгүй, ашиг орлогогүй, ажлын байр нь хомсдож байна. Татвараа төлж чадахгүй байна л гэсэн үг аж ахуйн нэгжүүд чинь. Тэгэхээр нөхцөл байдал ямар байх нь вэ. Төлбөрийн тэнцэл гэдэг зүйл чинь алдагдалтай болчхож байна. Нөгөө валютын ханш, олдог орлого, валютаар ордог орлого чинь байхгүй болчхож байна гэсэн ийм нөхцөл байдлууд өнөөдөр ингээд нөхцөл байдал байна.

Гэтэл энэ байдал яагаад бас ийм байдал үүсчхэв ээ гэдэг. Зарим тоонуудыг харахад үнэхээр бас тийм хайран он жилүүд өнгөрсөн хугацаанд байсан байна лээ. Өнгөрсөн 10 жилд бид нар уул уурхайгаас 90 тэрбум долларын борлуулалтын орлого орсон байна лээ. Өнгөрсөн 10 жилд. Тэрний өмнөх 10 жилд бид нар 30 тэрбумыг олж байсан байна лээ. Сүүлийн 10 жилд маш таатай буюу түүхий эдийн үнэд таатай буюу үндсэндээ өмнөх 10 жилээс 3 дахин илүү өндөр орлого олсон. Өнөөдөр валютын нөөц олон зүйл дээр бид нар дарамт үзчихээд төсвийн тодотгол, олон олон зүйл хасалт, таналт, олон олон зүйлүүдийг ингээд яриад ийм байдалтай өнөөдөр ингээд байж байна. Тэгэхээр үнэхээр яг сүүлийн 10 жилийг үзэх юм бол бараг сүүлийн 10 сараас бусад нь 1 нам засагласан ийм л нөхцөл байдалд. Өнөөдөр Эдийн засгийн өрсөлдөх чадварын судалгааны байгууллагаас бас эдийн засгийн эрх чөлөөний индексийг гаргадаг 2 байгууллагаас судалгаа гаргасан байна лээ. Нэг дээр нь 4 байраар ухарсан, нэг дээр нь 2 байраар ухарсан

буюу яг ердийн бизнесүүдийн, бизнесийн орчны нөхцөл байдал ийм л байдалтай ийм байна.

Тэгээд энэ бүгд эцсийн эцэст саяын ингээд том тоонууд 2 дугаар асуудал байх. Статистикийн газраас гаргасан мэдээллээр иргэдийг нь тэр тусмаа хөдөөгийн иргэдийн бодит орлого 2019 оны улсын дунджаас доогуур байна гэдэг. Иргэд дээр мөнгө очдоггүй, иргэд эдийн засагтай оролцдоггүй, иргэд нь ядуу, төсөв нь томроод байдаг, борлуулалтын орлого нь 3, 4 дахин ихсээд байдаг ийм л тогтолцооны алдаа бид нарт байгаа. Гэтэл сайд нар ингээд дахиж, Их Хурлын дарга дахиад 1 минут гүйцээгээд авчихъя. Нөгөө сайд нар нь улираад ажил маш сайн байна гэдэг ийм нөхцөл байдалтай.

Тэгээд эдийн засгийг харах юм бол ийм бид нарт ийм шарталтын байдалтай гэх юм уу урьд нь сайхан идэж уучихсан яг өнөөдөр ингээд шарталт эхэлж байна. Шарталт гэдэг чинь магадгүй эндээс бид нар ус ууж, шингэн ууж, шингэн залгуулах ёстой байх. Энэ нь магадгүй тэр нөгөө Олон улсын валютын сан маань ч хүлээж байгаа юм билүү. Нөхцөл байдал ийм төвөгтэй ийм байхад яагаад энэ бүтэц, бүрэлдэхүүн тогтолцоо чинь яг хуучнаараа явж байгаа юм бэ? Энэ дээр чинь өөрчлөлт оруулах ёстой, нөхцөл байдалд бодит тоонууд ийм зүйл илэрхийлж байхад өөрчлөлт орох ёстой биз дээ гэдэг би Ерөнхий сайдаас ийм л зүйл асуухыг хүсэж байгаа юм.

Яагаад энд ингээд Засгийн газрын тоо, сайд нарын тоо, нөгөө төсвийн хэмнэлт маань хаачив? Яагаад ийм том данхар гэж байгаа зүйл маань энэ чигээрээ цаашаа ингээд явчхаж байгаа юм? Яагаад бодлогын өөрчлөлт, мөрийн хөтөлбөрийн өөрчлөлт, тогтолцооны өөрчлөлт энд ингээд хийгдэхгүй шууд зөвхөн хэдэн хүнээ солиод ингээд урагшилья гэж байгаа юм бэ? Бүх зүйл зөв, зүйтэй байна гэж та нөхцөл байдлыг үнэлж байгаа юу?

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Дөнгөж саяхан бид хамтарсан Засгийн газар маш сайн ажилласан гээд аль аль намын гишүүд маань ажлынх нь үр дүнг үнэлээд ярьж байсан. Өнөөдөр бүх юм болохгүй болчихсон бол энэ бас бид хамтарсан Засгийн газрын ажлын үр дүн гэж үзнэ.

Гэхдээ өнөөдрийн төсөвт учирч байгаа орлогын тасал, дарамт бол манай гадаад эдийн засгаас хэт хамааралтай, уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийн энэ бүтцийн алдаа өнгөрсөн жилүүд бий, өнгөрсөн 1, 2 жилд бий болчихсон зүйл биш. Өнөөдөр гадаад шок, тарифын дайн, худалдааны нөхцөл, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалаад нүүрсний үнэ бараг 2 дахин уначихлаа. Үндсэндээ 40, 50 хувиар уначихлаа. Энэ бидний өндөр үнээр зарж байсан манай 15 төгрөгийн 9 төгрөг нь үндсэндээ нүүрснээс орж ирдэг энэ эдийн засагт том дарамт учруулж байгаа. Тэгэхдээ би гол зүйлийг нь гуравхан зүйлийг хэлчихмээр байна.

Нэгдүгээрт нь бол бид бүтэц өөрчлөөд, бүтцийн тухай болон бүрэлдэхүүний тухай хууль өөрчлөөд л бүрэлд нь өөрчлөөд байх боломж алга. Хууль, эрх зүйн хайчинд байна. Хууль зүйн хувьд энэ боломжгүй байна Засгийн газар бүрдэж байж энэ ажил хийгдэнэ.

Хоёрдугаарт нь цаг хугацааны хайчинд байна. Наадмын маргааш намар гэдэг энэ өвөл бас хүндрэх төлөвтэй. Энэ зуншлагын байдлыг хар, хуурайшлын байдлыг хар, бороо ногооны байдлыг хар. Тэгэхээр бид нар гуравхан 7 хоногийн хугацаанд төсвийн тодотгол хийгээд ажилдаа урагшаа харж явахаас өөр зам алга. Түүнээс биш 1, 2 яам татан буугдаад л нийгэмд гоё харагдаж алга ташуулахдаа гол биш, ажлын үр дүн чухал. Бид томоохон төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлж, төрийн дарамтыг багасгаж, төрийн өмчийн компаниудын менежмент, шинэчлэл, хувьчлалыг хэрэгжүүлж, цогц том реформ хийхийг зорьж байна.

Гуравдугаарт нь энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг Ардчилсан намын ч мөрийн хөтөлбөр орсон. Ардын намын ч мөрийн хөтөлбөр орсон. ХҮН намын ч мөрийн хөтөлбөр орсон хамтын мөрийн хөтөлбөр. Энэ нийт ард сонгогчдынхоо саналыг гээхгүй гэж энэ Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлт, үзэл санааг амилуулах гэж хийсэн мөрийн хөтөлбөр гэж үзэж байгаа учраас энэ мөрийн хөтөлбөрийг өөрчлөхгүйгээр үргэлжлүүлж ажиллаж байгаа. Хийх ажил тодорхой.

Тэгэхээр ажлынхаа зорилгод нийцүүлж төсөв өөрчлөх, бүтцээ өөрчлөх боломжгүй. Бид ажлын зорилгоо хэвээр тавьж байна. Тэгээд л нэг Засгийн газар гарч ирээд л хуучин Засгийн газрынхаа бүх юмыг үгүйсгээд л цоо шинэ зохион бүтээгээд л, дугуй зохион бүтээгээд явах боломж ч алга, хугацаа ч алга, төсөв мөнгө ч алга. Ийм учраас энэ хамтарсан Засгийн газрын ч гэсэн энэ нийт ард иргэдийн хүсэн хүлээсэн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор явж байгаа энэ бүтэц. Тэрэнд тохируулж хийсэн бүтэц үргэлжилж ажиллах ёстой гэж үзэж байгаа юм.

Гуравдугаарт нь энэ улс төрийн хайчинд байна. Улс төрийн нөхцөл, гадаад нөхцөл байдал, бараг энэ Иран, Израилын нөхцөл байдал, дэлхийн геостратегийн хурц нөхцөл байдал маш хүйтэрч байна. Ийм учраас гаднаа хүйтэн байхад дотроо бид дулаан байх шаардлагатай болж байна. Дахин давтан хэлэхэд манай эдийн засгийн нөхцөл байдал, нөхцөл байдал бол илүү хүндрэхээс урьдчилан сэргийлж, яаралтай төсвийн тодотгол хийж энэ өөрчлөлтүүдээ хийхгүй бол бидний тулгарч байгаа бэрхшээлүүд дэлхий нийтээрээ л тулгарч байгаа том бэрхшээл болж байна.

Ийм учраас бид энэ хамтын мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийг зорьж энэ бүтцээ хэрэгжүүлж байна. Томоохон хөтөлбөрүүдийг ганц, хоёр сайд солиод л, ганц, хоёр хүн солиод л нийгэмд гоё харагдаж, алга ташуулахаас илүү бодит үр дүн бол бид томоохон төсвийн хэмнэлтийг хийж, төрийн албаны данхгар бүтцийг, данагар бүтцийг цомхон чадварлаг болгож, цахимжуулалт, хувьчлал, шинэчлэл, цогц өөрчлөлтийг хийх том ийм үүрэг зорилтыг хэрэгжүүлнэ. 14 мега төслөө эрэмбэлнэ. Энэ томоохон ажлуудыг төсвийн тодотголоо өргөн барих үеэр танилцуулах учраас өнөөдөр энэ бүтцээ яаралтай өргөн барих шаардлага болж байгаа. Ингэж томилж байж бид Бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульдаа ч гэсэн өөрчлөлт оруулах бололцоо бүрдэх юм билээ. Тийм .../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Занданшатар дарга гүйцээгээд хариулчихъя.

Г.Занданшатар: Тийм учраас үндсэндээ бид 4 үндэсний хороо, 59 зөвлөл, хороодыг татан буулгаж, төрийн албанд давхардал, чирэгдэл үүсгэж байгаа 14.4

мянган төрийн албаны давхардлыг арилгах чиглэлээр ажиллаж энийг нь нэлээн их хэмжээний мөнгөний хэмнэлт бий болгохоор ажиллаж байгаа. Түүнээс биш өнөөдөр, маргаашдаа 1, 2 хүн солиод бүтэц гоё харагдуулаад ингээд байхаасаа илүү энэ цомхон, чадварлаг төрийн алба, хувийн хэвшлээ дэмжсэн эдийн засаг, хариуцлагатай ил тод байдлыг эрхэмлэж ажиллах зорилгоор л яаралтай ажилдаа орох шаардлагатай учраас Засгийн газрын гишүүдээ томилохоор танилцуулж байна.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Ерөнхий сайдын оруулж ирсэн баг, сайд нарын хувьд таалах, таалахгүй нь тусдаа асуудал. Ажил хийх, хариуцаж явах хүн нь та өөрөө юм. Тийм болохоор энэ баг бүрдүүлэх гэж бодвол их л олон талын тэнцэл, баланс зөндөө л юм болсон байлгүй. Хариуцлагаа үүрээд явах гэж байгаа багт нь сайн ажиллахыг хүсье дээ. Тэгээд 3 зүйл хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт нь Засгийн газрын бүрэлдэхүүний тухай, бүтцийн тухай хууль хүчинтэй байгаа. Хүчинтэй хууль дотроосоо 3 ийм юунд байхгүй болчихож байна шүү дээ. Тэгэхээр ингээд хоосон яваад байвал нөгөө Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчим, Засгийн газрын өөрийнх нь үндсэн зорилго нь бас хууль хэрэгжүүлэх. Энэ дээр ийм хууль зүйн зөрчил үүсэх вий, энэ тал дээр анхаараасай гэж хүсэж байна. Бодвол тооцож бодсон л байгаа байх.

Хоёрдугаарт нь өнөөдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч маань гадаадаас түлш авчирч өвөл шатаана гэж хэлсэн. Тэгээд энэ дээр бас энэ тендер зарлагдчихсан байгаад байна л даа энэ байна. Хагас кокс хөх нүүрсээр хийсэн шахмал түлшийг Нийслэлийн Засаг даргын төсвийн ерөнхийлөн захирагчаар 226 тэрбум төгрөгөөр авна гээд. Тэгээд энэ 23 онд ийм юм явж байгаад больчихсон юм. Тэгээд энд яах вэ асуух гээд байгаа юм нь 10-аадхан хоногийн өмнө Улсын Их Хурал тогтоол баталсан. Тогтоол дээр энэ түлшинд, нүүрсэнд түлшинд төсвийн мөнгө зарцуулахгүй гээд гарчихсан 11 дүгээр заалт. Тэгээд 6 сарын 5-нд Улсын Их Хурал тогтоол гаргаад 6 сарын 10-нд нийслэл нь тендер зарлаад ингээд Улсын Их Хурлын шийдвэрээ тоодоггүй, энэ хотын ер нь саяын тэр автомашины татвар дээр ч гэсэндээ энэ дээр бас анхаарахгүй бол. Мэдэхгүй би энийг зөрчилтэй, хууль зүйн зөрчилтэй асуудал байна. Шууд харагдаж байгаа.

Эцэст нь хэлэхэд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн дээр, түрүүчийн энэ засаг дээр шинжлэх ухаан, инновацын асуудлыг 3 хуваагаад 3 яаманд тавьчихсанаас нь болоод маш их асуудал үүсэж байгаа. Энэ талаар албан бичгээр бланк дээр анхаарахыг хүсээд санал Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байгаа. Энийг танд бас мэдээлье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Жаргалсайханы Золжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ хууль дээдлэх зарчмын хүрээнд ч гэсэн тэр бид төсвийн тодотголоор энэ бүрэлдэхүүний хуульдаа өөрчлөлт оруулж, 4 Үндэсний хороо, 59 зүйлийг цэгцэлж зардлыг хэмнэх томоохон ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн тэр 3 төвийг бас Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний төв гээд энэ 3 төвийг нэгтгэж 1

төв болгож, чирэгдлийг багасгах чиглэлээр төсвийн тодотгол дээр зохион байгуулалтын ажил хийхээр төлөвлөж байна.

Ер нь оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлж, төрийн албаны чиг үүрэг давхардал, бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, удирдлага, гүйцэтгэх ажилтны зохистой харьцааг хангах бол төр иргэддээ ойрхон байх үйлчлэх хамгийн гол үндэс болно гэж үзэж байгаа юм. Ийм учраас төрийн албан хаагчдын зохистой орон тоог тогтоогоод, цалин хөлсийг нь бууруулахгүй харин ч үр дүнгээр нь санхүүжүүлдэг, цалинжуулдаг энэ тогтолцоог нэвтрүүлэх төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг нэгдсэн бодлогоор зохицуулахын тулд энэ хэмнэлтийг бүүр тодорхой хэлбэл төрийн албаны аттестатчиллыг явуулахаар бас төлөвлөж төсвийн тодотголтой хамт өргөн барихаар хэлэлцэж байна.

Хуулийн зөрчлийн хувьд хуулийн зөрчил үүсэхгүй гэж манай Хэрэг эрхлэх газар хуульчид бас үзсэн.

Асуултад нэмж хариулах асуудал бол, ер нь 108 хуулиар зардал нэмэгдээд байгаа Улсын Их Хурлаас Булгантуяа Улсын Их Хурлын дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг бас гарсан ажиллаж байгаа. Өргөн баригдсан хууль дээр энэ зардал хэмнэх чиглэлээр энэ 3 төв чинь орчихсон явж байна лээ. Тэд чинь тус тусдаа хуулиар байгуулагдаад, зардлууд нэмэгдээд тодорхой эрсдэлүүд үүсгээд байгаа гэж үзсэн байна лээ.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Бейсен: Шинээр сонгогдсон Ерөнхий сайд болон шинээр сонгогдож байгаа сайдууд, олон жил улиран сонгогдож байгаа архагшсан сайдууддаа бас ажлын амжилт хүсье. Олон дахин улиран сонгож байгаа сайдууд маань бас салбараа мэддэг учраас улиран сонгож байгаа гэж бодож байгаа. Ер нь туршлагатай гэж бодоод улиран сонгож байгаа байх. Тийм учраас нөгөө 14 мега төслөө ингээд хөдөлгөөд цаашаа аваад явчих байх. Улс орны хөгжүүлэлтийн төлөө явах байх гэж бодож байна.

Нөгөө талаар энэ манай аймгаас бас 1 сайдыг Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулж байгаа Ерөнхий сайд, Ардын намын бүлгийнхэндээ, сайдууддаа бас аймгийн нийт ард иргэдийн өмнөөс бас баярлалаа гэдгээ хэлье.

Энэ 3 асуулт асууя гэж бодож байна Нэгдүгээрт, энэ Эрүүл мэндийн сайдаас энэ ЭМД-ын санхүүжилтийн асуудал, боловсон хүчний хомсдолын асуудал байж байна. Эмнэлгүүдийн ихэнх нь өр зээлтэй, эмийн үнэ өндөр, ялангуяа баг, сумын эмийн сангийн асуудлууд дээр яаж ажиллая гэж бодож байна? Цаашдаа ямар төлөвлөгөө, бодлого баримталж ажиллах вэ гээд асууя.

Сангийн сайдаас энэ 2 аравны хэдэн их наядаар төсөвт танана, төсвийн тодотгол хийнэ гээд ярьж байна. Тэгэхээр эхэлсэн ажлууд бас байж байгаа. Энэний төсөв дээр бас харж үзэх үү ер нь? Жишээлбэл Баян-Өлгий аймгийн тэр оношилгооны төв гээд том 4, 5 давхар барилга баригдсан. Тэр нь юу гэнэ вэ цалингийн зөрүүний асуудал гэнэ үү 3 аравны хэдэн тэрбумтай холбоотой гацчихаад байгаа. Энийг чинь баруун бүсийн зөвлөгөөн болох үед хүлээлгэж өгнө

гэж ярьж байгаа. Урьд нь Баделхан гишүүн санаачлаад бид 3 гишүүн бас дэмжээд ингээд та бас дэмжээд ингээд тухайн үед нь төсвийг нь батлуулаад барилга нь бэлэн болсон. Дотоод заслын асуудлууд дээр нь төсөв нь хүрэлцэхгүй байгаа юм байна. Энд 3 аравны хэдэн тэрбум гэнэ ээ дээ материалуудыг нь танай Сангийн яамныхан мэдэж байгаа. Энийг шийдэж өгөх үү гэдэг асуудал байна.

Ерөнхий сайдаас асуух асуулт байна. Бүсүүдийн зөвлөгөөн хийсэн. Баруун аймгийнхыг 3 сарын 20-нд хийнэ гэсэн дараа нь 4 сар болсон, дараа нь 6 сар одоо ингээд засагтай холбоотой хойшлогдоод байна. Намар тийшээ болохоор чинь бас шийдэгдэх, шийдэхгүй асуудлууд байж байна. Энийг зун наадмын дараа ч юм уу, наадмаас өмнө ч хийх боломж байхгүй байх л даа. Баруун бүсийн зөвлөгөөнийг хэдийд хийх вэ, энэ талаар товлосон юм байна уу? Би 3 асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Түрүүн сайд нарт томилогдох гишүүдийн нэрсийг танилцуулахдаа бас 1 сайдын танилцуулга орхигдсон байна. Занданшатар даргыг нөхөж танилцуулахыг индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Гадаад бодлого тогтвортой, залгамж чанартай үргэлжлэхийн тулд бас жич танилцуулах ийм шаардлагатай ч бас байсан юм шиг байна. Ингээд Батмөнхийн Батцэцэгийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын албан тушаалд томилохоор танилцуулж байна.

Гадаад нөхцөл байдал эгзэгтэй, тогтворгүй үед Монгол Улсын гадаад бодлого тогтвортой байх учиртай. Энэ бол илэрхийлэл нь ч болно гэж бодож байна.

Ингээд 1973 онд Баянхонгор аймагт төрсөн 51 настай. Эхнэр, 3 хүүхэд, нөхөр 3 хүүхдийн хамт амьдардаг. 1992 онд Дархан хотын 13 дугаар дунд сургууль, 1996 онд МУИС-ийг ОУХДС-ийг төгссөн. 2000 онд СЭЗДС, 2005 онд Нидерланд Улсын Маастрихийн менежментийн их сургуулийг тус тус төгссөн. Олон улсын харилцааны ажилтан, багш, орчуулагч мэргэжилтэй. Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

1996-2005 онд “Мөнхийн үсэг” ХХК-ийн Ерөнхий захирал, 2005 онд “Аз хур” ХХК-ийг үүсгэн байгуулагч, 2005-2007 онд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагт Гадаад сурталчилгаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, 2007-2015 онд “Мөнхийн үсэг” группийн Удирдах зөвлөлийн дарга, 2010-2011 онд Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх, 2011-2012 онд Монгол Ардын намын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, 2015-16 онд Сангийн сайдын Гадаад харилцааны зөвлөх, 2016-2020 онд Гадаад харилцааны дэд сайд, 2021-2024 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд, 2024-2005 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдаар ажилласан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа. Гадаад харилцааны сайдад нэр дэвшигчийг танилцуулж дууслаа.

Д.Амарбаясгалан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүнийхээ асуултад хариулъя. Ер нь таны анхаарал тавьж байгаа зүйл ер нь анхан шатын тусламж, үйлчилгээ онцгой чухал. Ялангуяа орон нутагтаа, сум, дүүрэгтээ эмчилгээ үйлчилгээ зөв чиглүүлдэг байх энэ тогтолцоог бүрдүүлэхэд ялт ч үгүй л бид анхан шатны тусламжаа сайжруулах ёстой. Энэ дотор бид цахимжилтаа дуусгах ёстой. Энэ эмч, сувилагч нарын ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа баахан бичиг цаас бөглөдөг асуудлыг нэг мөр дуусгах ёстой. Цахим шилжилт бүрэн дуусах ёстой.

Хоёр дахь асуудал даатгалын сангийн санхүүжилт өөрөө их чухал. Би энийг Ерөнхий сайдтай нэлээн нарийн ярих ёстой гэж бодож байгаа. Одоо төсвийн тодотгол оруулахад бид бас ер нь энэ санхүүжилтээ, ЭМД-ын санхүүжилтээ яаж оновчтой болгох юм, байгаа мөнгөө яаж зөв зарцуулдаг байх юм, яаж хиймэл оюун ухааныг энэ том өгөгдөлтэй ашигладаг байх юм, яаж үр дүнтэй байлгах вэ гэдэг нэлээдгүй олон олон асуудлууд байгаа. Энэ дээр бас та бас зөвлөж хамтарч ажиллаарай гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан гишүүн асуултад хариулъя.

Б.Жавхлан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан байдаг. Тодотгол хийх хуулийн нөхцөл үүссэн байгаа. Тэр нь юу вэ гэхээр шинэ Засгийн газар байгуулагдаад Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулахаар болж байгаа. Ер нь хуулиараа Засгийн газрын нэршил, бүтцэд цэг, таслал, өөрчлөлт ороход л Төсвийн тодотгол хийх ийм шаардлага үүсдэг юм байгаа юм. Энэ удаа Үндсэн хуулийн шаардлага нь ингэж үүсэж байна. Үүнийг дагуулаад хэмнэлтийг нь тодотгол өргөн барих ийм үүргийг Ерөнхий сайд үүрэг өгсөн байгаа. Ингээд бид бэлдэж байна.

Тэгэхээр таны асуултад асуусан тэр зүйл дээр та санаа зовох зүйлгүй шүү. Юу вэ гэхээр Төсвийн тухай хуулийн 29.3 дугаар, 3.6 дугаар зүйл дээр юу гэж байдаг вэ гэхээр нэгэнт өмнө нь төсвийн хууль дээр тусгагдаад, гэрээ нь хийгдээд эхний санхүүжилтүүдээ аваад явж байгаа төслүүдийг дундуур нь ямар ч төсвийн тодотголоор тавьсан төсвийг нь хасаж болохгүй ээ гэсэн ийм хуулийн заалттай. Тийм учраас амжилттай үргэлжилнэ.

Харин нэмэлт төсвийг бол би хэрвээ хэлж мэдэхгүй байна. 350-аад тэрбум төгрөгийн нэмэлт төсвийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Б.Жавхлан: Тийм нийтдээ 350-аад тэрбум төгрөгийн нэмэлт төсвийг Үндэсний аудитын газар хянагдаж байгаа. Ингээд 2026 оны төсөв өргөн барихаас өмнө энэ хянагдаж дуусаад ирэх ёстой. Гэхдээ энэ бас бүгдээрээ орчихно гэсэн үг биш. 2026 оны төсөв нэлээн чанга орж ирнэ. Одоо энэ тодотголоор энэ дараах дүнгээрээ үндсэндээ суурь болж орж ирэх байх. Тэгэхээр нэмэлт төсөв нэлээн чанга орж ирнэ. Яг бүгд орж ирнэ, орж ирэхгүй гэж хэлэх боломж байхгүй байна. Тэгэхээр энэ удаагийн хэмнэлтийн тодотголыг ирэх долоо хоногт өргөн барина.

Тэр үед үргэлжлэх төсвийн бодлого нэлээн дэлгэрэнгүй та бүхний асуултад хариулаад явна.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Ерөнхий сайд, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд бас асуулт байна. Энэ эрүүл мэндийн салбарын цалин хөлсийг нэмэхгүй бол үнэхээр их, 80-аад хувь нь цалингийн зээлтэй, ажил нь хүнд, ачаалал нь их. Тийм учраас энэ дулаан, цахилгааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой эд нар ер нь байдал нь хүндрэх янзтай. Энэтэй холбоотой мэргэжлийн хомсдолд бас орж байна. Цалинг нь ядахдаа 1 дахин биш гэхэд 50 хувь нэмэх боломж байна уу, ер нь тэр талаар анхаарах боломж? Ер нь эрүүл мэндийн салбараа та бүгд анхаараад үз л дээ. Ачаалал их байна, өдөр шөнөгүй ажиллаж байна. Та бүгд ер нь бид нарын гишүүд маань бүгдээрээ дэмжих хэрэгтэй байна энийг ерөөсөө. Энийг нэмэх боломж байна уу? Ер нь ядахдаа 50 хувь?

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан гишүүн хариулт өгье.

Б.Жавхлан: Бейсен гишүүний асуултад нэмж хариулъя. Өнгөрсөн жилүүдэд төсвийн зардал талд нэлээн өндөр ачаалал өгсөн гол хэсэг нь бол энэ дээр цалингийн зардал байгаа. Төсвийн нэмэгдлийн ерөнхийдөө 65 хувь нь төрийн албан хаагчдын цалин. Тэр дундаа ерөөсөө 3 салбар байгаа. Боловсрол, энэ боловсролын салбар, мөн эрүүл мэндийн салбар. Гол 2 масс энд байдаг цалингийн нэмэгдлийн. Үндсэндээ бид КОВИД-ын үед 20, 21, 22 онуудад олигтой нэмж чадаагүй. Ингээд 23, 24 онуудад бол ер нь чамгүй нэмсэн. Нийт салбараар нь харах юм бол ер нь 70-80 хувь нэмсэн. Нэмэгдлүүдийг нь оруулж тооцох юм бол. Ингээд одоо бид цаашдаа маш тодорхой бодлоготой явна. Юу вэ гэхээр Төсвийн хууль дээр төрийн албан хаагч нарын цалинг үнийн өсөлттэй уялдуулж жил бүр нэмнэ гэж байгаа. Тэгэхээр ирэх жил бол 6-8 хувийн ийм хязгаар дотор нэмэх бид ийм хуулийн заалттай бөгөөд үүрэгтэй. Тэрнээс биш яг таны саяын.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Ө.Шижир: 2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Засгийн газар ДНБ-ийг 2028 он гэхэд 10 мянган долларт хүргэнэ гэсэн мөрийн хөтөлбөртөө оруулсан. Өнөөдрийн байдлаар 6800 доллар байгаа. Гэтэл 2025 оны эхний 5 сарын байдлыг харахад эдийн засгийн зарим үзүүлэлтүүд яг бодитойгоор энэ нөхцөл байдал руу хүрч чадах уу гэдэг ийм бас болгоомжлол байгаад байгаа юм.

Тийм учраас эдийн засгийн нөхцөл байдал өнгөрсөн жил чинь бид нар энэ оны төсвийг батлахдаа эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэнэ, ДНБ-ийг 93 их наяд хүргэнэ, тэгээд инфляцыг 6 хувьд барина гээд ингээд маш их өөдрөг төсөвлөсөн.

Гэтэл одоо өнөөдөр инфляц 8.3 хувь байгаа. Энэ байгаа бол одоо эдийн засгийн нөхцөл байдалтай хамааралтайгаар бас улам цаашаа өсөх байх. Төсвийн орлого бас 1 их наяд гаруй төгрөгөөр одоогоор тасалдчихсан байна. 2024 оны 4 дүгээр сар 2025 оны 5 дугаар сарын байдлаар гадаад валютын нөөц 3.7 сарын

нөөцтэй байна гэдэг энэ нөхцөл байдал цаашаа улам хүндрэх юм бол энэ гадаад валютын нөөцөөс багасна.

Тэгэхээр бид нар энэ гадаад валютын нөөц маань энэ эдийн засгийн хүндэрч байгаа нөхцөл байдлаа давж чадах уу гэдэг бас ийм асуудал. Яагаад энийг хэлээд байна вэ гэхээр би нөгөө ДНБ 10 мянган доллар хүргэж чадах уу гэдэг л ганц асуулт асуух гээд байгаа юм. Ер нь 2021 оноос хойш өнөөдрийг хүртэл бид нар гадаад импорт нийтдээ 2.4 их тэрбум доллароос 4.5 тэрбум доллар болоод ингээд 2 дахин өсчихсөн. Орлого олж байх үедээ ингээд хэт өөдрөгөөр төсөөлөөд төсвийн урсгал зардлыг хэт нэмэгдүүлсээр байгаад өнөөдөр бид нар төсвийн урсгал зарлал бас 1 их наяд төгрөгөөр бас ингээд дутчихсан яваад байгаа.

Тэгэхээр энгийнээр айлаар ярих юм бол айл хэдхэн сарын хугацаанд орлого олж байх хугацаандаа юу гэдэг юм авч болох зээл, хэрэглэж болох бүх хэрэглээний юмаа урьдчилаад авчихсан. Тэгээд орлого тасалдаад ирэхээр яаж төлөх вэ гэдэг ийм бас нөхцөл байдал руу орж байна л гэж үзээд байгаа юм л даа. Ингээд төсвийн зардлын чинь бараг 80 орчим хувь нь цалин, урсгал зардал, татаас, урсгалд шилжүүлдэг болчихсон. Бид нар ингээд ямар ч ийм хөрөнгө оруулалт хийх бас боломжийн хувьд маш бага болчихлоо. Үүнд ингээд нөхцөл байдлын хувьд харахад ингээд сүүлийн жилүүд бид нар бас энэ төсөв, эдийн засгийн бодлого дээрээ хангалттай зөв бодлого хийж чадсан уу гэдгийг би бас асуумаар байгаа юм. Тэгээд сая ер нь Ерөнхий сайд бас хэлж байна төрийн албаны данхар бүтэц гэж бас хэлж байна. Гэтэл өнөөдөр аж ахуйн нэгж, байгууллагуудын дундаж цалин 2.4 сая төгрөг байгаа төрийн өмч болон төсөвт байгууллагуудын үйлдвэрийн газруудын дундаж цалин 3.5 сая төгрөг болчихсон. Ингээд бид нар төсөв дагасан эдийн засагтай болчихсон.

Тийм учраас хүн төрийн байгууллагад ажилд орох, төрд илүү ажиллах ийм сонирхлууд нь илүү их болчихсон байна. Тэгээд бид нар ер нь цаашдаа бас улсын төсөв батлахдаа дараа нь гүйцэтгэлийн нээлттэй ийм бодит хэмжээгээр ингээд харж байхгүй бол газар тэнгэр шиг зөрүүтэй ийм өргөн анхны өргөн барьсан төсөл дараа нь үр дүн гараад байна. Тэгэхээр миний Ерөнхий сайдаас асуух ганц асуулт байгаа нь бид нар 2028 он гэхэд ДНБ-ээ 1 хүнд ноогдох 10 мянган доллар хүргэж чадах уу? Яагаад гэвэл эдийн засгийн нөхцөл байдал энэ жил бас сайнгүй. Ирэх жил бас тийм таатай биш байх нөхцөл байдал гадаад.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Өлзийхүүгийн Шижир гишүүний асуултад хариулъя. Ер нь ер нь 2025 онд статистик тооцооллоор, төсөөллөөр Жи Ди Пи пэр капита/GDP per capita/ буюу 1 хүнд оногдох ДНБ 7400 долларт хүрнэ гэж тооцоолж байсан Монголбанкны урьдчилсан тооцоо. Ханшийн дарамт, нөөц 5.1 тэрбум доллартой боловч валютын цэвэр нөөц хасах руу орсон байгаа. Энэ бол санхүүгийн дансны өсөлт нь бол жинхэнэ экспортын урсгал дансны орлогоосоо 491 сая долларын алдагдалтай 2 дахин буурчихсан тухай ярьсан.

Тийм учраас ийм олон дарамтууд байгаа учраас ер нь тоог тэгээд өнөөгийн гадаад нөхцөл байдал урьдчилан таамаглаж болохгүйгээр өөрчлөгдөж байгаа учраас зарим нь өөр, сүүлийн үеийн нөхцөл байдлыг дэлхийн 3 дугаар дайны

ирмэг дээр байна гэж олон улсын зарим шинжээчид дүгнэх болсон. Ийм нөхцөл байдалд цээжний мангаар тэд эд болчихно гээд шууд хэлэх бололцоогүй.

Тэгэхдээ бид томоохон төслүүдээ, мега төслүүдээ эрэмбэлээд хүний хөгжлийн том төсөл, хөтөлбөр гаргаснаараа бол бид энэ 5 жилийн хугацаанд ДНБ-ийг 1 хүнд оногдох ДНБ-ийг 10 мянган долларт хүргэх, 10 жилийн хугацаанд 2 дахин өсгөх энэ бодлогыг хэрэгжүүлэх бололцоотой гэж бодож байгаа юм. Хамгийн гол нь энэ дээр бид энэ үр ашиг, ил тод байдал, хариуцлага, мөн үр ашигтай менежментийг хэрэгжүүлж байж л энэ төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байж ийм үр дүнд хүрнэ. Монгол Улсын эдийн засаг бол 10 тэрбум долларт хүрэх боломж бий.

Гэхдээ уул уурхайн энэ супер цикл, хөрөнгө оруулалтын урсгал, институцийн реформ, засаглал, говерненс/ governance/ реформ гэдэг энэ 3 зэрэгцэж хэрэгжиж байж л үр дүнд хүрнэ. Өнөөдрийн энэ авлига, ил тод бус байдал, тогтворгүй байдал энэ өсөлтөд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл. Ийм учраас тогтвортой байдал, залгамж чанарыг би эрхэмлэж зөвхөн бүтцээрээ нэг оролдоод суугаад байдаг биш. Ширээ, сандал зөөгөөд л, яамны 1 үсэг солигдоход л бөөн зардал шүү дээ. Бланк хэвлэгдээд л, тамга тэмдэг солигдоод л, баахан хүмүүс сандал, ширээ зөөж давхиад л баахан хүний ажил орон тоог халж, солиод л ингээд бөөн бужигнаан болдог. Энэ бүх туршлагаар үр дүнд хүрдэггүй юм байна лээ. Гаднаа л их сайхан хэмнэлт хийгээд байгаа юм шиг мөртөө цаанаа улам л данхайгаад байдаг.

Тэгэхээр уг язгуур болсон төсвийн хэмнэлтийг, төрийн хэмнэлтийг, тэгээд үр ашгийг, бүтээмжийг чиглэсэн ийм том өөрчлөлтийг хийж байж чадвал бид энэ 10 тэрбум долларт хүрэх саяын 3 чиглэлээр өөрчлөлт хийж хийх бололцоотой. Ийм тооцоолол ч бий. 10 жилийн том төлөвлөгөө боловсруулсан байгаа. Тэгээд манай Сангийн сайд Болдын Жавхлан дэлгэрүүлж хариулна.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Ерөнхий сайд сая хэллээ үндсэндээ 3 гол ажил дээр фокус болно гээд. Мөн Шижир гишүүний хэлсэн дээр нэмж хэлэхэд бид 10 мянган доллар 1 хүнд ноогдох орлогоо тэр хэмжээнд хүргэх боломж байсаар байгаа. Байсаар байгаа. Энэ удаагийн эдийн засгийн энэ хүндрэл бол бидний өмнө тулгарч байгаа дараагийн шинэ сорилт. Тэрнээс энэ эдийн засгийн хямрал биш шүү. 2020, 2021 онуудад бид 2 хилээ хаалгачихсан, агаарын хилээ хаалгачихсан, дотооддоо хөл хориотой ийм хүнд үед эдийн засаг /-5/ хувь уначихсан. 2 жилийн дотор л бид энэ хүнд байдлаас гарч байсан. Дараа нь Хөгжлийн банкны мөн хямрал, мөн энэ геополитикийн хямрал гээд энэ олон хүнд үеүдийг бид нар давж гарсан. Энэнтэй харьцуулах юм бол энэ удаагийн сорилт бол хямрал огт биш. Сүүлийн өдрүүдэд олон улсын валютын сангаас 6 сард ирдэг ээлжит баг ирээд ажиллаж байгаа. Тэдний дүгнэж байгаагаар энэ удаа бол хямрал биш байна. Энийгээ удирдаж болохоор байна. Та бүхний хийх гэж байгаа энэ тодотгол .../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Төсвийн бодлогуудаа амжилттай хийх хэрэгтэй байна. Тэгвэл ер нь ингээд энэ хүндрэлээс гарах бас боломжууд байна гэдгийг хэлж байгаа. Тийм учраас таны хэлж байгаа тэр 10 мянган долларын зорилт бол хэвээрээ байгаа гэдгийг хэлье. Инфляц одоо 8 хувьтай байна. 6 хувь гэдэг бол зорилт шүү. Төв банкны зорилт байхгүй юу. Тэгэхгүй гүйцэтгэлээ хараад бид нар 8 хувь гэж зорьж болохгүй. Энэ 8 хувийг 6 хувь руу чиглүүлж бид нар зорилтын бодлогоо чиглүүлнэ ээ гэсэн үг. Төсвийн орлого 1 их наядаар дутаж байгаа. Тэрнээс биш энэ алдагдал биш шүү. Засгийн газар дутаж байгаа орлогынхоо хэмжээнд зарлагаа хийгээд явдаг. Бид нар 100 хувь байх ёстой 6 сарынхаа зардлыг бид нар 75 хувь дээр татаад явж байгаа гэсэн үг.

Тийм учраас бид нар орлогодоо тааруулаад үйл ажиллагааныхаа санхүүжилтийг бүрэн хийгээд явж байгаа. Өчигдрийн байдлаар нөөц 5.1 тэрбум доллар байна. Энэ нь 4.7 сарын импортын хэрэгцээг бүрэн хангаад энэ ингээд явж байгаа. Тантай санал нийлж байгаа зүйлүүд байна байна.

Тэр хөрөнгө оруулалтын хувьд бол бид нар ийм төсвийн нөхцөл байд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Тийм. Яагаад асуугаад байна вэ гэхээр 2028 он чинь удахгүй л дээ. Ингээд л 2, 3-хан жилээр хүрээд ирнэ. Тэгтэл бид нар 2024 онд баталж байсан Их Хурлаас баталсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр маань энэ нь үр дүндээ хүрч чадсан уу гэдэг л хамгийн эхний асуулт болж байгаа юм. Яагаад гэхээр 2020 оноос хойш валютын ханшийг бид нар өнөөдрийн байдлаар 750 орчим төгрөгөөр суларчихсан буюу алдчихсан. Он гарснаас хойш бараг 80 орчим төгрөгөөр валютаас чангарчихсан. Эсрэгээрээ гол бид нарын 105 доллароор нүүрс экспортолно гэж байсан үнэ маань уначихсан. Ингээд төсөөлж байсан орлого, төсөөлж байсан зардал 2 чинь ингээд 2 тийшээ явчхаж байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бид нар ханшийг барих гэдэг чинь бас аягүй хүнд асуудал болж байгаа. Тэгээд дээр нь энэ гадаад нөхцөл байдал яг КОВИД-ын хүрээнд Орос, Украины гэж ярьж байсан. Одоо бол өнөөдөр шинээр үүсэж байгаа нөхцөл байдлууд бас энэ манай эдийн засагт яаж нөлөөлөх вэ? Тийм учраас энэ бид нарын тооцоолол яг бодитой байж чадах уу, хэрвээ хүрэхгүй бол бодит тооцоололд хүрч чадахгүй бол яах вэ гэдэг утгаар л би асуугаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Тийм Шижир гишүүний санаа зовж байгааг ойлгож байна. Ерөөсөө гадаад эдийн засгийн нөхцөл байдал маш тогтворгүй, урьдчилан таамаглах боломжгүй байгаа нь үнэн. Эдийн засгийн хямрал гэж ДНБ-ий өсөлт 2 улирал дараалан сөрөг гарах юм бол хуучин 3 улирал гэдэг байсан. Сөрөг гарах юм бол энийг хямрал гэж үздэг. Одоо 4.6 хувьтай тэгээд үлээгдэж байгаа үзүүлэлт 6 хувь, Оюутолгой байна. Онтри байна. Ингээд өсөлтүүд, зэсийнх, алтны өсөлтүүд бий бол энийг нөхөх бололцоотой л доо.

Тэгэхдээ гадаад эрсдэл дор хаяад 2 жил үргэлжилнэ гэж эдийн засагчид үзэж байгаа. 1 хүний олгогдох ДНБ-ийг 10 мянган долларт хүргэхийн тулд валютын

ханшийг анхаарах хэрэгтэй байгаа. Энэ 90 оноос хойш 41 дахин өндөр өссөн тул импортынх гэж үзсэн, экспортын орлого хязгаарлагдмал болсон, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, дотоодын үйлдвэрлэлийг дэмжихгүй, ажлын байр бий болгохгүй ийм эдийн засгийн бүтцийг өөрчлөхгүйгээр бид нар ханшийг тогтвортой байлгах боломжгүй.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Тэгээд уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засаг маань мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлого явуулахыг шаарддаг. Ийм ч учраас бид хориг тавьж, төсөв дээр алдагдлыг бууруулах чиглэл барьж байсан. Тэгэхээр эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш байлгаж байж л ДНБ-ийг 10 мянган долларт хүргэх боломж нээгдэнэ. Өнөөдрийн нөхцөл байдал эдийн засгийн эрсдэлүүдийг тооцож үзэхэд томоохон төсөл, мега хөтөлбөрүүдээ хэрэгжүүлээд саяын өөрчлөлтүүдийг хийхэд бололцоотой.

Тэгэхдээ гадаад нөхцөл байдал, урьдчилан таалагдах бололцоогүй байгаа гэдэг нь бодит байдал. Эдийн засгийн өсөлт саарсан болохоос биш хямрал болоогүй. Ийм учраас бид 10 мянган долларт хүргэхийн төлөө ажиллана. 2024 онд эдийн засгийн шокийг давж, орлогын өсөлтийг хадгалах боломжийг бүрдүүлэхийн тулд төсвийн сахилга батаа сайжруулсан хэмнэлтийн төсвийн тодотгол хийж байж бид энэ зорилтынхоо эхний алхмыг хийнэ. Түрүүн хэлсэн тэр оффтейкийн гэрээнүүдийг дахин шалгах шаардлагатай. Экспортын.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Өнөөдөр бас Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бас кабинетын гишүүдээ танилцуулж байгааг Ерөнхий сайдын бүрэн эрх оруулж ирж байгаа асуудалд хүндэтгэлтэй хандаж байна.

Би одоо томилогдох энэ сайд нарт Ерөнхий сайддаа бас хань болж, гал барьж энэ бодлого гэдэг юм уу энэ зүйлээс их ухралгүй оруулж ирээсэй гэж хүсэж байна. Яг өнгөрсөн энэ Засгийн газрын үед үндсэндээ яг бодлогоо оруулж ирсэн сайд тун ховор байна. Тухай бүрийн цаг үеийн шинжтэй хэдэн асуудал цаг хугацаандаа батлагддаг асуудал оруулж ирсэн болохоос биш яг энэ салбарынхаа бодлогын асуудлаар Ж.Энхбаяр гишүүн 1 асуудал оруулж ирлээ, Шадар сайд 1 хуулийн төсөл өргөн барилаа Амарсайхан сайд, бусдууд нь ярьсаар байгаад л дууслаа шүү дээ. Учрал сайд бас цөөхөн хэдэн асуудлууд орж ирлээ. Том төслүүд явуулах. Бусдууд нь байгаагүй байхгүй юу. Тэгэхээр мань хэдэд ерөнхийдөө ийм уян гоё зүйлүүд сонсогдоод байгаа боловч яг бодитой ажил болгоё, бодлогыг нь дэмжээд Улсын Их Хурал дээр ажиллая гэхээр хуулийн төслүүд нь жишээ нь орж ирэхгүй байгаад л хамаг асуудал байлаа. Энэ дээрээ бас анхаарч ажиллахыг хүсэж байгаа юм.

Тэгэхээр миний хэлэх гэж байгаа санаа ийм зүйлийг хийх гэж байна гэж ирээдүй цаг дээр бага яриарай. Ийм зүйлийг хийлээ гэдэг өнгөрсөн цаг дээр бодит ажилтайгаар дараа нь ажлаа дүгнүүлэхэд сайд нар маань хичээж ажиллаасай гэж би нэгдүгээрт хүсэж байгаа юм. Нийтлэг байдлаар.

Хоёрдугаарт, энэ ерөнхийдөө нийтлэг байдлаар энэ төрийн албан дээр шийдэл, саналуудыг яахдаа аж ахуйн нэгж, иргэддээ сонголтыг тулах биш хэд хэдэн сонголтыг санал болгодог бодлогыг бүгд барихыг хичээгээсэй гэж хүсэж байна. Төрийн бодлого ард иргэддээ боломж өгөх байдлаар анхаараасай гэж хүсэж байгаа юм. Ийм зүйл рүү л сайд нар тэмүүлж ажиллаасай гэж хүсэж байна. Би ингээд Эдийн засаг, хөгжлийн яам дээр бас Учрал сайд очиж байгаа юм байна. Өнгөрсөн цаг хугацаанд бас нэлээн галтай асуудлуудыг л бас аваад гарахыг хичээгээд явлаа. Учрал сайд бас Худалдан авах ажиллагааны хууль хийчихнэ гээд нэлээн галтай зүйлүүдийг явж байсан боловч ингээд чиг үүрэг өөрчлөгдөж байгаа юм байна.

Тэгэхдээ Эдийн засаг, хөгжлийн яамыг бас өөр түвшинд аваачмаар байна Учрал сайд аа. Жилийн хөгжлийн төлөвлөгөө гээд болсон, болоогүй баахан баахан баахан юм жагсаагаад биччихээд, энийгээ яаж ч санхүүжүүлэх шийдэлгүй баахан явдаг ийм л байдалтай байлаа. Сая Пүрэвдорж дарга хэллээ шүү дээ өнгөрсөн жил эдийн засгийн өсөлт 7.9 хувьтай байсан өнөөдөр 2.4. Тэгээд Эдийн засаг, хөгжлийн яамыг сая Гантөмөр дарга яалаа. Иймэрхүү л байдалтай л ингээд хүлээж авч байна даа. Тэгэхээр энэ үзүүлэлт таны үед бас өссөн байгаасай гэж би хүсэж байна.

Тэгээд яг Монгол Улсын эдийн засгийг тэлэх, ард иргэдийн буюу өрхийн энэ орлогод нөлөөлөх ямар бодлого явбал бас энэ эдийн засаг яг бодит байдлаараа иргэн Дорж, Дулмаагийн кармад орж ирэх юм бэ гэдэг бодлогыг бас Эдийн засаг, хөгжлийн яам зөв бодлогоор гаргаж ирэхгүй бол ерөнхийдөө энд тэндхийн презентациудыг цуглуулдаг, баахан төсөл, хөтөлбөрүүдийг жагсааж биччихээд өөрсдөө ч тэрнийхээ учрыг олохгүй явж ирлээ шүү дээ. Энэ дээр би таныг өөрчлөлт гаргана гэж итгэж байна. Энэ дээр ямар бодлого явуулах вэ та хэлээч? Би Бямбацогт сайдаас асууя.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Ерөнхий сайд хэлсэн ТӨК-ийг 2 дахин бууруулна. Энэ дээр яг та эхний алхмыг хийгээрэй. Энэ Засгийн газар дээр төрийн алба данхайсан гэдэг үг биш төрийн алба, ТӨК тэд дахин буурлаа гэдэг үзүүлэлтийг би хүсмээр байна. Энийг яг өнөөдөр бас бодитой ямар байр суурьтай байгаа вэ? Хамгийн гол нь уул уурхай. Эдийн засаг, эдийн засаг, эдийн засаг. Энэний хамгийн чухал юм бол уул уурхай байгаа. Уул уурхайн салбар дээр яг ямар бодлого явуулах вэ? Нэр дэвшигч бас хариулаач. Өнөөдөр нүүрсэнд найдах хэрэггүй боллоо гэдэг дэлхий нийтийн энэ хандлага харуулж байна шүү дээ. Тэгэхээр бид хэд энэ орон нутагтайгаа, иргэдтэйгээ ойлголцоод шинэ төрлийн энэ ашигт малтмал, ялангуяа газрын ховор, энэ бусад төрлийн уул уурхайн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, энийгээ тулгуурласан аж үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл дээр яг дорвитой ямар алхам оруулж ирэх юм бэ? Энэ дээр бас нэр дэвшигч бас хариулаач.

Д.Амарбаясгалан: Учрал гишүүн эхлээд хариулт өгье.

Н.Учрал: Экспортын орлого, төсвийн орлого бол бас уул уурхайгаас хамааралтай. Тэгэхээр бүтцийн хувьд өөрөө тэр дуал депенденци ийм бүтэцтэй л ийм эдийн засагтай орон. Тийм учраас энэ түүхий эдийн үнээс хамааралтай байгаа учраас энэ олон улсын худалдааны дайн, энэ үнэ тариф өөрөө манайд

шууд нөлөөлдөг. Энэ ч утгаараа бол тухайн үед энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хуулийг батлан гаргах, дээрээс нь энэ Засгийн газрын бүтцэд энэ Эдийн засаг, хөгжлийн яам байгуулах үед бол хөгжлийн бодлогоо нэгтгэн зангидаад эргээд тэр 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө үнэлдэг, дүгнэдэг.

Дээрээс нь энэ төрийн захиргааны төв байгууллагууд болоод төрийн захиргааны байгууллага, аймаг, орон нутгууд өөрөө энэ Эдийн засаг, хөгжлийн яамны боловсруулж байгаа Хөгжлийн бодлого төлөвлөлтөө үйл ажиллагаагаа уялдуулдаг ийм механизм руу оръё гэдэг зорилгоор л анх энэ Эдийн засаг, хөгжлийн яамыг байгуулж байсан. Тэгээд ингээд статусыг нь өндөр тавиад Шадар сайдын түвшинд ажилладаг, цаашаа бас төсөв дээр нь ч хүртэл хяналтаа тавьдаг, төсөв орж ирэхэд хүртэл зөвшөөрлийг нь олгодог ийм эрхүүдийг бол тухайн үед Эдийн засаг, хөгжлийн яам дээр өгч байсан.

Тийм учраас бол цаашдаа бол энэ Эдийн засаг, хөгжлийн яам бол манай улс бол бүхэлдээ өөрөө мэдээж энэ экспортоо нэмэгдүүлэх зорилготойгоор энэ худалдааны эдийн засгаас илүү үйлдвэрлэгч эдийн засаг руу шилжих, тэгээд бид нар олон жил эдийн засгийг төрөлжүүлэе гэж ярилаа, солонгоруулъя гэж ярилаа. Бодит амьдрал дээр бол энэ түүхий эддээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг ийм бас улс орон болохын төлөө л зорих л ёстой.

Энэ ч утгаараа бол бид нар өнгөрсөн хугацаанд яг бодлогын шинэчлэлүүд дээр тодорхой алдаанууд бол бас гарч байсан. Энэ нь юу вэ гэвэл энэ мөнгөний нийлүүлэлтийг төрөлжүүлэх хүрээнд бол банкнаас гадуурх энэ санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэе, энэ дээр томоохон бодлогын шинэчлэлүүдийг хийе, даатгал, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэе, хувийн эрх зүйн шинэтгэл хийе ээ гээд олон жил ярьсан.

Миний хувьд бол өнгөрсөн хугацаанд энэ Хэрэг эрхлэхийн сайдаар ажиллаж байхдаа энэ мега төслүүдийг бас эхнээс нь авч орж ирээд Их Хурлаар батлуулах ажлуудыг хариуцаж байсан. Тэгэхээр энэ ажлуудаа үргэлжлүүлнэ. Энэ зөвшөөрлийн реформыг дуусгана. ТӨК-ийн бүтээмж, засаглал, ил тод байдлыг сайжруулах хууль Их Хурал дээр байгаа. Энэ хуулийг батлан гаргасны дараа ТӨК-удыг ч гэсэн нэгтгэж нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, цаашлаад энэ нээлттэй компани болгох чиглэлээр бол санхүүгийн зах зээлийг дэмжих бодлогыг бол барьж ажиллана. Мөн энэ 3 зөвшөөрөл тутмын 1 зөвшөөрлийг мэргэжлийн холбоонд шилжүүлэх ажлыг гардан гүйцэтгэнэ гэдгийг бас хэлэх ёстой.

Дээрээс нь бид нар бол Жи Ди Пи гэж их ярьж байгаа. Жи Ди Пи 10 мянган долларт хүрнэ гээд. Гэхдээ яг хүртээмж нь өөрөө иргэн бүр дээр очих уу, үгүй юу гэдгийг хэмжиж чаддаггүй. Тийм учраас нөгөө Жи Эн Ай гэж ярьж байгаа шүү дээ. Жи Эн Ай бид буюу энэ Жи Ди Пи-гийн өсөлт өөрөө амьдрал дээр иргэн болгонд тулж очиж байна уу, нөгөө хүртээмжийг нь бий болж байна уу гэдэг дээр анхаарах ёстой.

Ийм ч утгаараа бол Эдийн засаг, хөгжлийн яам цаашдаа энэ 14 мега төслүүдийг одоо прайриоти/priority/-г нь гаргана, эрэмбэлнэ, заримыг нь хойшлуулах арга хэмжээнүүдийг авна. Ингэснээрээ бол богино хугацаандаа бид нар ерөөсөө л энэ гадаад худалдаан дээрээ тохируулгаа хийе богино хугацаандаа. Мэдээж урт хугацаандаа энэ

худалдааны эдийн засгаас энэ үйлдвэрлэгч орон болох ажил руугаа орёе, цаашлаад бол энэ нэмүү өртөг шингэсэн, технологийн агууламж шингэсэн бүтээгдэхүүнүүдээ үйлдвэрлэе. Энэ мега төслүүдийн хүрээнд жагсаалтад байгаа энэ алт цэвэршүүлэх үйлдвэр, энэ гангийн үйлдвэр, бусад энэ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой төслүүдээ урагшлуулъя гэдэг ийм л бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийж хэрэгжүүлнэ гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням хариулт өгье уул уурхайн салбарын.

Г.Дамдинням: Эрхэм гишүүдийн энэ оройн мэнд хүргэе. Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлагдсан хэдэн заалтууд байгаад байгаа юм. Энэ соёлын салбар дээр бид нар анхаарч ажиллах ёстой асуудлууд бол нэгдүгээрт энэ геологийн судалгаа, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх тухай заалт энэ 3.3.1.2-т заагдсан байдаг. Шинэ орд газруудыг нээх, газрын хэвлийг нээгдсэн геометр мэдээллийн санг бүрдүүлж нээлттэй болгох тухай, 3.3.1.7-д газрын ховор элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ гээд. Нэгэнт өнгөрсөн хугацаанд бид Монгол Улсын Их Хурал 2024 онд байгуулагдахдаа Монгол Улсын Засгийн газрын 2024-28 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталчихсан байгаа учраас энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлд голлон анхаарч ажиллана.

Ингэхдээ хэд хэдэн зүйлийг бид нар бас анхаарах ёстой. Оролцогч талууд буюу төр, иргэн, хөрөнгө оруулагчдыг ойлголцуулдаг энэ механизмыг л бүрдүүлэх тал дээр нэлээн анхаарч ажиллах ёстой юм байгаа юм бид нар.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Г.Дамдинням: Тэгэхээр бид бол эрх зүйн орчны өөрчлөлтийг бол яаралтай оруулж ирж ярих ёстой. Харамсалтай нь энэ хөрөнгө оруулагчдаа айлгадаг Монгол Улсын Засгийн газраас, засаг төрөөс өгчихсөн чөлөө зөвшөөрлөө авчихсан энэ хөрөнгө оруулагчдыг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдаа хөөж туудаг энэ явдлууд өрнөж байгаа.

Нөгөө талдаа энэ бас ард иргэдийн хувьд аргагүй байдаг. Газар нутгаа ухуулаад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөсөө бол ахиухан авч өөрсдийнхөө ахуй амьдралыг сайжруулах, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, орон нутагтаа өөр хөрөнгө оруулалтуудыг татах энэ боломжийг нь дэмжих тал дээр уул уурхайн энэ салбар хариуцаж байгаа яам нэлээн идэвх чармайлттай ажиллах ёстой байдаг. Энэ олон улсын туршлагуудыг хэрэгжүүлэх чиглэлд анхаарч ажиллана гэсэн ийм бодолтой байна.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн хариулт өгье. Сайнзориг гишүүн асуултад хариулъя.

С.Бямбацогт: ТӨК-удын засаглал, менежмент, ил тод байдал, бүтээмж, үр өгөөж гээд их олон асуудал их бүрхэг байгаа. Үүгээр Улсын Их Хурал дээр хууль явж байгаа Улсын Их Хурал бас энэ хуулиа хурдан батлаад өгчихвөл нэг талдаа асуудал энд томоохон шийдэгдэнэ. Үүнийг хүлээхгүй бид нар бас томоохон

зураглал, судалгаа, шинжилгээ хийж зөвхөн хэлбэрийн өөрчлөлт биш агуулгын өөрчлөлт тоог ихэсгэх багасгах биш, чанарын өөрчлөлт хийх шаардлагатай. Тухайлах юм бол АТЗА компаниудыг нэгтгээд Авто замын засвар арчлалтын нэгтгэл гээд 21 аймгийн АЗЗА-г нэгтгэсэн ганцхан компанитай болчихсон юм шиг мөртөө зардал нэмэгдсэн, орон тоо нэмэгдсэн. 21 компани байсныг 1 болгосон юм шиг мөртөө. “Эрчист Монгол” компани байгуулсан эргээд хувьцаа эзэмшлээсээ хамаараад ингээд үүрэг хариуцлага нь хоёрдоод үүнээсээ болоод асуудал үүсэж байгаа. Иймэрхүү юмнуудыг цэгцлэхээс.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Ер нь бүгдэд нь амжилт хүсье. Тэгээд яг гол асуудал мэдээж танай, манай гэж байхгүй. Нэгэнт л энэ Улсын Их Хурал суудалтай бүх намуудын л мөрийн хөтөлбөр байгаа учраас энийг хэрэгжүүлэхэд бүгд анхааръя.

Хоёрдугаарт, би Доржханд болон Батбаатар даргаас та хэд маань эрх барьж байгаа. Тийм учраас Ерөнхий сайдын цаг дээр сөрөг цөөнхийн үг хэлж ингэдэг энэ тоглоомоо хэдүүлээ больчихъё. Энийг нэгдүгээрт бас маш ойлгомжтой болоод явчихъя гэж бодож байна.

Хоёрдугаарт, би бас ер нь энэ томилгоонууд дээр сөрөг хүчин маань ч гэсэн бас жендерийн тэгш байдлыг бас анхаараач. Ялангуяа ХҮН нам маань 2 суудал авч байгаа мөртөө 2-лаа эрэгтэй. Тэгэхээр ер нь зүгээр цааш цаашдаа төрийн бодлого дээр бас анхаараарай. Би зүгээр санал хэлж байгаа юм. Тэгээд Монгол Ардын нам л дотроо жендер яриад байдаг. Бусад намууд маань яагаад жендер ер нь ярьдаггүй юм бэ гэдэг зүйл байна. Ардчилсан нам жишээ нь Одноо сайдыг болгоод болж байсан байхгүй юу. Тэгэхээр магадгүй танайх ч гэсэн бас дараа дараагийн иймэрхүү зүйлүүд байвал ер нь зарчмын хувьд бас энэ жендер эрх тэгш байдлаа барьдаг баймаар байна. Би энийг л.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууж, үг хэлье.

У.Отгонбаяр: Та бүгдийнхээ энэ оройн мэндийг хүргэе. Шинэ Засгийн газар Ерөнхий сайд томилогдоод өнөөдөр кабинетынхаа сайд нарыг Улсын Их Хуралд оруулж ирж байна. Гадаад, дотоод нөхцөл байдал хүнд байгаа. Эдийн засаг улс төрийн цаг агаар салхитай, шуургатай нэн тааламжгүй байгаа энэ цаг мөчид шинэ Засгийн газар байгуулагдаж байгаа. Ард иргэд өнөөдөр цэнхэр дэлгэцээрээ хараад энэ салбар салбарын сайд нарт нэр дэвшиж байгаа нэр дэвшигч нарын хэлж байгаа ярьж байгаа бүгдийг нэгд нэгэнгүй сонсож байгаа. Тодорхой цаг хугацааны дараа бас ард иргэд асуултаа бас асуух байх энэ Засгийн газраас. Олон Засгийн газар дамнаж эдийн засгийг төрөлжүүлнэ, солонгоруулна гэдэг нэг талаараа уриа лоозон маягтай ийм асуудлуудыг ярьж ирсэн. Өнөөдөр энэ Засгийн газраас гадна талдаа тэр гоё сайхан харагдахаас гадна бодит үр дүнг л ард иргэд хүсэж байгаа.

Тэгээд би эндээс өнөөдөр нэг зүйлийг тодруулж асуух гээд байна. Энэ Засгийн газрын бүтэц сайд нарт энэ боомтын асуудал эрхэлсэн сайд, 20 минутын сайд, Хяналтын сайд нарыг энэ удаа больж байгаа юм байна. Тэгээд боомтын асуудал маань ямар сайдын бөөрөнд очиж байна вэ энэ хэн нэгэн сайдын бөөрөнд очоод хаягдах вий гэдэг би үүднээс санаа зовж асууж байгаа юм. Сая өнгөрсөн

хугацаанд Ганцмод-Гашуунсухайтын бүтээн байгуулалт хил холболтын бүтээн байгуулалтын ажил эхэлсэн.

Хоёрдугаарт, Шивээхүрэн-Сэхээ боомт явах ёстой. Гуравдугаарт, Бичигт-Зүүнхатавч гэж энэ боомтууд хил холболтын асуудлууд хийгдэх ёстой. Тийм учраас энэ дээр Ерөнхий сайд онцгой анхаарч өгөөрэй гэдгийг бас хэлмээр байна. Тэгээд энэ боомтын асуудал аль сайдын эрхлэх асуудлын хүрээнд очсон бэ, аль яаман дээр очиж байгаа вэ эс үгүй бол Ерөнхий сайдын харьяанд үлдэж байгаа юу гэдгийг бас тодорхой энэ дээр хариулт өгөөч ээ гэдгийг хэлье, асууя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Энэ чухал асуудал байна манай экспортыг дэмжихэд боомтын асуудал, боомтын дэд бүтцийн хөгжил хамгийн чухал. Одоогийн байдлаар Сангийн сайдын дэргэд Экспортыг дэмжих зөвлөл байгуулж ажиллаж байгаа юм билээ. Энэнтэй ч холбоотойгоор Сангийн сайдын дэргэд Боомтын үндэсний хороог шилжүүлэхээр төлөвлөж байна. Гэхдээ яг эцсийн шийдвэр нарийвчлан хэлэлцээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийг төсвийн тодотголтой хамт өргөн барихдаа энэ чиглэлээр тодорхой шийдлээ гаргаад эргэж танилцуулна. Тодорхой саналыг бас хүлээн авахаасаа өмнө гишүүдээс ирсэн саналыг бас харгалзан үзнэ гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Отгонбаяр гишүүн бас энэ боомтын хууль, эрх зүйн орчныг сайжруулахаар Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсгээ ахлаад ажиллаж байгаа тээ? Тэр концепц дээр яаж явж байгаа юм. Та тэр талаараа товчхон мэдээлэл өгчхөөч. Отгонбаяр гишүүн 1 минут.

У.Отгонбаяр: Би боомтын асуудал гэхээсээ бас гадна манай Дорнод аймгаас иргэн Ганганмөрөн гэж иргэн Ерөнхий сайд биш ээ Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад нэр дэвшигчээс бас асууж өгөөч ээ гэдэг бас асуулт надад илгээсэн байна. Энийг бас тодруулж асууя.

Монголын барилгачдын нэгдсэн холбооныхон ордны гадаа 14 хоног тайван суулт хийж байна. Монгол Улсын барилгачдад ажил олгох чиглэлээр ямар бодлого барьж ажиллах вэ? Энэ салбарын энэ бүтээн байгуулагч нарыг хүлээж авч уулзаж, бодлогоо тодорхой бодлогоо танилцуулах уу гэдгийг бас асууж өгөөч гэснийг бас асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Бат-Амгалан гишүүн хариулт өгье.

Э.Бат-Амгалан: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Ер нь барилгын салбар их хурдтай ажиллахыг шаарддаг. Та бүхэн маань мэдэж байгаа улирлын чанартай. Монголд бас эрс тэс уур амьсгалтай учраас хурдыг шаарддаг ийм салбар. Энэ 6 сарын 2-ноос эхлээд энэ ордны гадаа бас Барилгачдын холбооны бас төлөөллүүд жагсаал цуглаан хийгээд 15, 6 дахь хоног дээрээ явж байна. Нийслэлээс сая мэдээлэл авсан. Нийслэлийн удирдлагууд энэ гадаа зогсож байгаа улсуудтай уулзаад энэ Сэлбэ дэд төв дээр дараагийн 3, 4 дэх шатны энэ төслүүд дээр ажиллах боломж, бололцоог хөрөнгө оруулагч буюу Германы Дойче банкныхантай

гэрээ хийгээд эхний ээлжид Монголын компаниудыг бас оруулах ийм боломж бололцоотой.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Бат-Амгалан гишүүн гүйцээж хариулъя.

Э.Бат-Амгалан: Ийм мэдээллийг нийслэлийн удирдлагууд ийм мэдээллийг өгсөн. Тэгэхлээр энэ гадаа зогсож байгаа барилгачдын төлөөлөл, дотоодын барилгын үйлдвэрүүд, үйлдвэр эрхлэгч нар, томоохон компаниудын төлөөлөлд ер нь их тийм нааштай мэдээтэй байна гэж нэгдүгээрт харж байгаа. Мэдээж яаман дээр очоод ажиллахад хамгийн түрүүнд дотоодын томоохон компаниуд, үйлдвэрлэгч нар дотоодын гол томоохон компаниудтайгаа хамгийн түрүүнд уулзаж асуудлуудыг ярилцаж бодлогын хэмжээнд бас санал солилцоно гэсэн ийм бодолтой байгаа.

Д.Амарбаясгалан: Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ оройн мэнд хүргэе. Ерөнхий сайдыг томилж байхад уг нь өөрт нь хандаж хэлсэн дангаараа Засгийн газар байгуулбал их зүгээр байна гэж. Одоо давхар баахан сайд нартай ороод ирж байгаа учраас ер нь бол дэмжиж өгөөд явуулна. Таны туршлага, мэргэжлийн мэдлэг, улс төрийн туршлага энэ хүнд цаг үед Ерөнхий сайд хийхэд бол миний хувьд хангалттай тэнцэх хэмжээний хүн гэж итгэж байгаа. Танай сайд нар дотроос бас давхар дээлтэй ч гэсэн бас өнгөрсөн хугацаанд сайн ажиллаж байсан сайд нар байна. Энэ Тэргүүн шадар сайдаар томилогдох гэж байгаа Учрал сайд бол E-Mongolia гэдэг юм уу, эсвэл тэр ТӨК-удыг цэгцлэх асуудал дээр бас нэлээн тулгуу ажиллаад явж байгаа. Тэгээд Шадар сайд Амарсайхан сайд байна. Үндэсний цөөнхийн төлөөлөл болж орж ирж байгаа Аубакир гишүүн бас нэлээн амжилттай ажиллачих байх гэж. Зам, тээврийн сайд байна. Манай энэ Гадаад хэргийн сайд бас КОВИД-ын үед тэгээд энэ улс орон том улс орнуудын энэ дураараа байгаа үед Монгол Улсын Ерөнхийлөгчтэй хамтраад гадаад бодлогыг бас маш сайн хэрэгжүүлж байгаа гээд ингээд танай танхимд бол бас итгэл хүлээлгэх сайд нар нэлээн олон байна.

Зөв байх юм бол дэмжиж явна. Буруу байх юм бол Улсын Их Хурлын гишүүд Ардчилсан намынхан тэр дундаа байнга шүүмжлэл хэлж явна. Шүүмжийг бас маш сайн дааж яваарай гэдгийг Засгийн газар байгуулагдаж байгаа энэ мөчид нь хэлье. Тэгээд Учрал сайд бас энэ ТӨК-удыг цэгцлэх ажлаа бас хурдан шуурхай цэгцлээд эмх цэгцэд нь оруулаад өгөөрэй.

Төсөв удахгүй орж ирэх байх. Тэгээд төсвийг маш сайн үр ашигтайгаар танах хэрэгтэй байна. Өнгөрсөн хугацаанд юу гэдэг юм гадаадад томилолт жишээлэхэд болсон болоогүй аймаг, сумдын дарга нар гадаад руу маш их явдаг. Үр дүн хаана байгаа юм бүү мэд. Иргэд бол өвдлөө гэхэд Эрээн рүү ч явж чадахгүй ийм л нөхцөл байдалтай байгаа учраас энэ төсвийн таналтыг бас бодитойгоор хийгээрэй гэж та бүхэнд бас захиж хэлэх гэсэн юм.

Энэ төгрөгийн ханш бол өдрөөс өдөрт унаж байгаа энэ дээр бас нэлээн анхаарал хандуулж ажиллаасай гэж хүсэж байгаа.

Энэ авлигын асуудал байгаа даа ялангуяа энэ дунд шатын авлигын асуудлууд. Энэ дээр бас нэлээн анхаарал хандуулж ахиц, дэвшил гаргаасай гэж хүсэж байгаа.

Малчид руугаа чиглэсэн зээлийн бодлого биш яг малчдаа дэмжсэн бодлого хэрэгтэй байгаа шүү гэдгийг бас анхаарч ажиллаасай гэж хүсэж байгаа.

Тэгээд 1 л асуулт асууя. Энэ нэлээн энэ Ерөнхий сайдад нэр дэвшээд явж байхад та өөрөө нэлээн ярьсан орон сууцжуулалтын банкны талаар энэ аймаг, орон нутгуудад 8 хувийн зээл, байрны хүртээмж нэлээн муу байгаа. Энэ дээр та тодруулга өгөөч.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Орон сууцжуулалтын банкны гол идеологи, үзэл санаа бол энэ карбон кредит/carbon credits/ буюу хүлэмжийн хийг бууруулах хөнгөлөлттэй санхүүжилт олж орон сууцжуулалтыг нийлүүлэлт болон эрэлт талаас нь дэмжих бодлого гэж үзэж болно олон улсын хэмжээний. Жишээлбэл, Улаанбаатарын гэр хорооллыг 1 яндан буулгахад карбон кредит/carbon credits/, хөнгөлөлттэй зээл, хүлэмжийн хий бууруулж байгаа хөнгөлөлт, тусламж авах ёстой. Сая нийслэлийн гаргадаг 500 сая доллар зүгээр бонд энэ орон сууцжуулалтын банк грийн/green/ бонд гаргаад энэ гэр хорооллыг санхүүжүүлэх эх үүсвэр болгоод саяын яриад байдаг барилгын салбараа дэмжих. Нэг талдаа тэр гэр хороололд байгаа хүн өөрийн орон сууцад хаус болгох зээл хөнгөлөлттэй зээл, орон сууцын ипотекийн зээл авч болох бололцоотой бол, эвэл барилгын компаниудаа, үндэсний барилгын компаниуд дэмжигдээд зээл аваад тэр орон сууцжуулалтыг хэрэгжүүлэх бололцоог олгох, эрэлт талдаа эффордабл хаусинг/affordable housing/ буюу энэ багш нарт, эмч нарт, тусгай албан хаагч хаагч нар тус тусдаа л байшин бариад байна шүү дээ. Энийг илүү хямд өртөгтэй, илүү бага, санхүүжилтийн зардалтайгаар хэрэгжүүлэх ийм боломж юм байгаа. Энийгээ улсын хэмжээнд нэн ялангуяа аймаг сумын төвийн хэмжээнд ч гэсэн энэ төслийг нэгдсэн бодлого, хөтөлбөр, төлөвлөлттэйгөөр хэрэгжүүлж ирсэн. Солонгосын туршлага их чухал. Германы бас туршлага буюу ийм орон сууцжуулалтын банкны ипотекийн банкны ч гэсэн ийм олон хувилбарууд бий.

Хамгийн гол үндэс нь олон улсын ингээд грийн/green/ хямд эх үүсвэр мөнгө л хэрэгтэй байгаа шүү дээ манайд, гол нь энэ барилгын компаниудад, мөн барилгад орох. Энэ нөгөө талдаа барьцаа хөрөнгө нь өөрөө ирээдүйн барилга байшингаар баталгааждаг, барилга байшин үл хөдлөх хөрөнгийн үнэ цэн өсөж байдаг учраас өөрөө энэ эргэн төлөгдөх найдвартай ийм цогц банкны санхүүжилтийн систем болдог. Энэ бол их бодитой ажил болно гэдэгт итгэж байгаа. Энийг олон улсын туршлага гаднын мэргэжилтнүүдтэй ажиллаж байгаа. Ингээд орон сууцын хөтөлбөрийг, орон сууцжуулалтын хөтөлбөрийг хүн амын төвлөрөл, ажил эрхлэлтийн байдал, дэмжлэгтэйгээ уялдуулаад бодитой хэрэгжүүлэх ийм бололцоо байна гэсэн ийм санаа энэ орон сууцжуулалтын банкны санаа. Энэ талаар бас нэлээн том туршлага судалж, гаднын эрдэмтэн, судлаачидтай хамтарч ажиллаад 1 сарын өмнө энэ төслийг үндсэндээ боловсруулчихсан. Одоо Монголбанк ажлын хэсэг би Ерөнхий сайдаар томилогдсоныхоо дараа ажлын хэсэг байгуулсан байгаа. Ажлын хэсэг ойрын

хугацаанд шийдлийг гаргаад 100 хоногийн дотор энийг хэрэгжүүлэх эхлэлийг нь эхлүүлэх төлөвлөж ажиллаж байна.

Нэг асуудал нэмээд хариулчихъя. Тэр боомтын асуудал түрүүн цаг хүрээгүй амжаагүй. Энэ боомтын асуудал манай хөрш орнуудын энэ түвшинд ч гэсэн тэр Хил хамгаалах ерөнхийн газар, гадаад худалдааны, Гадаад харилцааны яам, худалдааны яам ийм олон Зам, тээврийн яамтай олон салбар дундын зохицуулалт шаарддаг учраас энийг бас Засгийн газар дээр нэлээн ярилцаж байж шийдэх бодлоготой байгаа гэж би тодруулаад хэлчих нь зүйтэй байх.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэболд: Занданшатар Ерөнхий сайдыг оруулаад 20 сайдтай Засгийн газар, 10 нь өмнөх Засгийн газраас шилжиж орж ирж байна. 38-61 насны 19 сайд харьцангуй залуу. Сэтгэл дундуур байгаа зүйл бол эмэгтэй сайд нарын тоо 2-хон байна. Аубакир гэх мэт үндэсний цөөнхөөс бас кабинет оруулж байгаа нь сайшаалтай.

Тэгээд нэг зүйлийг хэлэхэд энэ Монголын төрийн, Монгол төрийн Засгийн газар шүү. Монгол Улсын Засгийн газар шүү. Аль нэг намын хэвгий явах Засгийн газар биш шүү. Ажил үйлстээ өсөрхөж биш жудагтаа хандаарай гэж бүүр эхнээс нь захиж хэлмээр байна. Очоод л баахан бужигнуулаад л, намчирхаад л, халаа сэлгээ хийгээд байх юм бол ялгаварлан гадуурхсан сайдыг онцолж байгаад огцруулна шүү эхнээс нь хэлчихье. Утсаа оролдоод байгаа сайдууд наашаа түр харчих. Өмнөх Засгийн газар Ардчилсан нам, Ардын нам, ХҮН намын мөрийн хөтөлбөр 85.9 хувийн ижилсэлтэй гэж байсан. Энэ мөрийн хөтөлбөр нь үргэлжлээд явах юм байна. Тэгээд энэ мөрийн хөтөлбөрийг үргэлжлүүлээд Ардчилсан намын 8 сайдыг хасаад засгаас гаргасан ч гэсэн энэ томилгоогоор орсон хүмүүсийг бид нар бас эрхийг нь хамгаална шүү. Монгол төрд бол бас хэтэрхий намчирхахаасаа илүүтэйгээр энэ бодлого явахын тулд хүмүүсийг битгий ялгаварлан гадуурхаарай гэж хүсье.

Хоёрдугаарт, түрүүн тэр Сайнзориг гишүүн хэлээд байна. 2-хон сайд л ажилласан бодлогоо оруулж ирсэн гээд. Ийм байж болохгүй шүү. Бас энэ Туваан сайд эд нар гээд бодлогынхоо юмнуудыг оруулсан хүмүүс зөндөө байгаа шүү. Манай Одонтуяа сайд гээд. Тэгээд энэ бүхнийг нь өнгөрсөн цаг хугацаанд нь зөв дүгнээд үлдээхгүй, өнгөрснийх нь араас тэгээд тэгсэн ингэсэн гээд бас зөв, буруу юм яриад байх юм бол би ч гэсэн, бид нар ч гэсэн бас адилхан улс төр ярьж чадна шүү гэдгийг хэлмээр байна.

Ерөнхий сайдаас бол асуух гэж байгаа зүйл нь энэ ёс зүйн шалгуурыг та энэ кабинетдаа хэр зэрэг тавьж байгаа юм бэ? Нэр цэвэр байдлын шалгуурыг хэр цэвэр тавьж байгаа юм бэ? Энэ 2 асуултад хариулт авъя. Бас нэг хүсэлт байна. Монгол Улс парламентын засаглалтай улс. Парламентын гишүүд ард түмнийг төлөөлж байгаа. Гэтэл Засгийн газрын гишүүд нь цул алтан тэмдэг зүүдэг. Энд байгаа Засгийн газрын гишүүдийн энгэр дээр цул алтан тэмдэг байгаа. Улсын Их Хурлын гишүүд яадаг вэ гэхлээр 350 мянган төгрөгийн үнэтэй мөнгөн зүүлттэй байдаг юм. Тэр яаж байна гэхлээрээ цаагуураа алт, мөнгөөр ялгаад Засгийн

газрын гишүүд нь илүү чухал юм байна гэдэг ойлголтыг төрүүлэх тийм шинжтэй. Тэгэхээр энэ бэлгэдэл төдий зүйл биш. Харагдац байдал илэрхийлэмж байгаа юм.

Тийм учраас Засгийн газрын шинэ гишүүдийг алт биш, үнэт металл биш тийм энгэрийн тэмдэг зүүлгэх ёстой. Минутаа үргэлжлүүлж авна шүү. 2 сайдаас асуулт асууя. Чинбүрэн сайд бол энэ олон зүйл дээр Мөнхсайхан сайдтай маргаж байхыг харсан юм.

Д.Амарбаясгалан: Эрдэнэболд гишүүнд 1 минут нэмж өгье.

С.Эрдэнэболд: Тэгээд та өөрөө сайд болж байна. Та өөрөө сая утааны сонсгол удирдсан, зовлон бэрхшээлийг нь мэдэж байгаа. Урагшаа харж ажиллаарай. Мөнхсайхан сайдын бас зөвийг нь аваад өөрөө шинэчлэлээ зөв хийгээд яваарай гэж хүсье. Яагаад гэхээр энэ хүний эрхийн асар хүчтэй асуудлууд байгаа. Одоо ингээд л наадмын дараа намар хүйтэрнэ дахиад л утааны асуудал чинь болно шүү. Тэгэхээр энэ дээр бол бас тэр улсын төсвийн 6 хувийг эрүүл мэндтэй тэнцүүлэх ажлыг үе шаттайгаар хийнэ гэсэн мөрийн хөтөлбөрийг бүүр үхэн хатан араас нь хэрэгжүүлж яваарай гэж хүсэж байна. Энэ дээр та ямар итгэл үнэмшилтэй байна?

Хоёрдугаарт Мөнхбаатар сайд хүний эрхтэй холбоотой асуудлууд, багц хуулийн асуудлууд, энэ жил хүний эрхийн үндэсний 2 дугаар хөтөлбөр орж ирэх гээд маш олон асуудлуудыг Алтангэрэл сайд оруулсан. Энэ дээр та энэ бодлогын залгамж холбоог яаж авч явах вэ гэсэн асуултад хариулт авъя.

Эцэст нь хэлэхэд бол сая бас ингээд харагдаж байна лээ. Ерөнхий сайд санал тавьсан учраас л би орж байна гэсэн жүжиг хэрэггүй, улсынхаа төлөө хүчин зүтгэж ажиллаарай. Бүгдэд нь амжилт хүсье. 3 хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Чинбүрэн гишүүн хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Ер нь эрүүл мэндийн салбартаа бид зарцуулах энэ төсвөө ДНБ-ийхээ 6 хувиан аваачих туйлын том зорилго байх ёстой. Энэ дээр бас Их Хурлын гишүүд та бүгдийн бүрэн эрх байгаа. Төсөв батлах энэ юун дээрээ бас дэмжиж ажиллахыг хүсэж байна.

Ер нь бас бид байгаа төсөв мөнгөө яаж зөв зарцуулах вэ гэдэг бас асуудал яригдах ёстой. Өнгөрсөн парламент баталсан чухал хууль бол Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хууль. Өнөөдөр улаан бурхан тархалт их өндөр байгаа. 6 хүүхдийн амь нас эрсэдсэн байгаа. Энэ болгоны цаана энэ даатгуулагчдын мөнгө биш төрөөс гарах ёстой санхүүжилт байх ёстой. Тийм учраас энэ Засгийн газарт орвол кабинетын зарчмаараа ажиллаж, Ерөнхий сайд болон Сангийн сайдуудтай бас энэ асуудлаа нэлээдгүй ярьж хэдүүлээ халдварт өвчинд даатгалын сангаас биш улсын төсвөөсөө гарч эмчилдэг байх, ХӨСҮТ гүйцэтгэлийн санхүүжилтээр явдаггүй байх энэ тогтолцоог би хамгийн түрүүнд танилцуулна л гэж бодож байгаа. Ингэж бид зөв олон нийтийг хамарсан өвчинтэй зөв тэмцдэг энэ тогтолцоогоо л бүрдүүлж чадвал энэ зөв, зүйтэй зүйл болно гэж харж байгаа. Тийм учраас одоо байгаа нөөцийг яаж зөв зарцуулах вэ гэдэг бас л их том шатрын нүүдэл болно л гэж харж байна.

Д.Амарбаясгалан: Лхагвын Мөнхбаатар гишүүн асуултад хариулъя.

Л.Мөнхбаатар: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Ер нь иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх энэ ардчилсан нийгмийн үндэс байгаа. Энэ эрхийг баталгаажуулахад төрийн оролцоо бас их чухал байдаг. Энэ үүднээсээ төр өөрийнхөө бодлогоо гаргаж, хүний хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэгтэй. Өмнө нь хүний эрхийн үндэсний хөтөлбөр гэж батлан гаргасан. Энэ боловсруулалтыг нь анх Чимэд багш оролцож үүний ажлын алба нь Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр ажиллаж энэ хэрэгжилтийг нь хангаж ажилласан. Энэ тодорхой үр дүнд хүрсэн юм байгаа юм. Үүнийг энэ хөтөлбөр дээрээ үндэслээд хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн 2-ыг батлан гаргах шаардлагатай. Энийг харин өнөөгийн нийгмийн тулгамдаж байгаа асуудал, хүний эрхийг хангахтай холбоотой, мөн олон улсын сайн ажлуудын туршлага эдгээр зүйлүүдийг нэгтгээд боловсруулж хэрэгжүүлэх ажлыг нэн даруй боловсруулж оруулж ирэх шаардлага байгаа гэж харж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Л.Мөнхбаатар: Хүний эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нь бас тодорхой ажлуудыг хийх шаардлага байгаа. Түүнээс гадна нэгэнт хөндөгдсөн гэдэг юм уу, зөрчигдсөн эрхийг сэргээх асуудлыг бол нь бодлогыг нь тодорхой болгож, энэ чиглэлээр ажиллах шаардлага байна гэж би харж байгаа юм. Энэ чиглэлээр 1 дутагдалтай байдаг зүйл хууль зүйн туслалцаа авах асуудлыг бас нэлээн бид өргөн хүрээнд авч үздэг. Эрх зүйн боловсрол олгох энэ чиглэлээр бас нэлээн одоо цогц арга хэмжээ авах шаардлага байгаа гэж харж байгаагаа танд хэлье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье. Эрдэнэболд гишүүний асуултад.

Г.Занданшатар: Сүхбаатар Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын гишүүд сайд нарт ёс зүйн хариуцлагын талаар ер нь өндөр шаардлага тавьж ажиллана гэж бодож байгаа. Энэ төрийн албаны ёс зүй Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг би бас санаачилж Хэрэг эрхлэх газрын даргаар ажиллаж байх үеэсээ бас боловсруулж, хэлэлцүүлж Улсын Их Хурлаар баталсан. Энэ хуулийн дагуу зүгээр би шаардлага тавиад байх биш Засгийн газрын дэргэд Ёс зүйн хороо ажиллах ёстой юм. Ёс зүйн хороо төрийн албан хаагчдын төдийгүй бүх сайд нарын ёс зүйн зөрчил, үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. Гарсан гомдол, саналыг шийдвэрлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ийм цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр тусгагдсан. Энийгээ дагаад Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн хорооны салбарууд нь төрийн албаны төв байгууллага бүр дээр буюу яамд дээр орон нутагт ч гэсэн байх ёстой. Тэгэхээр нөгөө авлигагүй.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Тэгэхээр ер нь авлигагүй нийгэм ил тод байдал хариуцлагатай байдал гэдэг эцсийн дүндээ ёс зүйгээс эхлэх ёстой. Нийгмийн ёс зүйн хэм хэмжээ алдагдсан учраас л энэ эх захгүй төрд итгэх итгэл суларч төрийн нэр хүнд унаж, төр ард түмний хэлхээ холбоо харилцан итгэл суларч байгаа явдал

ёс зүйгээс эхлэх ёстой. Ёс зүй сайтай бол тэр аливаа авлига хээл хахууль, аливаа зөрчил ч гэсэн багасдаг ийм жамтай. Ийм учраас энэ Төрийн албаны ёс зүйн тухай хуулийг санаачилж батлуулсан. Энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Ер нь бүх нийт сайд Засгийн газрын гишүүддээ хандаж хэлэхэд энэ цаг мөчөөс эхлээд ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нэгдүгээрт гагцхүү улс орны эрх ашгийг тавьж, хоёрдугаарт, салбарынхаа эрх ашгийг тавьж, тэр хувийн эрх ашиг бизнес энэ тэр 20, 30, 100 дугаар байхгүй байх ёстой. Ийм зарчим тавьж ажиллана. Ингэж байж ард олныхоо итгэлийг олно. Үүний тулд ил тод байдлынхан. Бүх сайд нарын үйл ажиллагаа өмсөж зүүсэн хүртэл ил тод байх ёстой.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Шинэ Засгийн газарт бас амжилт хүсье. Цаг хугацаа явж байна 2 асуулт байгаа юм. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Хурдтай хөгжлийн төлөөх зориг гэдэг ийм хөтөлбөр байгаа. Энэ хөтөлбөрийг батлахад Ардчилсан нам, ХҮН нам хамтарч баталсан ийм хөтөлбөр. Засгийн газрын энэ үйл ажиллагааны хөтөлбөр цаашаа үргэлжлээд явах юм байна. Гэхдээ бүтцэд өөрчлөлт орчихсон. Тэгэхээр Иргэний зориг ногоон нам, Үндэсний эвсэл орохгүй гэдгээ мэдэгдэж байгаа юм шиг байна. Иргэний зориг ногоон нам энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ер нь хэрхэн ямар байр суурь баримталж ажиллах юм бэ гэдгийг нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь 2024 оны сонгуульд бид бүхэн энэ Баялгийн сангийн асуудлыг л ярьж орсон. Үнэхээр Монголын ард түмэн бас энэ баялагтаа эзэн болчих юм байна гэсэн ийм горьдлогоор энэ сонгуулийн үр дүн гарсан гэдэгт би итгэлтэй байдаг. Одоо ч энийг ард иргэд ярьдаг. Тэгэхээр энэ дээр Монгол Улсын Ерөнхийлөгч байр сууриа илэрхийлсэн байна лээ. Сая бас шинээр томилогдож байгаа сайд нарт энэ Баялгийн сангийн асуудал дээр олигтойхон шиг ажиллаарай гэж ингэж бас үүрэг даалгавар өгсөн гэж би сая бас ойлголоо. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын хувьд энэ ажлыг бас эхлүүлэх гэж бас нэлээдгүй ноцолдсон, их ч дайсантай болсон байх. Занданшатар дарга Ерөнхий сайд томилогдохдоо үргэлжлүүлж ажиллана гэдэг ийм зүйлийг бас хэлсэн. Тэгэхээр энэ дээр би энэ эвслийн Засгийн газар энэ Иргэний Зориг Ногоон нам Баялгийн сан дээр ямар байр суурьтай байгаа юм бэ гэдгийг нь бас тодруулъя гэж ингэж бас бодож байгаа юм.

Нөгөө талдаа ер нь энэ баялгийн сан ярихаар бүгдээрээ л дэмжинэ, дэмжинэ, дэмжинэ л гэдэг болсон байна. Бодитой үр дүн гаргамаар байна. Баялгийн сангийн асуудал ярихаар 2, 3 орд ярьж хэрэлддэг түүгээрээ энэ том асуудлыг ингэж саармагжуулдаг.

Тэгэхээр миний хувьд Их Хурлын даргад хандаж юу хэлэх гэж байна вэ, Ерөнхий сайдад юу хэлэх гэж байна вэ гэвэл энэ Баялгийн сангийн асуудал буюу энэ Монголын стратегийн энэ 16 орд түүний цаана байгаа 30 хэдэн ордыг Баялгийн сан руугаа авчрах энэ үйл явцыг Улсын Их Хурал дээр сардаа юм уу, улиралдаа байдаг юм уу Ерөнхий сайдын цаг дээр бас танилцуулга хийж байгаач ээ. Үнэхээр яг энэ ажил явж байгаа юм уу, явахгүй байгаа юм уу гэдгийг бас ингэж танилцуулдаг байгаад үүгээрээ ард иргэд энэ баялагтаа бид нар эзэн болж чадах

эсэхийг бас дүгнээд явдаг баймаар байна гэж би ингэж харж байгаа. Манай ард иргэд ч гэсэн энийг ингэж бас гэдгийг би бас хэлэх гэж байгаа юм.

Тэгэхээр энэ Засгийн газрын хууль, дүрэм янз янзын энэ дэгийн хууль дээрээ болж байна уу, үгүй юу? Энэ дээр ерөнхийдөө ямархуу байр суурьтай байх вэ? 1 минутаа авчихъя дарга.

Тийм тэгээд яах вэ бид нар ингээд цаг үеийн асуудал яриад л тэгээд л ийм л юм руугаа анхаарлаа хандуулаад байдаг. Ард иргэдийн амьдралд үнэхээр чанарын өөрчлөлт оруулах юм бол энэ Баялгийн сан шүү дээ. Өнөөдөр бид нар татвар ярьж байна, нийгмийн даатгал ярьж байна. Энэ чинь бол маш бага. Зүгээр өдрийн хоолонд нь жоохон нэмэр болох төдий л юм байхгүй юу.

Гэтэл ард иргэд 2028 онд бид нар баялагтаа эзэн болчихсон байна гэж ингэж бодож 2024 оны сонгуульд орсон байхгүй юу. Тэгэхээр бид нар асуудлыг, цаг үеийнхээ асуудлыг ярихаасаа гадна ард түмний гол хүлээгээд байгаа энэ Баялгийн сангийн асуудлыг би Улсын Их Хурал дээр тогтмол цагт ярьдаг, хэлдэг, тайлагнадаг байгаасай гэж ингэж бас бодож байгаа гэдгээ бас хэлье. Би энэ бүтцэд шинээр орж ирж байгаа Иргэний Зориг Ногоон Нам энэ Баялгийн сан дээр, энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ямар байр суурьтай байдаг юм бэ гэдгийг бас би тодруулъя гэж ингэж бас бодсон юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал гишүүн хариулт өгье.

Н.Учрал: Хамтарсан Засгийн газрын, 3 намын хамтарсан Засгийн газрын гэрээг бас ажлын хэсгийг нь ахалж бас би боловсруулахад бас оролцсон. Тухайн үед Наранбаяр сайд, Алтангэрэл сайд гээд бид энэ ХБНГУ-ын энэ хамтарсан Засгийн газрын гэрээний туршлагыг бол бас судалж энэ гэрээг боловсруулсан. Тухайн үед гэрээг боловсруулахдаа энэ хамтарсан Засгийн газрыг бүрдүүлж ирсэн Ардчилсан намын 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийн Үндэсний баялгийн сантай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилго, зорилтуудаас бас тусгасан.

Гэхдээ онцгойлон энэ эдийн засгийн эрх, эрх чөлөө, энэ хувийн эрх зүйн шинэчлэлийг хийх, энэ даатгал, хөрөнгийн зах зээл, энэ төр, хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх энэ үндсэн зорилго, зарчмуудыг тухайн үед энэ хамтарсан Засгийн газрын гэрээнд тусгасан. Мөн ХҮН намын бол энэ эрчим хүчний реформын зорилго, зорилтуудыг боловсролын салбарын шинэчлэлүүдийг бас энэ хамтарсан Засгийн газрын гэрээнд тусгасан.

Тэгэхээр энэ удаа Засгийн газар бол мөн ХҮН нам, Иргэний зориг ногоон намтай бас хамтарч байгуулагдаж байгаа учраас тухайн үеийн бас энэ хамтарсан Засгийн газрын гэрээнд тусгагдсан зорилго, зорилтууд нэгэнт Их Хурлаас батлагдсан бодлогын баримт бичиг учраас бол хэрэгжээд явах нь ойлгомжтой. Тухайн үед хамтарсан Засгийн газрын гэрээг боловсруулж байхад би яг өөрийнхөө нэр дээр Иргэний зориг ногоон намын дарга Батбаатар даргад бас энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр саналаа илгээгээч ээ гэдэг хүсэлтийг явуулж байхад Иргэний зориг ногоон намын 24 оны их хурлын сонгуульд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрүүдийнхээ бас жишиг болгох заалтуудыг тусгаач ээ гэдэг саналыг Батбаатар дарга илгээж байсан. Үүнд Баялгийн сангийн энэ хууль, эрх зүйн орчны

хэрэгжилт бол тусаж байсан. Тэгэхээр улс төрийн намууд бол бүгдээрээ Үндэсний баялгийн сангийн хуулиа хэрэгжүүлэх гэдэг дээр бол зорилго бол нэг байгаа гэж бид нар ойлгож байгаа.

Цаашдаа бол энэ Үндэсний баялгийн сангийн хуулийн дагуу энэ 34 хувийг тэр борлуулалтаас нь шууд АМНАТ авах уу, эсвэл бүтээгдэхүүнээр орлуулах уу ч гэдэг юм уу, бүтээгдэхүүн хуваахаар орлуулах уу ч гэдэг юм уу энэ хэлэлцээр бол явах нь ойлгомжтой. Тэгэхээр цаашдаа Эдийн засаг, хөгжлийн сайдын хуваарийн хувиар ч гэсэн би энэ Баялгийн сангийнхаа хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг бол үргэлжлүүлээд хэлэлцээрээ хийгээд явна гэсэн ийм бол бодолтой байгаа. Ерөнхий сайдын зүгээс ч гэсэн ийм бас үүрэг даалгаврыг өгсөн.

Тэгэхээр Занданшатар Ерөнхий сайдын хувьд бас анх томилогдохдоо манай Засгийн газрын хамгийн том мега төсөл хүний хөгжил байна гэдгээ зарласан. Тэгэхдээ хүний хөгжил рүү чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бид нарт бол эдийн засгаа тэлэх шаардлагатай. Тэгэхээр бид нар бол эдийн засгаа төрөлжүүлэх шаардлагатай, экспортоо нэмэгдүүлэх шаардлагатай. Үүнд юу хэрэгцээтэй вэ гэвэл Баялгийн сан хэлэлцээрүүд хийгдэх ёстой.

Тэгэхээр Баялгийн сангийн хэлэлцээр үргэлжилнэ. Тэр стратегийн ордод хамаарч байгаа орд газруудыг нэмэгдүүлэх тогтоолыг Их Хуралд барина. Одоо стратегийн ордод хамаарч байгаа энэ стратегийн ордуудыг эзэмшиж байгаа хувийн хэвшилтэй ширээний ард сууна. Зүгээр хэлэлцээр гэдгийг бол бид нар зүгээр ийм хэрүүл маргаан гэж ойлгохгүй дү ... хийнэ, санхүүгийн нотлох баримтууд баримт шинжилгээ дээр тулгуурлана. Ингээд хож хож гэсэн зарчим дээр хэлэлцээрүүд үргэлжилнэ. Үүний үр дүнд Баялгийн сан бид Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед Е-Монгол дээр харагдаж байгаа энэ мөнгөн дүнг нэмэгдүүлэхийн төлөө бид нар та бүхний баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана л гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Би Батбаатар даргаас бас асууж байгаа юм улс төрийн нам засагт хамтарч байна.

Хоёрдугаарт, энэ Их Хурал дээр ер нь энэ явцыг нь ярьж баймаар байгаа юм. Зөвхөн Байнгын хороон дээр биш, эсвэл Байнгын хороон дээрээ ч гэсэн болж байна. Эсвэл хэн нэгэн БЭТ гарч ирээд л ингэнэ тэгнэ гээд л ингээд л маш сүртэй сүртэй юм яриад байдаг. Хэлцэл маань ямар шатад явж байгаа юм, яг яаж байгаа юм? Ойлголцож байгаа юм уу, ойлголцохгүй байгаа юм уу? Энэ тал дээрээ бид нар ингээд ард иргэддээ бас нээлттэй байх юмаа байлгамаар юм шиг надад бас санагдаад байгаа юм. Тэгэхгүй ингээд Баялгийн сан ярихаар хийнэ ээ, явна аа, дэмжинэ ээ гээд ингээд байгаад баймааргүй байна. гэж. Тэгээд энэ бас манай ард иргэдээс л гарч байгаа хүсэлт. Өнөөдрийн ард иргэдийн ярьж байгаа энэ цалин нэм, тэтгэвэр нэм энэ бүх шаардлагуудын эцсийн дүндээ хүрэх гол амжилт нь энэ Баялгийн сан л байна гэж ойрын хэдэн жилдээ би энийг л ингэж харж байгаа юм. Тийм учраас шахаж шаардаж бас ажиллана гэдгээ зориуд протоколд бас тэмдэглүүлэх гэж үг хэлж байгаа юм. Тэгээд Батбаатар даргын хариултыг сонсьё.

Д.Амарбаясгалан: Тийм. Идэрбат гишүүний асууж байгаа энэ Баялгийн сан нэгэнт хууль батлагдсан. Аль нэг намын Баялгийн сан гэдэг, эс үгүй бол аль нэг Засгийн газрын Баялгийн сан гэдэг ойлголт бол байхгүй. Харин Улсын Их Хурлын зүгээс Баялгийн санг тогтвортой байлгах үүднээс Монголбанкаар дамжуулж ерөнхий хяналтаа тавьж чаддаг болох нь бол хууль, эрх зүйн орчны жоохон өөрчлөлтийг хийгээд баталгаатай болгох нь зөв байх гэж бодож байгаа.

Яагаад гэхээр Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой, улс төрийн намуудын өдөр тутмын улс төрийн үйл ажиллагаатай холбоотойгоор Баялгийн сангийн орлого, зарлага яригдаад байдаг нь бол цаашдаа зохимжгүй. Тэгэхээр Баялгийн сан маш тогтвортой ажиллах нөхцөл, боломж гэдэг бол Улсын Их Хурлынхаа хяналтад Монголбанкаараа дамжиж удирдлага хангагдаж явж байх нь бол зарчмын асуудал болох байх гэж ингэж харж байгаа. Тэгээд энэ чиглэлээр бас Засгийн газраас бас анхаарал хандуулах болов уу гэж бодож байна.

Батбаатар гишүүн хариулт өгье.

Б.Батбаатар: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуультай холбогдуулаад Иргэний зориг ногоон намын байр суурийг асуусан учраас Иргэний зориг ногоон намын байр суурийг илэрхийлье. Иргэний зориг ногоон нам бол тэртээ 1999-нд ардчилсан хувьсгал, шударга ёс гажуудсан тэр цаг мөчид түрэн гарсан улс төрийн нам. Мөн Ногоон нам нэгдэж Иргэний зориг ногоон нам болсон Байгаль орчин, ногоон хөгжил гэдэг нэгэн баганатай, шударга, ёс, хүний эрхийн төлөөх нөгөө баганатай. Ийм 2 баганатай улс төрийн хүчин. Тийм учраас бид нар монголчуудын, иргэдийнхээ эрх, эрх чөлөө тэр талд нь байдаг. Авлигатай тэмцэх анхны хуулийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Батбаатар: Авлигатай тэмцэх анхны хуулийг санаачилж байсан. Атрын 3 дугаар аяныг эхлүүлж байсан. Гадаад бодлогын хувьд улс орон төлөөлж, Засгийн газарт оролцож байсан ийм улс төрийн нам. Бид нарын 2024 оны мөрийн хөтөлбөр түрүүн Учрал сайдын хэлдгээр Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тодорхой хэмжээгээр туссан. Түүн дотор Засгийн газар иргэдтэйгээ ашгийн төлөө өрсөлдөж болохгүй ээ, ашгийн төлөөх Засгийн газрын аж ахуйн нэгж байж болохгүй ээ гэдэг заалт хүртэл байгаа. Баялгаасаа Монголын иргэд бүгд хүртэж эзэн нь байх ёстой. Ер нь Засгийн газрын үйл ажиллагаа энэ 3.5 сая Монголчуудынхаа төлөө, Их Хурал ч гэсэн энэ Монголчуудаа ядууралгүй амьдруулахын төлөө чиглэх ёстой. Иргэний зориг ногоон намын үзэл баримтлал, байр суурь энэ дээр оршиж төвлөрч байдаг.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүний асуултад тодруулж хариулъя. Тэгэхээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Улсын Их Хурлаар 2024 онд баталсан. Энэ хуулиар стратегийн орд газрууд, орлого төвлөрүүлэгч этгээд, ногдол ашиг, АМНАТ, АМНАТ-ийн эх үүсвэрийг тодорхой заачихсан. Энэ хүрээндээ яриа, хэлэлцээр л явуулах шаардлагатай.

Хоёрдугаарт, хамгийн гол нь тэр ил тод байдлыг хуульчлаад заачихсан Үндэсний баялгийн сангийн ил тод байдал тайлагнал гээд бүрэлдэхүүн хэсэгтэй энэ хууль дотор үүгээр энэ төсвийн салшгүй хэсэг байна. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн салшгүй төсвийн гүйцэтгэлтэй хамт аудит хийгддэг, Улсын Их Хуралд танилцуулагддаг ийм сан тусгай зориулалтын сан гэж явдаг. Төрөлжсөн сан гэж явдаг.

Тийм учраас энэ угаасаа Улсын Их Хурлын хяналтад байдаг. Энэ чинь хагас бүтэн жилээр тайланг нь, нэгдсэн төсвийн тайлантай хамт ирүүлдэг, үүнд нь аудит хийгддэг ийм хяналт байдаг. Энэ дээр харин яагаад энэ дээр харин

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Энийг ингээд бодитой хэрэгжүүлж Баялгийн сангийн тогтвортой байдлын тэр заалтуудыг бодитой хэрэгжүүлэх шаардлага байгаа. Монголбанканд Төрийн сангийн дансанд байршиж тэр Ирээдүйн өв сан энэ тэр хүүгүй хэвтээд байсан учраас бодлогын хүүгийн доод хэмжээнээс дээш орлоготой байхаар, валютаар хадгалж байхаар, бас мөнгөө үржүүлж байхаар суугаад үүн дээр Засгийн газар хяналт тавих, Улсын Их Хуралд тайлагнаж байхаар Монголбанк Засгийн газартай гэрээ байгуулсны үндсэн дээр Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд бодлогын хүүгээс багагүй хувиар хүү тооцохоор заасан хуульчид. Энийгээ Швейцарын банкны хүүгээр, гадаад валютаар хадгалаад 1.2 тэрбум доллар орчим хүртэл өсгөх чиглэлээр ажиллаж, ер нь Хуримтлалын сангийн данс байршуулсан мөнгийг иргэн бүр дээр нээнэ гэдэг энэ хуулийн заалтуудыг харин хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Энийг Их Хуралд тайлагнаад төсвийн нэгдсэн гүйцэтгэл тайлагнахдаа хамт тайлагнаад явах учиртай. Энэ чинь хуулиараа маргааш, нөгөөдөр тайлагнах ёстой.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Гишүүд оройн мэнд хүргэе. Засгийн газар 16 яамтай, 19 сайдтай байхаар орж ирж байгаа юм байна. 3 яамгүй сайдыг бол дараа нь төсвийн тодотгол хэлэлцэхдээ хасах байдлаар зохион байгуулж байгаа юм байна. Боомтыг бол ер нь Сангийн яамны харьяанд бөөрөнд аваачиж нааж орхиж ерөөсөө болохгүй юм байгаа юм. Энэ манай Шинэ сэргэлтийн бодлогын хамгийн эхэнд нь боомтын асуудал гээд маш олон ажлууд хийгээд эхэлсэн, төлөвлөчихсөн ийм том асуудал байгаа. Тийм учраас Ерөнхий сайд энэ Боомтын Үндэсний хороогоо өөрөө ахлаад явах нь цаашдаа зүйтэй болов уу гэсэн ийм санаа байгаа.

Тэр Хяналтын сайд байхгүй болсон. Хяналтын ер нь үйл ажиллагаа, хүнсний аюулгүй байдал, байгаль орчны асуудал гээд их чухал асуудал байгаа. Тэгээд стандарт гээд. Үүнийг бол Шадар сайд хариуцаад тэгээд хуучин татан буулгачихсан байгаа мэргэжлийн хяналтыг эргэж сэргээгээд, ингээд хөндлөнгийн хяналтыг бий болгоод, нэг гарт төвлөрүүлээд ингээд явах нь илүү үр дүнтэй байх болов уу гэсэн ийм бодолтой байгаа.

Хотын 20 минутын асуудал энэ нийслэл Улаанбаатар хотын асуудал учраас нийслэл нь хариуцаад явахад болохгүй юм байхгүй болов уу гэсэн ийм саналтай байна. Сайд нар маань бол хуучин туршлагатай сайдууд ч байна, шинээр орж ирж байгаа сайдууд ч байна. Сайд нартаа хүсэхэд бол ард иргэдтэйгээ ойрхон, аймаг,

сум, орон нутгаараа явж, тэдний амьдрал, байдлыг газар дээр нь үзэж, аль болохоор танилцаж, зөв бодлого шийдвэрийг цаашдаа өөр өөрийнхөө салбарт гаргаж яваасай гэж ингэж хүсэж байгаа юм. Сайдын суудал гэдэг бол шагнал биш энэ бол үүрэг, хариуцлага байх ёстой. Тийм учраас энэ иргэдтэйгээ ойрхон, иргэдийнхээ ажил амьдралыг мэдэрч ажиллах ёстой гэж бодож байгаа юм.

Дараагийн дугаарт нь энэ 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгоно гээд. Энэ цомхотголыг хийхдээ дээрээс нь шүүрдэх байдлаар энэ олон удирдлагууд, энэ нийслэл Улаанбаатарт төвлөрсөн олон байгууллага, хороо, комисс, олон яамд, агентлагуудаасаа эхэлж энэ цомхотголыг хийгээрэй. Эсрэгээрээ хөдөө орон нутаг чинь бол боловсон хүчний хомсдолтой байгаа шүү. Ялангуяа энэ сумын түвшинд ажиллах боловсон хүчин нэн ховор байгаагаас төрийн үйлчилгээ иргэддээ сайн хүрч чадахгүй ийм байдалтай байгаа учраас энэ цомхотголыг хийхдээ тэгшитгэж биш энэ дарга, удирдлагууд, төсөв хаана их үрэлгэн зарж байгаа энэ дээрээ анхаарч цомхотголыг хийгээрэй гэж хүсэх байна.

Дараагийн дугаарт энэ ТӨК-уд дээр реформ хийхгүй бол болохгүй болсон байна. Нийтдээ 450 гаруй төрийн өмчит төрийн болон орон нутгийн өмчит компанид 60 мянга гаруй хүн ажиллаж байгаа. Тэгэхээр зэрэг энэ ТӨК .../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Гишүүдийнхээ болон ард иргэдийнхээ энэ хорооны амгаланг айлтгая. Та нэмж асуух уу? Наранбаатар гишүүнд 1 минут нэмж өгье.

Н.Наранбаатар: Энэ сая Улсын Их Хурлаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг 1 жилээр хойшлуулсан юм. Тийм учраас одоо үлдэж байгаа энэ жилийн хугацаанд маш сайн ажиллаж, бэлтгэл ажлыг маш сайн хангаж, энэ хуулийнхаа хэрэгжилтийг хангахгүй бол энэ орон нутагт чинь зөндөө олон асуудлууд шийдлээ хүлээгээд хот болох, тосгон болох энэ ажлууд нь хүлээгдээд хоцорсон байж байгаа. Тийм учраас энэ дээр онцгой анхаарч ажиллах ёстой.

Нөгөө тал даар энэ бүсчилсэн хөгжлийн асуудал чинь бид нар нэлээн их зөвлөгөөн, хурал, семинар их хийж байна. Одоо ер нь бодит ажил бий болгох, ялангуяа бүсчилсэн хөгжлийг цааш нь амилуулахад энэ хууль, эрх зүйн орчнуудыг нэлээн сайтар шинэчлэх шаардлагатай. Тухайлах юм бол Нэгжийн хууль, Төсвийн тухай хууль, мөн Бүсийн удирдлага, зохицуулалтын тухай хууль гэх мэтчилэн олон хуулиудад зайлшгүй өөрчлөлт оруулж энэ бүсийн асуудлаа цааш нь амилуулж ажиллах.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Наранбаатар гишүүний асуултад Ерөнхий сайд хариулна.

Г.Занданшатар: Боомтын асуудал, Нанзадын Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Боомтын асуудлыг энэ салангид сайд хороо, агентлагаар тусгай болгох нь үр ашиггүй юм билээ гэж бодож байгаа юм. Энэ давхардчихсан бүтэц үрэлгэн зардал тэгээд дэд бүтэц логиستيкийн бодлоготойгоо уялдахгүйгээр боомтын нэрээр ингээд ажилтан албан тушаалтан ингээд ажлууд хуваарилагдаж байгаа нь үр хөнөөлтэй. Энэ агентлагууд боомтын чиглэлийнх бүгд нийлээд 30-40 тэрбум төгрөгийн зардал гаргаж. Ингээд чиг үүргийн давхардлаас шалтгаалж шийдвэр гаргалт нь удааширчихсан энэ бүтэц чинь Зам, тээвэр, хөгжлийн яам,

Гадаад харилцааны яам, Хил хамгаалах ерөнхий газар, Гаалийн ерөнхий газрын ийм дундын ажлын давтамжуудтай 3, 4 байгууллагын оронд 1 бодлогын нэгжээр шийдвэрлэвэл 20 тэрбум төгрөг хэмнэх бололцоотой гэж үзнэ.

ОХУ, БНХАУ гээд манай хөрш зэргэлдээ улсуудад бол Тээврийн яамныхаа харьцаа байдаг. Зам, тээвэр худалдаа Гадаад харилцааныхаа дэргэд төвлөрсөн аль төвлөрсөн Сингапурт ч гэсэн Тээврийн яамныхаа дэргэд төвлөрсөн байх жишээтэй. Энэ тээврийн болон худалдааны бодлоготойгоо л уялдаж байгаа юм. Тэгэхээр манай хувьд тээврийн зам, тээвэр худалдааны бодлоготойгоо л уялдаж Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Тээврийн яамны бодлоготой уялдах нь зүйтэй. Хуучин Гадаад харилцааны, дээр намайг Гадаад харилцааны сайд байхад байдаг байсан юм. Тэр тэгэхээр зөвхөн дипломат чиглэл болоод эдийн засгийн чиглэл нь бас хаягдчихдаг талтай. Бүсчилсэн хөгжлийн хувьд бүсчилсэн хөгжлийг амилуулахын тулд Үндэсний хөгжлийн тухай хуулийг баталж, бүсийн түвшний төлөвлөлт, хөрөнгө оруулалт, татвар, зээлийн бодлогыг оновчтой болгоод орон нутагт бүсэд эрх мэдлийг шилжүүлэх замаар төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлж байж энэ бодитой болно. Тухайлбал, бүсийн зөвлөлийг эрх хэмжээтэй шийдвэр гаргах дэд бүтцийн болон газар, эрх зүйн ийм шийдэлтэй болгож байж бүтцүүд хөгжинө. Тэгээд эхний ээлждээ энэ Хархорин хотыг л бодит ажил хэрэг болгох Улсын Их Хурлаас баталсан хуулийг хэрэгжүүлж байж төвлөрөл саарах, бүс чөлөөлөлт ингэж үе шаттай хэрэгжсэн олон улсын туршлагыг судалж хэрэгжүүлэх шаардлагатай, бодитой болгож хэрэгжүүлэх энэ төсөв хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлогоор хэрэгжинэ гэдгийг онцлон хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Ерөнхий сайдын бас бодлыг асууя. Энэ уул уурхайн төслүүд хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй маш их тулгарч байгаа. Тэгээд шалтгаан нь бол уул уурхайгаас орж байгаа орон нутагт өгч байгаа өгөөж байхгүй байгаа. Төсөв уул уурхайгаас орж ирж байгаа АМНАТ-ын төлбөр, бусад төлбөрүүдийг бол үндсэндээ улсын нэгдсэн төсөвт хуваарилаад эргээд маш бага хэмжээгээр хуваарилж байгаа учраас л энэ сумын хөгжил, энэ аймгийн хөгжил гээд шаардлагатай хөрөнгө оруулалтууд хийгдэж чадахгүй, бэлчээр нутаггүй, уух усгүй, цэцэрлэг, сургуульгүй ийм байдалтай л байгаад байгаа юм. Тийм учраас бид нар цаашдаа энэ том төслөөд уул уурхай дагасан төслүүдээ хэрэгжүүлнэ гэвэл АМНАТ-ийн тодорхой хувийг нь тухайн аймаг сумд нь заавал үлдээдэг байх шаардлагатай. Тэгэхээр энэ дээр та цаашдаа ямар бодлого барьж ажиллах вэ? Орон нут.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Занданшатар хариулъя.

Г.Занданшатар: Нанзадын Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ АМНАТ-ийг тодорхой хувийг орон нутагт үлдээх шийдвэрийг төсвийн төвлөрлийг сааруулах зорилгоор Улсын Их Хурлаас баталж байсан 10 хувь байсан. Одоо 20 хувь болгоно гэж манай Сангийн яам бас төлөвлөж байгаа юм билээ. Гэхдээ 3.4 их наядын АМНАТ Өмнөговь аймаг төлөөд яг тэр харьцаагаараа болохоор бага төлж байна гэсэн ийм тоо баримтыг өнгөрсөн хэлэлцүүлгийн үеэр гишүүд ярьсан. Ийм учраас АМНАТ-ын бодлогыг хувь хэмжээнээс нь хамаарсан шатлалтай болгох. Ховдын Дарви сум гэхэд чинь уул уурхайтай сум учраас төсвийн орлогын нэмэгдэл нь хэдэн тэрбум болдог. Ингээд их үр ашигтай болж байсан ийм жишгүүд

бий. Энгийг их оновчтой уялдан зохицуулах замаар төсвийн хуваарилалтыг орон нутгийг хөгжүүлэхэд энэ уул уурхайн өгөөжийг өгдөг байх ёстой. Тэгэхгүй орон нутгийн иргэд нь өгөөж өгөхгүй бол.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууна. Алга байна. Тогтмолын Мөнхсайхан гишүүн асуулт асууна.

Т.Мөнхсайхан: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Шинэ томилогдож байгаа сайд нараа дэмжиж байгаа. Манай эрүүл мэндийн салбарт эмч гишүүн томилогдож байна. Энэ маш их давуу талыг авчирдаг учраас дэмжиж байгаа. Тэгээд эрүүл мэндийн салбарыг бас хоёртоо удирдаж сайдаар ажиллаж байсан хүний хувьд Чинбүрэн гишүүнтэй өнгөрсөн хугацаанд бас нэлээдгүй хамтарч ажиллаж байсан мэдэх хүний хувьд 3 зүйлийг анхаарч ажиллаасай гэж бодож байгаа.

Нэгдүгээрт, энэ бодлогын хийгдэж байсан томоохон ажлуудыг цааш нь үргэлжлүүлж үр дүнг нь үзээсэй. Энэ дотор энэ цахимжилтын бодлого өнөөдөр манай эрүүл мэндийн салбар 100 хувь цахимжихад энэ ажил нь 90 хувьтай явж байгаа. Энгийг гүйцээх юм ард иргэдэд, эмч эмнэлгийн ажилчид маш их хэрэгтэй зүйл болно.

Хоёрдугаарт, энэ төвлөрөл сааруулах бодлого энийг бид нар аймаг орон нутаг, ард иргэд, амьдарч байгаа бүс нутагтаа тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж байгаа гэх мэтчилэн энэ хэрэгтэй ард иргэдэд үр өгөөжөө өгөх энэ бодлогуудыг үргэлжлүүлж ажиллаасай гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ салбарын ажлын яг үнэхээр гүн рүү нь орж асуудлуудыг нь тогтоож, гарц гаргалгааг нь шийдэж ажиллаасай. Аль болох хий хоосон энэ попролоос жоохон хол байж ажиллаасай гэж ингэж хүсэж байгаа юм.

Гуравдугаарт, ашиг сонирхлын зөрчлөөс, ашиг сонирхлоос ангид байж энэ салбарт хийгдэж байгаа энэ ажлуудыг бодлогуудыг бас үргэлжлүүлж авч яваасай. Ялангуяа энэ эм дээр хийгдэж байгаа бодлого, нэг эх үүсвэрийн худалдан авалтын асуудал, энэ хууль шинэ гарсан хууль номынхоо дагуу хийгдэж байгаа. Энэ ажил ард иргэдэд үр өгөөжөө өгөөд өнөөдөр үр дүнгээ өгөөд ард иргэдийн сайшаалыг хүртээд явж байгаа энэ ажлуудаа хийж хэрэгжүүлээсэй гэдэг ийм зарчмын 3 зүйлийг танаас их хүсэж байгаа юм.

Ерөнхий сайд ч хэлж байгаа. Ер нь энэ цаашдаа энэ эрүүл мэнд, боловсролын салбараа өндөр түвшинд дэмжиж ажиллана. Энэ хүний хө хөгжлийн асуудлыг ер нь онцгой анхаарна гэж байгаа юм. Тэгвэл эрүүл мэндийн салбарын хувьд санхүүжилт нь гүйцэтгэлийн санхүүжилт рүү шилжсэн улсын хэмжээнд анхны энэ салбар байгаад байгаа юм. Тэгээд өнгөрсөн 5 жилийн хугацаанд голдирлоо бас чамгүй олоод явж байгаа. Одоо харин тавигдаж байгаа төсөв, мөнгө нь хүрэхгүй байгаа учраас ингээд тусламж, үйлчилгээ дээрээ зайлшгүй хязгаарлалт хийгээд байгаа. Одоо тэгээд жил болгон ДНБ-д эзлэх хувийг 1 хувиар нэмэгдүүлж яваад өнөөдрийн байгаа 3 хувийг 28 он гэхэд 6 хувьд хүргэчих юм бол эрүүл мэндийн салбарын чинь асуудал тэр чигээрээ бүрэн шийдэгдэх гээд байгаа юм. Санхүү мөнгө нь хүрэлцээтэй байхад тусламж, үйлчилгээ нь энэнтэйгээ уялддаг энэ гол тогтолцоог бий болгоод амжилттай явж байгаа юм. Тэгэхээр ирэх оны төсвийг та яг 4 хувьд.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Асуултаа нэгмөсөн 1 минут нэмээд өгчих.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр энэ манай эрүүл мэндийн салбарт хийгдсэн энэ санхүүжилтийн хувьд энэ томоохон реформыг яг дэмжиж бодит биеллээ олж ямар нэгэн тусламж, үйлчилгээ дээр хязгаарлалт хийхгүйгээр ард иргэддээ тусламж, үйлчилгээ хүргэх энэ боломжийн санхүүжилтийг бий болгох энэ ДНБ-ий 6 хувьд хүргэхийн тулд ирэх онд 26 онд 4 хувьд хүргэе, 27 онд 5 28 онд 6 хувьд хүргэе ээ гэдэг зорилтыг тавиад 26 оны төсвийн төсөөллийг ДНБ-ий 4 хувиар өгчихсөн байгаа. Энэ энэ 4 хувьд хүргэхэд их тийм хүнд асуудал биш. Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалаад байхгүйгээр 4 хувьд хүргэж байгаа боломжтой ийм тоо, судалгаанууд байгаа. Тэгэхээр энийг ирэх оны төсвийг яг 4 хувьд хүргэж та бүхэн маань ингэж ажиллах уу гэдэг энэ зүйлийг Ерөнхий сайд, Сангийн сайд нараас тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Болдын Жавхлан хариул.

Б.Жавхлан: Мөнхсайхан сайд аа та өөрөө төсөв мөнгө сайн мэдэх хүний хувьд асуулт маань л тиймэрхүү байна даа. 2026 оныхоо төсвийн хүрээний мэдэгдлээ бид баталчихсан шүү дээ Их Хурлаар. Одоо тэгээд бид нар тодотгол орж байна. Тэгэхээр энэ тодотголын дараах дүн 2026 оны төсвийн суурь болно. Дандаа агшиж орно, агшиж орно. Аль ч салбарын төсөв энэ жилийнхээс тэлж чадахгүй. Ямар ч боломж байхгүй. Дотоодын нийт дүн өсөх хэрээр бид төсвөө аль болох өсгөхгүйгээр хэмнээд танаад илүү их, үр дүнтэй, 1 төгрөг бүрээр илүү их өгөөж бүтээх ийм бодлого руугаа ингээд явж байгаа. Ийм үед яг номинал дүнг ДНБ-тэй нь харьцуулж өсгөнө гэхээсээ илүүтэйгээр тухайн салбарт зарцуулж байгаа 1 төгрөгөөр илүү их үр дүн илүү их, эмчилгээ үзүүлэх, илүү их хүртээмжтэй байх тэр менежментийг яах хийх вэ гэдэг дээрээ л сайд нар маань ухаан зарцуулах ёстой юм байгаа юм. Тэгэхээр ирэх жил бол энэ жилийнхээс нэмэгдэх ямар ч боломж байхгүй.

Б.Пүрэвдорж: Тодруулсан. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Түүхэнд Занданшатарар гэж овоглогдох шинэ Засгийн газар ингээд ажилдаа орох гэж байна. Энэ дотор сайдад тусгайлан баяр хүргэе гэж бодож байна. Намбарын Энхбаярын Батшугар танд амжилт хүсье. Та бас олон юм ярьж дөвчигнөдөггүй хийе гэсэн ажлаа нухацтай судалдаг, ард түмнийхээ зовлон, бэрхшээлийг ойлгодог залуу боловсон хүчин байна. Танд амжилт хүсье. Бусад сайдуудад нь захъя. Ерөнхий сайд та нарыг нэрийг чинь дэвшүүлж толгойгоороо Улсын Их Хурлын өмнө хариуцаж Монгол төрд тангараг өргүүлж байгаа хүн шүү. Ерөнхий сайд чинь хэн ч байж болно. Тэр хүнээсээ битгий урваарай. Урвах тусмаа улам зоригжино гэж айхтар үг байдаг. Засгийн газрын эрхэм сайдууд та бүхэн битгий урваарай. Ингээд 2, 3-хан асуулт асууя.

Нэг захиасаа нэмээд хэлчихье. Монгол Ардын нам дангаараа Засгийн газар байгуулах гээд тэгсэн чинь жоохон юм болдоггүй л дээ. Жишээлбэл, ганган хүүхэн гарах гэж байтал толины өмнө эргэлдээд байдаг уруулаа будмаар байдаг Иргэний зориг ногоон нам, ХҮН нам битгий уруулын будаг нь байгаарай. Мэйк ап/make up/ нь биш шүү та нар хамтарч ажиллаж хариуцлагаа үүрэх ёстой гэдгээ ухаарна биз.

5 дугаар сарын 12-нд Говийн бүсэд Засгийн газрын чуулган хуралдсан. Энэ дээр маш зөв, зүйтэй асуудлуудыг ярьсан. Засгийн газрын тогтоол гараагүй Ерөнхий сайд аа. Энэ тогтоолыг тэмдэглэлээс нь харж гаргаж өгөөч.

Ногоон намаас томилогдож байгаа Батбаатар сайдаас асууя. Говийн усны төслөө хэр сайн мэдэх вэ? Ерөнхий сайд байхдаа говийн бүсийн тэргүүн төсөл дээр энэ говийг усжуулах Хэрлэн-Тооно, Орхон-Онги төслийг тавьж өгнө гэсэн. Энийг соён гэгээрүүлэх гадагшаа, дотогшоо явж судалгаа хийх тэр багийг байгуулаад тэр зардлыг Эрдэнэс Тавантолгойгоос төлүүлнэ гэж амлаж байсан. Монгол төр залгамж халаанд байх ёстой энэ асуудал дээр манлайлал үзүүлж ажиллаж өгөөч.

Цогтцэций сумд 1000 гаруй ажилчид, уурхайчид ажил хаяад суулт хийж байна. Монгол төр сандал, ширээгээ булаацалдаад 1 ч төрийн байгууллагаас хайхарч үзсэнгүй. Маргааш Цогтцэций сумд ажиллана. Тэгээд шинээр томилогдож байгаа Аубакир сайд, Дамдинням сайд нарт эхний шаардлагыг чинь Цогтцэций сумаас авчирна.

Дээрээс нь Учрал сайдыг манай Дорноговийн Улаанбадрах сум, Хөвсгөл сумынхан дуудсаар сар гаруй боллоо. Та очих уу? Тэгээд Ерөнхий сайдаас асуулаа, Батбаатар сайдаас асуулаа, Учрал сайдаас асуулаа 3 асуултдаа хариулт аваад нэмж бас тодруулъя.

Б.Пүрэвдорж: Батын Батбаатар гишүүн хариулъя.

Б.Батбаатар: Өнөөдөр 6 сарын 17 олон улсын цөлжилттэй тэмцэх өдөр. Цөлжилттэй тэмцэх өдөр одоо бид нар усны тухай ярих нь зүй ёсны асуудал.

Ер нь говийн усны төсөл гэдэг ганцхан хязгаар дотор усны асуудлыг багтааж болохгүй. Ус олон улсын гэрээ, конвенц олон зүйлээс шалтгаалдаг. Ус гол мөрний эх урсгал гарцыг өөрчлөх энэ бүхэнд гадаад хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа ойлголцох шаардлага байгаа. Зөвхөн Монголын говь дотор бодох юм бол бид нар энэ асуудлыг шийдэж чадахгүй. Иргэний зориг ногоон нам суурь үндсэн үзэл баримтлалынхаа хувьд ногоон үзэл баримтлалыг тээж явдгийнхаа хувьд энэ асуудал дээр хангалттай манлайлал үзүүлж ажиллаж чадна. Энэ манлайллыг үзүүлэхэд Улсын Их Хуралд суугаа 5 намын 126 гишүүн дэмжиж ажиллах нь ирээдүйн Монгол Улсад бидний үр хүүхдэд чухал шүү гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулна.

Г.Занданшатар: Говийн бүсийн чуулганаар дэд бүтэц, ус, эрчим хүчний хомсдол, уул уурхайн өгөөж хөдөөгийн ард иргэдэд хүрэхгүй байгаа асуудал, саяын АМНАТ орон нутгийн иргэдэд очих өгөөжийн асуудлыг, уул уурхай тэлэлтийн зохицуулалтын асуудал зэргийг ярьсан ч Засгийн газар тэмдэглэл хэлбэрээр гаргасан юм билээ. Тогтоол тухайн үедээ гараагүй. Засгийн газрын тухай хуульд холбогдох журмаар бол хэлэлцээд нэгэнт Засгийн газрын хуралдааны шийдвэр протокол хэлбэрээр гарчихсан бол дараа нь тогтоол болгох боломж хязгаарлагдмал. Дараа нь жич дахиж авч хэлэлцээд тодорхой асуудлыг

судлаад тогтоол энэ устай холбоотой болон бусад асуудлаар гарах шаардлагатай гэж үзэж байна. Засгийн газрын хуулиараа тийм.

Харин усжуулалтын төслийн хувьд бол энэ 2.7 их наядын өртөгтэй энэ төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хий.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас дахиад юм асууя даа. Энэ чинь зүгээр тунхгийн чанартай асуудал биш байхгүй юу. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд дээрээс нь Тэргүүн Шадар сайд хэр их манлайлал үзүүлнэ. Энэ Орхон-Онги, Хэрлэн, говь төсөл чинь явах ёстой байхгүй юу даа. Энэ зөвхөн говийн усны төсөл биш, энэ Монгол Улсын усны төсөл. Ирэх онд КОП 17 явна. Эндээс хөрөнгө босгох шаардлагатай. Тэгэхээр та манлайлал үзүүлж ажиллах ёстой. Монголын говь өнөөдөр урсгагч нулимсгүй болсон байгаа. Тэгэхээр энэ зүгээр тунхгийн Иргэний зориг ногоон нам нэрдээ “ногоон” гэдэг үг оруулсан гэдэгтэй адилхан зүйл биш юм Батбаатар сайд аа. Танаас дахиад бүүр амлалт авмаар байна.

Ерөнхий сайд аа тэгэхээр тогтоол гарахгүй гэсэн үг юм уу? Говийн бүсэд хуралдсан тэр хуралдаан чинь тэмдэглэл хэвээр үлдчихсэн юм бол дахиад говийн бүсэд хурал хийх юм уу?

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулъя.

Г.Занданшатар: Засгийн газрын хуралдааны шийдвэр, протокол буюу Засгийн газрын хуралдааны тэмдэглэл хэлбэрээр тогтоол хэлбэрээр тухайн үедээ албажиж гардаг. Нэгэнт албажиж гарчихсан шийдвэрийг дахиж хэлэлцээд ер нь тусдаа ажлын хэсэг байгуулаад говийн усны асуудлаар бас говийн сонгогдсон гишүүд ч оролцоод заавал манай хурлын тоо цөөдөөгүй, асуудлууд нь тодорхой, төслүүд нь тодорхой. Тийм учраас тэн дээр ажлын хэсэг ажиллаад Засгийн газрын тогтоолыг холбогдох сайд нар оруулж ирээд баталж болно. Эдийн засаг, хөгжлийн сайд, Уул уурхайн сайд, Зам, тээвэр, хөгжлийн сайд гээд. Энэ нь бол илүү сайд нар төслөө боловсруулж ороод тогтоолын төслөө боловсруулаад яамдаас санал аваад ингээд Эдийн засаг, Сангийн яам санхүү, эдийн засгийн талаас, Хууль зүй, дотоод хэргийн яам хууль зүйн яамны талаасаа дүгнэлтүүдээ гаргаж байгаад тогтоол албаж гаргадаг. Засгийн газрын хуралдааны процедур жишиг нь ийм. Ийм учраас тогтоол гаргах шаардлагатай бол ингээд устай процесс.../минут дуусав./

Б.Пүрэвдорж:Нэр дэвшигч Батын Батбаатар хариулна.

Б.Батбаатар: Устай холбоотой Хэрлэн-Тооно төслийг би нэлээн судалсан. Ерөнхийдөө Усны бодлогын газар дээр гарч байгаа ТЭЗҮ хараахан гүйцээгүй байхад нь материалуудыг нь татаж авч харсан. Бусад зүйлүүд дээр нь бас тодорхой хэмжээгээр асууж лавласан. Устай холбоотой асуудал бол бид нар цахилгаан станцууд өмнөх жишгээр мэдэж байгаа шүү дээ УЦС барья. Хойд хөршөөсөө зөвшөөрөл авдаг, гэрээ хэлэлцээр хийдэг. Тэгэхээр бид нар энэ устай холбоотой асуудлыг бид нарын хувьд хамгийн том төвөгшил ихтэй, шийдэхэд хүндрэлтэй асуудал. Хөрш орнуудтайгаа ойлголцох асуудал юм байна лээ. Хөрөнгө оруулалт, гүйцэтгэл, ажиллах тэр боломж нь харьцангуй.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Мөнхбаясгалан гишүүн ээ тодруулаад хэрэггүй юм байна хадуураад явчихлаа. Тэгээд бүүр энэ наадах концепцоо сайн тайлбарлаж өөр дээр нь очиж хэлж өг.

Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууя.

3.Мэндсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ерөнхий сайд маань шинэ Засгийн газрын бүтцээ танилцуулж байна. Ерөнхий сайдаас асуух асуулт байна. Мэдээж улс орны эдийн засаг чухал уу гэвэл чухал. Уул уурхай төслүүдээ хөдөлгөх нь зөв үү? Зөв. Гэхдээ энэ дээр бас орон нутагт тулгамдаад байгаа асуудлыг өнөөдөр дуугарахгүй байж болохгүй байна. Сүүлийн 2, 3 өдөр Ховд аймгийн Мянгат суманд Халзан Бүргэдэйн ордын асуудлаар ард иргэд аж ахуйн нэгжийн хооронд мөргөлдөөн гэж хэлэхэд болно. Ийм зүйлүүд болж байна. Аймгийн цагдаагийн байгууллага нь ч чих нь дүлий, төр засаг маань ч чих нь дүлий. Энэ түрүүн бас нэр дэвшигч, Уул уурхайн сайдад нэр дэвшигч Дамдинням гишүүн маань бас хэлж байна л даа. Аливаа уул уурхайн төслийг явуулахдаа хөрөнгө оруулагч төр, иргэний хоорондын зөвшилцлийг бий болгох замаар явна гэж. Тэгээд начир дээрээ ийм зүйл алга байна. 3 өдөр тэнд ард иргэд хувийн хэвшил хоёрын хооронд мөргөлдөөн болж байна.

Өмнө нь 2 жилийн өмнө Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ Ховд аймгийн ард иргэдтэй очиж уулзахдаа Халзан бүрэгтэй орд дээр Монгол Улсын Засгийн газар тусгайлсан бодлого байхгүй ээ. Хэрвээ энэ нутгийн ард иргэд та бүгд маань энэ төслийг эсэргүүцэж байгаа бол явуулахгүй ээ гэж хэлсэн. Үүнээс хойш энэ нутгийн иргэд энэ Ховд аймгийн иргэд санал нэгтэй энэ төслийг эсэргүүцэж байгаа. Шаардлагатай бол би танд нутгийн иргэдийнхээ, Ховд аймгийн иргэдийн дунд санал асуулга явуулаад энийг нэгтгээд өгч болно. Тэгэхээр энэ дээр Ерөнхий сайд яг ямар байр суурьтай байгаа вэ? Энэ телевизээр бас нутгийн маань иргэд үзэж байгаа байх. Ерөнхий сайдын хувьд энэ дээр маш тодорхой хариулж өгөөч гэж хүсмээр байна.

Хоёрдугаарт, ТӨК-удыг цөөлнө гэж их ярьж байгаа. Хамгийн сүүлийн хамгийн том алдаатай шийдвэр бол “Эрдчист Монгол”. Энэ асуудлыг эргэж харах нь зүйтэй гэж бодож байна. Би Ерөнхий сайд энэ асуудлыг эргэж хараасай гэж хүсэж байна. Эрчим хүчний салбарыг 1 биетэй 4 толгойтой могой шиг болгосон. Үлгэрт ийм байдаг байх. Ингээд яваад мэргэжлийн шуурхай удирдлагаар хангадаг салбарыг эзэнгүйжүүлсэн. Асуудал үүссэн энэний удирдлагын энэ салаалсан бүтцээс болж. Нөгөө муу нэртэй гэдэг шиг Чойжилсүрэн сайд энэ дээр улайгаад хоцорсон нийгэмд гөвүүлээд. Нөгөө их мундаг юм яриад байсан хүмүүс алга болсон. “Эрчист Монгол” компани 7-хон хоногийн дотор буцаагаад эрчим хүчний компаниудын хувийг шилжүүлж байна. Ийм асуудлыг эргэж хармаар байна. Энэ “Эрчист Монгол” гэдэг компанийг татан буулгах ёстой. Одоо яг Дэлгэрсайхан сайд дээр энэ зовлон ирнэ. Энэ зам, тээврийн салбарын шуурхай удирдлагатай МИАТ эд нар дээр эрсдэл үүсгэх асуудлаас урьдчилж энэ асуудлыг таныг шийдээч ээ гэж хүсэх байна. Тэгэхгүйгээр энэ асуудал маань цаашаа явахгүй. Ийм үр дүнгүй бүтцүүдийг бий болгож болохгүй.

Хоёрдугаарт, та бас түрүүн танилцуулахдаа энэ үндэсний хороонууд .../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя.

З.Мэндсайхан: Тэгээд түрүүн танилцуулахдаа энэ Үндэсний хороонуудыг татан буулгана гэж байна. Энэ их маш зүйтэй. Энийг таныг бас дэмжиж байна. Энэ асуудлуудыг өмнө нь ч би төсөв хэлэлцэх үеэр ярьж байсан.

Энэ сайд нар бас эхнээсээ ийм хариуцлагагүй байж болохгүй. Энэ Доржханд сайдад би хандаж хэлэх гэсэн юм. Үнэнд гүйцэгдэх худлыг их яриад баймааргүй байна төрийн сайд хүн байж байж. АНУ-аас сэргээгдэх эрчим хүчний салбарт 2 тэрбум долларыг амжилттай татаж чадлаа гэдэг хувийн Пи Ар хийсэн. Тэр мөнгө хаа байна? Төрийн сайд ингэж 1 салбар энэ хувийнхаа Пи Ар-д зориулж ийм гоомой, бодлогогүй худал хуурмаг мэдээлэл цацаж болохгүй. Энийгээ цаашдаа анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт, ХҮН намынханд хандаж хэлэхэд та нар 8-лаа. Засгийн газрын ямар нэгэн асуудал орж ирэхэд 4 нь эсэргүүцдэг, 4 нь дэмждэг. Тэгээд үр дүн нь тэг. Ийм байдлаар та бүгд маань засагт хамт.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар хариулъя.

Г.Занданшатар: Яг тодорхой орд газрын байгаль орчны үнэлгээ нөлөөлөл болон төслийн үр өгөөжийн талаар бас судалж байж хэлэх нь зөв байх. Ерөнхийдөө энэ орон нутгийн иргэдийн уурхайтай харилцах харилцааны талаар нэгдүгээрт хариуцлагатай уул уурхай.

Хоёрдугаарт, энэ төслийн үр ашиг, өгөөжийг нутгийн ард иргэд хүртдэг байх явдал.

Гуравдугаарт, байгаль орчны нөлөөлөл, хүрээлэн байгаа орчин, амьдрах орчинд нь сөргөөр нөлөөлөхгүй байх тэр орчин нөхцөлийг бүрдүүлэх асуудал. Энэ цогц шийдлийг институтийн хувьд болон хууль эрх зүйн хувьд, Засгийн газрын хувьд шийдэхгүй бол аливаа уул уурхайн томоохон төслүүд бас ийм эсэргүүцэлтэй тулгардаг нийтлэг бэрхшээл байна. Иргэдийн эсэргүүцэл төслийг биш энэ тэгш бус өгөөж, дундын цавчаа гэж нэрлэдэг дарга нар, аймгийн дарга, сумын дарга нартайгаа зөрчилдөөн, нууц гэрээг эсэргүүцэж байгаа хэлбэр илүү их байдаг. Энийг ил тод хариуцлагатай уурхай орон нутагт үр өгөөжтэй хэлбэрээр нутагтаа хөгжил, дэвшил авчирч байвал өгөөжийн хувийг нь тодорхой болгох, орон нутагт нөлөөллийн бүсийн гэрээ байгуулах, шийдвэр гаргалтдаа иргэдийг оролцуулах замаар энэ итгэлийг сэргээж болно. Энэ нийтлэг бол уул уурхайд тулгарч байгаа хөдөө орон нутаг орон нутгийн иргэд болон уул уурхайн төслүүдийн хоорондын Оюутолгой ч бай, Тавантолгой ч байгаа, учирч байгаа энэ Өмнөговь аймагт нэн ялангуяа учирч байгаа бэрхшээл дээр тулгуурлаж тэгж хэлж болно.

Ер нь “Эрчист Монгол” компанийг төрийн өмчийн компанийн шинэчлэл гэж биш, бодитоор эрх мэдлийг нөгөө яг таны хэлдгээр салбарлуулсан хяналтгүй бүтцийн шинэ давхарга, чиг үүргийн давхардлууд энэ Үндэсний хороотой адилхан энэ чиг үүргийн давхардал, хариуцлагыг эзэнгүйдүүлж, олон толгойтой болгож энэ эрсдэлт нөхцөл байдал үүсэх үндсэн нөхцөл болсон гэж мэргэжлийн

байгууллагууд дүгнэж байгаа. Ер нь төрийн өмчийн компаниуд ил тод хувьцаат мэргэжлийн удирдлагатай байх нь зөв жишиг.

Ийм учраас энэний ялангуяа эрчим хүчний салбарт бий болж байгаа нөхцөл байдлыг 1 толгойтой болгоно. Ийм учраас тэр Эрчим хүчний зөвлөл, Эрчим хүчний хороо, эрчим хүчний компаниудыг нэгдсэн удирдлагатай байхгүй бол эрчим хүчний салбар стратегийн салбар. 1 толгойтой байхгүй бол болдоггүй ийм сахилга, дэг журамтай онцгой салбар. Цахилгаан станцууд онцгой объектууд. Энэ дээр хариуцлага салаалах, эзэнгүйдэх, олон удирдлагатай, олон толгойтой болоод ирэхээр л энэ нэршил л гарах нэг менежментийн шалтгаан болсон гэж үзнэ.

Дамдинням сайд хариулъя. Дамдинням нэр дэвшигч хариулах уу?

Б.Пүрэвдорж: Нэмж Гонгорын Дамдинням гишүүн хариулъя.

Г.Дамдинням: Тийм тэгэхээр энэ Халзан Бүрэгтэй холбоотой асуудал бол Ерөнхий сайд ерөнхийд нь хэлчихлээ дээ. Яах вэ гол асуудал бол юу байгаад байгаа юм. Нэгдүгээрт, иргэдийн мэдээлэлгүй байдал. Тэдэнд очиж байгаа бас энэ уул уурхайн салбарыг ойлгуулах энэ тал дээр аж ахуйн нэгжүүдийн маань оролцоо, санал санаачилга бас тогтвортой уул уурхайн энэ зарчмынхаа хүрээнд явж өгөхгүй байгаа. Уул уурхайг явуулах нийгмийн зөвшөөрөл гэж ойлголт олон улсад байдаг. Нийгмийн зөвшөөрлийг бий болгож байж төрийн зөвшөөрөл бодит амьтай хэрэгжиж явдаг. Тэгэхгүй тэрийг бас цагдаагаар ч гэдэг юм уу, хүчний байгууллагуудаар хамгаалаад хүчээр шийддэг ойлголт ерөөсөө байхгүй болсон.

Тийм учраас бол энэ хөрөнгө оруулагч төр ард иргэдийг ойлголцуулах ажлуудыг хийж байх ёстой. Энэ ийм аргачлалыг амжилттай хийсэн жишээ бол Увс аймагт бол байсан байдаг. Гаднын компаниуд их амжилттай хийсэн байдаг. Энэ аргачлалуудыг бас бид нар судалж шинжлэх ухааны үндэстэй ажиллах ёстой энэ дээр.

Б.Пүрэвдорж: Мэндсайхан гишүүн нэмж тодруулъя.

З.Мэндсайхан: Ерөнхий сайд аа ер нь энэ асуудлыг та бүхэн та бас нухацтай авч үзэж ер нь энэ төслийг зогсох талд нь Засгийн газраар хэлэлцэж шийдвэр гаргаж өгөөч ээ гэж хүсэлт байна.

Хоёрдугаарт, үнэхээрийн нөхцөл байдалтай нь Дамдинням сайд та ажлаа авангуутаа очиж танилцах хэрэгтэй. Энэ нутгийн ард түмэнтэй би таныг урьж байна хамт явъя. Энэ хүсэлтийг танд албан ёсоор тавья.

Б.Пүрэвдорж: Нэгэнт бас энэ асуудал яригдсан учраас бас тэр орон нутгаас сонгогдсон хүний хувьд нэг зүйлийг хэлье. Ер нь Халзан Бүрэгтэйн асуудал бол иргэдийн хувьд нэлээн эсэргүүцэлтэй тулж байгаа. Гэвч Монгол Улсын Ерөнхий сайд Герман улсад очоод Халзан Бүрэгтэй ашиглах тухай ярьдаг, Японд очоод бас ашиглах тухай ярьдаг. Тэгсэн мөртөө иргэдтэй уулзах болохлоор 1 Их Хурлын гишүүнийг гаргахын тулд иргэдийн, иргэд шийдэхгүй бол бид Засгийн газар дэмжихгүй гэж ярьдаг. Тэгсэн үүнийхээ дараагаар сайд нарыгаа тэр асуудлыг шийд гэж шахдаг. Ийм л байсан.

Тийм учраас энэ хайгуулын үед маш их эсэргүүцэл өнгөрсөн 11 сард гарсан. Ардын намын 3 гишүүн байхгүй алга болчихоод аргагүйн эрхэнд Ховд аймгийн Засаг даргад үүрэг өгч байж тэр бас юуг зогсох шийдвэрийг гаргаж гаргасан. Харамсалтай нь шүүхэд өгөөд өчнөөн олон тэрбум төгрөгийн хохирол нэхсэн байна лээ. Тэгээд Засгийн газар нь өөрсдөө ингээд чив чимээгүй суучхаад тэгээд 1 хэдэн асуудалд их тийм холбоо байхгүй хэдэн гишүүдийг болон Мэндсайхан гишүүн ялангуяа ингээд ийм газар тавьж өгчхөөд ингээд яваад байж болохгүй. Тийм учраас Засгийн газар тодорхой энэ асуудлаар хуралдаж, тэр иргэдийн нөхцөл байдалтай Дамдинням гишүүн очиж танилцаад тэр Мэндсайхан гишүүнтэй хамт явах хэрэгтэй. Яг нутгийнх нь хүн. Тэгээд очиж танилцаад тэгээд эндээ цаашаа яах юм? Тэгээд Ерөнхий сайд нь өөрөө гарч ирж өөрөө явуулахгүй гэж хэлсэн бол дараагийн Ерөнхий сайд нь энэ асуудал дээрээ өөрөө гарч ирж мэдэгдэл хийж тэр нэг талд нь гаргах тэр ажлыг хийх хэрэгтэй.

Б.Пүрэвдорж: Чинбатын Номин гишүүн асуултад хариулъя.

Ч.Номин: Та бүхэндээ энэ оройн мэндийг хүргэе. Их Хурлын дарга би бүтэн минутаа авчихъя. Юун түрүүнд Занданшатар дарга болон түүний Засгийн газарт амжилт хүсье.

Нөгөө талдаа бас Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаар ажлаа авч байгаа Ундрам гишүүндээ бас баяр хүргэе. Үүнээс гадна амжилт хүсье. Би таныг соёл оюуны ухамсрыг түгээж чадна гэдэгт итгэлтэй байгаа.

Манай бол салбар 4 салбараас бүрдэж байгаа та бас мэдэж байгаа болов уу. 480 гаруй төрийн байгууллагад 7 мянга гаруй хүмүүс ажилладаг. Үүнээс гадна аж ахуйн нэгүүдийн тоон дээр бас өндөр ажил олгогч талаасаа ч гэсэн ойролцоогоор 10 гаруй хувь нь, ажлын байрны 10 гаруй хувь нь энэ салбарт байдаг. Тэр дундаа залуучууд ихтэй ийм салбар байдаг. Өнгөрсөн жилүүдийн хугацаанд өнгөрсөн 4 жилийн хугацаанд соёлын салбарын хувьд соёлын салбарын сэргэлтийн жилүүд байсан гэж хэлж болно. Бид бүхэн соёлын салбарынхаа хууль, эрх зүйн тогтолцоо цаашлаад хүний нөөцөө тодорхой болгож бодлогоо бүрэн гаргасан байгаа. Соёлын өвийг хадгалж хамгаалах, дээрээс нь урлаг уран бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нөгөө талдаа өв соёлыг түгээн дэлгэрүүлэх энэ ажил дээр бол эрчимтэй ажилласан. Тэгээд энийг бас та бодлогын түвшинд цааш нь хэрэгжүүлээд аваад явах болов уу гэж бодож байна. Спорт, залуучуудын хувьд бол бодлого нь тодорхой болсон. Тэгээд бодлогын залгамж халааг таныг бас үргэлжлүүлэн авч явах болов уу гэж бодож байна.

Нэн ялангуяа Монгол Улсын нийт хүн амын 30 хувь болсон залуучуудын салбарын залуучуудын орон сууцжуулах, хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа малчин залуучуудын асуудал дээр таныг илүү анхаарч ажиллах байх гэж харж байна. Үүнээс гадна манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хүрээнд бол энэ олон улсын сурталчилгааг хийж авч явдаг байсан. Хэдийгээр энэ Засгийн газрын тухай хуулиараа Гадаад харилцааны яаман дээр байдаг байсан ч манай яам хийж авч явж байсан. Энэ хүрээндээ олон улсын зөөлөн хүчний индекс 14 байраар урагшилсан. Соёлын харилцаа 21 байраар индексийн түвшинд урагшилсан. Олон улсын сурталчилгаа мөн 30 байраар урагшилсан гээд олон амжилтууд гарсан.

Тэгэхээр энэ ажлыг бас та өөрөө үргэлжлүүлж явах уу, эс үгүй бол энийг Гадаад харилцааныхаа яаманд шилжүүлэх үү гэдгээ шийдвэрлэх ёстой байх. Яагаад вэ гэхээр эдгээр ажлыг хийж хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын дэлхийд үнэлэгдэх үнэ цэн, Монгол хүний дэлхийд үнэлэгдэх үнэ цэн цаашид хөрөнгө оруулалтыг татах боломжуудыг бид нар нээлттэй болгосон гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ ажил бас манай спорт соёлоор дамжуулан өргөн цар хүрээтэй явсан гэдгийг хэлье. Тэгээд таны цаашдын ажилд амжилт хүсье. Та бол энэ салбарыг бүрэн мэдэж байгаа. Миний хувьд таныг 100 хувь дэмжиж ажиллана.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Мэндбаярын Мандхай гишүүн алга байна. Байна уу? Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна. Болдын Уянга гишүүн байна тийм үү? Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Шинэ сайд нар томилогдох гэж байна. Хэдэн асуултууд бас хэдэн үг байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас бас 2-3 тодруулга асуух зүйл байна. Өнөөдөр иргэдийн хүсэж байгаа хамгийн их хүлээлттэй байгаа асуудлуудын нэг нь нийгмийн хамгааллын нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн талаар иргэд бас аж ахуйн нэгжүүд яг чих тавин хүлээж байна. НДШ-ийг бууруулах асуудал дээр ямар байр суурьтай байгаа вэ? Тухайлбал НДШ-ийг хэт өндөр байна гээд 2023 онд D-Paliament.mn дээр санал асуулга явуулсан. 105 мянган хүн бууруулах дээр саналаа өгч энэ асуудал дээр бас нийгмийн анхааралд орсон гэж ойлгож болно. НДШ-ийн хувь хэмжээ өндөр байх нь сангийн орлогыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө одоохондоо үзүүлж байгаа. Алсдаа энэ нь өөрөө хөдөлмөрийн зах зээлд ажиллагсдын тоо буурах, даатгуулагчдын тоо буурах зэрэг сөрөг нөлөө үзүүлэх хандлагатай байгаа. Иргэд насаараа хөдөлмөрлөж байгаа. 20, 30, 40 жил хөдөлмөрлөөд тэтгэвэртээ гарч байгаа.

Яг энэ нийгмийн даатгал төлсөн энэ бодит үр шимээ иргэд маань хүртэж чадахгүй байгаа. Эрэгтэйчүүдийн дундаж наслалт бас богино. Энэ дээр яг ямар шийдлийг та бас ажил хэрэг болгох вэ? Өнөөдөр ахмадуудын маань 70 орчим хувь нь тэтгэврийн зээлтэй байгаа шүү дээ. Ахмадуудын маань. Тэтгэврийн зээл авдаг бас тэр нөхцөл байдал нь хумигдсан. 24 сар байсан энэ нь багассан гэж байгаа юм. Энэ дээр иргэд болон энэ ахмадууд маань бас үнэхээр их бухимдалтай байгаа. Үнэхээр их мессеж бичиж байна асууж өгөөч гээд. Энийг энэ ахмадууддаа бид бүхэн бас нээж өгье л дөө. Тэтгэврээ хангалттай аваг, гадаад, дотоодод аялаг, юм үзэг, чөлөөт цагаа бас тэр үр бүтээлтэй өнгөрүүлэг. Энэ дээр нь бас тодорхой шийдлийг гаргаж өгөхгүй бол зөвхөн сая өнгөрсөн жил орчмын хугацаанд хүүхдүүд нь л тэтгэврийг нь аваад үрээд хаячихдаг юм шиг машины зээл авдаг юм шиг ийм ойлголттой болсон шүү дээ. Энэ дээр яг тодорхой бас байр суурийг илэрхийлээч гэж хүсэж байна.

Боловсролын сайдаас бас тодруулах 2 зүйл байна. Өнөөдөр манай улсын хэмжээнд ЕБС, цэцэрлэгийн хэмжээнд 1 сая 60 мянга орчим хүүхэд суралцаж байна. Үдийн цай хөтөлбөр хэрэгжиж байгаа. Цэцэрлэгийн хүүхэд 4 мянга орчим төгрөг, ЕБС-ийн хүүхдүүд 2500 төгрөгт энэ өдрийн хоол, цэцэрлэгийн зардал байгаа.

Б.Пүрэвдорж: Нэмэлт 1 минутыг өгье.

Н.Алтаншагай: Нэмэгдүүлэх боломж байгаа юу гэдэг дээр асууж байна.

Хоёрдугаарт, энэ зөвхөн ЕБС дээрээ бага ангийн хүүхдүүд энэ үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байгаа. Тэгэхээр дунд анги руу шилжүүлэх бага, дунд ангийнхан энэ үдийн хоол хөтөлбөрт хамрагдах энэ боломжийг эрэлхийлээч. Мөнгийг нь бас энэ Боловсролын сайдын хувьд энэ оны төсөв дээр бас сайн бас шаргуу хөөцөлд тавиулж өгөөч гэж байгаа.

Хоёр дахь асуудал нь болохоор энэ ерөнхий боловсролын 12 жилийн тогтолцоотой байгаа юм. Хөдөө орон нутгаас их ирж байгаа асуултуудын 6 настнуудыг яах юм бэ? Хөдөө орон нутагт их хүндрэлтэй байна. Хичээлийнх нь хөтөлбөр бас их өндөр байна гэж байгаа юм. Олон улсын жишгээр 1, 2 дугаар анги бол энэ хичээлийнх нь хөтөлбөр, агуулга нь бас харьцангуй хөнгөн байх энэ чиглэл рүү нь явуулах. Ялангуяа энэ хөдөө орон нутгийн хүн хүсэж байгаа шүү дээ бүүр 7 настайгаас нь оруулж болдоггүй юм уу гээд. Энэ дээр бодитой яг үр дүнд хүрэхүйц алхмыг бодлогыг оруулж ирээч ээ гэж танаас хүсэж байна. Хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Эхлээд Аубакир нэр нэр дэвшигч хариулна.

Т.Аубакир: Баярлалаа. Алтаншагай гишүүн их чухал асуудал хөндөж байна л даа. Яах арга байхгүй бас нийгмийн өмнө тулгарч байгаа цаашдаа бид нар бас алсаа бодож шинэчлэлүүдийг хийх ёстой энэ зүйлүүдийг дурдаж байна. Нэг амьсгаагаар яг энэ хувь хэмжээг бууруулах тал дээр НДШ-ийн эргээд төсөвтөө ачаалал өгөхөөр харагдаж байгаа. Зайлшгүй хийх ёстой реформ мөн үү гэвэл мөн. Энх-Амгалан сайд ажиллаж байх хугацаандаа бол бас хуулийн төслүүд боловсруулаад бэлэн болж байгаа юм байна. Зарим гишүүдийн зүгээс ч гэсэн энэ дээр ч буулгах асуудлыг байнга ярьдаг. Суурь бүтцийг нь яг авч үзэхгүй бол шууд хувь хэмжээг бууруулна гэдэг бол бас эрсдэл дагуулах магадлалтай харагдаж байгаа юм. Одоо энэ НДШ-ийг шууд хувиар бууруулахад хүнд байгаа. Харин ажил олгогчийн төлөх шимтгэлийн хэмжээнд ажилтантай адил хязгаар тогтоох санал бас боловсруулах бас бололцоотой.

Залуучууд, оюутнууд ажил хийх юм бол НДШ төлөхгүй байхаар зохицуулалт хийхээр бас бодлого гаргаж ажиллах бодолтой байна. НДШ-ийг бууруулснаар цаашдаа тэтгэврийн хэмжээ бас буурах ийм эрсдэл үүсэх магадлалтай. Тийм учраас бид нар эргээд бас энэ Засгийн газрын түвшинд ярьж байгаад хуулиудыг боловсруулж бас ажиллана.

Таны 2 дахь асуудал энэ тэтгэврийн зээл яах арга байхгүй энэ нийгэмд бас тулгамдчихсан л асуудал л даа. Энэ өндөр настай хүмүүс маань тэтгэврийн зээлээ аваад тодорхой хэмжээний бас зарим амьжиргаагаа залгуулах зайлшгүй шаардлагатай болчихсон. Мөн энэ дээр нь арилжааны банкнууд бас хэт их ашиг хийгээд байна гэдэг бас тал байдаг. Энийг бас цаашдаа ажиллах явцдаа хэдүүлээ нийлээд бас боловсронгуй болох бололцоотой гэж харж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Боловсролын сайд Наранбаяр 3 минутаар хариулчих. Нэлээн олон асуулт байна лээ.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ үдийн цай хөтөлбөрийн тухайд өнөөдөр 1-5 дугаар ангид хүүхдэд хоол өгч байгаа. Дунд сургуулийн хүүхдүүдийг оролцуулах боломж байна уу энд гэсэн ийм асуулт байлаа. Тэгэхээр бид тооцоо хийж үзээд 26 оныхоо төсвийн хүсэлтэд энийг оруулж үзсэн. 6-9 дүгээр ангийн нийтдээ 249820 хүүхэд байна. Энийг нь тарифыг нь 5500 төгрөгөөр энэ түүхий эдийн зардал нь л шүү дээ. Ингээд тооцоод үзэхэд 2026 онд шаардлагатай санхүүжилт нь 240.5 тэрбум төгрөг болж байгаа. Тэгээд дотуур байранд амьдарч байгаа нийтдээ 42798 хүүхэд байна. Өнөөдөр энийг нь ахлахыг нь 6300-гаар үдийн хоолных нь тарифыг нь, дунд, багыг 6 мянган төгрөгөөр тус тус тооцоод ингээд олгож байгаа. Тэгээд энэ дээр нийтдээ ингээд нэмэгдээд явах юм бол бид 9300, 9000 гэсэн ийм байдлаар нэмэх юм бол 111 тэрбум 600 сая төгрөг шаардлагатай гэж ингэж харж байгаа. Тэгэхээр өмнөх оныхоо төсвөөс 46.4 хувиар өснө. Ийм тооцоо хийгдсэн байгаа.

Зүгээр энэ дээр бас хэд хэдэн бас юу байхад. Ноднин жил энэ Улаанбаатар хотын цэцэрлэгүүдэд 1000 төгрөгөөр цэцэрлэгийн хоолных нь зардлыг нэмж эцэг, эхээс хурааж ингэж эхэлсэн. Үүгээр хүүхдүүдийн хоол тэжээлийн байдал эрс сайжирсан. Түүний зэрэгцээ Боловсролын ерөнхий хуульд байгаа энэ эцэг, эх нь хуваалцдаг энэ зарчим ингэж амилж эхэлсэн байгаа юм. Эндээс олон эерэг сайн үр дүн гарсан. Цаашдаа бид зөвхөн төр талаасаа бүгдийг даагаад явах нь зүйтэй юу үгүй юу гэдгийг бас асуулт болгож тавих ёстой гэж ингэж харж байгаа.

Бага ангийн хүүхдийн ялангуяа 6 настай хүүхдийн энэ элсэлтийн тухайд энэ таны хэлээд байгаа үнэн. Хөдөө орон нутагт үнэхээрийн нийгмийн ийм айхтар ийм асуудал болж байгаа. Тэгэхээр бид багийн бага сургууль гэсэн концепцыг гаргаж ирээд энэ багийн бага сургууль дээрээ зөвхөн бага сургуульдаа хүүхдүүд эцэг эхээсээ дотуур байранд очиж сурахгүйгээр ингээд суралцах ийм боломжтой. Түүний зэрэгцээ боловсролын ерөнхий хууль дээр бас заалт бий. Хэрвээ шаардлагатай гэж үзэх юм бол зөвшөөрлөө аваад 7 наснаас бас оруулж болдог ийм заалт бий.

Тэгэхээр зэрэг ер нь цаашдаа бид энэ сүү хөтөлбөрийг үндэснийхээ аж ахуйн нэгжтэй хамтраад хэрэгжүүлэх өнөөдөр бол ингээд орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд бас өөрсдөө санаачлаад ингээд хийчихсэн. Зарим аймгууд, зарим дүүргүүдэд ингээд хийчихсэн сайн жишээ байгаа. Цаашдаа бид бас эцэг эхийн энэ оролцоог хангаад энэ хүүхдийн хоол, тэжээлийн нөхцөл байдлыг сайжруулах ийм зайлшгүй шаардлагатай гэж харж байгаа. Ялангуяа ингэж сайжирч ирснээрээ юу болдог вэ гэхээрээ зэрэг дундаж нурууны өндөр нь өсдөг, өсгөлүүн болдог, эрүүл болдог, сайн суралцдаг, сурлагын чанар дээшилдэг ийм эерэг.../минут дуусав./

Б.Пүрэвдорж: Тодруулчихсан дахиад болно доо. Би тэгээд бүр нэлээн урт хариулуулж өглөө шүү дээ. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Ерөнхий сайд болон шинэ Засгийн газрын бүрэлдэхүүнд нь. үйл ажиллагаанд нь амжилт хүсье. 2026 оны төлөвлөгөөг хэвээр нь үргэлжлүүлэх ийм бас төлөвлөгөөтэй ажиллаж байгаа гээд Ерөнхий сайд бас үгэндээ дурдсан. 26 оны төлөвлөгөөнд хөдөө аж ахуйн салбарын тулгуур бааз түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэх чухал хөтөлбөр болох Шинэ хоршоо хөдөлгөөний талаар 1 ч үг, үсэг ороогүй. Салбарын сайд нь өмнөх санал

хураалтаар төлөвлөгөө танилцуулахад өөрөө дэмжээгүй. Ийм эсрэг санал өгсөн байгаа. Одоо сайд үргэлжлээд ажиллах юм байна. Засгийн газрын тогтоолтой энэ Шинэ хоршоо хөдөлгөөний 5 жилийн хөтөлбөр нийт хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 5-ны 1 нь гараад 22 мянган малчин 6200 орчим хоршоод хамрагдаад үр дүнгээ хүртээд явж байгаа. Шинэ засаг дээр энэ хөтөлбөрийг ямар бүтэц хэрэгжүүлэх вэ гэдэг нь тодорхойгүй байна. Хуучин Үндэсний хороо Шадар сайд Амарсайхан даргаар энэ Шинэ хоршоо хөдөлгөөн салбар дундын уялдааг хангах Үндэсний хороо байгуулагдаад ажиллаж байсан. Энэ бүтэц хэвээрээ үргэлжлэх үү? Хоршоо хаана удирдагдах вэ? Үндсэндээ хоршооны үндсэн зорилго энэ ЖДҮ-лэгчдийг нэгдэж, зах зээлийн хэлэлцээр хийх, энэ чадварыг нь сайжруулах бас явдал байгаа юм. Хоршоо дэмжигдэхгүй тохиолдолд энэ хүмүүс бүтээгдэхүүнээ дамжлага багатайгаар, ашиг багатайгаар борлуулах эсвэл бүүр борлуулж чадахгүй байх ийм эрсдэл үүсэж байгаа юм. Энэ хоршооны үйл ажиллагаа ганцхан хөдөө, аж ахуйн салбар бус сум багийн төвлөрсөн. энэ хөгжлийг анхаарч байгаа.

Тэгэхээр яам өөрөө бодлогоороо дэмжихгүй бол сум багийн төвлөрсөн хөгжил дэмжигдэхгүй гэсэн үг. Тэр хоршоо нь зөвхөн эдийн засгийн нэгж биш орон нутгийн ажил эрхлэлт, санхүү, сургалт, нийгмийн идэвхийг өөрөө урамшуулдаг бүтэц гэж харж байгаа. Хэрэв хоршоо байхгүй байх юм бол сум, орон нутгийн хөгжлийн түлхүүр өөрөө алдагдана. Орон нутагт энэ орлогын найдвартай эх үүсвэр байхгүй бол залуучууд хотоо зорих, ядуурал нэмэгдэх, нийгмийн асуудлууд хурцдах нөхцөл байдал бүрдэнэ гэж харж байна. Тэгэхээр энэ хөдөө, аж ахуйн салбарын энэ хариуцлагагүй байдал ч гэсэн нэмэгдэнэ. Хоршоогоор дамжин хэрэгжих ёстой энэ хяналт, стандартад нийцүүлэлт байхгүй. Хүнсний аюулгүй байдал, энэ экологийн тэнцвэр алдагдах ийм эрсдэл байгаа. Олон улсын жишиг Канад, Япон зэрэг улсуудад хоршоо нь зөвхөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх биш нийгмийн тогтвортой байдал, хүнсний баталгаат байдал, хүнсний аюулгүй байдал, тогтвортой хөдөө орон нутгийн хөгжлийг чухал багана гэж харж байгаа. Тэгэхлээр энэ малчдын амьжиргааг дэмжсэн хөтөлбөрийг сайд нь дэмжихгүй

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

М.Мандхай: Тэгэхээр энэ сайд нь дэмжихгүй байгааг дэмжиж өгөөч ээ гэж Ерөнхий сайд болон энэ Шадар сайд Амарсайхан 2-оос чин сэтгэлээсээ хүсэж байна.

Наранбаяр сайдаас бас юм асуух гэсэн юм. Та ингээд ажлаа үргэлжлүүлээд ажиллах юм байна. Шинэ хоршоог хөгжүүлэх зорилготой хоршоодын гишүүдийг чадавхжуулах, хоршооны менежер бэлтгэх, түргэвчилсэн болон зэрэг олгох сургалтуудыг ХААИС дээр хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаж байгаа. Энэ ажил хэрэгжих үү, энэ ажил үргэлжлэх үү? Тэтгэлэгт хөтөлбөртэй уях төлөвлөгөө бас ярьж байсан. Энэ ажил бас үргэлжлээд ажил хэрэг болох уу гэдгийг асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Амарсайхан гишүүн хариулт өгье.

С.Амарсайхан: Өнөөдрийн байдлаар Монгол Улсад нийтдээ 195 мянган малчин өрх байна. Шинэ хоршоо хөдөлгөөн анх үүсгэн байгуулагдсанаас хойш нийтдээ бараг 100 мянган хоршооны гишүүд бүртгэгдсэн, нийтдээ 95118 малчин

хоршоонд гишүүнээр үндсэндээ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Нийт 6885 хоршоо, гишүүн 23581 малчин өрх үйл ажиллагаа салбар бүрд хөдөө, аж ахуйн салбарт явуулж нийтдээ 798 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон. Тэгээд Шинэ хоршооны хөдөлгөөн бол үндсэндээ энэ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарсан, гарч байгаа эрсдэл, гамшгийн хохирлыг бууруулах үндэсний ондоошил, нүүдлийн мал аж ахуйгаа хадгалж цааш нь орчин үеийн мал аж ахуйн салбарын шинэчлэлтэй хослуулж хөгжүүлэх үндэсний ийм чухал бодлого шийдвэр Улсын Их Хурал Засгийн газраар хөтөлбөр нь батлагдсан.

Цаашдаа энэ Шинэ хоршоо хөдөлгөөнийг бол үндэсний хэмжээнд дундын хоршоо болгож бүсчилж 21 аймаг, 330 сумын дунд бүсчилсэн маягаар явуулах. Тэгээд дундын болон үндэсний хоршоог түүхий эд, нийлүүлэлт, ханган нийлүүлэлт, тээвэр ложистик, тэгээд зах зээлийн сувгуудыг нь хүртэл нээж өгөх, экспортын бараа, бүтээгдэхүүнүүдийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх чиглэлүүд дээр бид илүү идэвхжүүлж ажиллана гэж төлөвлөж байгаа. Үндэсний хороо үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж өнөөдрийн байдлаар нийтдээ Зээлийн батлан даалтын сан улсын хэмжээнд нийт 300 тэрбум гаруй төгрөгийн зээлд батлан даалт гаргасан. Татварын ерөнхий газрын албан мэдээллээр 2024 оны эцэс гэхэд 1490 хоршоо татварын тайлангаа ирүүлсэн. 591.3 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж байгаа. 745.5 сая төгрөгийн эргэн төлөлттэй ингээд маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Бүтцийн талаар тодруулж нэмж хариулъя. Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Ер нь бол энэ бүтэц, зохион байгуулалтын талаар малчид хоршоологчдын өөрсдийнх нь үндсэн идэвх санаачилга маш идэвхтэй байгаа. Өнөөдрийн байдлаар ДНБ-ий 10 хувийг үйлдвэрлэж нийт ажиллах хүчний 25 хувийг бүрдүүлж байгаа уламжлалт мал аж ахуйн салбар өөрөө орчин үеийн ногоон эдийн засаг байгаль орчинд ээлтэй ийм чиглэлээр бүтэц зохион байгуулалтыг илүү цааш нь сайжруулна. Үндэсний хороо үйл ажиллагаагаа явуулж байгаа үндэсний хороо үндсэндээ бол аймаг орон нутгийн удирдлагууд цаашлаад бол Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бүтэц, үйл ажиллагаатай илүү уялдаж энэ Шинэ хоршоо хөдөлгөөнийг гадаад, дотоодын хөнгөлөлттэй зээл, тусламж, мөн зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт төсвийн эх үүсвэр гэхээсээ илүүтэй цаашлаад бизнес зах зээлийнх нь зарчмаар бүтэц, зохион байгуулалтыг нь илүү өргөжүүлж явуулах ийм төлөвлөгөөтэй байгаа.

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Би ингэж асуусан юм. Шинэ хоршоо хөдөлгөөний хөдөлгөөнтэй холбоотой 1 ч үг, үсэг төсвийн асуудал 26 оны төлөвлөгөөнд орж ирээгүй байхгүй юу. Тэгэхлээр энэ Шадар сайд Амарсайханы ярьж байгаа энэ асуудал чинь аль бүтэц нэгж дээр нэгдүгээрт, хэрэгжих юм? Хоёрдугаарт 26 оны төл төлөвлөгөөнд дахиж тодотгол болж орж ирэх юм уу? Энэ ерөөсөө төлөвлөгөөнд тусгагдаагүй учраас би 42 дугаар захирамжаар энэ Хөдөө аж ахуйн үйлдвэрчдийг дэмждэг, Шинэ хоршоог эрчимжүүлэх ажлын хэсэг ахалдаг хүний хувьд санаа зовж асууж байгаа юм. Энийг тодорхой болгож өгөөч ээ л гэдэг асуулт тавиад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Амарсайхан гишүүн хариулт өгье.

С.Амарсайхан: Монгол Улсын Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр Шинэ хоршооны үйл ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлнэ, эрчимжүүлнэ гэж маш тодорхой заасан нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Үндэсний хорооны зардал төлөвлөгөө, төсвийн тодотгол 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй бас уялдуулж тусгагдах ёстой байсан боловч бас төсвийн үеэр тодорхой шалтгааны улмаас орхигдсон байсан тул бас Засгийн газрын нөөц хөрөнгөөс энэ Үндэсний хорооны үйл ажиллагааны зардал гарч өнөөдрийн байдлаар явж байгаа. 26 оноос эхлээд улсын төсөвт энэ Үндэсний хорооны үйл ажиллагаа, энэ шинэ хоршооны хөтөлбөрийн санхүүжилтийг тусгаж цааш нь уялдуулж явах зайлшгүй шаардлага байгаа гэдэг дээр энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахад яригдсан. Тэгээд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 95 дугаар тогтоолоор Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдаа холбоог хангах, үйл ажиллагаа төсөв хөтөлбөртэйгөө цааш нь 26 оны төсөвт тус.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

С.Амарсайхан: Ер нь салбар дундын зохицуулалт бас яг эрчим хүчтэй адилхан бас ийм давхардал, хийдэл, зөрчлийн улмаас ийм ойлгомжгүй байдал үүсэж байгаа жишээнүүд бий. Тэгэхдээ Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгох зээлийн санхүүжилтийн татаас нь 105.3 тэрбум төгрөг 2025 оны улсын төсөвт суусан. 730 орчим тэрбум төгрөгийн зээл олгочихсон 21.3 мянган малчинд зээл олгочихсон гэсэн 23.1 мянган малчинд энэ хөнгөлөлттэй зээл олгочихсон гэсэн статистиктай зээлээр дэмжиж байгаа Шинэ хоршоо хөдөлгөөн өрнөж байгаа. Энийг зөвхөн зээлийн хүрээнд төдийгүй энэ үндэсний хөдөлгөөн болгож байж таны хэлээд байгаа тэр түүхий эд бэлтгэлийн сүлжээ цогц хөдөө, аж ахуйн салбартайгаа уялдаж байж цогц хөдөлгөөн болгож хөгжих шаардлагатай гэж үзэж байна. Тэгээд энд миний ойлгож байгаагаар Шадар сайдын ажлын хүрээнд Үндэсний хороо ажиллаж байгаа тийм ээ тийм. Шадар сайдын хүрээнд Үндэсний хороо ажиллаж байгаа юм байна лээ. Энд учраас Хөдөө аж ахуйн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултад.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр 2 асуулт байна. Тэгэхээр Шинэ хоршооны менежер Шинэ хоршоог дэмжих энэ сургалт явж байгаа юу гэвэл энэ ХААИС дээр нээгдэж байгаа. Энэ тантай ярилцаад тэгээд тэрний дараа энэ өөрөө ажил хэрэг болоод явсан. Би бас энэ Шинэ хоршоо хөдөлгөөний бас энэ удирдах хүмүүстэй уулзаад энэ сургалтыг илүү оновчтой, үр дүнтэй болгох талаар нь санал солилцоод энийгээ ХААИС-ийн захирал Баасансүхэд хэлээд энэ сургалтыг улам малчиндаа ойр, хоршоондоо ойр ийм байдлаар зохион байгуулах, оновчтой зохион байгуулах талаар хамтран ажиллаж байгаа.

Мөн малчин өрхийн гишүүний боловсрол сургалтыг дэмжих арга хэмжээ гээд бас энэ Боловсролын яамнаас төсвийг нь гаргаад энэ жилдээ 250 малчин өрхийг дэмжих ийм сургалтыг хийх ийм зүйлийг шийдвэрлэсэн. Тэтгэлэгт хөтөлбөрийн тухайд Боловсролын зээлийн сангийн журам шинэчлэгдээд Малчны тухай хуулийн 4.2.5 дээр байгаа тэр заалт хэрэгжиж эхэлнэ. Өөрөөр хэлбэл, малчнаар 10 жил тасралтгүй ажилласан ийм өрхийн хүүхдийг төрийн өмчийн

сургуульд яг мал аж ахуй, бэлчээр судлалын чиглэлээр, тэжээлийн чиглэлээр.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: Мал аж ахуй, бэлчээр тэжээлийн чиглэлээр үнэ төлбөргүй сургах энэ бодлого хэрэгжээд явна. Энэ Зээлийн сангаар саяын 1 сард батлагдсан. Энэ хууль нь өөрөө 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж байгаа. Сая энэ 5 сард билүү Засгийн газрын тогтоолоор Зээлийн сангийн журам шинэчлэгдэж гарсан. Тэгэхээрээ тэрүүгээрээ энэ бүрэн хэрэгжих ийм боломжтой болсон байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя. Үг хэлье.

О.Номинчимэг: Ерөнхий сайд болон түүний кабинетын бүрэлдэхүүнд орж байгаа сайд нартаа ажлын амжилт хүсье. Ер нь ард иргэд хэн сайд байх энэ их чухал биш. Гол нь төрийн ажил хурдан шуурхай явж иргэдэд өдөр тутмын амьдралд нь өөрчлөлт, үр дүн гаргаасай л гэж хүсэж байгаа. Би энэ өнөөдөр бол 1 л зүйлийг бас их онцолж захиж хэлмээр байгаа. Түрүүн хэн гишүүн хэлчхэв ээ Пүрэвдорж гишүүн хэлчхэв үү дээ эдийн засгийн энэ нөхцөл байдалд энэ худалдааны олон улсын гадаад худалдаагаа чөлөөлөх хэрэгтэй шүү гээд. Тэгээд энэ дээр бид нарын хамгийн эхэнд хийж байгаа энэ хэлэлцээр бол энэ Евроазийн худалдааны түр хэлэлцээр байгаа. Энэ хэлэлцээрийг хэн нэгний махны үйлдвэр жоохон ашигтай ажиллахын төлөө дотоодын хүнс үйлдвэрлэгчдээ нурааж унагаах хэмжээнд ийм хэлэлцээр биш байгаасай гэж хүсэж байгаа.

Өмнө ч гэсэн байр сууриа илэрхийлж байсан. Энэ хэлэлцээр дээр янжуур тамхины, тамхин бүтээгдэхүүний гаалийн албан татварыг тэглэхээр орж ирсэн байсан. Энэ хэлэлцээрийг хийхдээ Эдийн засаг, хөгжлийн яам маш сэтгэлгүй хандсан. Гантөмөр сайд сэтгэлгүй хандсан. Хүнс, хөдөө аж ахуйн яам ч гэсэн энэ дээр маш сэтгэлгүй хандсан. Ингээд зөвшилцөхөөр Улсын Их Хуралд орж ирээд Байнгын хороод дээр энийг яриад хамгийн сүүлд Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооноос энэ тамхиныхаа асуудлыг анхаараач ээ гээд замичантай санал, дүгнэлтийг гаргасан. Энэний дараа яаж байна. гээд ингээд харахаар Эдийн засаг, хөгжлийн яам Гантөмөр сайдаас цаад тал руугаа маш тийм өөх ч биш булчирхай ч биш бичиг явсан байна лээ. Одоо яана нэг ийм юм яриад байна.

Гэхдээ авсан ч болно, авахгүй ч болно ухааны юм. Би тэр бичгийг үнэхээр хараад Гантөмөр сайд сэтгэлгүй ажиллаж байна даа л гэж бодсон. Тэгээд Гантөмөр сайдтай ярихаар ёстой уучлаарай энийг үнэхээр анхаарч чадаагүй, анхааралгүй явчихжээ уучлаарай гэж байгаа юм. Нэг сайдын уучлаагаар Монголын иргэдийн хавдрыг эмчлэхгүй шүү. Нэг сайдын уучлаарай гэдэг үгээр Монголын өсвөр үе, ирээдүйн эрүүл мэндийг хамгаалж чадахгүй шүү. Тэгээд энэ ер нь яагаад ийм хэлцэл явчхав гэдгийг судалж үзсэн.

Тэгтэл энэ хэлэлцээр гэдэг юмыг чинь олон улсын хэлэлцээрийг хийгээд ерөнхий зургаа гаргачхаад Улсын Их Хуралтайгаа зөвшилцөх гэдэг процесс явдаг. Ингээд Улсын Их Хурлаасаа санал, дүгнэлтээ аваад дахин сайжруулах юм байвал сайжруулаад, гэрээгээ хийгээд, соёрхон батлах гэдэг процесс руу явдаг. Гэтэл энэ

хэлэлцээр чинь Улсын Их Хуралд зөвшилцөхөөр оруулахаасаа өмнө нөгөө талтайгаа эцсийн болзлоо гэдэг ийм юмаа хэлчихсэн юм байна лээ. Нөгөө тал нь аль хэдийн юмаа эцэслэчихсэн шүү дээ та нар юу гээд байгаа юм бэ л гэдэг юм явж байна лээ. Одоо олон улсын гадаад мэдээллээр 6 сарын 26-нд Минскд энэ хэлэлцээрийг Монгол Улс гарын үсэг зурах гэж байна гэдэг мэдээлэл явж байгаа. Цаг нь маш их тулчихсан байгаа.

Тэгэхээр би энэ дээр Эдийн засгийн хөгжлийн яам, шинэ сайд, Шадар сайд, Учрал сайддаа маш их захиж хэлмээр байгаа. Учрал сайд өмнөх гадаад хэлэлцээр олон хөрөнгө оруулалтын энэ хэлэлцээрүүдээр маш чамбай ажилласан маш туршлагатай энэ багуудыг авч ажилласан ийм туршлагатай хүн. Тэгэхээр та энэ алдааг засаж энэ асуудал дээр анхааралтай ажиллаж, энийгээ засаж, залруулж бас орж ирэх тал дээр гарын үсэг та зурах тал дээр анхаарч ажиллаарай.

Тэгэхгүй бол энэ чигээрээ тамхиныхаа гаалийн албан татварыг хасахгүйгээр орж ирэх юм бол энэ хэлэлцээр Улсын Их Хурал дээр соёрхон батлагдах шат руугаа орж чадахгүй шүү. Ингэж ирээдүйгээ хорлосон 3 жилийн хугацаатай ч бай, энийгээ ийм үр дүн гарахаар хэлэлцээрийг парламент хүлээн зөвшөөрөхгүй байгаа шүү гэдгийг бас сануулаад сайд нартаа энэ дээр бас анхаарч ажиллаасай гэсэн энэ хүсэлт захиасыг хэлж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд шинээр томилогдож байгаа Засгийн газартаа амжилт хүсье. Тэгэхээр миний зүгээс Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд болоод Байгаль орчин, уур амьсгалын хөгжлийн сайд нарт яг 2 салбар дээр нь байгаа 2 чухал хуулийн төслийн ийм агуулгаар хэдэн үг дайя гэж бодсон юм.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Дамдинням танд хандаад энэ Ашигт малтмалын тухай хуультай холбоотой асуудлыг тодруулаад чуулганы индэр дээрээс хэдэн тоо, баримт хэлэхийг хүслээ. Тэгээд өмнөх засгийн үед орж ирэх байх гээд нэлээн хүлээлттэй байсан Эрдэс баялгийн салбар тэр чигтээ Ашигт малтмалын хуулийг хүлээж байгаа. Яагаад хүлээж байгаа юм бэ гэхээр одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль 2006 онд шинэчлэн найруулагдсан. Үүнээс хойш бусад хуулийг дагасан байдлаар 350 гаруй давсан өөрчлөлтийг авчихсан. Тэгээд анхны үзэл баримтлалаа ерөөсөө агуулгад нь хүрэхгүй ийм хууль аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт хэрэгжиж байгаа. Тэгээд өнгөрсөн өмнөх засгийн үед хэрвээ ороод ирчихсэн байсан бол өнөөдөр бид нар хэлэлцээд явах байлаа. Гэхдээ та өөрөө яг мэргэжлийн салбарын хүн учраас салбартай танилцах тэгээд дасах тиймэрхүү зүйлүүд байхгүй шууд ажил руугаа ороод явбал хөндлөнгөөс ч гэсэн их ажиж байсан байх. Тэгэхээр энэ Ашигт малтмалын тухай хуулийг заавал сануулаад хэлэх хэрэгтэй байгаа юм.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатар танд энэ устай холбоотой хуулиуд дээр нэлээн сайн анхаарал хандуулах ёстой байгааг анхааруулж хэлэхийг хүссэн юм. Та тэгээд эргээгээд уулзах шаардлагатай угаасаа Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Ажлын хэсгийг миний бие ахалж байгаа учраас маргааш ажлын хэсгийн хурлаар бас ерөнхий тайлан боогдох гэж байгаа учраас дүгнэлтүүдийг танд хэлье.

Устай холбоотой 4 үндсэн хууль, том хууль байгаа. Энэ хуулиудад давхардал, хийдлийн судалгааг энэ ажлын хэсэг хийсэн байгаа. Тэгээд хуулиуд 2012 оноос хойш огт хөндөгдөөгүй жижиг тийм засварууд орсон ийм байдалтай байна. Тэгээд та мэдэж байгаа байх өнөөдөр усны асуудлуудыг гишүүд хөндөж ярьж байгаа. Та ч нэлээн төслүүдээ судалсан гэж хариулж байна лээ? Энэ олзуурхууштай хэсэг. Тэгэхдээ хууль, эрх зүйн орчин нь хангалттай сайн байж байж энэ цаашаа явах ёстой.

Тэгэхээр газрын доорх усны судалгааг та заавал анхаараад төсөвтөө нэлээн сайн тусгаж орж ирүүлэх ийм шаардлагатай байгаа. Учрыг нь зүгээр тоон баримтаар хэлэх юм бол Монгол Улсын нутаг дэвсгэрийг 100 хувь гэж үзэх юм бол газрын доор бид нар устай юм уу, үгүй юм уу гэдгийг нь ер нь 17 хувьд нь л мэдэж байгаа юм. Бусад газраа ерөөсөө судалгаа хийгээгүй гэсэн үг. Тэгэхээр энэ дээр та анхаараад цаашаа ажиллавал их сайн байх болно. Тэгээд хамтарч ажиллахад мэдээж усны ажлын хэсэгт ажилласан гишүүд миний бие бас ажиллахад бэлэн гэдгээ илэрхийлье.

Тэгээд Дамдинням гишүүн салбарын хүн Ашигт малтмалын тухай хуулийг мэдээж хөндлөнгөөс харж байсан байх. Ер нь та энэ хуультай холбоотойгоор энэ ямар ажлуудыг хийж хэрэгжүүлье гэж ер нь төлөвлөж байгаа юм болоо? Тэр талаас танаас хариулт аваад дахин асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Дамдинням гишүүн хариулт өгье.

Г.Дамдинням: Уянга гишүүн манай энэ ялангуяа геологийн салбарын их том мэргэжилтэн. Энэ салбарт дэд сайдын түвшинд бас ажиллаж байсан, Геологийн төвд ажиллаж байсан ийм хүн ялт ч үгүй салбараа ингээд дэмжээд яриад явдаг.

Бид энэ уул уурхайг дэмжих парламентын лоббиг бүлэг гэж байгуулаад миний бие ахлаад ингээд бас ажиллаж байсан өмнөх парламентад. Манай Үүрийнтуяа гишүүн, Нанзадын Наранбаатар гишүүний ахалсан энэ Ашигт малтмалын хуулийн 20 гаруй гишүүн энэ хүнээс бүрдсэн Улсын Их Хурлын дарга Амарбаясгалангийн захирамжаар бий болсон ажлын хэсэг Эрдэс, баялгийн яамтайгаа яриад үндсэндээ манай Туваан сайдтай нэлээн цаг гаргаж суусан. Хуулийн төсөл бэлэн болсон гэж ойлгож байгаа. Эцсийн драфтыг нь хараагүй байна. Эцсийн драфтыг нь өөрөөр хэлбэл эцсийн бичигдчихсэн байгаа хэлбэрийг нь бол танилцаад уул, уурхайн салбарын парламент дахь лобби бүлгийн өөрөөр хэлбэл, энэ салбарын эрх зүйн орчны төлөө санаа зовж байгаа. Энэ салбар дээр хөрөнгө оруулалтыг татах ёстой энэ салбарын нийгмийн ойлголтыг сайжруулах чиглэлд хамтарч ажиллах, тогтвортой хариуцлагатай уурхайн чиглэлийг барьсан энэ өөрчлөлтийг хийх тал дээр хэдүүлээ бас цуг суугаад ойрын ирээдүйд ярих ийм бодолтой байна. Ашигт малтмалын хууль бол маш олон удаа өөрчлөлт орсон. Энэ миний нэр дэвшээд явж байгаа салбарт 2 том хуулийн орчин ер нь орж ирнэ дээ гэсэн ийм хүлээлттэй байна.

Нэгдүгээрт, Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга.

Хоёрдугаарт, энэ Биржийн тухай хууль гэсэн ийм 2 том хууль удахгүй орж ирэх ёстой. Тэгэхээр өөрийн биеэр танилцаж, мөн бас энэ ажлын хэсгийн гишүүдтэйгээ дахин сууж байгаад энийг оруулж ирнэ гэсэн ийм бодолтой байгаагаа илэрхийлье. Та бүхэн маань бас хамтдаа ажиллана гэдэгт итгэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Бямбацогт сайдаас заавал асуулт асуух хэрэгтэй байгаа юм. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт “Эрдэнэс Тавантолгой” компани үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд явж байгаа. Тэгээд өмнөх засгийн бүтэцтэй адилаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Эрдэнэс Монголын үйл ажиллагааг хариуцах байх гэж бодож байгаагийн хүрээнд асууж байгаа юм.

Ханбогд сум гээд Оюутолгойн үйл ажиллагаагаа явуулж байгаа сум байгаа. Тэнд яг тэр Оюутолгойн үйл ажиллагаанаас Ханбогдын хөгжлийн хурдасгуур гээд сан. Яг Ханбогдын үйл ажиллагаа, хөгжилд зориулагдаад үйл ажиллагаа явуулж байна. “Говийн оюу” сан гээд 10 жил болж байгаа сан байна. Эрдэнэс Тавантолгойд маань болохоор аягүй том компани мөртөө орон нутгийн яг тийм газар байхгүй орон нутгийн асуудал хариуцсан. Бүүр ийм сангийн асуудал ч бас байдаггүй. Тэгэхээр энэ дээр та ер нь ямар арга хэмжээ авъя гэж бодож байна вэ? Цогтцэций сумыг хөгжүүлэх хэрэгтэй байна. Тэгээд ер нь Эрдэнэс Тавантолгойг тэр чигт нь Цогтцэций рүү нүүлгэх нь зөв гэж боддог. Эрдэнэттэй адилхан.

Д.Амарбаясгалан: Бямбацогт гишүүн хариулт өгье.

С.Бямбацогт: Байгалийн баялгийн өгөөжийг Монгол Улсын иргэн болгон хүртэх эрхтэй Үндсэн хуулиар заасан. Энэ эрхийг бас хэрэгжүүлэх тал дээр Үндэсний баялгийн сангийн хууль баталсан. Энэ баялагтаа эзэн байх асуудлыг бол өмнөх Засгийн газар явуулж байсан энэ Засгийн газраас Ерөнхий сайд Шадар Занданшатар сайд бас үргэлжлүүлж явуулна гэж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бид бас бодлогыг авч үзнэ.

Ер нь юу гэдэг юм зарим уурхай дээр сан байгуулаад өгөөжийг нь бас тодорхой хүртээд орон нутгийн иргэддээ сэтгэл хангалуун байгаад ажиллаж болдог. Зарим газар нь ерөөсөө эзэнгүй юм шиг ерөөсөө л байгалийн баялаг нь ухаад алга болчихдог, ард иргэд нь өгөөж байдаггүй үүнээсээ болоод иргэд нь бухимддаг. Иймэрхүү бас тэгш бус ялгавартай тухайн компанийн удирдлагууд, иргэдийн хоорондын харилцааны ойлголцлоос хамаардаг. Энийг л бид нар жигдлэх ёстой. Хаана хаанаа хүн болгон сэтгэл хангалуун бай.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

М.Ганхүлэг: Монгол Улсын Ерөнхий сайд маань өөрийн бүрэн эрхийн дагуу комбинатын бүрэлдэхүүнээ бас танилцуулж байна. Хүндэтгэж байна. Залуу гишүүдийн хувьд бас тодорхой бас зарчмын бас шаардлагуудыг бас тавьсан. Тэгээд энэ бас битгий бас зөвхөн асуудлыг тулгадаг байгаасай, үг дуугүй бас тодорхой асуудлыг бас шууд ингээд дагаад явна гэхээсээ илүүтэй зөвшилцөл, ойлголцол, илүү бас нийгмийн хүсэмжлэлийг бас ойлгосон хамтын шийдлүүдийг бас гаргадаг байгаасай гэдэг ийм алхам байсан гэдгийг бас би бас хэлье. Засгийн

газрын ажил үйл ажиллагааг цаашдаа ч тодорхой асуудлууд дээр нь зарчмын шаардлагуудаа тавиад агуулгаар нь дэмжээд ажиллаад явна гэдгээ бас илэрхийлье. Амжилт хүсье.

Ерөнхий сайдын маань хувьд бас улс төрийн гараа Хүнс, хөдөө аж ахуйн салбараас эхэлсэн та. Дэд сайдаар бас ажиллаж эхэлсэн. Энэ утгаараа бас би зарим бас саяын асуудлуудыг бас нэлээн нухацтай бас авч үзээсэй. Ялангуяа хөдөө, аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа эдгээр томоохон хөтөлбөрүүдийн ямар ямар хөтөлбөрүүд нь үргэлжлэх, аль хэсгийг нь эс үгүй бол жоохон өөрчлөх ийм ерөнхий агуулгаараа тийм тодорхой ийм бодлого байгаа юу гэдгийг бас би ерөнхий агуулгаар нь асууя.

Хоёрт нь энэ саяын яриад байгаа энэ Үндэсний хороотой холбогдолтой асуудлыг татан буулгана гэхээр Шинэ хоршоо хөдөлгөөнийг хаана хариуцах вэ гэдэг ийм асуудал тулгарч байгаа юм. Тийм учраас та бас Засгийн газрын бүрэлдэхүүнээрээ энэ асуудал дээр нэлээн нухацтай бас хандаж энэ ажлыг өргөжүүлэх асуудал дээр бас анхаараасай гэж ингэж хэлмээр байгаа юм. Монгол Улсын 3 малчин тутмын 1 нь өнгөрсөн 1 жилийн хугацаанд хоршооны гишүүн болчихсон байгаа. Яг өнөөдрийн байдлаар 10 малчин тутмын 1 нь зээлээ авсан байгаа. Үлдсэн малчид нь дараагийн 5 жилдээ багтаад энэ тодорхой боломжийг ашиглаад энэ уур амьсгалын өөрчлөлт мал аж ахуйн үйлдвэрлэлээ сайжруулах энэ боломжийг бүрэн дүүрэн эдлэх боломжийг та Засгийн газрын тэргүүний хувьд олгох уу гэдэг дээр бас яг ажил эхэлж байгаа энэ цаг үед бас тодорхой байр сууриа илэрхийлчхээсэй гэдэг ийм асуудал байгаа юм. Яг аль бүтэц маань хариуцаж ажиллах вэ гэдгийг бас асуугаад байгаа юм.

Хоёр дахь нь экспортыг дэмжих чиглэл дээрээ яг одоо тодорхой. бас үр дүнгүүд гаргах нэгж, бүтцээ бас хаанаа байлгавал зүгээр вэ? Ер нь хөдөө аж ахуйн энэ өртгийн сүлжээний анхан болон яг энэ экспорт буюу хамгийн сүүлийн энэ шатан дээрээ л төр тодорхой хэмжээнд оролцоод бусад шатад нь хувийн хэвшлийнхэн, малчид, тариаланчид, үйлдвэрлэгч нар өөрсдөө бас бие даагаад явах боломжийг нь олгох нь зөв юм болов уу гэсэн ийм санаа, бодолтой байгаа юм.

Өнөөдөр олон улсуудтай бид бүхэн протоколууд байгуулж байна, хэлэлцээрүүд хийж байна. Яг үүний хойноос байнгын бас харилцаа холбоо тогтоогоод хойноос нь ажиллаж байгаа энэ нэгж маань сул байгаад байгаа юм. Нэг хэсэг Сангийн яаман дээр, Гадаад харилцааны яаман дээр гаалийн асуу.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Нэмэлт 1 минут уу? Ганхүлэг гишүүнд нэмэлт 1 минут өгье.

М.Ганхүлэг: ... гээд нэлээн салангид ийм бодлогууд бас яваад байгаа юм. Тэгэхээр та Засгийн газрын бас бүтэц, бүрэлдэхүүний асуудал дээрээ энэ Шинэ хоршоотой холбогдолтой асуудлыг хаанаа байрлуулах вэ? Мөн дээрээс нь экспортын энэхүү бас нэгжийг илүү өргөн цар хүрээнд ажиллах боломжийг нь олгож байж бусад салбаруудаа дэмжих энэ бодлогууд бас явах юм болов уу даа гэсэн ийм саналтай бас байгаа юм. Тэгэхээр ерөнхий агуулгаараа Хөдөө аж ахуйн дэд сайдаас ажлын гараагаа эхэлж байсан хүний хувьд саяын яриад байгаа энэ

хөтөлбөрүүдийг, мөн хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа энэ асуудлууд дээр та өөрийн байр сууриа бас тодорхой илэрхийлээд бас энэ иргэд, малчдадаа бас бас тодорхой ойлголтыг бас өгөөд эхлэх нь зөв болов уу гэж бодож байна.

Мөн аягүй их давхардаж байгаа зүйл бол Мөнххолбоо гэдэг холбоо, Шинэ хоршоо хөдөлгөөн гэж хөдөлгөөн, энэ байгаль хамгааллын нөхөрлөл гээд олон энэ нэгжүүдэд бас малчдыг бид бүхэн хуваагаад бас байгаа. Тэгэхээр эдгээр бас бүтцүүдийг нэгтгэн зохион байгуулахаас авхуулаад реформын.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ хоршооны асуудал Япон, Солонгос зэрэг оронд энэ дэд бүтцийн түүхий эдийн сүлжээний гол механизм нь хоршоод байж, хоршоодыг орон нутгийн банкаар, хөдөө аж ахуйн банкаар дамжуулж зээлжүүлж, хөдөлмөрийн хуваарилалтыг энэ зохион байгуулалтын хөдөлмөрийн хуваарилалтыг зах зээлд нэвтрүүлж, дундын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлж ийм хамтарч ашигладаг ийм сайн туршлагатай.

Тэгтэл одоо Шинэ хоршоо хөдөлгөөн тэгэхдээ хөдөөгийн хоршоодын дийлэнх нь хөдөө аж ахуйн чиглэлийн хоршоод л байгаа шүү дээ. Хэрвээ малчдын хоршоо тэгж байгаа бол энэ Хөдөө аж ахуйн яамтайгаа уялдахгүй уялдах ёстой. Шинэ хоршоо хөдөлгөөнийг 2026 оны төсөвт тусгахын тулд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэд тусгай бодлогын нэгж байгуулаад санхүүжилтийн шугам нээх бодлогын дэмжлэг үзүүлэх, тэр нь өөрөө нөгөө түүхий эд бэлтгэлийн ч чэйн кластерын системээр хоршоодыг үндэсний үйлдвэрлэлтэй холбох түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бий болгох, малчдыг хоршоонд сургах, дадлагажуулах, элсүүлэх энэ цогц бодлого ийм зохион байгуулалтын хувьд тэд хэрэгжүүлэх шаардлагатай.

Ийм ч учраас энэ Монгол мал 1, 2 хөтөлбөр Атрын 4 дүгээр хөтөлбөр ч тэр Цагаан алт, Хүнсний хувьсгал гээд энэ олон хөтөлбөр байгаа ба бүхний. Энэ олон хөтөлбөр хэрэглэж байгаа. Энэ хүнсний үйлдвэрлэл, экспорт, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих тэгээд орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих бас тулгуур бодлогод уялдах ёстой. Тийм учраас хөдөө, аж ахуйн экспортыг нэмж байж мал, уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгаа төрөлжүүлнэ солонгоруулна гэдэг чинь ерөөсөө л энэ. Ийм учраас тэр гадаад зах зээл Евроазийн зах зээлийг нээж байгаа ноос, ноолуур тэгээд л чацарганын гүн боловсруулалт ч байна. Ноос ноолууран бүтээгдэхүүн гэхэд Евроазийн зах зээл 12 тэрбум доллар гэж байл уу. Би алдаагүй бол энэ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр тооцоо судалгаа байж байгаа. Ингээд бид нар 2 тэрбум долларын мах, махан бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ноос ноолууран бүтээгдэхүүн 10, 20 хувьд нь гарахад л ийм бололцоо Евроазийн зах зээлд байгаа энэ зах зээлийг нь нээж өгч байна.

Тэгэхээр энэ хорио цээр, мал эмнэлэг, эрүүлжүүлэлт, монгол экспорт энэ цогц хөтөлбөрөө хэрэгжүүлж байж энэ хөдөө, аж ахуйн олон давхардсан хөдөлгөөнийг дэмжихийн тулд нэгдсэн дата бүртгэлийг бий болгох, цахимжуулах ийм маркетинг, тоног төхөөрөмж, цогц систем нэвтрүүлэх ийм бодлогын нэгтгэл хийхгүй бол тус тусдаа хөтөлбөрүүд ингээд яваад хоорондоо уялдахгүй бол зардал үр ашиггүй санхүүжигдэнэ. Бас багагүй мөнгө зарцуулж байгаа. Маш их

хөнгөлөлттэй зээл өгч байгаа. Энэ маань үр дүнтэй зах зээлдээ хүрч, эзэндээ очиж тэгээд бас эргэж төлөгддөг, хамгийн гол нь тэр төсөл үр дүнтэй хэрэгждэг байх нөхцөлийг зах зээлийн зарчим арга, механизмтайгаа уялдуулж хэрэгжихгүй бол одоогийн байдлаа үр ашгийг нь сайжруулах шаардлагатай л гэж бодож байгаа юм. Тийм учраас нэгдсэн тийм таск форс/ tax force/ байгуулж ажиллах хэрэгтэй. Энэ дээр хөдөө аж ахуйн чиглэлээр ажилладаг хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүд та бүхэн бас өөрсдөө бас санаачилгатай ажиллаж, яам дундын зохицуулалт, үндэсний хөдөлгөөн хороогоо яаж сайжруулах вэ гэдэг дээр та бүхний саналыг сонсож ажиллана гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэбат: Занданшатар Ерөнхий сайдын кабинетыг дэмжиж байна. Энэний өмнөх Засгийн газраас миний хамгийн түрүүнд асууж байсан асуулт энэ эдийн засгийн үр өгөөж айл гэрийн өрх хаалгаар яаж орох вэ? 1 хүнд ноогдох ДНБ 10 мянган долларт хүргэж болно. Тэр тэгэхдээ аль хэсэгт нь хэдэн хувиар яаж хүртээмжтэй очих вэ гэдэг тал дээр бодит үнэлгээ, дүгнэлтийг хийх ёстой.

Тийм учраас энэ тал дээр 10 мянган долларт хүргэх гэдэг энэ зорилтод ирэх 4 жил хүрнэ гэж энэ мөрийн хөтөлбөрт ерөнхийдөө тавьсан байж байгаа. Энэний хүртээмж гэдэг зүйл дээр нь анхаарахгүй бол болохгүй ээ гэдгийг захиж хэлмээр байна. Тэгэхээр энэ тал дээр ямархуу бодлого бодож байгаа вэ гэдгийг асуумаар байна. Мэдээж иргэд маань ирэх 3 жилийн хугацаанд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, өрхийн бодит орлого аж ахуйн нэгж байгууллагууд маань миний орлого яг яаж сайжирсан бэ, миний борлуулалт хэрхэн өссөн бэ гэдэг тал дээр бодитоор үнэлэлт, дүгнэлт өгнө.

Тийм учраас Засгийн газар маань энэ тал дээр түрүүний Жавхлан сайд хэлчхэв үү дээ жилдээ 6 хувиар л цалин, тэтгэврийг ингээд аргалаад яваад байна гэх юм бол энэ бодитоор нэмэгдүүлэх гэсэн үг биш. Инфляцыг зүгээр хаах хэмжээний л явна гэсэн үг.

Дээрээс нь 1 зүйл энэ иргэдийн цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн. энэ зээлүүдийг 50 хувьд нь хязгаарлаад санхүүгийнх нь тодорхой хэрэгцээнүүдийг нь хязгаарлалт тогтоосон валютын ханш өсөж байгаатай холбоотой хэрэглээний зээлүүдийн үлдэгдлүүд өсөж байгаатай холбоотой иймэрхүү арга хэмжээ авах нь юу вэ? Нөгөө талаар харахад ахмад гэдэг манайд эрт тэтгэвэрт гардаг 40, 44-тай, 50-тай хүмүүст орон сууцын зээл олгодоггүй юм байна. ЖДҮ-лэлийн зээл олгодоггүй юм байна. Харахад тэтгэврийн зээл мэт харагдаад байгаа боловч энэ чинь цаанаа бизнес хийдэг юм байна, аж ахуй эрхлэх гэж оролддог юм байна. Тийм учраас энэ боломжийг нь манай ЖДҮ-лэл, Хөдөө аж ахуйн яам, Гэр бүл, хөдөлмөрийн яам, бусад энэ бизнесийг дэмжих энэ юунууд дээр давхар судалж үзэх хэрэгтэй юм байна лээ шүү гэдгийг бас хэлмээр байна.

Ордуудаа авна гэдэг энэ гэрээ хэлэлцээрүүдийг бас богино хугацаанд хийх ёстой гэдгийг хэлмээр байна. Одоо авах, авахгүй, өгөх, өгөхгүй, тэрнийх энэнийх гэдэг байдал дээр энийг маш шуурхай Засгийн газар маань ажиллах болов уу гэж бодож байна.

Сайд нартаа нэг зүйлийг хийхэд бас хувийнхаа тойргийг маллаад бусдынхаа тойргийг битгий мартчихаарай. Энэ тал дээр Монгол Улс нэг л тойрог нэг л ард түмэн. Тийм учраас энэ тал дээр бас гишүүдтэйгээ илүү их сайн хамтарч ажиллаарай гэдгийг бас хэлмээр байна. Эрүүл мэндийн сайдаас хэлмээр байна. Өөрөө энэ салбарыг сайн мэдэх хүн хаана нь алдаа, оноо байгаагаа мэдэж байгаа. Гишүүд дунд ч гэсэн мэргэжлийн экспертүүд нэлээн судалгаа хийчихсэн энэ хүмүүс байж байгаа. Энэ зүйлээ хамтдаа хийгээд явах ёстой шүү гэдгийг бас хэлмээр байна. 1 минутаа аваад үргэлжлүүлээд хийчихье.

Нийгмийн даатгал, татварын реформ дээр уг нь нэлээн бас хүмүүс хүлээлт байгаад байдаг. Гэхдээ яг энэ эдийн засгийн нөхцөл байдал дээр тохируулаад бид нар аажмаар ийшээ шилжих шаардлага байна уу гэж харж байгаа. Тухайлбал, нийгмийн даатгалын реформ, шинэчлэл дээр ард иргэдийн хүлээгээд байгаа шиг огцом бууруулах, татвар ч гэсэн шууд 1 хувь болгох энэ тэр гээд нэлээн өндөр хүлээлттэй байгаад байсан. Тэгээд энэ тодорхой өмнө нь оруулж ирсэн энэ татварын шинэчлэлүүд нь хэвээрээ орж ирэх үү, арай өөрчлөгдөх үү? Энэ эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор гэдгийг хэлмээр байна.

Орон сууцын үнэ бас нэлээн үнэтэй байна. Энэ тал дээр яг ямар чухам ямар бодлого бодож байна? Аюулгүй байдлын асуудал дээр бас хэлмээр байна. Янз бүрийн осол аваар энд тэнд гарах юм. Нийгэм даяараа шуугих юм. Их Хурал, Засгийн газрын асуудал болж хувирах юм. Тийм учраас энэ хөдөлмөрийн аюулгүй байдал, орчны аюулгүй байдал дээр манай сайд нар маань анхаараарай. Нийгмийн түншлэлийн энэ харилцаагаа улам сэргээгээрэй. Ажил олгогч ажилчныхаа төлөөлөлтэй уулздаг сайд байгаарай гэдгийг бас захиж хэлье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Д.Үүрийнтуяа: Ерөнхий сайд түүний кабинетын шинээр томилогдож байгаа сайд нарт амжилт хүсэж, баяр хүргэе.

Наранбаяр сайдаас надад 1 асуулт байна Засгийн газрын 321 дүгээр тогтоол 2021 оны, 2024 оны 102 дугаар тогтоол, 2025 оны 215 дугаар тогтоол орон нутгийн их, дээд сургуульд сурч байгаа оюутны сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлөх тухай тогтоол хоорондоо зөрчилтэй хүчин төгөлдөр 2 тогтоол байна гэдэг асуудлыг би танд тавьж ойлгуулж хэлсэн.

4 сарын 30-ны өдөр хойд бүсийн зөвлөгөөн дээр иргэн Эрдэнэбулганы асуусан яг энэ асуултад та энэ асуудлыг шийднэ ээ гэж хариулсан. Харамсалтай нь 25 оны 215-аар та энэ асуудлыг Засгийн газрын барьж байгаа бүсчилсэн хөгжлийн бодлогынхоо эсрэг, орон нутагт ажиллаж байгаа их, дээд сургуулийнхаа эсрэг орон нутагт сурч байгаа оюутнуудын эсрэг гаргасан. Энэ 50 хувийн хөнгөлөлтийг хүчингүй болгосон. 600 гаруй оюутан жилдээ энэ орон нутагт сурч байсан. Ядаад энэ тогтоолд чинь итгэж найдаад элсчихсэн хүүхдүүдийг төгсгөчхөж болоогүй юм уу? Энэ бүсчилсэн хөгжлийн бодлого мөн юм уу, төр засгийн бодлого ийм уймраа байж болдог юм уу? Тодорхой хариулт өгөөч. Яг энэ бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөний үеэр Эрдэнэт медиал эмнэлгийн асуудал хөндөгдсөн Чинбүрэн гишүүн ээ би санал гаргасан. Эрдэнэт медиалыг Хойд бүсийн хавдрын төв болгож Хавдар судлалын үндэсний төв болгох шийдвэрийг тухайн үед Засгийн

газар гаргасан. Тогтоол нь болтол гараагүй байна энэ асуудлыг та мэдэж байгаа юу? Энийг анхаарч ажиллаж өгөөч хэд хэдэн санал байгаа юм. Өнөөдөр бид нар эдийн засгийн нөхцөл хүндэрч байгаа талаар ярьж байна. Энэ хүндрэлээс богино хугацаанд гарахын тулд Эдийн засаг, хөгжлийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яам яг 1 механизм шиг ажиллах ёстой. Төлөвлөж байгаа, мөнгө олж ирж байгаа, зарцуулж байгаа 3 үндсэн субъект өнөөдөр та 3 дээр Монгол Улсын эдийн засаг тогтож байгаа шүү. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам зөвхөн уул уурхайн яам биш ээ аж үйлдвэржилтийн бодлогыг авч явах ёстой. Хүнд, хөнгөн үйлдвэрийн асуудлууд уур уурхайгаас орж ирж байгаа энэ орлого дээрээ тулгуурлаж аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж байж эдийн засгийн өсөлт өнөөдөр өрх болгонд хүрнэ. Энэ тал дээр бид нар уялдаа холбоогүй ажиллаж байгаагаас өнөөдөр 14 мега төслөө манай Эдийн засаг, хөгжлийн яам энд тэндээс асууж сураад асуусан асуултад хугацаанд нь хариу гаргаад өгчхөж чадахгүй, мэдээллээ нэгтгэж ч чадахгүй өнөөдрийг хүртэл сууж байгаа. Би 1 минутаа нэмээд авчихъя дарга.

Тийм учраас энэ яамдын уялдаа холбоог хангаж, богино хугацаанд эдийн засгийн өсөлтийг гаргахын тулд энэ 3 яамны ажлын уялдаа холбоог нягтруулах зайлшгүй шаардлага байгаа шүү гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, эрхэм сайд нар аа ажил ихтэйгээ ойлгож байгаа. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэх ажилд хүндэтгэлтэй, хариуцлагатай хандаач ээ.

Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах эрхтэй, хуулийн төсөл өргөн барьдаг. Засгийн газар дээр энэ хуулийг манай салбарын яам оруулж ирэх гэж байгаа юм. Төсөл нь ч бэлэн болоогүй байхад дэмжихээс татгалзсан саналыг өгдөг. Яагаад 2 хууль санаачлах эрхтэй субъектүүд хоорондоо яриад энэ асуудлаа нэгтгээд оруулж болохгүй татгалзаж хариу өгч байгаа юм бэ? Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах бүрэн эрхэд халдаж болохгүй шүү дээ. Яамдын сайд нар би 2025 он гарсаар 1 асуулга, 2 асуулт, 2 албан бичиг хүссэн бичиг явуулсан хариу.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн хариулт өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ тэр Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөний үеэр эд нар ярьсан зүйлээ санаж байна. Тантай ярьсан зүйлээ ч маш сайн санаж байна. Тэгэхээр энэ Нийгмийн халамжийн тухай хуулийн заалт энэтэй холбоотойгоор хууль давсан ийм журам бид гаргаж чадахгүй ийм л юм болчихсон юм. Юу вэ гэхээр яг уг нь ингээд орон нутгийн их, дээд сургуульд суралцах юм бол хөнгөлөлт үзүүлээд тэгээд 100 хувийн тэтгэлэгтэйгээр сурах боломжийг бий болгосон боловчиг нөгөө талдаа тэр Нийгмийн халамжийн хуульд байдаг тэр заалтууд өөрөөр хэлбэл, нийгмийнх нь халамжийн хувьд заавал халамж авдаг ийм байвал ийм 100 хувь хөнгөлөлт үзүүлнэ гэсэн. Энэ амьжиргааны түвшний ийм заалт орж ирсэн. Энийг хууль нь заалттай учраас бид яаж ч чадаагүй.

Тэгээд энэ 215 дугаар тогтоолоор бид шинэчлэн баталснаар 102 дугаар тогтоол нь хүчингүй болоод энэнийхээ 9 дүгээр зүйлд орон нутгийн үйл ажиллагаа, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг тусгаад

өгчихсөн байгаа. Тэгээд 50 хувь дээрээ зээл аваад бас сурч бас болж байгаа. ийм нөхцөл байдал үүссэн.

Дээд боловсролын тухай хуулийн 4.1.7-д сургалтын төлбөрийн хөнгөлөлт гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг тооцож төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг гэсэн байгаа. Тэгэхээр ингээд хавтгайруулж олгож болохгүй болчихоод байгааг бас танд ойлгуулъя. Засгийн газрын 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагчдад сургалтын хөтөлбөрийн хөнгөлөлт үзүүлнэ гэж заасны дагуу 50 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт үзүүлэх санхүүжилтэд нийтдээ 22-24 онд 7346 суралцагчид 11 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. 25 оны төсвийн тухай хуульд энэ зориулалтаар 4.9 төгрөг тэрбум төгрөгийг батлаад хэрэгжүүлж байгаа ийм нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр бид энэ 24 онд нийтдээ 1 мянга 1853 суралцагчдад 3.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байдаг. Гэхдээ энэ нь хэрэгжиж эхэлсэн цагаасаа хойш тусгайлан ийм төсөв хянагдаж батлагдаагүй. Бид Боловсролын зээлийн сан дээр үүсчихсэн байгаа хэмнэгдсэн зардлаас нь ингэж санхүүжүүлж ирсэн ийм тал бий. Бас ингээд орон нутгийн яг энэ хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургуулийн улсуудтай уулзахад элсэлтийн квотын асуудал маш их хөнддөг. Түүний зэрэгцээ төлбөрийн асуудлыг жишээлбэл анагаахын шинжлэх ухааны харьяаны Дорноговьд байгаа сургуулийнхан гэхэд яг анагаахын шинжлэх ухааны харьяа тэгээд Дорноговьтой элсэлтээ нэмэгдүүлэхийн тулд доогуур, хямд үнээр өөрөөр хэлбэл илүү хямд нөхцөлөөр ингээд оюутан сургах ийм боломжийг олгооч ээ гэдэг. Энийг бид бас шийдэх боломжтой гэж харж байгаа юм. Ийм байдлаар эрсдэлийг нэмэгдүүлэх нь их чухал байна гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн хариулт өгье.

Ж.Чинбүрэн: Үүрийнтуяа гишүүний тэр хэлж байгаа санал маш чухал. Энэ “Медикал” эмнэлгийг Эрдэнэтийн хөрөнгөөр босгосон их сайхан, гоё эмнэлэг. Нэгдсэн эмнэлгийн түвшинд ажиллаж чадах үүнийг бас энэ төвийн бүсийн хавдрын эмнэлэг болгоно гэдэг санаачилга их зөв байгаа. Тэгээд би бас юунаас Засгийн газраас асууя. Энэ дээр анхаарал тавьж ажиллая.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт гишүүн хариулт өгье. Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль дээр Засгийн газраас санал өгдөг. Өгөхдөө татгалзаж болно, татгалзахгүй дэмжиж болно. Аль ч тохиолдолд Улсын Их Хурлын гишүүн хуулиа Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд хэлэлцүүлэх бололцоотой.

Дэмжихгүй байлаа гэдэг маань хэлэлцүүлэх эрхийг нь хязгаарлаж байгаа гэсэн үг бас биш. Ижил төсөлтэй агуулгатай, ижил төстэй, зохицуулалттай ийм хуулиуд байх юм бол Засгийн газрын санаачилсан хууль, Улсын Их Хурлын

гишүүний санаачилсан хууль аль алийг нь Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь шийдээд хамтатгаад хэлэлцээд явчихдаг ийм л зохицуулалт байгаа. Тийм болохоор Улсын Их Хурлын Засгийн газрын дэмжихгүй гээд өгч байгаа санал нь Улсын Их Хурлын гишүүний хууль санаачлах эрхэд халдаж байгаа, хязгаарлаж байгаа гэсэн үг биш. Тэгээд энийг бас гишүүд маань бас зөв ойлгоорой. 30 хоногийн дотор хуулийн хугацаанд саналаа өгөх ёстой. Тэр нь хэлэлцэгдэх ёстой. Санал өгөхгүй бол дэмжсэнд тооцоод цаашид хэлэлцээд явчихдаг ийм дэгтэй. Асуулга, асуулт мөн адилхан. Хуулийн хугацаанд саналаа өгөхгүй бол хариуцлага хүлээнэ.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал гишүүн хариулт өгье.

Н.Учрал: Энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний хуульд заасны дагуу энэ Тэргүүн шадар сайд Эдийн засаг, хөгжлийн сайдын бас үндсэн үүрэг бол улсын хөгжлийн бодлого болон макро эдийн засгийн төлөвлөлтийг нэгдсэн байдлаар удирдан зохицон байгуулах ийм үүргийг хүлээдэг. Нэг ёсондоо бол яг энэ эдийн засгийн өсөлт, инфляц, төсвийн бодлого, төлбөрийн тэнцэл зэрэг энэ макро түвшний бодлогын зохицуулалтуудыг нь хийгээд 1 цонхоор харах энэ бололцоог л олгох ёстой.

Өнгөрсөн хугацаанд бол яг энэ уялдаа холбоог бол бид нар хангах дээр бас алдаанууд гаргасан. Тийм учраас бол бид нар Засгийн газар бүтэц, бүрэлдэхүүний хууль дээр бас эргэж харж өөрчлөлт оруулаад энэ 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрөө үнэлдэг дүгнэдэг энэ бас зөв механизм руу нь чиг үүргийн хувьд бол бүрэн шинжилгээ хийж, давхардлыг арилгах зорилгоор бол ажиллана.

Энэ хүрээндээ яг хөгжлийн бодлого төлөвлөлт, урт хугацааны бодлоготой яг өнөөдрийн макро эдийн засгийн бодлогуудын уялдааг хангаад гишүүдэд ч гэсэн нэг цонхоор харах бололцоог.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Наранбаяр сайд би таны наад яриад байгаа хууль, журмыг чинь мэдэж байна. Тийм юм бол яагаад анхнаасаа хууль зөрчөөд тогтоол гаргасан юм? Хоёр дахь Засгийн газрын тогтоолоороо тэрийгээ хүчингүй болгохгүй яасан юм, яах гэж ард иргэдийг хуурч тэнд 1000 гаруй оюутныг тэгвэл ийм байдлаар элсүүлчхээд сургалтын төлбөрийг нэмчхэж байгаа юм? Та яах гэж тэр Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн дээр шийднэ ээ гэж амласан юм? Тэгвэл хууль зөрчөөд байгаа юм бол би асуулт, асуулга тавьсан. Улсын Их Хурлын гишүүний асуулгыг танд хүргүүлсэн. Хариу өгсөн больё доо гэсэн бичиг ирсэн. Та ер нь тэр бичиг дээр гарын үсэг зурахдаа харсан уу? Ингэж хандмааргүй байна. Энэ асуудал дээр нийтлэг жишгээрээ эрхэм сайд нар маань ач холбогдол өгч бас анхаараасай гэж хүсэж байна. Сайд нарын ачаалал их байдаг байх. Гэхдээ та бүхний ард бүхэл бүтэн баг байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. Шинэ Засгийн газарт сайдаар ажиллахаар сонгогдсон та бүхэнд амжилт хүсье. Юуны өмнө нэг зүйлийг захиж

хэлмээр байна. Төрийн сайдын сэнтий бол хүрэх цэг бус, эхлэх цэг гэдгийг сануулж хэлье.

Салбартаа өөриймсөг хандаж, салбарын хөгжлийг чин сэтгэлээр, шударгаар, зарчимтайгаар түүчээлэх, асуудлыг бодитоор шийдвэрлэх, шуурхай шийдвэрлэх, яамдын хүний нөөцийг чадавхжуулах, орон тоог цомхотгож бүтээмжтэй, үр дүнтэй, хүнд сурталгүй, ил тод, нээлттэй ажиллахад анхаарахыг хүсэж байна.

Мэргэжлийн хүний хувьд Байгаль орчны яам, Хот байгуулалтын яаманд нэг зүйлийг хэлмээр байна. Зун болсон гээд утаагаа мартаж болохгүй ээ. Өвлөөс урьтаж бид нар байшин, гэрийг дулаалах ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байгаа. Утааг дулаалахаар л шийддэг тийм л боломжтой. Өөр боломж бидэнд байхгүй. Гэр, байшинг дулаалах үндэсний бодлогыг хэрэгжүүлэх, ногоон зээлийн тогтолцоог оновчлох ажлуудыг яаралтай хийх хэрэгтэй байна. Энэ дээр нягт хамтарч ажилламаар байна гэсэн санал байна.

Ерөнхий сайдаас 1 асуулт байна. Өмнөх Засгийн газар 2025 оныг Нийслэлийн хөгжлийг дэмжих жилээр зарлаад хотын утаа, түгжрэлийг шийдэх Засгийн газрын түвшний шуурхай штабын хурлыг хагас сайн өдөр болгон зохион байгуулсан. Бид нар хичээл амарсан гээд түгжрэлээ мартаж болохгүй. Намараас өмнө бид нар түгжрэлийг шийдэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа. Энэ шуурхай штабын хурлыг үргэлжлүүлж зохион байгуулах уу?

Төсвийн тодотгол хийнэ гэж байгаа. Энэ дээр бас ерөнхий зүйл хэлмээр байна. Засгийн газар төсвийг оновчтой төлөвлөх, төсөл, арга хэмжээний эрэмбийг гаргах, тэрийгээ зөв боловсруулах хэрэгтэй байна. Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам энэ тал дээр анхаарч ажиллахыг хүсье.

Наранбаяр сайдаас Боловсролын зээлийн сантай холбоотой 1 асуулт байна. Энэ жил 15 тэрбум төгрөгөөр ойролцоогоор 70 орчим оюутанд дотоод, гадаадад сурахад нь тэтгэлэг олгоно гэж байгаа юм. Сонгон шалгаруулалт нь одоо явж байна. Гэхдээ 1 асуудлыг хөндөхгүй бол болохгүй байна. Журамд тусгаагүй мөртөө хувь хүний мэдээллийг авна гээд байгаа юм. Ямар мэдээлэл вэ гэхлээр тэнцсэн сургуулийнх нь бүртгэлийн сайтад нь нэвтрэх нэр, нууц үгийг нь авна гээд байгаа юм. Банкаар бол өөрийнхөө дансанд нэвтрэх нэр, нууц үгээ өг өө гээд байгаа юм. Ийм мэдээллийг ингэж авч болохгүй. Энэ асуудлыг сонгон шалгаруулалт дуусахаас өмнө залруулах боломжтой юу? Ирэх 7 хоногоор эцсийн хугацаа нь байгаа. Монгол Улсын ирээдүйг үүрч явах оюутан, залуучуудын зорилго, мөрөөдөл нь энэ журмын буруу заалтаар хаагдах гээд байна. Энэ асуудлыг нэн яаралтай шийдэх хэрэгтэй байна. Хэзээ шийдэх вэ гэсэн 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: 2025 оныг Нийслэлийн хөгжлийг дэмжих жил болгон зарласан. Тэгэхдээ түгжрэл мэдээж жил болгон зарласнаар буурчихгүй. Бодитой алхам тодорхой бодлого шаардлагатай. Ер нь урт хугацааны шийдэл, дунд хугацааны шийдэл, богино хугацааны шийдэл гээд түгжрэлийг бууруулахтай

холбоотой санал, санаачилгууд ярьж байгаа юм байна лээ. Ойрын хугацаандаа гэхэд төрийн албан хаагчийн хагас өдрийг ээлжлэн хэрэгжүүлэх, оргил цагийн ачааллыг тараах, сургуулийн хичээлийн цаг, төрийн үйлчилгээний хуваарийг уялдуулан зохицуулах гэх мэтчилэн богино хугацааны уулзалтыг хэлэлцдэг. Түгжрэлийн асуудлаар хагас сайн бүрд хийдэг уулзалт нь нийслэлийн тээврийн ачаалал, шийдэл уялдааг богино хугацааны ийм шийдлүүдийг л ярилцах талбар болж талбар болж шилжиж байсан юм байна лээ.

Гэхдээ бодит нөлөөнд хэлэлцсэн асуудал тогтоол шийдвэр болж, хэрэгжилтийн хяналттай уялдаж байсан үед л үр дүнтэй үр дүнд хүрнэ. Тодорхой институцлэл, механизм болж байж, үгүй бол үр дүнгүй зөвлөгөөн хэвээрээ байна. Тэгэхээр энэ бодитой хурал зөвлөгөөн, бодитой шийдэл, гаргалгаа аль өдөр хуралдахаасаа үл хамааран тийм механизмыг шинэчлэх шаардлагатай. Тодорхой шийдлүүд шаардлагатай гэж бодож байна.

Ер нь зөвхөн түгжрэл биш одоогоос эхлэхгүй бол энэ утааны асуудал ч гэсэн тэр. Ер нь урт хугацаандаа төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлж Улаанбаатарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт болгон улам л түгжрэлийг нэмэгдүүлээд Улаанбаатар руу шилжих хөдөлгөөнийг нэмэгдүүлээд л байх юм бол, машин нэмэгдээд л байх юм бол Улаанбаатарын түгжрэл хэзээ ч шийдэгдэхгүй. Тийм учраас Хархорин, энэ Хөшигтийн хөндий шинэ хот, нисэхийн хот гээд энэ, тэр Хүннү хот гээд энэ шийдлүүд урт хугацааны шийдэл дунд хугацаа, ойрын хугацаанд түгжрэлийг шийдэх бодлогыг нэг мөр сайн зурж аваад тэрний хэрэгжилтийг нь хагас сайн өдөр болгон хянадаг, шилждэг мониторингийн ийм систем, автомат цахимжуулалтын тогтолцоо, тээвэр хөдөлгөөнийг уулзварын гарцуудыг, нүхэн гарцуудыг гэх мэтчилэн ийм тодорхой чөтгөр детальд байдаг гэдэг шиг энэ деталиуд дээр ажиллах шаардлага нь бодитой юм.

Тэгэхдээ үргэлжлэх эсэхийг энэ бодит алхмуудтай уялдуулж, хагас сайн өдөр бүр хэлэлцсэн асуудлыг нь Засгийн газрын тогтоол, нийслэлийн цахим ч хэлбэрээр баталж хэрэгжихийн хугацаа хариуцагч нь ямар тодорхой болж байна үнэлэлт, дүгнэлт өгч байж хэрэгжилтийн явцыг иргэдэд ил тод мэдэж, тайлагнаж, улирал тутам үнэлгээ хийдэг тогтолцоог бий болгох замаар эхний ээлждээ үнэлэлт, дүгнэлт өгч байж энэ ажлыг бодитой болгоно үргэлжлүүлэх эсэхийг шийднэ гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Наранбаяр гишүүн хариулт өгье.

П.Наранбаяр: Боловсролын зээлийн сангийн журам шинэчлэгдээд үүгээрээ хүнээс үл хамаараад урьд нь жишээлбэл нэгэнт гадаадын шилдэг их, дээд сургуульд тэнцчихсэн хүнээс Англи хэлний мэдлэгийг нь шалгаж авдаг ийм тэгээд бас дахиад ярилцлагын шалгалт авдаг ч юм уу хүнээс хамаарсан маш их юм байсныг энэ жилээс эхлээд тухайн хүнтэйгээ уулзахгүйгээр шууд бүх зүйлийг нь автоматаар ингээд бүрдүүлэлт нь яг үнэн зөв, материал нь бүрэн байвал ингээд тэнцэх ийм систем рүү шилжүүлж оруулсан юм. Тэгэхээр цахим шалгаруулалтад сургуулийн урилга, үргэлжлүүлэн сурагчийн тухайд дүнгийн мэдээлэл, тэтгэлгийн баримтыг үндэслэн шалгаруулах шаардлагатай байдаг. Энийг PDF-ээр тэр хүлээж авахаар урьд нь 23, 24 онуудад хуурамчаар үйлдээд ирүүлж байсан ийм тохиолдлууд нэлээн гарсан юм байна лээ.

Тийм учраас энийг шалгах ийм шаардлага гараад тэгээд энэ удаад нууцын яг ийм яг мэдээллийн эзний зөвшөөрөлтэйгөөр хувь хүний нуу.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6.1-д заасны дагуу яг мэдээллийн эзний зөвшөөрлөөр нууцын баталгаа гаргасан ажлын хэсгийн 2 гишүүн материал баталгаажуулалтыг 2 хоногт хийгээд тэгээд үгийг нь солиулдаг ийм ажил хийж байгаа тэгээд хувь хүний яг нууцад халдаж байгаа гэхээсээ илүү тухайн их сургуулиас нь тухайн нууцлалын гэрээтэй шууд харьцаад хүмүүс нь харьцаад ингээд авчаж байгаа. Тэгээд олон дамжлага дамжуулахгүйгээр тухайн сургуулиас нь тэр материал нь яг зөв байна уу, буруу байна уу гэдгийг мөн хуурамч биш байна уу, үгүй юү гэдгийг магадалж байгаа ийм ажил яваад байгаа.

Гэхдээ таны хэлсэнчлэн энэ өшөө илүү боловсронгуй болгох хэрэгтэй. Жишээлбэл зүүм/zoom/-ээр харж байгаад яг энэ юм нь мөн үү үгүй юү гэдгийг видео колл/video call/ хийгээд секрет зүүм/secret zoom/-ийн систем эд нар ашиглаад янз янзын юм байж болох байх. Тэгэхээр энийг бас бодолцож үзье. Энэ жилийнхээ тухайд бид яг энэ материалыг ингээд цуглуулаад аваад явж байгаа. Ер нь Ерөнхийлөгчийн илгээлт 2100 дээр яг ийм аргаар явсан. Энэ бол үр дүнгээ өгсөн л юм байна лээ л дээ. Хуурамч материал ирээ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Баасанжаргал: Ерөнхий сайдаас 3 асуулт, 1 санал хэлье.

Нэгдүгээр асуудал та бараг намайг ямар асуулт асуух гэж байгааг мэдэж байгаа байх. Нэгдүгээр асуулт Жендерийн квотыг яагаад барьж орж ирсэнгүй вэ? 10 хувь болоод буучихлаа. Манай эмэгтэй сайдад нэр дэвшигчид ямар шалгуурыг хангасангүй вэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Хоёрдугаарт, дахиад бас би энийг бас олон нийтээс ч гэсэндээ олон нийтэд бас та ярьж байсан. Яг энэ сайдын томилгооны шалгуур үзүүлэлт юу байв гэдэг дээр хариулт өгөөч. Тэгээд яг үнэндээ бол бид нар яг тийм итгэл үнэмшил төрүүлэхүйц ийм шалгуур үзүүлэлтийн тухай яриад энэ сайд маань энэ шалгуур үзүүлэлтийг хангасан учраас гээд ингээд яримаар байна. Тэгээд цаашид энэ ажлын үнэлгээнд нь ч гэсэндээ хэрэг болох болов уу гэж бодож байна.

Гуравдугаар асуулт энэ улирч ажиллаж байгаа сайд нараар ядаж энэ ажлын тайланг нь тавиулах ч гэдэг юм уу, ийм процессын соёл ер нь орж ирэхгүй юм уу? Манай Монгол Ардын намын гишүүд тэр гарын үсэг зураад өгсөн гээд байгаа шаардлага чинь ерөөсөө л ийм процесс байхгүй юу. Яг энэ нөгөө сайдаар томилогдож байгаа хүмүүсийн шалгуур нь тодорхойгүй, хэн нь яаж томилогддог нь тодорхойгүй тэгээд энийг чинь ард иргэд ийм тодорхойгүй учраас иргэд бүгдээрээ энийг дандаа ийм санхүү, мөнгө, лоббитой л холбож ойлгож байна шүү дээ. Тэгэхээр энд чинь улс төрчид бид нар өөрсдөө энэ дээр хариулт өгөх ёстой, өөрсдөө бид нар тодорхой байх ёстой.

Тэгэхээр ядаж ингээд намын бүлгийн хурал дээрээ ч юм уу хуучин сайд нарынхаа тайланг тавиулдаг ч юм уу ийм ийм процессууд уг нь жоохон ч гэсэн ийм процессын элементүүд ороод ирсэн бол бид нарт маш их ийм итгэл үнэмшил төрөх байлаа. Тэгэхээр энэ дээр бас хуучин сайд нарыг улираан томилсон шалтгаан, шалгуур үзүүлэлтийг хэлээч. Шалтгаан нь бол мэдээж төрийн бодлого залгамж халаа гэж өмнө нь нэлээн хэдэн удаа давтаад ярьчихсан учраас тэгэхээр яг нөгөө хэнийг ямар шалгуураар гэдэг дээр илүү хариулж өгөөч ээ гэж хүсэх гэсэн юм.

Тэгээд 1 санал байна. Бүх энэ нөгөө салбарын сайд нар маань иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагуудтайгаа хамтарч ажиллах иргэдийн оролцоог хангах тал дээр иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах тал дээр илүү жаахан нээлттэй ажиллаасай гэж бодож байна. Тэгэхээр та бүхэн бүх зүйлийг мэдэж чадахгүй, хийж чадахгүй. Та бүхэнд бүх мэргэн санаа төрөхгүй. Тэгэхээр иргэд та бүхэнд хамгийн их энэ тал дээр чинь дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа иргэний нийгэм төрийн бус байгууллагуудыг хамтын ажиллагаа энэ салбарууд дээр сайжраасай гэж хүсэж байгаа.

Тухайлбал, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл байна. Ерөнхий сайд ахалж ажиллах ёстой. Тэгээд энэ дээр жишээ нь аутизмтай хүүхдүүдийн асуудал дээр бид нар маш хойрго байгаа. Эрүүл мэндийн яам энэ дээр маш хойрго хандаж байгаа аутизмтай хүүхдийн эрхийн асуудал дээр. Нөгөө л Шар хад сэтгэцийн эмнэлэг дээр очиж үзүүлж.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Баасанжаргал гишүүнд 1 минут нэмж өгье.

Х.Баасанжаргал: Аутизмтай хүүхдүүдийн групп тогтоох асуудал жилд 1 удаа дахиад л нөгөө шар хадны эмнэлэгт очиж үзүүлдэг хэвээрээ байгаа. 3, 4 шат дамжлага хэвээрээ байгаа гээд ингээд маш олон ийм яг анхан шатанд хөрсөн дээрээ бол ийм хүндрэлтэй асуудлууд байгаа. Тэгэхээр энийг шийдэхэд иргэний нийгэм яг энэ чиглэлээ ажилладаг төрийн бус байгууллагуудтайгаа хамтарч ажиллавал илүү та бүхэнд илүү хялбар бөгөөд асуудалд аягүй шийдэлттэй та бүхэнд ч гэсэндээ илүү тус дэм болж ажиллана гэж хүсэж байгаа юм. Тэгэхээр энэ иргэний нийгэм төрийн бус байгууллагуудтай ажиллах дээрээ бас нэлээн нээлттэй хандаарай гээд.

Эцэст нь хэдийгээр жендерийн квотыг энэ удаагийн Засгийн газар хангаж орж ирээгүй ч гэсэн би бүх энэ танхимд сууж байгаа гишүүддээ бүгдэд нь баярлалаа гэж хэлье. Нийтдээ 52 гишүүн энэ жендерийн квотыг шаардаж гарын үсэг зурсан. Энэ маш том ахиц дэвшил. Ялангуяа эрэгтэй гишүүдийн зүгээс 29 эрэгтэй гишүүн энэ дээр бол гарын үсэг зурсан. Энэ бол урьд өмнө байгаагүй ахиц дэвшил. Тэгэхээр та бүхэндээ бүгдэд нь маш их талархаж байгаагаа илэрхийлье. Манай бусад гишүүд ганцхан бүгдээрээ жендер.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ерөнхий сайдаар томилогдох үед Улсын Их Хурлын үг хэлсэн гишүүд бүгдээрээ энэ Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хангах, мега төслүүдийг хэрэгжүүлэх, бодлогын тогтвортой байдлыг хангах талаар саналаа хэлж байсан. Бодлогын тогтвортой байдлыг яаж үргэлжлүүлэх вэ, яах вэ

талаар өмнөх Ерөнхий сайд намын даргатай зөвлөлдөж ярьж байхад тодорхой сайдуудыг заавал үлдээж ажиллуулах нь энэ төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх баталгаа бас ажлаа мэдэж байгаа шинэ хүн ирээд хэдэн сар 6 сар ч болдог юм уу энэ ажил алдагдана гэсэн ийм тодорхой тоо баримттай, үндэслэлтэй саналуудыг хэлж байсан. Тухайлбал, Онтри-гийн асуудал гээд л тэгж байна. Тэр талаар яриа хэлэлцээр хийж байсан сайдууд байна. Гашуунсухайт төмөр замын яриа хэлэлцээ ... хийж байсан Зөвхөн Ерөнхий сайдтай оролцож байсан яриа хэлэлцээнд оролцож байсан тэр сайд нар нарийн нюанс, бодлогуудыг мэдэж байгаа.

Ийм учраас өмнөх Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хангахын тулд зарим сайдуудыг улираан томилсон. Энэ эхлүүлсэн хөтөлбөрүүдийг тасалдуулахгүйн тулд, хэрэгжилтийн үр дүнг нь гүйцээхийн тулд, институтийн тогтвортой байдлыг хангахын тулд гаргасан бодлогын шийдвэр гэж үзэж байгаа юм. Ийм учраас Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг өргөжүүлж өөрчлөхгүйгээр, энэ цаг хугацаа алдахгүйгээр цаашаа үргэлжлүүлж явах ийм шаардлага байгаа юм. Энэ өмнөх Засгийн газрын хэрэгжүүлж байсан 20 гаруй Үндэсний хөтөлбөр. 20 гаруй үндэсний хөтөлбөрийг дор хаяад тасралтгүй үргэлжлүүлж хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангах шалгуураар шалгуур нь ийм улиралт хийгдсэн гэж хэлж болно.

Өмнөх Засгийн газрын тайланг олон нийтэд ил тод тавиулах нь хариуцлага, бодлогын залгамж чанарыг үнэлэх чухал алхам. Энэ талаар ч гэсэн холбогдох сайд нар бас ярьж ажлаа тайлагнасан гэж би ойлгосон. Улсын Их Хурал Угаасаа Засгийн газрын хэрэгжилтийн ажлын тайланг хагас жилээр үнэлж хэлэлцдэг. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцдэг тийм журамтай, хөтөлбөртэй. Зардлын үр ашиг, зорилт биелэлтийн талаар тайлагнах Их Хурлын Их Хурал дээр энэ ажил явагддаг. Төсвийн гүйцэтгэлээс авхуулаад бүх тайлан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт.

Жендерийн квотыг 10 хувиар жендерийн квот ийм учраас жендерийн бодлоготой холбоогүй юм. Энэ намуудын нэр дэвшүүлэх эрх, хамтын ажиллагааны зарчим, энэ чинь ир Иргэний зориг гээд Зориг агсны үйл хэргийг үргэлжлүүлэхээр ардчиллын зорилгоор байгуулагдсан нам. Ногоон үзэл баримтлал энэ чинь нөгөө улс төрийн Улсын Их Хурлын 4 гишүүний асуудал биш энэ бүхэл бүтэн намын байр суурь, ард түмний саналтай холбоотой сонголтууд. Сонгуулийн шударга өрсөлдөөнд чиглэсэн ийм зохицуулалтаар энэ Засгийн газар бүрдсэн. Жинхэнэ жендерийн бодлого нь эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих бодит механизмыг бий болгох явдал. Энэ санаачилгыг харин ч би дэмжиж жендерийн эрх тэгш байдлын асуудлаар Тогтвортой хөгжлийн зорилт 14 олон улсын чуулга хуралдааныг зохион байгуулж, энд өнөөдрийн парламентад жендерийн квотыг 30 хувь, 28 хувь, 40 хувь болгох санаачилгууд жендерийн санаачилга дээр олон улсын хурал хийж тухайн үед Сонгуулийн хууль хэлэлцэж байхад дэмжиж ажилласныг манай эмэгтэй Их Хурлын гишүүд мэдэж байгаа. Энэ бодит дэмжлэг. Харин ч бид жендерийн мэдрэмжтэй байж тодорхой асуудлуудыг шийдсэн. Өнөөдрийн улс төрийн нөхцөл байдалтай энэ 2 дахь.

Цаг байгаа учраас аутизмын асуудалд ер нь гишүүд өөрсдөө бас санаачилгатай ажиллах хэрэгтэй байгаа. Зөвхөн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах нь жагсаалтаар сонгогдсон гишүүдийн нэн ялангуяа үүрэг хариуцлага байх ёстой. Одоо тэр Худалдаа аж үйлдвэрийн

танхимаас төлөөлсөн бизнес эрх ашгийг төлөөлж байгаа бол тэднийхээ дуу хоолойг уулзаад хурал зөвлөгөөн хийгээд, санааг нь Их Хурал дээр дуу хоолойг нь гаргадаг байх ийм механизм бүрдүүлэх ёстой. Аутизмын асуудалд Трамп Ерөнхийлөгч АНУ-ын Ерөнхийлөгчөөр томилогдоод Аутизм кэйрс акт/autism cares act/ гэж батлаад судалгаа, эрт илрүүлэлт, боловсрол, үйлчилгээний санхүүжилт, стандартыг нь баталж нэмэгдүүлсэн.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Г.Занданшатар: Монголд ч гэсэн аутизмын оношилгоог бодитой хийдэг анхан шатад нэвтрүүлэх тийм мэргэжлийн эмч, багш дутмаг байхад энийг бид сонсоод энийг нь бэлдэхээс авхуулаад тэгээд ер нь аутизм төдийгүй тусгай хэрэгцээт боловсролын хэрэгцээ шаардлага ер нь хөдөө орон нутагт ч гэсэн бүсчилж ийм байгуулах шаардлагатай. Тэгээд энэ асуудлыг бид нар анхааруулах цаг болсон. Энэ дээр манай Саранчулуун гишүүн маань маш санаачилгатай ажиллаж байгаа. Маш чухал санаачилгууд дэвшүүлсэн. Би бүлэг дээр зөвхөн аутизм, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой тэднийг дэмжих хууль, эрх зүйн акт, хуулийн хэрэгжилт, төсөв, мөнгөний бодлого боловсруулах лобби бүлэг байгуулъя гэж бодож байгаа. Манай Саранчулуун гишүүний тодорхой санал эхлээд хэлсэн. Энд ч гэсэн аутизмын кэйрс акт/autism cares act/-ыг бас гишүүд өөрсдөө санаачлаад явах хэрэгтэй. Засгийн газар мэдээж бүх зүйлийг хийж чадахгүй. Тэгэхээр аутизмтай тэмцэх хөтөлбөр, актыг Их Хурлын гишүүд бас санаачлаад тухайн эцэг эхчүүд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтраад ажиллах бололцоо нээлттэй. Энэ дээр.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Галбадрах: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Ерөнхий сайдын багийг дэмжиж байгаа. Та бүхэндээ шинэ сайд нартаа амжилт хүсье. Эв эеийг эрхэмлэе гэж Их Хурлын гишүүддээ уриалахыг хүсэж байна. Гадаад, дотоодын ямааргүй хүнд нөхцөл байдалд хөгжлийн ээдрээтэй цаг үед манай энэ Засгийн газар маань шинээр байгуулагдаж байгаа. Энэ Засгийн газрыг тогтвортой байлгахад л бид нар анхааръя гэдэгт нь гэж уриалж байгаа юм. Бодлогынх нь залгамж холбоог нь үргэлжлүүлж явахад бид бас дэмжиж өгье.

Харин эсрэгээрээ хийсэн болгоныг нь өөлөөд, улыг нь шагайгаад явбал ямар ч хүний, ямар ч салбарын, ямар ч байгууллагын ажил урагш явдаггүй гэдгийг бид мэддэг. Харин дэмжээд урам өгөөд явбал ямар ч байгууллага ямар ч хүн урам аваад ажилладаг. Тийм учраас бид сая засгийн газраа жил ч хүрэхгүй. Ингээд энэ дээрээ бид бас сургамж аваад цаашдаа тогтвортой байхад нь анхааръя гэдгийг. Харин алдаа гаргаад, идэж уугаад байвал хатуу хариуцлагаа тооцоод явах нь зүйтэй. Ийм учраас сайд нараасаа маш хариуцлагатай, манлайлалтай хамгийн гол нь багаар хамтарч ажилладаг байхыг л та бүхнээсээ хүсэж байна.

Ингээд олон нийт ард түмэн бол улс төрчдийг, сайд дарга нарыг хөгжлийн чөдөр тушаа гэж хэлдэг. Өнгөрсөн цаг хугацаанд улс төрчдийн гаргасан тэр алдаа завхрал тэр Засгийн газрын гишүүдийн хагарал зөрчил, амиа бодсон байдал, хуйвалдааны улмаас улсын хөгжлөө маш олон жилээр бид нар хойш татаж асар их боломжийг алдсаныг бид мэдэж байгаа. Одоо үүнийг давтаж болохгүй. Бид

бүгдээрээ үүнийг ингээд хянаад давхар хяналттайгаар ингээд явцгаая. гэдгийг хэлэх байна.

Ингээд Ерөнхий сайдаас 2 асуулт байна. 3 асуулт байна. Засгийн газар нэгдмэл ажиллаж чадахгүй салбар болгон амиа бодсон салангид бодлого боловсруулж, төлөвлөлт хийдэг. Үүнийг хэрхэн оновчлох вэ? Тэргүүлэх салбараа хэрхэн тодорхойлсон бэ? Тэргүүлэх салбараа эрэмбэлж хөрөнгө оруулалтыг хэрхэн хуваарилж байна вэ? Боловсролын жилтэй холбоотой хөрөнгө оруулалтыг хасахгүй байж чадах уу гэдэг асуултыг асууя. Тэгээд Ерөнхий сайд маань та “Ярап луугаа хөгжье” гэж их ярьж уриалдаг хүн. Хүний хөгжлийн бодлогыг мега төслийн хэмжээнд авч үзнэ гэдгээ илэрхийлж байгаад талархаж байгаа. Боловсролын сайд Наранбаяр ч гэсэн өөрөө Японд сурсан ийм боловсрол эзэмшсэн хүн. Та бүхнийг маш сайн хамтарч ажиллаасай гэж ингэж хүсэж байна.

Тэгээд Боловсролын сайдаас бас асуух асуулт байна. 26 оныг Боловсролын жил болгосонд салбарынхан талархаж байгаа. Хөрөнгө оруулалтыг хэдэн хувиар нэмэгдүүлэх вэ? Төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн ажилтны орон тооны жишиг норматив батлагдахгүй удаад байгаа. Энэ ямар шатдаа явж байна вэ? Дараагийн хамгийн сүүлийн асуулт бол төрийн өмчийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Галбадрах гишүүнд 1 минут нэмж өгье.

Ж.Галбадрах: Төрийн өмч ЕБС-ийн 500 гаруй багшийг хамруулан манай ажлын хэсгээс хамруулсан судалгаа ингэж авсан. Багшийн нэр хүндийг өсгөх, цалин хангамжийг нэмэгдүүлэх, ямар тодорхой дэмжих бодлого явуулах талаар багш талаар асуулт хийсэн. Тэгээд үнэхээр энэ асуултын хариу нь багшийн хомсдол үнэхээр бодитоор нүүрлээд байгаа нь гарч ирсэн. Жишээлбэл, энэ дотор 1 асуулт л гэхэд 1-2 жилд багшаар ажиллахаа болих талаар бод та бодож байгаа юу гэсэн асуултад 29 хувь нь заримдаа, 22 хувь нь ойр ойрхон, 19 хувь нь байнга буюу нийтдээ ингээд энэ бүгдийг нэмбэл 70 орчим хувь нь багшаа солих гэсэн бодол төрсөн байна. Ийм учраас бид багшгүй болох ийм аюул нүүрлэх байгаа учраас багшийг дэмжих, багшийн энэ хомсдолыг арилгах талаар ямар бодитой бодлого боловсруулж байна вэ гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Галбадрах гишүүний асуултад хариулъя. Сайхан санаачилга дэвшүүлсэнд талархаж байна.

Нэгдүгээрт, Засгийн газар нэгдмэл байдлаар буюу танхимын зарчмаар ажиллах ёстой. Энэ шаардлагыг хатуу тавьж ажиллана. Уламжлал, шинэчлэлийг хослуулсан Засгийн газар бий гэж үзэж байгаа. Яагаад гэвэл 7 шинэ 8, Ардын намын 15 сайд гэхэд 7 шинэ, 7 хуучин 8 шинэ. Тэгэхээр шинэчлэлийг ч хэрэгжүүлнэ, уламжлалыг ч барина. Тэгэхдээ танхимын зарчим баримталж ажиллана.

Нэгдүгээрт, ер нь боловсрол ер нь “Япон лугаа адил хөгжье” гэдэг үйлдвэрлэгч орон болох ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн тулд үндэсний үйлдвэрлэлийг дэмжих гэсэн эдийн засгийн төлөвлөлт, макро эдийн засгийн тэнцвэрийг хангасан бодлогын зэрэгцээ хамгийн гол нь

боловсролын салбарт хийсэн хөрөнгө оруулалт 1 төгрөг ирээдүйн 100 төгрөг гэдэг боловсролоо дэмжсэн тэнд тэр эдийн засгийн төлөвлөлттэйгөө боловсролын төлөвлөлт уялдсан энэ төлөвлөлтийн бодлого нь та бид бас ярьж байсан Наранбаяр, Галбадрах гишүүн бид нар энэ чиглэлээр ярилцаж боловсролын реформын талаар ярилцаж, Боловсролын хуулийн шинэчлэлд та бүхэн бас идэвхтэй оролцсонд талархалтай байдаг.

Ер нь боловсролын хөрөнгө оруулалтыг энэ 2026 оныг боловсролын жил болгон зарласантай холбоотойгоор бууруулахгүй зарчим ийм учраас баримтална. Бүх төлөөллийг оруулсан ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байгаа юм билээ. Энэ хүрээнд 2 ээлжээс дээш коэффициент бүхий байршлуудад сургууль, цэцэрлэг шинээр барих тооцооллыг их өгөгдөлд суурилж, хүн амын тоо их өгөгдөлд суурилж гаргасан юм билээ. Энэ хүрээнд 2026-2028 онд улсын хэмжээнд 108 сургууль, 95 цэцэрлэг, 95 цэцэрлэг барих тооцоолол гарсан.

Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлэхдээ он дамжих төслийг тэргүүн эгнээнд хэрэгжүүлэх, экспортыг нэмэгдүүлсэн, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төслүүдийг дэмжих, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх төсөл, эрчим хүчний хараат байдал, одоо энэ чинь 70 хэдэн, 190-ээд сая долларын импорт эрчим хүч авч байна. Хүний хөгжил, боловсрол нийгэм рүү чиглэсэн энэ боловсрол, эрүүл мэндийн салбарын төсөл, арга хэмжээг чухалчилбал зүгээр гэсэн нөгөө тэргүүлэх чиглэлийг. Ер нь, ингэснээрээ ер нь зарчмын хувьд боловсролын салбарын хөрөнгө оруулалтаа бууруулахгүй. Яагаад гэвэл хүний хөгжил манай мега төсөл байна гэсэн учраас.

Ер нь урьдчилсан тооцооллоор ээлжийн коэффициентийг 2 ээлжийн коэффициентийг 2 болгоно гэж бодоход урьдчилсан тооцооллоор 2.6 их наядын хөрөнгө оруулалт шаардлагатай юм байна лээ. Ер нь энэ боловсролын стандарт, шаардлагаа кутрипел каликс/quadruple.../ буюу дөрвөлсөн зангилаан дээр тэр боловсон хүчнийг ашиглах, төгсөгчийг ашиглах ёстой хувийн хэвшил, салбар, төр, багш нар, эрдэм шинжилгээ, судалгаа, тэгээд оюутан гэсэн энэ 4 хэлхээн дээр боловсролын салбартаа суралцагч гэсэн энэ 4 хэлхээн дээр боловсролын салбартаа хувийн хэвшил, иргэний нийгэм, иргэдийн оролцоог хангасан цахим боловсрол, зайны боловсрол гэсэн дижитал боловсролын цоо шинэ платформ боловсруулж, хөдөө орон нутгийг хангах гэх мэтчилэн тодорхой төсөөллийг энэ боловсролын реформын хүрээнд боловсролын жилийн хувьд бас боловсруулсан байгаа. Энэ дээр Галбадрах багшийг Наранбаяр сайдтай бас хамтарч, Наранбаяр гишүүнтэй хамтарч энэ талаар ярилцаж хамтран ажиллахыг хүсэж байна. Санал онолоо, хувь нэмэр оруулж санаачилгатай ажиллаарай энэ чиглэлээр гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуултад хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ бас энд хөрөнгө оруулалтыг нэмэх асуудлаар бид тооцоод үзэхэд ер нь боловсролын салбарын төсвийн динамикийг ингээд харах юм бол 25 онд нийтдээ 4.4 их наяд төгрөг байсан. Энийг 6.8 их наяд руу оруулах ийм шаардлагатай байгаа. Ерөөсөө нийт төсвийн зарлагын 18.5 хувь, ДНБ-д эзлэх хувийг 6.8 хувьд хүргэх ийм шаардлага байна гэж хараад байгаа.

Ер нь ингэж бид цогцоор нь шийдэхгүй бол ер нь алдах нь их байна. Цаашаагаа алдах нь их байна. Нэг ингээд алдчихсан юмыг эргүүлж нөхөхийн ийм аргагүй ийм алдаа руу орох ийм магадлал байна гэж бид хараад байгаа. Ялангуяа эхний 5 жилдээ багшилж байгаа багш нарын бараг 5-8 жил дотроо больж байгаа хэмжээ нь 60-70 хувь хүрчхээд байгаа. Өнөөдөр ийм. Тэгээд таны хэлж байгаа энэ судалгааны дүнд больё гэж бодож байгаа багш нар нь ингээд 70 хувьд хүрээд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ дээр багшийн, энэ багшийн ажлаар, багшаар ажиллаад сэтгэл ханамж нь өндөр байхын тулд нэгдүгээрт энэ цалин хангамжийнх нь асуудлуудыг шийдэх шаардлагатай. Цалин хангамж хэдийгээр бас сүүлийн жилүүдэд нэмэгдэж ирсэн ч гэсэн өнөөдөр бас энэ тэр болгон хүрэлцээтэй биш байгаа нь ойлгомжтой байгаа. Түүний зэрэгцээ ялангуяа энэ залуу багш нарыг дэмжих тал дээр бид бас их алдаад байгаа юм байна гэдэг нь харагдаж байгаа. Залуу багш нарыг орон сууцаар нь дэмжих, залуу багш нарыг гадаадад сурахад нь дэмжих ийм бодлого зайлшгүй шаардлагатай. Тэгээд Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Боловсролыг дэмжих жилийн ажлын хэсэгт Ундрам гишүүн, мөн Галбадрах гишүүн хамтраад ажиллаад явж байгаа энэ асуудлыг цогцоор нь шийдвэрлэх ийм үндсэн шаардлага байгаа гэж харж байгаа. Бид бас Засгийн газрынхаа хөтөлбөр, төлөвлөгөөнд оруулчихсан гадаад улсад Англи хэл болоод магистр, докторт нийт 10-аад мянган багшийг бэлдэнэ гээд ингээд оруулчихсан байгаа юм. Энийгээ ажил хэрэг болгож эхлэх шаардлагатай байгаа гэж хар.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн, Жанчивын Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Баярлалаа. Ерөнхий сайд маань энэ хүний хөгжлийг мега төслийн хэмжээнд авч үзнэ гэж энийг бүүр баталгаатай, баттай, суурьтай ингэж хэлж байгаад их талархаж байгаа. Тэгээд бид нарын хувьд суурь судалгаануудыг сайн хийж байгаа. Би өөрөө ажлын хэсгийг ахалж явж байгаа хүний хувьд хийсэн. Боловсролын жилийг дэмжихтэй холбогдуулаад бас яаман дээр ажлын хэсэг гарсан. Чанарын хэсгийг нь манай Ундрам гишүүн ахалж байсан. Хүртээмжийг нь би өөрөө ахлаад явж байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр их дорвитой, бодитой энэ ажлуудыг хийх гээд хөгжлийн төлөвлөгөөнд нэлээн зүйл тусгагдсан байгаа. Гэхдээ орлого маань ингээд багасаж байгаатай холбогдуулаад 2 их наядаар тасарна гэдэгтэй холбогдуулаад санаа зовох зүйлүүд байгаа. Энийгээ яг Сангийн сайдаас бас нэмэлт авъя гэж бодож байсан. Баярлалаа амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан гишүүн нэмэлт хариулт өгье.

Б.Жавхлан: Галаа гишүүний асуултад зүгээр нэмэлт мэдээлэл өгье. Бид ирэх жил Боловсролын жил болгон зарласан байгаа. Шинэ Засгийн газар мэдээж энэ бодлогоо үргэлжлүүлнэ. Гэхдээ яг төсвийн хөрөнгө оруулалт дээр бас хэт их өндөр хүлээлт байж болохгүй шүү. Энийг эртхэн хэлье ээ, эртхэн хэлье. Бид энд гайхах юм байхгүй. Төсвийн хүрээгээ бид баталчихсан байгаа. Төсвийн хүрээн дотроо л хөрөнгө оруулалтууд маань багтана. Өөрөөр хэлбэл, бид энэ жилийнхээ тоон дээр төсвийн хүрээгээ баталсан. Дээрээс нь одоо тодотгол гэж байгаа.

Тэгэхээр энэ тодотголын суурь энэ жилийн гүйцэтгэл 2-ын дунд л төсвийн тоонууд орж ирнэ. Тэгэхээр энэ жилийн хөрөнгө оруулалтын тоо бол их өсөхгүй гарч ирнэ. Бусад салбарууд маань боловсролын жил болсонтой холбогдуулж зарим хөрөнгө оруулалтуудаа хойш нь татаж, боловсролын салбартаа боломж тавих ийм замаар л бид боловсролынхоо жилийн хөрөнгө оруулалтуудыг нэмэх ийм орон зай гарах болов уу нэгд.

Хоёрт.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тийм зөвхөн хөрөнгө оруулалтаас гадна бусад өөр хууль, эрх зүйн орчин төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын хөрөнгө оруулалтууд гээд олон хувилбар, олон эх үүсвэрээр боловсролын салбараа дэмжих боломжууд байгаа. Энэ дээр Их Хурлын гишүүд маань их санаачилгатай хамтарч ажиллана гэж найдаж байна. Галбадрах гишүүнд чухалчлан танд талархал илэрхийлье. Энэ жилийн хувьд бид боловсролын жилийн төсвийг маш онцлог төлөвлөлтийг нь бэлдэж байгаа. Юу вэ гэхээр Улсын Их Хурал дээрээс гарсан ажлын хэсэгтээ бид аль хэдийн бүүр 1 сараас эхлээд хамтарч, 26 оны төсөв дээр боловсролын салбарын төсөв дээр хамтарч ажиллаад ямар ч байсан судалгаа, их өгөгдөл дээр суурилсан энэ хамран суугдалтын коэффициентийг сайжруулах бүхий л датануудаа аль хэдийн бэлэн болгосон. Энэ маш сайн хэрэг, маш сайн ийм жишээ болох ийм төсвийн төлөвлөлт болж байгаа. Энийгээ харин хэдүүлээ яаж ийгээд боломжит хэмжээнд нь шингээх тал дээр дараагийн.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн асуулт асууж, үг хэлье.

М.Нарантуяа-Нара: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Тэгэхээр аливаа зүйлийн эхлэлд ерөөл өргөх нь муугийн ёс биш Монголын ёс. Тийм учраас хэдийгээр цоо шинээр бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдээгүй ч гэсэн зарим нэгэн тодорхой шинэчлэлүүдийн хүрээнд шинэ Засгийн газарт амжилт хүсье. Энэ шинэ Засгийн газарт бас манай Иргэний зориг ногоон нам хамтарч Байгаль орчны яамыг хариуцаж ажиллахаар болсон байна. Тэгэхээр энэ бас нэг талаараа манай Иргэний зориг ногоон намын хувьд иргэдэд танилцуулсан, амласан энэ мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх бас таатай нөхцөл, боломж гэж харж байна. Нөгөө талаар бас энэ яамны ажлыг илүү сайн ажиллуулах нь магадгүй 28 онд манай Иргэний зориг ногоон нам илүү олон суудалтай болох уу, эс үгүй бол илүү дордох уу гэдгийн бас нэгэн дүн байх ийм эгзэгтэй бас ийм мөч болов уу гэж бодож байна.

Тэгээд сая Ерөнхий сайдын хэлж байгаа зарим үгнүүдээс яагаад энэ өмнөх сайдуудыг улираан томилов гэдэг дээр бас хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үргэлжлүүлэх гэсэн ийм зүйлүүд явагдаж байна. Тэрийг бас ойлгож болно.

Гэхдээ нөгөө талаараа эрчим хүчний салбар элгээрээ хэвтчихсэн, эрдэнэт хүний амь нас бас эрсэдсэн, өчнөөн 200 орчим тэрбумын хохирол улсад учирчихсан ийм байж байгаа. Тэгэхээр зэрэг энэ салбарынхаа яамны сайдыг та улируулж сонгосон нь хөтөлбөрөө хэрэгжүүл гэсэн юм уу, эс үгүй бол маш яаралтай алдаагаа засаад энэ яамыг, салбарыг маш яаралтай хөл дээр нь босох энэ алдаагаа зас гээд та дахин томилов уу? Мөн түүнчлэн Ерөнхий сайд та энэ

эрчим хүчний реформ, шинэчлэл, энэ өрсөлдөөнт зах зээл, либералчлалыг яг юу гэж харж байгаа вэ? Энэ салбарт юу хийх вэ? Би яагаад энэ асуултыг асуугаад байна гэхээр дөнгөж сая хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлын хэсгийн ажлаар ДЦС 3 дээр бас ажиллаад ирэхдээ бас багагүй зүйлийг мэдэж ирсэн.

Жишээлбэл, энэ Эрчим хүчний яам маш яаралтай энэ улсын энэ гамшгийн нөөцийн мөнгөнөөс энэ маш сайн чанарын энэ турбин аваад энэ дэлбэрсэн энэ асуудлыг маш яаралтай засаж залруулах ийм ажил бас байгаа юм байна. Тэгээд мэргэжлийн хүмүүс бас хэлж байна ДЦС-4-өө илүү дулаан гаргахад ашиглаад цахилгаан үйлдвэрлэлтийг нь багасгаад 3-ыг тэр хооронд нь засаж, залруулах ийм ажлуудыг бас танай энэ Эрчим хүчний яам хийж чадах уу? Одоо ингээд энэ асуудлыг шийдэхгүй бол ирэх наадмын дараа гэхэд бид нар намар гээд л мөн төд удахгүй 1 минутаа үргэлжлүүлээд авчихъя. Төд удахгүй энэ Улаанбаатар хотын 1 сая 700 мянга гаруй иргэдийн дулаан, тог цахилгааны асуудал хөндөгдөөд эхэлнэ. Энэ асуудлыг бүрэн нааштай шийдэхгүй бол энэ байгаль орчинд харшилдаг нөгөө утаа, униарыг чинь асуудал, хүний эрүүл мэнд, амь насны асуудал улам том дэгдээд эхэлнэ.

Тэгэхээр зэрэг манай бас энэ Иргэний зориг ногоон намын энэ хариуцаж ажиллах энэ салбар яаманд маш том хүндрэлтэй асуудлууд бас нүүрлэх учраас энэ салбар салбарын хөгжил, хуваарилалт хариуцлагыг бас жигд хүртээмжтэй, хариуцлагатай байлгах ажлыг бас таныг сайн хийгээсэй гэж бодож байна.

Эцэст нь хэлэхэд манай Иргэний зориг ногоон намын дарга Батын Батбаатар та энэ яаманд, яамыг ахалснаар та энэ намын энэ яаманд ажиллах мэрит зарчим хангахгүй хүмүүсийн өмнө ажилтай болгох үүрэгтэй хүн биш шүү. Хамгийн гол нь та энэ яамыг илүү сайн ажиллуулж, энэ боломжийг ашиглаж, зөв ашиглаж намынхаа мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зөвхөн манай намын төдийгүй улс эх орны байгаль орчны бүхий л асуудлыг хариуцна гэдэг маш том. Тэгэхээр танд бас амжилт хүсэж илүү хариуцлагатай ажиллах ийм үүрэгт нь амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ Нара гишүүн тээ? Хэн хариулах юм? Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Нара гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ цахилгаан станцад гарсан дэлбэрэлт, осол бол нэг талаасаа хариуцлагыг, нэг талаасаа чиг үүргийн давхардал тэнд сайд, яам нь хариуцахаа больчихсон, өөр толгойнууд гарчихсан, эрчим хүчний 1 компани байгуулагдчихсан, тэдний ТУЗ-ийн томилдог, тэр нь томилогдоогүй энэ тэр гээд бас яг хариуцлагын асуудал дээрээ ийм тогтолцооны алдаатай нөхцөл байдал үүссэнд нөлөөлсөн гэж үзэж байгаа.

Ер нь нийслэлийн тэр ноцтой ослын мөрөөр нийслэл дэх газраас холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран шалгаад тагнуул, цагдаа, мөн мэргэжлийн байгууллагуудын шалгалтыг оруулсан байгаа. Эрчим хүчний хүчний сайдын удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг аварт өртсөн 9 дүгээр турбины хэсгийг задалж шинжлэх шаардлагатай, задалж шинжилж байгаа эцсийн дүгнэлт гараагүй байна. Хөрөнгө оруулалт, үр дүнгийн. Ингээд энэ нэлээн тод тодорхой асуудлууд хийгдэж байгаа. Ер нь бол бид нарт бас томоохон эрсдэлүүд учирч болзошгүй байдал үүссэн. Хэрвээ Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150мвт-ын 2 дугаар

блок 11 дүгээр сардаа амжиж ашиглалтад орохгүй бол 11, 12 дугаар саруудад 101мвт цахилгаан эрчим хүчээр хязгаарлаж ажиллахаас гарцгүй өөр тийм шийдэлд хүрч байгаа.

Ийм учраас эрчим хүчний сайд нэмж хариулна. Яагаад энэ хариуцлагаа ингэж хүлээж ажиллаж байгаа юм бэ гэдэг дээр.

Нэгдүгээрт нь Эрчим хүчний сайд энэ либералчилж сэргээгдэх эрчим хүчний бодлогыг үргэлжлүүлж хэрэгжүүлэхийн тулд ажиллаж байгаа. Энэ дээр нэлээн тодорхой олон асуудлууд, Амгалангийн цахилгаан станц, цахилгаан станцын эвдрэлд богино хугацаатайгаар санхүүжилт босгохын тулд онцгой нөхцөл тогтоож, төсвийн тодотголгүйгээр энэ асуудлыг шийдвэрлэх, санхүүжилт гаргах, эрчим хүчний компаниудад урьдчилгаа зээл авах, төрийн өмчийн компаниуд буюу хуримтлагдсан ашгаас санхүүжилт авах гэсэн олон хувилбараар сайд ажиллаж байгаа юм байна лээ.

Ийм учраас цахилгаан станцын эвдрэлд богино хугацаанд дэд станц шугамын насжилтын нэгдсэн аудит хийх шаардлагатай, яаралтай засварын жагсаалт гаргах шаардлагатай, урсгал зардлын санг нэмэгдүүлж, шуурхай засварын бригад, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах гээд энэ олон цогц ажлуудыг хийж байгаа. Энэ реформуудыг хэрэгжүүлэхийн тулд 3 том реформыг хэрэгжүүлж байгаа гэж Ерөнхий сайд маань хэлсэн. Өмнөх Ерөнхий сайд маань. Энэ улираан томъёолох шалтгаан дээр нэгдүгээрт салбарын тогтвортой байдлын либералчлалыг үргэлжлүүлэх шаардлагатай.

Хоёрдугаарт, 24 оноос дамжуулах шугам эх үүсвэрийн томоохон төслүүд, Амгалангийн өргөтгөл, шинэ цахилгаан станцын ТЭЗҮ, 5 дугаар цахилгаан станцын төслүүд хэрэгжиж байгаа.

Гуравдугаарт, хамгийн чухал нь ногоон намтай ч холбоотой үзэл санаа бол сэргээгдэх эрчим хүчний 4 том төслийг Вьетнамын хөрөнгө оруулагчидтай болон шууд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар сэргээгдэх эрчим хүчний томоохон төслүүдийг, дээр нь Эрдэнэбүрэнгийн УЦС, Эгийн голын УЦС гэх мэт сэргээгдэх эрчим хүчний ажлуудыг хэрэгжүүлээд үүрээд явж байгаа учраас энэ реформыг үргэлжлүүлэх нь чухал байна. Эрчим хүчний асуудал чухал бай байна. Ийм учраас хариуцлагыг нь үүрүүлж байгаа юм. Энэ талаар Чойжилсүрэн сайд амлалт, үүргээ авч асуултад хариулна.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн гишүүн нэмэлт хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Гишүүдийнхээ оройн амрыг эрье. Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Нарантуяа гишүүн ээ ийм ТЭЦ 3 дээр 6 сарын 2-ны шөнө харамсалтай зүйл болсон. 9 дүгээр турбин гэмтсэн. Эрдэнэт хүний амь хохирсон, улсад олон 10 тэрбум төгрөгийн хохирол учирсан ийм үйл үйл явдал болсон гэдгийг бас хэлье. Би энэ ослын дараа бол сэтгүүлчид уулзахад бол ёс зүйн хариуцлага хүлээхэд бэлэн байна гэдгээ хэлсэн.

Хоёрдугаарт, хууль зүйн хариуцлага хүлээхэд бол бас 1 зүйлийг бас тодорхой тайлбарлаж хэлэхгүй бол болохгүй нь ээ. 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Засгийн газрын тогтоол гараад эрчим хүчний салбарын ТӨХК-удын

хувьцааны дийлэнх хувийг “Эрчист Монгол” компанид шилжүүлсэн. Энэ асуудал 3 сарын 19-нөөс эхлээд “Эрчист Монгол” компани эрчим хүчний салбарын ТӨК-удын менежментийн эрхийг хэрэгжүүлж байсан гэсэн үг. 6 сарын 2-ны ослын дараа 6 сарын 4-ний Засгийн газрын хуралдаанаар “Эрчист Монгол” компаниас энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Засгийн газарт танилцуулга хийсэн. 6 сарын 10-наас эхлээд буцаагаад Засгийн газрын тогтоол гараад эрчим хүчний салбарын ТӨК-удын хувьцааны дийлэнх хувь буюу 66 хувийг Эрчим хүчний сайд, Эрчим хүчний яаманд буцаагаад шилжүүлсэн. Одоо бид нар ТЭЦ 3 дээр гарсан аваарын нөхцөл байдлыг тодруулах ажлыг тагнуул, цагдаа хамтарсан ажил хэсэг явж байгаа. Мөн үүнээс гадна Ерөнхий сайдын захирамжаар болон Эрчим хүчний сайдын захирамжаар ажлын хэсгүүд гараад сэргээн босгох төлөвлөгөөг ирэх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанд танилцуулна. Эхний ээлжид дулааны асуудлыг шийдэх ёстой. Энэ асуудал ойролцоогоор урьдчилсан байдлаар бидний тооцооллоор 7.4 тэрбум төгрөгөөр дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэдэг байсан горимоос зөвхөн дулаан үйлдвэрлэдэг горим руу зуухны хувьд гэмтээгүй байгаа учраас 9 дүгээр турбинтэй холбоотой зуух ийм ажлыг эхний ээлжид хийж хэрэгжүүлнэ. 9 сарын 15-наас эхлээд 2025-2026 оны өвлийн оргил ачаалал эхлэх учраас энэ.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн тодруулж асууя.

М.Нарантуяа-Нара: Баярлалаа. Тэгэхээр манай ажлын хэсэг цахилгаан станц дээр ажиллахад тэнд бас 1 зүйлийг онцолж харсан. Тэр нь болохоор энэ улсын чухал энэ ач холбогдолтой хүний амь нас, олон мянган, олон сая хүнийг дулаан, цахилгаанаар хангаж байгаа энэ хүчин зүйл бүхий техник, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг тэр Тендерийн тухай хуулиар ингээд авч байгаа нь бас аягүй учир дутагдалтай юм байна лээ шүү.

Яагаад гэвэл Тендерийн тухай хууль чинь хамгийн хямдхан, хамгийн боломжийн үнэтэйг авах ийм заалттай байж байдаг. Гэтэл энд яг энэ эрчим хүчний салбарт ялангуяа энэ чухал ач холбогдолтой техник, технологи дээр тэр мөнгө татаад байх биш хамгийн сайныг нь, хамгийн баталгаатайг нь авах ийм хэрэгцээ шаардлага байгаа юм байна гэж би харсан. Тэгэхээр та бас энийг цаашид анхаараарай.

Мөн түүнчлэн энэ нөгөө маш яаралтай турбин нөгөө авах ажлыг энэ улсын нөөцийн, аюулгүй нөөцийн мөнгө гэж бас байна шүү дээ. Тэгэхээр тэндээс авах бас боломж юу байна? Та тэр боломжийг бас сайн судлаарай гэж.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Одонтуяа: Тэгэхээр би бас шинээр томилогдож байгаа Ундрам гишүүндээ, Батцэцэг гишүүндээ бас баяр хүргэж, амжилт хүсмээр байна. Ялангуяа Батцэцэг сайддаа бас баяр хүргэе. Өнгөрсөн 4 жил олон улсын байдал бас ээдрээтэй, нөхцөл байдал амаргүй үед бас энэ салбарыг нэр хүндтэй удирдаад явсан. Ингээд Монгол Улсын нэр хүндийг өндөрт өргөхөд бас таны оруулсан хувь

нэмэр их чухал байсан. Хамгийн гол нь энэ үед энэ бүх тунг нь яг сайхан тааруулж байсан. Тэгэхээр би танд бас цаашдынх нь ажилд улам их амжилт хүсье.

Би Батбаатар сайдад бас дэмжиж байна, амжилт хүсэж байна. Ингээд хэд хэдэн зүйлийг бас хэлье гэж бодож байна. Бидний үед хэдийгээр цөөхөн сар ажилласан ч гэсэн бид олон чухал реформын сууриудыг тавьсан байгаа. Ялангуяа та бол энэ төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхэд онцгой анхаарч ажилламаар юм билээ. Яагаад гэхлээр бид төрийн зарим чиг үүргийг төрийн бусаа хувийн хэвслээр гүйцэтгүүлнэ ээ гээд их сайхан олон яриад байгаа боловч би сая ингээд л зоригтой шилжүүлбэ гээд л яг ширээний ард суугаад бид хэлэлцээ хийгээд л ингээд л ажиллах гэхээр маш олон хууль, дүрэм, журамд энийг хязгаарлалчихсан байдаг. Ерөөсөө Монгол Улсын төр хувийн хэвшилдээ, ТББ-даа мөнгө өгчихнө гэхээс бүүр байж яддаг. Тэгэхээр энийг бол бид нар их өөрчилмөөр юм билээ.

Ялангуяа байгаль орчны салбар бол дангаараа энэ бүх ачааг үүрч дийлэхгүй. Зөвхөн хувийн хэвшил, ТББ-тайгаа хамтарч энэ ачааг үүрч ард нь гарах юм байна лээ. Тийм учраас энийг таныг бас та манай бас Ардчилсан намд байсан энэ суурь байгаа учраас энэ хувийн хэвшлийг сайн дэмжээрэй гэж хүсэж байна.

Хоёр дахь асуудал энэ дараа жил болох КОП-ын хурал байгаа НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх 17 дугаар бага хурал. Тэгэхээр сая бас Нарантуяа-Нара гишүүн хэллээ шүү дээ. Иргэний зориг ногоон нам сайн дүн авах уу, муу дүн авах уу гэдгийг бид нар бас дүнгээ тавиулна гэж. Тэгэхээр энэ цөлжилтийн хурлыг хэрхэн зохион байгуулснаар бид нар зөвхөн 1 яам биш, 1 нам биш ерөөсөө улсаараа дүнгээ тавиулна. Тийм учраас энэ дээр Монгол Улсын Ерөнхий сайд бас та энэ талаар бас хариулт өгөөрэй. Ер нь энэ хурлаа бид яаж амжилттай хийе гэж бодож байна? Сая Саудын Арабд болсон хуралд нийт 20 мянган хүн оролцоод, 147 орны бүх Байгаль орчны сайд нар, дэд сайд нар, зарим орны Ерөнхий сайдууд ирж байгаа. Тэгэхээр энэ бидний нөгөө ярьж заншсанаар АСЕМ-ийн хурал шиг 4, 5 дахин ийм том хурал байгаа. Тэгэхээр энд бид нар онцгой анхаарч ажиллах ёстой юм байна. Бас 1 чухал ажил бол энэ салбарын 12 хуулийг өргөн бариад хэлэлцүүлэхэд бэлдсэн байгаа. Тэгэхээр дарга 1 би минутаа нэмээд авчихъя Амараа дарга.

Д.Амарбаясгалан: Одонтуяа гишүүнд 1 минут өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ 12 хуулийг бэлдсэн байгаа энийг Батбаатар сайд яаралтай өргөн бариад Улсын Их Хуралд бас гишүүдтэйгээ хамтраад энийг батлуулах юм бол бас энэ салбарын хувьд том алхам болно. Энэ бол тал нь бол шинэчилсэн найруулгын төсөл байгаа. Ялангуяа чухал хууль гэвэл Хөрс хамгаалах хууль, Цөлжилттэй тэмцэх хууль, Усны тухай хууль, Ойн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль гээд хамгийн чухал 12 хууль бол байгаа. Бас нэг чухал зүйл энэ салбарын гадаад харилцаанд бас онцгой та анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Энэ салбарт ерөөсөө байгаль орчны салбарын дипломаси/diplomacy/ гэдэг бол өөрөө маш чухал ийм том салбар болчихсон. Асар их олон сая, олон тэрбум долларууд энэ байгаль орчны салбарт эргэлдэж байдаг. Тэгэхээр эдийн засгийн салбарт бид нар хөрөнгө оруулалт татах

гэхээр ашигтай юм уу ашиггүй юм уу гээд байдаг. Гэтэл энэ салбарт асар их.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ерөнхий сайд хариулт өгье. Нэр дэвшигч, томилогдох этгээдүүд танхимд орж ирье.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн энэ КОП-ын асуудлыг хамгийн сайн мэдэж байгаа хүн. Ямар зовлон, бэрхшээл байгааг өөрөө бол яана одоо баларлаа л гээд явж байсан. Тийм учраас надаас асуултыг өөрөө мэдэж байгаа хүн. Харин ч энэ Батбаатар сайдыг сайн дэмжиж, зөвлөж, хамтарч ажиллахыг танаас хүсэж байна. Яг үнэн хэрэг дээрээ дараа жил болох гэж байгаа КОП-ын хурлын ажил зуун задгай байна. Хаана болох нь ч бараг харанхуй хэвээрээ. Төсөв мөнгө, хөрөнгө оруулалт, зохицуулалт нь. Бусад улсууд чинь 2 жилийн өмнө бараг юмаа хийчхээд, шийдчихээд тэр хурлаа зарладаг байхад энэ асуудал үнэхээр хутга тулгасан асуудал байгаа. Энэ дээр гэрийн дипломси/green diplomasy/ хийгээд таны хэлж байгаа тэр дипломат арга хэрэгсэл, ур чадвар, олон улсын хамтын ажиллагааг энэ цөлжилттэй тэмцэх Монгол Улсын болон дэлхий нийтийн чухал зорилтын талаар энэ дээд хэмжээний уулзалтыг өндөр түвшинд зохион байгуулах хариуцлагыг манай Батбаатар дарга, Батбаатар гишүүн, Батын Батбаатар гишүүн бас хариуцаж ажиллах үүрэг хүлээнэ.

Тэгэхдээ Одонтуяа гишүүн бусад салбарын сайд нартай нягт хамтран ажиллаж байж, улс төрийн маш өндөр дэмжлэгтэй байж байж энэ ажил энэ ард гарна. Энэ бол намын ажил биш, энэ улсын ажил шүү. Монгол Улсын эрх ашиг, нэр хүнд, нүүр царай дэлхий нийтийн өмнө тавьж байгаа асуудал. Ийм учраас манай Одонтуяа гишүүнтэйгээ бас нягт хамтарч ажиллах хэрэгтэй. Одонтуяа гишүүн ч гэсэн сайн дэмжиж ажиллаарай гэж танаас хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Сонгбайгийн Замира гишүүн асуулт асууж, үг хэлье. Баярлалаа.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 4 асуулт байна. Нэгдүгээрт Чойжилсүрэн сайдаас асуумаар байна. Цахилгааны үнэ, халаалтын үнэ дахиж нэмэгдэх үү?

Хоёрдугаарт Чинбүрэн гишүүнээс асуумаар байна. Аутизмтай хүүхдүүд гээд сая Баасанжаргал гишүүн ч хэллээ л дээ. Аутизмтай хүүхдүүд энэ Монгол даяар энэ хотод ирээд Шархадны эмнэлэгт үзүүлж байгаад л группээ тогтоолгодог юм байна. Ингээд Монгол даяар аймгуудыг, сумуудыг чирэгдэл болгохгүйгээр орон нутгаас нь юунд группт гаргаж өгөх боломж байгаа юу? Сангийн сайд Жавхлан сайдаас асуумаар байна. Банкны салбарыг эмх цэгцэд оруулах уу, зээлийн хүүг бууруулах уу? Зам, тээврийн сайдаас асуумаар байна. Одоо манай онгоцны тийз гээд од дотооддоо нисэж байгаа онгоцны тийз гадаад оронд нисэж байгаа онгоцны тийзээс үнэтэй байна. Энийг ер нь ард түмний аж байдлыг харж байж бууруулах боломж байна уу? Ийм 4 асуулт байна. Тэгээд шинэ Засгийн газрыг ард түмэн өндөр хүлээлттэй харж байна. Тийм учраас бага улс төржиж их ажил хийх хэрэгтэй. Монгол оронд газар авсан авлигал, хээл хахуулийн асуудлыг таслан зогсоож байж хөгжил дэвшил ирж, эдийн засаг сэргэж, төр засаг тогтворжих болно. Энийг та бүхэн бүгд мэдэж байгаа гээд бодож байна. Тийм учраас энэ хээл хахууль, авлигын асуудалд шийдвэрт арга хэмжээ авах хэрэгтэй.

Гуравдугаарт, шинэ Засгийн газарт орж байгаа манай Иргэний зориг ногоон нам хамтран ажиллаж байгаад би маш их баяртай байна. Манай Иргэний зориг ногоон намын дарга Батбаатар дарга Байгаль орчны яамыг дээд зэргээр авч явна. Манай Иргэний зориг хамтран ажиллана гээд найдаж байгаа.

Шинэ Засгийн газар, шинээр томилогдож байгаа сайдуудад бүгдэд ажилд нь өндөр амжилт хүсье. Баярлалаа. Нэмж асуух юм байвал тодруулна дараа нь.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье. Жавхлан гишүүн, Болдын Жавхлан гишүүн хариулт өгье.

Б.Жавхлан: Замира гишүүний асуултад хариулъя. Банкны салбарыг эмх цэгцэд оруулах уу гээд төв банкны л эрхэлдэг асуудал л даа. Тэд нар маань илүү их тодорхой хариулт өгөх байх. Яах вэ Засгийн газрын зүгээс тэр дундаа Сангийн яамны зүгээс бид нарын оролцох чадвар суваг гэвэл төсвийн бодлого, мөнгөний бодлого 2-ыг уялдуулснаар энэ макро тэнцвэртэй бодлогыг хангах л асуудал юм байгаа юм.

Макро тэнцвэртэй байдлын асуудал гэдэг маань ерөөсөө эдийн засгийн бүтцийн асуудал болоод л ярина. Түрүүн олон гишүүд асууж байсан Шижир гишүүн ч саяын асууж байсан. Одоо ингээд л валютын ханш, нөөцийн асуудал гээд л ийм тогтворгүй байдал үүсэж байгаа юм байна. Ерөөсөө манай энэ эдийн засгийн ерөнхий бүтэц маань ерөөсөө сүүлийн 30 жил энэ худалдааны эдийн засагтай л явж ирсэн. Энийг бид нар хүчтэй хувийн сектор дээр суурилсан, үйлдвэрлэгч, экспортлогч ийм эдийн засгийн бүтэц рүү л бид нар шилжүүлэх. Шилжүүлэх гол арга зам маань 14 мега төсөл л юм байгаа юм. Ингэж чадваас макро тэнцвэртэй байдал өөрөө дархлаажиж, тэр үед аяндаа энэ өөрөө зээлийн хүү буугаад ирнэ.

Тэгэхээр зээлийн хүү маань өөрөө олон юмнаас шалтгаалдаг бодлогын хүү, тэгээд инфляцын тогтвортой байдал, инфляцын нам доор байдал гээд. Тэгэхээр энийг нэг дор ч юм уу, эсвэл 1 жилд шийддэг асуудал биш. Энэ ерөөсөө томоохон яг бүтцийн өөрчлөлтийн ийм асуудал байдаг учраас Засгийн газар, төв банк 2-ын бодлогын нийцтэй байдал хамгийн чухал байна. Энэний төлөө бид одоо чармайж ажиллана. Ерөнхий сайдын барьж байгаа бодлогууд ч гэсэн мөн энэ рүү яв цав чиглэнэ ээ гэдгийг хэлье. Одоо үүсээд байгаа эдийн засгийн хүндрэл маань, үнэнийг хэлэхэд, зээлийн хүүг бууруулах биш зээлийн хүүг өсгөх ийм эрсдэлтэй ийм орчин бас цаг хугацааны ийм сорилт тулгараад байгаа.

Тийм учраас аль болох ойрын хугацаанд зээлийн хүүг өсгөхгүй байх, энэ түвшинд нь хадгалах, мөнгөний бодлогыг нь илүү хатуу орчин руу оруулахгүй байх, мөн бид төсвийн хэмнэлтийн горимд шилжиж, энийгээ энэ жилдээ, мөн ирэх жилдээ үргэлжлүүлэн тогтвортой барьснаар таны ч саяын хэлж байгаа, хүсэж байгаа, бидний ч зорьж байгаа тэр орчин бий болно гэж үзэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн нэмж хариулъя.

Ж.Чинбүрэн: Замира гишүүний асуултад хариулъя. Ер нь бас хэд хэдэн ч удаа бид аутизмын тухай бас ярьж байх шиг байна. Энэ Ерөнхий сайд ч гэсэн бас

их чухал Трампын бодлогыг бас хэлж өгсөн. Ер нь аутизм гэж юу юм бэ гэхлээр энэ дэлхийд 1000 хүүхэд тутам 10-12 хүүхэд өвддөг. Голдуу эрэгтэй хүүхэд 4 дахин их, эмэгтэй хүүхдээ бодоход илүү өвддөг. Энэ өвчин биш. Энэ хөгжил. Нийгэм нь нийгмийн юу гэх юм бэ дээ хөгжлийн доройтол ч гэж хэлж болохгүй, энийг бүүр яг өвчин ч гэж хэлж болохгүй. Хамгийн гол зүйл эрт оношлох л ёстой. 18-24 сартайд нь оношилж чадах юм бол эрт үед нь нийгэмшүүлэх, эрт үед нь хэл, ярианы гүйцэтгэлд илүү сургах, өөрийгөө арчлах тэр боломжийг олгох энэ үйлдлүүдийг хийх ёстой. Тийм учраас бид аутизмын холбоотой хамтраад Монгол Улсад аутизмын эсрэг ийм бүхэл бүтэн хөтөлбөр хэрэгтэй байгаа гэдгийг зориуд хэлж, энэ дээр онцгой ач холбогдол тавина гэдгийг танд хэлье.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Замира гишүүнийхээ асуултад хариулъя. Орон нутгийн онгоцны тийзийн үнийг бууруулах асуудал тавьж байна. Орон нутгийн онгоцны тийзийн үнийг бид энэ аялал жуулчлалтай холбогдуулж бууруулах дээр ажиллаж байгаа. Яагаад гэвэл өнгөрсөн Засгийн газрын тогтоол гаргаж энэ аялал жуулчлал дээр сезоны үед нь энэ онгоцны тийзийн үнийг бууруулах арга хэмжээ ав гэсний дагуу энэ онгоцны тийзийн үнийг ингээд ойрын үед бууруулна. Тэгэхдээ энд хамгийн чухал гол нөлөөлөх юм бол онгоцны түлшний асуудал бас шууд холбоотой шүү гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Яагаад вэ гэхлээр онгоцны түлш хэрвээ цаашдаа ингээд нэмэгдвэл бид онгоцны тийзийн үнийг бууруулна гэж бас худлаа хэлж болохгүй. Тийм учраас тооцоо.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан гишүүн гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Тийм учраас тооцоо хийгээд тийзийн үнийг ямар хэмжээнд бууруулах боломжтой вэ гэдгийг би бас эргэж танд хэлье. Ер нь аялал жуулчлал илүүтэй явж байгаа ялангуяа Баян-Өлгий, Ховд, энэ Мөрөн, тэгээд энэ Өмнөговийн чиглэлийн энэ онгоцны билетүүдийн үнэ дээр энэ аялал жуулчлалтай холбогдуулж бууруулж байгаа учраас энэ манай иргэдэд бас давхар хамаарна гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн гишүүн хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Замира гишүүний асуултад хариулъя. 2024 оны 11 сарын 1-ний өдрөөс цахилгаан эрчим хүчний үнийг өртөгт нь ойртуулах арга хэмжээ 1 удаа авсан. Улаанбаатар хотын тухайд бол дулааны эрчим хүчний үнийг 2025 оны 5 сарын 16-ны өдрөөс нэмэгдүүлэх ийм шийдвэрийг Эрчим хүчний тухай хуулиар Эрчим хүчний зохицуулах хороо бие дааж шийдэх учиртай ийм шийдвэр гарчихсан байсан. Энэ 2025 оны 2 сарын төгсгөлөөр Засгийн газрын тогтоол гараад энэ үнэ нэмэгдүүлсэн шийдвэрүүдийг 2025 он дуустал нэмж үнэ нэмэгдүүлэхгүй гэсэн ийм шийдвэр гарчихсан байгаа. Эрчим хүчний зохицуулах хороо энэ дээр дараагийнхаа бодлого, шийдвэрийг танилцуулах байх.

Д.Амарбаясгалан: Замира гишүүн тодруулж асууя.

С.Замира: Дэлгэрсайхан сайдаас бас нэг юм тодруулмаар байна. Нэлээд улс орнуудаас манай Монгол оронд нислэг хийж байгаа юм байна шүү дээ. Түрүүн би Казахстан Улсад “Цэнхэр алт” гээд усны асуудлын форум дээр оролцоход тэндхийн парламентын бүлгэмийн даргатай нь уулзсан юм. Тэр үед манай Баян-Өлгий аймаг-Астана-Улаанбаатар гэсэн чиглэлээр Айр Астана гээд онгоцыг буулгаж өгөөч ээ гэсэн хүсэлт тавьсан. Энэ шийдвэрлэх асуудал гэсэн. Энэ тал дээр та дэмжиж ажиллах уу, ямар бодол санаатай байна? Тэр дээр хариу өгчхөөч.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Өмнө нь та өөрөө мэдэж байгаа Казахстан- Баян-Өлгийн хооронд онгоц нисдэг байсан. Энэ нислэгийг сэргээхэд асуудал байхгүй. Яагаад вэ гэхлээр бид аль болохоор гадаад харилцаа, тэнд тэр дундаа агаарынхаа гадаад харилцааг нэлээн өргөжүүлж байгаа.

Хоёрдугаарт бас жуулчдыг хүндрүүлэхгүй байхын тулд шууд орон нутагт нь буух, буулгах ийм арга хэмжээ авч байгаа учраас энэ дамжин нисэх Астана-Баян-Өлгий-Улаанбаатар гэсэн энэ дамжин нисэх нислэгийг бид бас эргээд Иргэний нисэхийн үндэсний төвтэйгөө яриад тэгээд танд мэдэгдье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Ц.Баатархүү: Маш хариуцлагатай ажилд нэр дэвшиж байгаа сайдууддаа амжилт хүсье. Би хэдхэн санал хэлэх гэсэн юм. Бүгдийг биш чухлыг, хэлбэр биш агуулгыг харж шинэ нэр дэвшиж байгаа сайдууд ажиллана гэж бодож байна. Үр дагавартай биш учир шалтгаантай тэмцэж, үндсэн шалтгааныг нь олж илрүүлж асуудлыг шийднэ ээ гэж найдаж байна. Бидний 30 жилийн түүх үр дагавартай нь тэмцсэн. Утаатай, яндантай, зуухтай, түлштэй тэмцсэн учир шалтгаантай нь ажиллаагүй. Шинээр очиж байгаа сайдууд салбарынхаа бүх зүйлд оролцох гэж оролдох нь алдаа болох байх гэж бодож байна. 1 асуудлыг өнгөрсөн 3 жилийн хугацаанд 1 сайд Монгол Улсын өмнө тулгамдсан 1 асуудлыг шийдчих юм бол Монгол Улсын 20 асуудал шийдэгдэнэ. Нэг мөсөн шийдэгдэнэ. Нэг л том реформыг хийгээсэй гэж бодож байна. Үүнийг хийхийн тулд зүйл дээр та бүхэн маань анхаараасай гэж бодож байна. Энэ хөгжлийн хөтөлбөр, бидний энэ бодлогын бичиг баримтууд дандаа сайн сайхан зүйлийн жагсаалтууд байдаг. Хийх ёстой бүх зүйлийн жагсаалт байдаг. Тэгээд хойноос нь улсын төсөв тавиулах гэж хөөцөлдөнө. Мэдээж төсөв хүрэхгүй. Тэгэхээр төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа аль төслийг нь эхэлж хийх юм нөгөө төсөлдөө ямар нөлөө үзүүлэх юм бэ, хэдэн хувиар эерэг нөлөө үзүүлэх юм, хэдэн хувиар сөрөг нөлөө үзүүлэх юм бэ гэдэг төслүүдийн уялдааг маш сайн гаргаасай гэж бодож байна.

Хоёрдугаарт нь салбарынхаа энэ мастер төлөвлөгөө гэдэг зүйлийг хамгийн түрүүнд харж, энийг чиг баримтлалаа болгож ажиллаасай гэж бодож байна.

Ерөнхий сайдад хандаж 2 зүйлийг хэлье. Монгол Улсын Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн тэргүүнээр Ерөнхий сайд ажилладаг. Сүүлийн 30 жил Монгол Улс хүүхдийн байгууламж, хүүхдийн бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжлийн төлөө томоохон төслийг хийгээгүй юм байна лээ. 10 жилийн сургуулиудынх нь биеийн тамирын талбай орон сууцын барилгууд болж хувирсан. Хүүхдүүд зундаа амардаг зуслангууд нь насанд хүрэгчдийн амралт, амралтын бааз болсон. Хүүхдийн номын

ордон банк болж хувирсан. Тэгэхээр Монголчуудын итгэл, сэтгэлээр хүүхдийн төлөө фондод 25 тэрбум төгрөг байна. Энэ мөнгийг Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн төлөө хамгийн оновчтой зүйлд энэ жилээс эхлүүлээд зориг гаргаад шийдэж зарцуулаасай гэж бодож байна. Хоёрдугаарт нь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Баатархүү гишүүнд минут нэмж өгье.

Ц.Баатархүү: Нийслэл Улаанбаатар хотын хөгжилд онцгой их анхаараасай. Хүн амын 50 хувь нь байна. Инженерийн дэд бүтцийн хүрэлцээгүй байдалд иргэд маань амьдарч байна. Өнгөрсөн Оюун-Эрдэнийн Засгийн газар бид нар нийслэл Улаанбаатар хотын шуурхай хуралдааныг хийдэг байсан. Тодорхой хэмжээнд үр дүнд хүрсэн. Харилцаа холбооны компаниуд өнөөдөр Улаанбаатар хотын агаар орчин, үнэр, дуу чимээний бохирдлыг бууруулахын тулд “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд хамгийн олон мод ургуулж ядсан айл өрхүүдийг өөрсдийнхөө хэмжээнд урамшуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан энэ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж байгаагаа зарласан. Яг үүн шиг салбар салбараараа Улаанбаатар хотыг дэд бүтэцтэй болгох, ногоон болгох, карбон кредит системтэй уялдуулах энэ чиглэлд Ерөнхий сайд илүү их анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Ингээд шинэ баг бүрэлдэхүүнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Мөнхбат: Шинэ Засгийн газрын бүрэлдэхүүнд орж ажиллах болж байгаа эрхэм сайд нарт бас ажлын амжилт хүсье. Тэгээд өнгөрсөн Засгийн газарт бас сайн ажиллаж байсан зарим сайд нар энэ Засгийн газарт үргэлжлүүлээд ажиллаж байгаа явдалд нь талархалтай байна. Жишээ нь манай Дэлгэрсайхан сайд байна. Учрал сайд, Батцэцэг сайд, Наранбаяр сайд, Амарсайхан сайд гэх мэтчилэн сайд нартаа ажлын амжилт хүсэж байна. Мөн шинээр томилогдож байгаа бас олон сайхан залуучууд бас сайд болж байгаад нь амжилт хүсье. Ялангуяа энэ Бат-Амгалан сайддаа энэ Барилга, орон сууцжуулалтын сайдаар томилогдож байгаа явдалд нь баяр хүргэж, амжилт хүсье.

Тэгээд бидний чухал зүйл бол энэ бүсчилсэн хөгжил, түүний ар дээр хөдөөгийн хөгжил гэж байгаа. Тэгээд Барилга, хот байгуулалтын сайд Батсуурь сайдын үед эхлүүлсэн энэ орон нутагт орон сууцжуулах энэ асуудлыг үргэлжлүүлээд ингээд яваасай гэж танаас хүсэж байна. Таныг бүрэн дүүрэн тэр тал дээр дэмжих байх гэж ингэж бодож байна.

Энэ Эрчим хүчний сайдаас юм асууя. Энэ 2019 онд энэ Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж бид нар энэ сэргээгдэх эрчим хүчний зөвшөөрлийг сонгон шалгаруулж өгдөг болсон юм байна лээ. 19 оноос хойш энэ өөрчлөлт орсны дараагаас хойш 1 ч төсөл яваагүй, 1 ч зөвшөөрөл олгогдоогүй. Энэ ямар учиртай байдаг юм, юундаа байгаад энэ зөвшөөрөл нь олгогддоггүй юм бэ? Энэнээс болоод олон гадна, дотнын хөрөнгө оруулалтууд ингээд дагаад зогсчихдог, хүлээгээд байгаад байдаг ийм асуудал байна. Энэ дээр хариу өгөөч гэж ингэж хүсэж байна.

Хоёрдугаарт энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаас Батбаатар сайдаас асууя. Манай энэ говийн бүс, Монгол Улс өөрөө ер нь

үндсэндээ 70-н хэдэн хувь нь цөлжчихсэн. Тэр дундаа энэ говийн бүс нутаг бол энэ цөлжилтөд хамгийн их өртөж байгаа ийм бүс нутаг. Түрүүн бас манай зарим гишүүд асууж байна энэ гадаргын усыг говь руу чиглүүлэх тал дээр энэ Одонтуяа сайдын хувьд хийж хэрэгжүүлж байсан энэ ажлуудыг үргэлжлүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Ялангуяа энэ сум болгонд хөв цөөрөм бий болгох, энэ үерийн усыг хуримтлуулах гэх чиглэлийн энэ ажлууд дээр бол бид нар онцгой анхаарч үргэлжлүүлж ингээд явах

Д.Амарбаясгалан: 1 минут нэмдгийн дэгийнхээ учрыг л манайхан ерөөсөө ойлгохоо байчхаад байна шүү дээ. Хүн болгон 1 минутаа албатай юм шиг нэмж авдаг боллоо шүү. Мөнхбат гишүүндээ 1 минут нэмж өгье.

Ц.Мөнхбат: Тэгэхээр зэрэг энэ говийн бүс рүү энэ олон улсын байгаль орчны чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдийг чиглүүлэх тал дээр, энэ гадаргын усны сая хэдхэн хоногийн өмнө нээлтээ хийж байсан тэр Онги-Цагаан Бургастайн усны төсөл энэ тэрийг бол нэн тэргүүнд явуулах ийм шаардлагууд байгаа. Энэ дээр таныг нэлээн сайн судалж, хуучин энэ яамны боловсон хүчнүүдтэй сайхан хамтраад ингээд ажиллахыг хүсэж байна. Тэгээд энэ төслүүд дээр бид нар энэ байгаль орчин, уур амьсгалын чиглэлийн энэ бүх асуудлууд дээр өдөр тутам анхаарал хандуулж ажиллана. Тэгэхээр зэрэг тантай хамгийн их харьцах, хамтарч ажиллах ийм л хүмүүс. Тийм болохоор таныг энэ тал дээр илүү их ажиллаарай гэж ингэж хүсье.

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлье. Уучлаарай Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Мөнхбат гишүүний асуултад хариулъя. 2019 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулаад тендерээр буюу уралдаант сонгон шалгаруулалтаар төсөл хэрэгжүүлэх ийм хуулийн өөрчлөлт орсон. Түүнээс хойш шинээр тусгай зөвшөөрөл бичигдээгүй байгаа нь үнэн. Гол шалтгаан бол нар болон салхины цахилгаан станц барьсан тохиолдолд нар ороод, салхи зогссон үед бол бид нар энэ энэ чадлыг аль нэг газар нөөцлөх учиртай. Ийм нөөцлөх бололцоо агшин зуурт майнерварлах чадвартай ийм станцууд байхгүй, газ юм уу, усан станцууд байхгүй байгаа учраас өнөөдрийн байдлаар энэ тусгай зөвшөөрлүүд, төслүүд явахгүй байгаа юм.

Гэхдээ сүүлийн үед бид нар энэ энд Вьетнамын хөрөнгө оруулалтын компани 400мвт-аар 4 цагийн туршид гаргаж чадах ийм батарей станцуудыг 4 байршил дээр өөрийн хөрөнгө оруулалт барья гэсэн ийм шийдвэр гаргаад явж байна. Энэ батарей станц ашиглалтад орсон тохиолдолд бид нар чадал нөөцлөх бололцоо бүрдэж байгаа учраас 3 багц тендерийн бэлтгэл ажлыг хийгээд явж байгаа юм. Эхнийх нь бол баруун бүс дээр нийтдээ 60 мегаваттын нарны цахилгаан станц, 50мвт-ын хүчин чадалтай эзлэх чадал нь бол 180мвт цагийн багтаамжтай батарей хураагуурын станцын тендер зарлахаар төслийн бэлтгэл ажил хийгээд явж байгаа 1 ийм багц ажил байна.

2 дахь багц нь бол зүүн бүсийн эрчим хүчний системд холбогдохоор 55мвт-ын нарны цахилгаан станц, 25мвт-ын-ын батарей хуримтлуур эзлэх үнэ нь бол 70мвт-ын цаг багтаамжтай байхаар батарей ийм 2 багц тендер зарлахаар эрчим

хүчний тухай хуулийн дагуу бид нар бэлтгэл ажлыг хийгээд энэ ондоо багтаад ийм зорилго тавиад явж байгаа.

Гуравдугаарт нь Дэлхийн банк олон улсын санхүүгийн корпорацтай хамтраад 100мвт-ын хүчин чадалтай салхин цахилгаан станцын төслийг өрсөлдөөн сонгон шалгаруулалтаар бас зарлаж үзье гэдэг ийм 3 багц ажлын бэлтгэл ажил хийгээд явж байгаа. Энэ 2024, 2025 оны 2 дугаар хагас, 2026 оны эхний хагастаа багтаад ийм сэргээгдэх эрчим хүчний тухайд 3 төслийн бэлтгэл ажил хангаад явж байгаа гэдэг ийм л мэдээлэл байна.

Д.Амарбаясгалан: Жудгийн Баярмаа гишүүн асуулт асууя. Үг хэлье.

Ж.Баярмаа: Бид нар өмнөх гишүүд ч зөндөө л дурдсан байх. Нөгөө төрийг цомхон болгоно гээд Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт ч бас бүүр өгүүлбэрээрээ тусчихсан байгаа юм. Төрийн албыг цомхон, чадварлаг болгоно гээд. Энэнтэй холбоотой энэ 20 сайд чинь яг яахаар болчхов? Тодотголтой цуг цоо шинэ бүтэц орж ирээд тэгэхдээ энэ 20 сайд буюу энэ яамнуудын чинь тоо цөөрөхөөр байгаа юм уу, эс үгүй бол энэ чигтээ ингээд үлдэх гэж байгаа юм уу гэдэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт энэ сайд нарыгаа үлдээж байгаа шалгуурууд нь ер нь юу юм болоо гээд? Мэдээж зарим нэгэн сайдууд сайн ажилласан л гэж байна. Тааруу ажилласан л гэж байна. Гэтэл нийгэм бас хэнийг яаж дүгнэж байгаа юм болоо гэдэг асуулт байна. Шулуухан хэлэхэд би Сангийн сайдыг үлдээж байгааг бас жоохон гайхаж байна л даа.

Тэгэхдээ яах вэ нөгөө тодотгол орж ирээд бүтэц өөрчлөгдөхөөр өөрчлөх гэж байгаа юм уу, үгүй юү мэдэхгүй байна. Одоо бид нар чинь гишүүн болоод жил болоогүй хугацаанд 4 дэх тодотголоо хийх гэж байна. Тэгэхээр ер нь бол сонгодог парламент, сонгодог засаглалтай улсад бол төсвөөс болж их асуудал үүсдэг. Төсвийн тодотгол хийгдэж байна гэдэг чинь тооцоолол буруу байсан байна, төлөвлөлт буруу байсан байна. л гэсэн үг. Гэтэл 1 жилд 4 дэх тодотголоо хийх гээд, яах вэ тодотгол л юу байх вэ дээ 4 дэх төсвөө батлах гээд явж байна гэдэг энэ хэний хариуцлагатай холбоотой юм? Би Жавхлан сайдад хувь хүнд ямар ч асуудал байхгүй зүгээр энэ тодотгол энэ олон хийж байгаа нь өөрөө асуудал биш үү гэдэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт магадгүй бас Жавхлан сайдад хариулж магадгүй юм л даа. Одоо энэ татварын багц хууль орж ирэхэд энэ танай намын бодлогод ч байна, энэ Засгийн газрын хөтөлбөрт ч гэсэн энэ 3.2.1.4 бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулна гээд. Тэгэхээр дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах ямар бодлого баримтлах юм бол? Тэгэхгүй бол статистикаар бол хувь хүний орлогын албан татварын тайлангаар 24 онд 10 саяас дээш цалинтай иргэд 8 мянга л байдаг юм байна. Тэгээд энийгээ бид нар дунд орлоготой иргэн, эсвэл өндөр орлоготой иргэн гэж үзэж байгаа юм уу? Ер нь бага орлоготой иргэн нь хэдээс хэд байдаг юм? Тэгээд? Энэ 8 мянга гэдэг тоо чинь 50, 100 мянга хүрч байж сая бид нар тэр нөгөө брэйн дрэйн/brain drain/ ингээд гадагшаа цувах энэ цуваа зогсоох ийм магадлал үүсэх юм. Тэгэхгүй бол энэ өндөр ачаалалтай татвараас болоод Монголд ажил хийх сонирхолтой хүн бүүр байхгүй болж байна. Болж л өгвөл гадагшаа гарахыг хүсэж байна. Энэнтэй холбоотой

судалгаа ч байдаг бүүр 65 хүртэлх насны 18-аас билүү 65 хувь нь боломж олдвол гадагшаа гарна гэсэн байгаа юм.

Тэгэхээр дундаж иргэдийнхээ энэ орлогыг өөрсдөд нь бас үлдээх энэ бодлогыг баримтлахгүй бол энэ дундаж орлоготой иргэд чинь энэ инфляц, энэ үнийн өсөлтдөө идэгдээд доошоо бага орлоготой иргэд болох гээд байна. Бага орлоготой иргэд маань бүүр нөгөө өмнөх сайдууд тодорхойлсончлон ул руу явах гээд байна. Тэгэхээр энэ дээр ямар бодлого баримтлах юм бол?

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Ж.Баярмаа: Тэгээд энэ татварын багц хууль чинь яаж орж ирэх юм? Хуучин төслөөр явж байгаа дээр бол тийм дорвитой шинэчлэл харагдахгүй байгаа. Ялангуяа хувь хүн дээр бол 80 орчим мянган төгрөгийн л юу гэх юм бэ дээ өгөөж үлдэх ийм шинжтэй харагдсан. Тэгэхээр энийг бол танай Засгийн газар нэлээн дорвитой өөрчлөхгүй бол энэ иргэдээ ерөөсөө алдаад дуусах нь ээ залуучууд аа.

2 үндсэн шалтгаанаар гадагшаа явдаг тээ? Мэдээж залуучууд бол үргэлж гадагшаа тэмүүлдэг, эсвэл нөгөө өндөр боловсролтой ийм хүмүүс нь гадагшаа явж байна. Тэгэхээр энэ дээр ер нь энэ иргэдээ Монгол Улсдаа тогтоох чиглэлээр ямар бодлого баримталж ажиллах вэ? 1 асуулт энэ сайд нарыг урамшуулал, цалинтай холбоотой энэ гадаад улсуудын жишээг та авч хэрэгжүүлэх үү? Жишээлбэл Сингапурын жишээ ДНБ-ий өсөлттэй хамааруулж сайд нарын, Их Хурлын гишүүдийнх ч бас байж болно цалин, эсвэл урамшууллыг тогтоодог ч юм уу энэ систем рүү оруулж хариуцлагажуулахгүй бол ерөөсөө ингээд л ямар ч хариуцлага байхгүй. Баахан сайд.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Хариулт өгье Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Ер нь төрийг цомхон, чадварлаг болгох ганц, хоёр яамны тоо хэмнээд л дэд сайд энэ тэрийг байхгүй болгосноороо дорвитой хэмнэлт гарахгүй юм билээ. Бүх газруудад чиг үүргийн давхардал байна, бүтцийн давхардал байна. Жишээлбэл, Инновац, цахим бодлого, харилцаа холбооны газар гэхэд л И-Монголиа, Дата төв, зохицуулах хороо, агентлаг. Энийг цэгцлэхэд л 20 тэрбум төгрөг хэмнэх бололцоотой. Энэ бол бараг 10 яамны төсөв юу үйл ажиллагааны зардлын хувьд. Тэгээд л сандал ширээ, тамга тэмдэг, бланк, 1 үсэг өөрчлөгдөхөд л баахан тэмдэг болоод л тэрнээс дээш зардал болж байснаас нийт төрийн албаны түвшинд цомхон чадварлаг бодох төсвийн хэмнэлтийн тодотголыг бид оруулж ирнэ гэж төлөвлөж байгаа. Үүгээр төрийн албыг 9 хувиар цомхотгохоор төрийн аттестатчилал, төрийн албаны аттестатчилал болон чиг үүргийн давхардлыг шинжилж байна.

Нэгдүгээрт энэ чиг үүргийн давхардлууд жишээлбэл, эрчим хүчний төв, зохицуулах, эрчим хүчний салбарт л гэхэд л 3, 4 толгойтой. Эрчим хүчний компани, агентлаг ингээд давхардлууд бий болчихсон. Энэ одоо ингээд өнөөдрийн бас хариуцлагагүй байдал, дэлбэрэлт энэ тэртэй ч зарим талаас шууд холбоотой. Хариуцлага хүлээх эзэнгүй. Ингэж чиг үүргийн давхардал болгоныг хэмжиж үзээд нэгдүгээрт чиг үүргийн давхардлаар.

Хоёрдугаарт энэ төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх. Тэр цахимжуулалт, инновац, E-Mongolia-тай холбоотой зарим ажлыг хувийн хэвслүүд гүйцэтгээд байж байна. Дата энэ хиймэл оюун ухааны эрин үе.

Гуравдугаарт өмч хувьчлал болон төрийн албаны бүтцийн өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх. Төрийн албаны төрийн компанийн шинэчлэл. Төрийн албаны чиг үүргийн шинэчлэл гээд энэ цогцоороо ийм 5 багцаар тулгуурласан цогцоороо энэ чиг үүрэг давхардал, цахимжилт, цахимжилтаар бас олон ажил үүрэг чиг үүрэг хэмнэгдэж болж байна. Ийм 5 чиг баримжаатай төрийн албаны энэ цомхон чадварлаг гэсэн тэр бүтцийг углуургаар нь хэрэгжүүлэхийг зорьж байна. Ингэснээрээ төрийн оролцоог ч бас хязгаарлах, хувийн хэвшлийг ч дэмжих цогц бодлоготойгоо уялдана. Энийг төсвийн тодотголоор оруулж төсвийн тодотгол ийм л болж байгаа юм. Сайд нарыг улируулдаг бол тодорхой шалгуур би түрүүн хэлсэн. Жишээлбэл, гадаад бодлого тогтвортой байх ёстой. Гадаад ертөнцөд манай нэр хүнд гадаад бодлогын үйл ажиллагаа сайн байгааг та бүхэн мэдэж байгаа.

Ингээд дэлгэрүүлээд ярих юм бол хүн болгоноор Сангийн яаман дээр гэхэд бид экспортын зөвлөл энэ “Онтри”-тэй хийж байгаа яриа хэлэлцээр, татварын маргаан, одоо арбитр руу 9 сард очих гэж байна олон улсын арбитр руу. Дараа нь дээр нь энэ хил гааль, боомттой холбоотой зохицуулалт, экспортыг нэмэгдүүлэх бодлого төсөв бүгд Сангийн яаман дээр энэ үргэлжлээд явж байна. Ахиад л шинэ хүн тавьдаг энэ гол гол түлхүүр мега төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд энэ татварын реформ дээр ч гэсэн ахиад л шинэ хүн тавиад л ахиад л 6 сар, ахиад энэ төсвийн тодотголыг хийгээд хэдэн хоног суугаад хийчихсэн энэ яамнууд чинь энийгээ хэрэгжүүлэхгүй бол өөр хүн ирээд энийг ойлгох гээд ахиад хэдэн сар. Бид нарт ингээд зогсох цаг, эрх алга. Төрийн алба тасралтгүй явж байж өнөөдрийн дэлхий ертөнц гадна талдаа ийм хүнд дайны нөхцөл байдал хүндэрч гео стратеги, геополитикийн байдал хүндэрч, улам тодорхойгүй болж байхад бид бодлогын тогтвортой байдлаа хадгалах хэрэгтэй.

Ер нь тэгээд Сангийн сайд хэзээ ч сайн нэртэй байдаггүй юм. Дандаа толгой сэгсэрч байх ёстой төрийн сан барьж байгаа хүн бүх хүнд их найрсаг сайн харагддаг хүн бол муу сангийн сайд гэж олон улсад хэлэгддэг. Дэндүү сайхан зантай байх юм бол төрийн сан төсвийн алдагдал ч нэмэгддэг. Тэгэхдээ бүх шатад хариуцлага сахилгыг нэмж шахаж ажиллана. Татварын реформын талаар ч гэсэн бүх хүмүүст оногдоно шүү дээ. 800 мянган төгрөгийн. 10 саяын цалинтай хүн байсан ч гэсэн 800 мянган төгрөг хүртэл нь хөнгөлөгдөнө, 1 хувь болно энэ тэр гээд. Тэгэхдээ энийг бид татварын реформыг бас нэлээн гүнзгийрүүлж төсвийн хуультай 8, 9 .../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан гишүүн нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Шинэ Их Хурал дангаар өргөснөөсөө хойш хуулийн хүрээнд өргөн баригдсан 2 дахь удаагийн тодотголыг удахгүй хэлэлцэнэ. 2 дахь удаагийн шүү 4 биш нэгдүгээрт.

Хоёрдугаарт татварын реформыг сүүлийн 1, 2 сарын дотор бэлдчихсэн зүйл биш ээ. Энэ сүүлийн бид 2-3 жилийн хугацаанд бэлдэж байгаа юм. 2-3 жилийн хугацаанд. Яг энийг бүхэлд нь ярина гэвэл хэдэн өдөр ярих сэдэв. Таны асуусан яг

нюанстай юмнууд дээр чинь тодорхой хариулт өгье гэж ингэж бодож байна. Татвар ноогдуулахаар иргэдийн орлогын түвшнээр нь бага, дунд, өндөр орлоготой гэж ялгагдаггүй, ялгагдаггүй. Энэ удаагийн татварын онцлог бол прогрессив буюу шаталсан татварын ийм систем рүү шилжинэ. Энэ иргэд дээр хэд хэдэн сувгаар нөлөөлж очлоо. НӨАТ-ын хуулиар Хувь хүний орлогын албан татварын хуулиар, мөн Аж ахуйн нэгжийн орлогын.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан гишүүн гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Тухайлбал, НӨАТ энд худалдан авалтын түвшин хэмжээ хязгаар ялгахгүй. 1 өрх жишээ нь 2 сая төгрөгийн хүнс худалдан авалт хийдэг бол 4 ам бүлтэй байлаа гэхэд 4 ам бүл дээрээ хуваагаад 500, 500 мянгаар НӨАТ-аа бичүүлэхэд тэр өрх тэр сардаа жишээ нь НӨАТ-ын буцаан авалт 100 хувь буцааж авах жишээтэй.

Тэгэхээр тэр бол өрхөөр нь, орлогоор нь ерөөсөө ялгаж байгаа зүйл биш. 10 сая төгрөгийн худалдан авалт хийдэг өрх бол эхний 2 сая төгрөг дээрээ саяын миний хэлдэг зохицуулалтыг хийхэд бас л ингээд л худалдан авалт нь тэр хэмжээгээр буураад л явчихна. Хувь хүний орлогын албан татвар дээр жишээ нь дунджаар 2.3 сая ийм ер нь цалингийн системтэй юм манайх 1 хүний. Тэгэхээр эхний 800 мянган төгрөг дээрээ татвар нь бүрэн чөлөөлөгдчихнө. Үлдсэн хэмжээ дээрээ хуучнаараа 10 мянгаараа, 10 хувиараа төлөөд л явна. Тэрнээс биш бага.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Тэгэхээр Сангийн сайд Жавхлан 2021 оноос хойш ажиллаад төсвийн зардал 2 дахин нэмэгдсэн. Тэгээд 15 их наяд байсан төсөв 30 их наяд болсон, юмны үнэ 33 хувиар нэмэгдсэн, ханш 20 хувиар суларсан, зээлийн хүү 5.2 функтээр өссөн, гадаад өр 12 хувиар өссөн, төлбөрийн тэнцлийн урсгал, зардлын алдагдал 55 хувиар өссөн. Тэгэхээр өмнөх Засгийн газар унахад гол нөлөөлсөн хүмүүсийн 1 бол Жавхлан сайд. Тэгээд тоон үзүүлэлтээр чадахгүй гэдэг нь тодорхой байгаад байхад Монгол Ардын намд өөр Сангийн сайд хийх хүн байхгүй байгаад байгаа юм уу гэж асууя.

Жавхлан сайдаас бас асууя. Анх гишүүн болоод асууж байсан 100 тэрбум төгрөгөөр 24 сумд Соёлын төв барих хэрэг байгаа юм уу? Тэрнийхээ оронд ач холбогдлоор нь эрчим хүчний төслүүдээ явуулж болохгүй юм уу гээд асууж байсан. Тухайн үед таны байр суурь Соёлын төвүүдээ барих хэрэгтэй гэж байсан. Өнөөдөр ахиад асууя. Та энэ байр суурь дээрээ байгаа юу?

Дараагийн бол Чойжилсүрэн сайд 2022 оноос хойш Эрчим хүчний сайд хийж байгаа. Энэ хугацаанд салбарт ямар ч шинэчлэл хийгдээгүй. Оюун-Эрдэнийн Ерөнхий сайд эрчим хүчний реформыг маш зоригтой эхлүүлсэн. Гэхдээ тэр хүний хийсэн алдаа нь Чойжилсүрэн сайдыг Эрчим хүчний сайдаар өөрийнхөө кабинетад авсан гэж би харж байгаа юм. Тэгэхээр Занданшатар Ерөнхий сайд та энэ алдааг давтаад хийх гэж байна гэж харж байна.

Яагаад гэхээр өнгөрсөн өвөл иргэдээ хуучин цахилгаан станцууд дэлбэрэхэд бэлэн болчихоод байна гээд айлгаж байгаад үнэ, тарифаа нэмсэн. Үр

дүнд нь 550 тэрбумыг бид нар цуглуулсан. Яг бодитоор 77 тэрбум нь л хуучин цахилгаан станцуудыг шинэчлэхэд орсон. Тэгээд Чойжилсүрэн сайд 2 л төслийг хөдөлгөхийн төлөө явсан. Нэг нь бодийн гэгддэг Бөөрөлжүүтийн 300мвт-ын цахилгаан станц. Нийслэлээс 300 тэрбум төгрөгийг бондоос аваад өгсөн. Дараагийнх нь Баянгийн гэгддэг эсвэл өөрийнх нь ч гэж хүмүүс ярьдаг 600мвт-ын цахилгаан станцын төсөл байгаа юм. Бусад төслүүдийг бүгдийг нь хав дараад явуулаагүй. Бусад хөрөнгө оруулагч нар жижиг цахилгаан станцууд бүх төслүүд зогссон. Энийг бүгдээрээ мэдэж байгаа юм.

Тэгээд Занданшатар Ерөнхий сайдаас бас асуумаар байна. Энэ Эрчим хүч, Зам тээвэр, барилгын яамандаа бүгдийг нь нэгтгээд Дэд бүтцийн яам гэж болгоод төслүүдээ ач холбогдлоор нь эрэмбэлээд уялдаа холбоотой явуулчхаж болохгүй байсан юм уу? Дээрээс нь энэ таны Засгийн газар хэрвээ унах эсэргүүцэлтэй тулгарах юм бол энэ сөрөг хүчнээс байхгүй гэж харж байна. Өнөөдөр таны кабинетдаа авч томилж байгаа Сангийн сайдын буруу бодлого Эрчим хүчний сайдын эс үйлдэхүйгээс болж энэ эрсдэл үүсэх байх гэдгийг өнөөдөр би танд анхааруулж хэлье гэж бодсон юм. Тэгээд бас өнөөдөр л гэхэд би Монголын түрийвчийг барьж байгаа Жавхлан сайд дээрээс нь Монголын хамгийн баян хүмүүсийн нэг Чойжилсүрэн сайдын эсрэг үг хэлчихлээ. Тэгэхээр энэ дээр гомдоод ч байдаг юм уу, 1 минутаа нэмээд авчихъя тэгэх үү?

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

С.Цэнгүүн: Тэгэхээр энэ дээр гомдоод ч байдаг юм уу эсвэл сошиалаар янз бүрээр над руу гүтгэлэг, дайралтууд ирээд ийм байдлуудаар ажиллах уу? Өмнөх Засгийн газарт энэ маш хүнд байсан. Тэрнээс болж Улсын Их Хурлын гишүүд бас айдаст автсан. Тэгэхээр Улсын Их Хурлын маш том сөрөг хүчин болж Ардчилсан намын гишүүд гарч байгаа юм. Тэгэхээр бид бүхэн хүчтэй дуу хоолойгоо илэрхийлээд явна. Тэгэхээр сөрөг хүчин хийх орон зайг бас өгөх үү гэдгийг Занданшатар Ерөнхий сайдаас асууя. Үгүй ээ тэгээд хууль хяналтын байгууллагууд болон сошиалаараа дайруулаад байдаг биз дээ?

Д.Амарбаясгалан: Гишүүн асуулт асууж байна. Хариулт өгье Ерөнхий сайд.

Г.Занданшатар: Гишүүний асуултад хариулъя. Ер нь би Засгийн газрын гишүүдэд 1 үндсэн шаардлага тавина. Энэ хариуцлагатай, ёс зүйтэй байх. Үүний тулд Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах. Энэ бол парламентат ёсны зарчим. Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтнууд тэр дотроо Засгийн газрын гишүүд Улсын Их Хурлын чуулгандаа оролцож, гишүүдийн асуултад хариулж, Улсын Их Хуралд хүндэтгэлтэй ханддаг байхыг би зарчмаа болгож бүх сайд нараас танхимын эхний хурал дээрээ би хариуцлагын гэрээ байгуулж ажиллана гэж бодож байгаа.

Хоёрдугаарт, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, аливаа хувийн ашиг сонирхол, аливаа нөлөөллөөс ангид байхыг шаардаж ажилла. Ийм сэжим, сэжүүр, баримт гарах юм бол шууд ажлаас чөлөөлөх болно шүү гэдгийг анхааруулж байгаа юм. Энэ бас парламент ёсны зарчим. Тийм учраас сөрөг, эерэг хүчиндээ ч гол биш, нийт Улсын Их Хурлын гишүүддээ, сайд нартаа хүндэтгэлтэй ханддаг, хамтарч ажилладаг, асуултад нь, хариултад нь хүндрэлтэй хандаг байх ёстой.

Хоёрдугаарт гишүүд ч гэсэн бас бодлогын мэтгэлцээнийг илүү хувийн шинж чанартай биш бодлогын мэтгэлцээн өрнүүлж, тухайн салбар дээр нь эрчим хүчний салбар, бусад салбарууд дээр ийм бодлогын мэтгэлцээн өрнүүлэхийг дэмжиж ажиллана. Эрүүл байхыг, бид эрүүл нийгмийг хүсэж байгаа юм бол, эрүүл ардчилсан тогтолцоог хүсэж байгаа юм бол эрүүл мэтгэлцээн, нотолгоонд суурилсан бодит мэтгэлцээн өрнүүлдэг байх л зарчмыг хандаж ирнэ. Тэгэхээр чөтгөр детальд гэж ер нь тоонд байдаг гэж санхүүчид ярьдаг юм.

Тийм учраас тоо бол өнөөдрийн нөхцөл байдал бол 1 хүний буруу гэхээсээ илүү дэлхий даяар болж байгаа тарифын дайн, геополитикийн нөхцөл байдал, геостратик, бензиний үнэ өсөж байгаа Ойрх Дорнодын нөхцөл байдал, Израил, Ираны дайн, гаднаа энэ хүйтэрч байгаа нөхцөл байдал нүүрсний үнийг 2 дахин унагаад одоо 40, 50 хувиар унаж байна. Бидний хамгийн сайн сенараар тооцоход үнэ өртөг бол хэдийгээр биет хэмжээ харьцангуй гайгүй юм шиг болж байгаа боловч Хятадын эдийн засагт болж байгаа дарамт, чөлөөлөлтүүд бидэнд энэ төсвийн сахилга батаа чангатгахаас өөр энэ уламжлал туршлагатай хүн тоон дээр ажиллахаас өөр аргагүй нөхцөл байдлыг бий болгож байгаа. Субъектив хандахаасаа илүү бид объектив хандах ёстой. Нүүрсний үнэ 50 хувьд хямдарсан төдийгүй манай эдийн засагт энийгээ дагаад экспорт, гадаад хөрөнгө оруулалт, валютын ханш онд ам.долларын хүү өндөр, өнөөдөр бодлогын дунд зээлийн дундаж хүү 17.2 байна. Хятадын эдийн засгийн удаашрал, хойно болж байгаа дайн, тээвэр ложистикийн хүндрэл, геополитикийн хүндрэл зэргээс шалтгаалж дэлхий даяар өсөж байгаа үнийн өсөлт, экспортын хүндрэл, төсвийн хүндрэл, орлого тасалдаж байгаа явдлыг бид хүний буруугаас болсон гэж үзэхгүй.

Харин хувь хүнтэй холбоотой алдаа дутагдал байвал бид өршөөхгүй. Энийгээ бүгдэд нь хэлж хариуцлагын гэрээ байгуулна. Өнөөгийн энэ бодлогод ам.долларын хүүгийн өсөлт, хүүгийн өсөлт доллар хэвлэгдээд үнэ нь унахад алтны үнэ өсөж байгаатай шууд харьцуулагдана, Хятадын эдийн засгийн бууралт, сааралт, экспортын үнийн савлагаа нөлөөлж байна. Одоо валютын урсгалыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах, төсвийн алдагдлыг бууруулах шаардлагатай байна. Тэгтэл яг энэ гэрээ хэлэлцээрүүдийг Чайна Энержитэй энэ хил боомт дээр Ерөнхий сайдтай хамт яваад ажиллаад ирсэн учраас өмнөх Ерөнхий сайд бол Сангийн сайд үргэлжлүүлж ажиллаж байж энэ тоо баримтууд, “Онтри”-тай хийж байгаа, Оюутолгойтой хийж байгаа гэрээ хэлэлцээрүүдийн нөхцөлүүд, нарийн татварын маргаан, тариф олон асуудлууд дээр үргэлжлүүлж ажиллах нь гэсэн ийм зайлшгүй шаардлагын үүднээс би энэ гол сайд нарыг үргэлжлүүлж ажиллах нь зүйтэй гэж үзсэн. Тэгэхдээ энэ Засгийн газар уламжлалт шинэчлэлийн Засгийн газар.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан гишүүн хариулт өгье.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүн ээ миний минут яваад байна шүү. Гишүүний асуултад хариулъя. Асуусан эхний асуултад Ерөнхий сайд хариулчих шиг боллоо. Тэр би танд дахиад л ижилхэн л хариулт өгөх нь дээ. Бид төлөвлөгөөндөө сургуулиа ч барина, цэцэрлэгээ ч барина, эмнэлгээ ч барина, эрчим хүчнийхээ реформыг ч хийнэ ингээд оруулчихсан байдаг. Харин хэзээ ямар хэмжээтэй хийх вэ гэдгийг олон зүйлээс шалтгаална. Төсвийн хэмжээ, өөр эх үүсвэр, боломжит зүйлүүд юу байна вэ гээд. Тэрийг харин чухалчлах тэр эрэмбэлэхийг тийм бас субъектив байдлаар харж бас болохгүй шүү болохгүй. Өнөөдөр мэдээж эрчим хүч

тулгамдчихсан асуудал. Боломжтой газар нь үнэхээр шаардлагатай бол тэнд суман дээр соёлын төв нь дутмаг байвал тэрийг нь барих хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Барих л хэрэгтэй. Тэгэхээр тэр нь өөрөө бид нар бас өөр зүйлээр эрэмбэлэх хэрэгтэй юм байгаа юм. Тэрнээс биш гэнэт тийм Пүрэвдорж гишүүн ээ та өөрөө хүндэтгэлтэй хандаарай би энд хариулж байна шүү дээ. Миний минут яваад байна. Та өөрийнхөө минут дээр ярь л даа наадхаа. Та суудал дээрээ суучхаад наад юмнуудаа яривал яасан юм бэ? Энүүгээр ингээд агсам тавиад яваад байх юм. Тийм байна Цэнгүүн гишүүн ээ тэгээд амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн гишүүн хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүнийхээ асуултад хариулъя. Мэдээж Засгийн газрын гишүүд Улсын Их Хурлын гишүүд хүндэтгэлтэй хандана. Цэнгүүн гишүүнд би бол хувиасаа маш их хүндэтгэлтэй хандаж байгаа. Эрчим хүчний реформ, үндэсний хороонд бид цуг шийдвэр гаргасан. Цахилгаан эрчим хүчний үнийг өртөгт нь ойртуулах ажиллагаанд улс төрийн манлайлал аваад надтай цугтаа шийдвэр гарсан. Энэ шийдвэр маань харамсалтай нь олон нийтэд бас богино хугацаандаа, ойрын хугацаандаа шүүмжлэл дагуулж байгаа учраас сүүлийн үед бол Цэнгүүн гишүүн маань манийгаа гайгүй шүүмжилдэг болсон. Манийгаа шүүмжлэхээр таны рейтинг олон нийтийн дунд өсөж байгаа бол би өдөр болгон танаар шүүмжлүүлэхэд бэлэн байна. Энийг бас залуу улс төрч хүн гол нь эх оронч санаа гаргаад ийм юун дээр хамт явсан юм. Ингээд шүүмжлүүлэхэд бас хэлээд, дахин хэлээд би бэлэн байна. Өдөр болгон шүүмжлүүлбэл бүүр сайн. Таны.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Болсон. Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Батчимэг: Сайдад нэр дэвшигч гишүүддээ амжилт хүсье. Магадгүй миний Ерөнхий сайдаас асуух асуулт танилцуулгын явцад хөндөгдсөн байж магадгүй. Гэхдээ би бас хуулийн хүрээнд тодруулж асууя гэж бодож байна. Ерөнхий сайд та Засгийн газрын гишүүн сайдад нэр дэвшигчдээ танилцуулах үедээ Хяналт үнэлгээний хороо, 20 минутын хот болон боомтын сэргэлтийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн 3 сайдын орон тоог өөрийн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын бусад гишүүдэд хариуцуулан хуваарилж хэмнэлт хийсэн гээд хэлчихсэн. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт би энийг хуулийн юуг нь авсан. Хэрэв энэ хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан Монгол Улсын сайд нарын эрхлэх асуудлыг нэгээс нөгөөд шилжүүлэх, 1 орон тоонд нэгтгэх, өөрчлөлт оруулах бол энэ тухай саналаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлсний үндсэн дээр гүйцэтгэнэ гээд маш тодорхой заачихсан байгаа. Тэгэхээр энэ заалтын дагуу Монгол Улсын сайд нарын эрхлэх асуудлыг нэгээс нөгөөд шилжүүлэх гэдэг нь та Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах санал гаргах ёстой гэж би хувьдаа ойлгож байна.

Өөрөөр хэлбэл, энэ дээрх 3 сайдын эрхлэх асуудал буюу чиг үүргийн аль чиг үүргийг аль сайддаа шилжүүлж байгаа нь тодорхой байх ёстой. Гэтэл Засгийн

газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт дээрх 3 сайдын эрхлэх асуудлыг аль 1 сайдын эрхлэх асуудалд шилжүүлсэн, өөрчлөлт оруулсан гэдэг зүйл одоо тодорхой биш байна. Энэ 3 сайдын орон тоо тэгвэл хэвээр байгаа гэж ойлгож болох уу? Өөрөөр хэлбэл, энэ 3 сайдын орон тоог хэмнэхийн тулд Ерөнхий сайд та Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай гэсэн 3 хуулийн төслийг цогцоор нь Улсын Их Хуралд өнөөдөр өргөн мэдүүлж хэлэлцүүлэх ёстой байсан биш үү? Энэ асуултад Ерөнхий сайдаас хариулт авъя.

Хууль зүй, дотоод хэргийн сайдад нэр дэвшигч Мөнхбаатар, Зам, тээврийн сайдад нэр дэвшигч Дэлгэрсайхан сайдаас асуулт асууя. 2020-2024 оны хугацаанд Монгол Улсын нийт осол гэмтлийн тэргүүлэх шалтгааны эхний 3-д зам, тээврийн осол орсон байгаа юм. 2024 оны байдлаар нийт 30977 зам, тээврийн осол бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.8 хувиар өс.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Батчимэг гишүүнд 1 минут нэмж өгье.

П.Батчимэг: Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.8 хувиар өссөн энэ дүн, статистик мэдээ байна. Тэгэхээр 30977 зам, тээврийн ослын улмаас 4493 хүн амь нас, эрүүл мэндээрээ өнөөдөр хохироод байна. 631 хүн амь насаа алдсан ийм харамсалтай мэдээ байна. Ингээд үзэхэд Монгол Улсад зам, тээврийн ослын нөхцөл байдал дайн мөргөлдөөнтэй ядуу буурай орнуудын ийм нөхцөл байдлын хэмжээнд хүрсэн байна. Миний бие нийслэл хотын хэмжээнд тулгамдсан асуудал болсон бичил цахилгаан тээврийн хэрэгсэл сурон, скутерийн хуулийг өргөн барих энэ процессын үйл ажиллагаа маш удаашралтай төрийн захиргааны төв байгууллага Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам, тээврийн яамнаас оролцоо маш муу ирүүлсэн сана.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Би Пүрэвийн Батчимэг гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23.1.6-д Засгийн газрын гишүүдийн эрхлэх ажлыг тодруулан хуваарилж, түүний гүйцэтгэлд хяналт тавина гэж Ерөнхий сайдын бүрэн эрхэд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын дотоод зохион байгуулалтын хүрээнд Хяналт үнэлгээ Үндэсний хорооны дарга, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд нарын асуудлыг давхар хариуцуулан гүйцэтгэх бүрэн боломжтой гэж үзсэн.

Гэхдээ танилцуулгын үеэр дурдсанчлан Дэгийн тухай хуулиар Засгийн газрын бүтцийн тухай хууль, нэн ялангуяа Бүрэлдэхүүний тухай хуулийг Хууль тогтоомжийн хуулийн дагуу иж бүрдэл хангуулдаг, Хууль тогтоомжийн хуулийн дагуу өргөн мэдүүлдэг болчихсон байна. Энэ тохиолдолд Засгийн газар хуралдаж, нэн яаралтай горимоор өргөн барьсан тохиолдолд хэлэлцэх бололцоотой. Тэгтэл Засгийн газар яаралтай хэлэлцэх шаардлагатай ийм цаг хугацааны болон хууль, эрх зүйн хайчинд байна гэж хэлсэн.

Тэгэхээр Засгийн газар Ерөнхий сайдаас өөр хүн одоогоор байхгүй байна. Засгийн газар хуралдах бүрэн боломжгүй байна. Засгийн газрын хуралдааны шийдвэр гарах боломжгүй гэсэн үг. Энэ хууль, эрх зүйн асуудлыг зохицуулахын

тулд л шууд Бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийг хэлэлцүүлэхгүйгээр шууд эхний ээлждээ Засгийн газрын гишүүддээ танилцуулж, томилж байгаа юм. Энэ 3 хороог цомхотгож байгаа юм. Төсвийн тодотголыг өргөн барихдаа энэ 3 хорооны эрх, үүргийг таны дурдсан хуулиудын дагуу өнөөдөр томилохгүй орхиод цомхотгож 3 сайдаар цомхотгох төдийгүй энэ 4 Үндэсний хороо, цаашлаад 59 зөвлөл давхардал, хийдэл, зөрчлүүд, давхардсан агентлаг, бүтцүүд байгааг цэгцэлж, төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цомхотгох зарчмаар нэг мөр цомхотголын ажлыг л нийгэмд зөвхөн таалагдахын тулд 1, 2 яам нэр ус солиод тэгээд яг үндсэндээ зардал бараг хэвээрээ үлддэг юм байна лээ орон тоог, хүн халж болохгүй. Нэмэлт хүн халсны 6 сарын зардал гаргахаас авхуулаад тамга тэмдэг, ширээ сандал энэ тэр гэж бөөн ажил болохоос илүү ингэж ажилдаа шуурхай орох нь зөв гэж үзээд цаг хугацааны шаардлага төсвийн тодотгол оруулах бодлоготойгоо уялдуулж, энэ танилцуулгыг хийж сайд нарыг томилж, уламжлал шинэчлэлийг хослуулж, Засгийн газрыг бүрдүүлж байна.

Д.Амарбаясгалан: Батчимэг гишүүн тодруулж асууя.

П.Батчимэг: Ерөнхий сайд таны хэлж байгааг ойлгож байна л даа. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхой болгох, энийг хийх процессын ажил бас их ярвигтай, цаг хугацаа шаардсан ажил байсан гэдгийг ойлгож байна. Гэхдээ Засгийн газрын тухай хуулийг Үндсэн хуулийн хүрээнд энэ үзэл баримтлалын үндсэн дээр уг нь өнөөдөр Засгийн газрын гишүүдийг Их хуралд оруулж ирж танилцуулах энэ явц нь дараа нь байх байсан юм болов уу л гэж ойлгож байгаа юм. Эхлээд бол хуулиа барьж Их Хуралд саналаа оруулж ирж бүрэлдэхүүнийг танилцуулаад дараа нь бүрэлдэхүүнээ танилцуулсан бол зүйтэй байсан болов уу л гэж. Тэгвэл Засгийн газрын гишүүдийн чиг үүрэг хүртэл тодорхой болно. Боомт хаашаа орох вэ, Хяналт хаашаа орох вэ ингээд л асуудал хөндөгдөөд гишүүд ч гэсэн бас түрүүн асууж байсан л даа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Г.Занданшатар: Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуульд заагдсан зохицуулалтаар Үндсэн хуулийн 39.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг санал болгож, Улсын Их Хурал батална гэсэн заалттай. Харин Засгийн газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцуулна гэж тусгагдсан бөгөөд бүтэц, бүрэлдэхүүний тухай тусгай зохицуулалт байхгүй. Өөрөөр хэлбэл, жишээлбэл, 21 оны Засгийн газар, 21 онд шинэ Засгийн газар байгуулахад Бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулахгүйгээр зарим сайд нарыг сольж өөрчлөөд томилж байсан ийм практик, прецедентүүд, жишгүүд байгаа. Ийм учраас энд ямарваа нэгэн хуулийн зөрчил байхгүй гэж үзсэн.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Би таны ярьж байгаа осол гэмтэл, энэ осол аваарын асуудал 2024 он онд 30 мянга гаруйгаар өссөн, 22 хувь өссөн гэж энэ тоотой санал нэг байна. Ер нь энэ 3 үндсэн шалтгаан байгаа энэ осол гэмтэл гарах, ер нь аваар осол гарах.

Нэгдүгээрт, Монгол Улсад импортоор орж ирж байгаа машины тоо өмнөх жилүүдийнхээс маш ихээр ихэссэн. Том оврын болон жижиг тээврийн хэрэгсэл өнөөдрийн байдлаар гэхэд 74 мянгаар нэмэгдсэн байна. Зөвхөн хагас жилийн хугацаанд л гэж ярьж байгаа юм шүү дээ.

Хоёрдугаарт, замын насжилт их өндөр болсон. Ер нь өөрөөр хэлбэл бид нар ингээд мянганы зам тавьснаас хойш ер нь тэр үедээ Мянганы замыг 7700 гаруй километр мянганы зам.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Хоёрдугаар шалтгаан нь энэ.

Гурав дахь шалтгаан замын эвдрэл үүнтэй холбогдуулж маш их эвдэрсэн. Ялангуяа хүнд даацын машинууд хулгайгаар тээвэр хийх нь олширсон. Үүнээс болж эвдэрсэн зам дээгүүр сүлжиж явахаас өгсүүлээд ингээд мөн даац хэтрүүлснээсээ болж машин нь өөрөө бас энэ аваар, осол гарахаас урьдчилан сэргийлж тоормослох энэ орон зайн хэмжээ багасах энэ байдлуудаас шалтгаалаад осол аваарын хэмжээ ихсэж байгаа. Тийм учраас цаашдаа бид энэ хүнд даацын энэ хулгайгаар даац хэтрүүлээд явж байгаа энэ асуудалтай нэлээдгүй Зам, тээврийн яам тэмцэж байгаа.

Хоёрдугаарт, замын насжилт өндөр болсонтой холбогдуулан зам засварын ажлыг нэлээдгүй энэ жил маш сайн хийгдэж байгаа. Жишээлбэл, өнгөрсөн онд энэ Өмнөговь.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Хосбаяр: Шинээр томилогдож байгаа сайд нарт бас ажлын амжилт хүсье. Та бүхэн бас энэ улс орныхоо бүтээн байгуулалтад онцгойлон анхаарч ажиллаарай. Мэдээж шинэ Засгийн газрын эхний ажил энэ төсвийн тодотголыг оруулж ирэх юм шиг байна. Тэгээд хасах тодотгол гэж яриад байгаа. Миний хувьд өнгөрсөн жил төсвийн тодотгол, хасах тодотгол хийж байхад ч гэсэн бас хэлж байсан. Ер нь энэ улс орон чинь яаж хөгжих юм бэ?Хөдөө орон нутаг чинь маш их хийх ажил байна. Маш их бүтээн байгуулалт хиймээр байна. Тэгээд мэдээж төсвийн урсгал зардал, шаардлагагүй урсгал зардлаас хэрэгцээгүй зардал бас тэр танах зүйлүүд байвал хасаж болох байх.

Гэхдээ нөгөө талдаа хөрөнгө оруулалтаа л хасаад байдаг. Жишээлбэл бид нар 25 оны төсвийн тодотгол хийхдээ өчнөөн олон замын томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг хасаж байсан. Жишээлбэл Налайхаас Тэрэлж хүрэх 4 эгнээ зам, Дарханаас Сэлэнгэ ортол 4 эгнээ зам гээд. Тэгээд энэ бүтээн байгуулалтуудыг хассанаар хувийн хэвшилд халгаатай байгаа юм л даа. Энэ төсвийн хөрөнгө оруулалт энэ их мөнгө чинь хувийн хэвشلээр дамжиж эдийн засаг руу ордог, хувийн хэвшил энэ дээр чинь бас тогтож амьдардаг, хувийн хэвшилд ээлтэй ийм олон зүйлүүд байгаа л даа. Тэгээд бид нар төсвөө тодотгоно, төсвийн таналт хийнэ гэхээр хөрөнгө оруулалтаа хасна.

Гэтэл уг нь миний бодлоор энэ Засгийн газрыг энэ төлөвлөсөн орлогоо ол, эрсдэлээ зөв тооц, арга саам, арга зам хай, өөр боломж бололцоогоо нээ, дайчил.

Ер нь энэ хэмнэсэн зардлаараа төсвийн хөрөнгө оруулалт энэ хөдөө орон нутгаа хөгжүүлэх дэд бүтцийн ажлуудыг хий гэж ингэж шаардаж, шахаж Улсын Их Хурал ажилламаар байна л даа.

Тэгэхгүй болохоор одоо төсвийг их дүн тавьчихаад хасах амархан л даа. Одоо энэ сайд нар тэгээд өө хасаж байна, өө төсөв тодотгохгүй бол болохгүй, эдийн засаг муу байна, гадаад орчин муу байна гээд л ингээд л явах шиг амархан зүйл байхгүй л гэж ойлгож байна л даа. Тэгэхээр би энэ дээр эсрэг байр суурьтай энэ төсвийн тодотголоор орлогоо ол, энэ төсвийн шаардлагагүй зардлуудаа хас, харин тэр зөрүүгээр нь энэ хөдөө орон нутаг энэ хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлаа хий гэсэн ийм зүйлийг хэлмээр байна.

Ерөнхий сайдыг томилогдож байхад бас асууж байсан. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль гээд 2003 оноос, 2023 онд хэрэгжиж эхэлснээсээ хойш ганц ч олигтой яриа хэлэлцээр амжилттай хэрэгжсэн төсөл байхгүй ийм хууль байгаа. Тэгээд энийгээ Эдийн засаг, хөгжлийн шинээр томилогдох сайд яаралтай оруулж ирээд энэ хувийн хэвшилдээ ээлтэй энэ зүйлээ оруулж ирээд хийгээрэй. Тэгэхгүй бол хувийн хэвшилд маш их боломж байгаа. Төртэйгөө түншлэх гэхээр төр нь ингээд өөрийгөө хамгаалсан эрсдэлээс хамгаалсан бүх зүйл дээр хувийн хэвшилд ачааг үүрүүлсэн ийм зүй хууль байгаа шүү. Энийгээ яаралтай оруулж ирээрэй гэдэг ийм зүйлийг хэлье.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Гишүүний асуултад хариулъя. Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Төсвийн тодотголыг хэлэлцэх үеэрээ бид нар сүүлийн 2, 3 хоног Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төслийн өөрчлөлтийг бэлтгэсэн. Яамдаас санал авч байгаа. Ойрын хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөж энэ ондоо багтааж хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

Ер нь төсвийн эдийн засгийн бодлогын хувьд ийм болчихоод байгаа шүү дээ. Суурь ...гоор суурь хувилбараар төсвийн орлого 2.3 их наядаар буурахаар өөрөөр хэлбэл би 105 сая тонн нүүрс 105 доллароор тооцоод 83 сая тонн нүүрс экспортолно гээд төсөвт тусгачихсан. Одоогийн гарч байгаа байдал, бодит үнийн өөрчлөлт суурь хувилбараар бол бид нүүрсний одоогийн үнийн бууралтаар тооцоход 2.3 их наядаар тооцно.

Харин энэнээс муу хувилбар байж болох хувилбартай. Ойрын 2 жилд нүүрсний үнэ өсөхгүй буурна гэсэн олон улсын тооцоо байна. Үүгээр 3.2 их наядаар төсвийн орлого буурах тооцоотой. Ингээд энэ энийг чинь танахгүй бол энэ илүүдэл зардлыг чинь яаж нөхөх вэ, зээл авч нөхнө, нөгөө өрийн дарамт чинь нэмэгдэнэ. Авсан зээлийн хэмжээгээр валютын ханш өсөж дотоодын иргэдийн ачаан дээр инфляц үнийн өсөлт болж буурна. Ийм учраас иргэдээрээ дарамт учруулж байснаас төр өөрийнхөө бүсийг чангалж илүү дутуу зардлаа танаж байж л энэ хүндрэлтэй нөхцөл байдлыг давна гэж үзэж төсвийн тодотголыг яаралтай хийх гэж үзэж байгаа юм.

Тэгэхгүй бол энэ хөрөнгө оруулалт, зардал болгоны маань боломж нь ард нь мөнгө нь байдаг сан хөдөө болгонд сум барих юм. Сум болгонд аймаг болгонд тэр хөрөнгө оруулалтаа хэрэгжүүлэхийн төлөө л байна. Тэгэхдээ эдийн засаг гэдэг

бол хүний хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөц бололцоогоор шийдэх ухаан гэдгийг л бид бас тооцож ойлгож ажиллах ийм бодит шаардлага үүссэн. Бидний хэрэгцээ хязгааргүй байна. Зам барилга бариад, метро барих даанч бидний нөөц мөнгө хязгаарлалттай. Өнөөдөр гадаад байдлаас болоод улам хүндрэлтэй болж байна. Ийм учраас байгаа боломж нөөцөө шалтгаалаад уламжлал шинэчлэлийг хосолсон Засгийн газар байхгүй бол шинэ тутам 100 хувь шинэ Засгийн газар байгууллаа гэхэд бид цаг алдах тусам бидэнд том эрсдэлийг авчрах гадаад нөхцөл байдал үүсээд байна. Үүнийг ойлгож байгаа гишүүдээ бас баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ганбатын Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Би яах вэ тэгээд л бүтээн байгуулалт хийе анхаараарай гэж эхэнд нь хэлсэн шинэ танхимын Засгийн газрын гишүүдэд. Тэгээд улс оронд маш их хийх ажил байгаа. Ингээд төсвийнхөө хөрөнгө оруулалтыг таначихлаа. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль нь явахгүй. Тэгэхээр ер нь бид нар энэ бүрэн эрхийн хугацаанд 28 он хүртэл ер нь энэ улс оронд чинь ямар боломж бололцоогоор ажил хийх юм бэ? Тэгэхээр энэ Сангийн сайд бас байр сууриа хэлээч. Бас Эдийн засаг, хөгжлийн сайд. Ер нь бид нар тэр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа явуулах, тэр бартераа явуулах ер нь энэ бүтээн байгуулалтын ажил энэ улсын хөгжилд чинь цаг хугацаа чухал шүү дээ. Түүнээс биш ингээд хэмнэж байгаа нь, танаж байгаа нь тэгэхээр эдийн засаг хүнд байна гээд л байгаад л байвал байгаад л байна шүү дээ. Тэгэхээр хэзээ хөгжил ирэх юм бэ? Тийм учраас 28 оноос өмнө жоохон ажил хиймээр байна.

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал гишүүн хариулт өгье.

Н.Учрал: Манайх шиг бас энэ уул уурхайн бүтээгдэхүүний үнээс хэт хамааралтай ийм хос хамааралт бүтэцтэй эдийн засагтай оронд бол бид цаашдаа энэ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг бол мэдээж дэмжих ёстой. Тэгээд энэ утгаараа зүгээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийж хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтыг Засгийн газар батлуулдаг эрх байдаг. Тэгэхээр үүнийг бол бид нар цаг тухайд нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх энэ жагсаалтуудыг батлаад бүх талын дэмжлэг үзүүлээд явахаас өөр арга зам бол байхгүй.

Мэдээж хэмнэлтийг бол энэ чиг үүргийн шинжилгээ дээр өнгөрсөн хугацаанд төрийн хэмнэлтийн зөвлөл дээр бид нар ажиллаж хийсэн. Тэрнээс биш хэт их хэмнэлт гэж бас бүрэн ярих зохимжгүй. Тэгээд дотоод эрэлт бол бас байхгүй болно. Таны ярьж байгаа зөв. Тийм учраас энэ улам бас агшаахгүйн тулд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийж хэрэгжүүлэх төслүүдээ бол илүү үе тэргүүн ээлжид авч хэрэгжүүлнэ л гэж зорино.

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Хонь бүрэн чоно цатгалан гэдэг шиг л юм болох гээд байна л даа. Ер нь сүүлийн 30 жилд манай Монголын төрийн эрх баригчдын явж ирсэн замнал ерөөсөө л өөрсдөө л сандал суудалтай болоод л авчих юм бол ард иргэдийгээ бүр ор тас мартдаг. Тэгээд л 4 хэдэн жилийн дараа сонгуулийн санал авахын тулд очоод гэнэт хайр зарлаад явчихдаг. Энэ ёс зүйгүй байдлыг хэзээ

зогсох юм бэ гэж нэгдүгээрт бүүр асуумаар санагдаж байна бүх хүнээс, бүх гишүүдээс.

Ерөнхий сайд Занданшатарас 1 асуулт байна. Төрийн албанд 20-40 жил өөрийн амьдрал, залуу нас, эрүүл мэнд, бүх зүйлээ зарцуулаад ингээд ажиллаж ажиллаад тэтгэвэртээ гардаг. Тэтгэвэрт гарахдаа тэтгэмж гээд 36 сартай тэнцэх хэмжээний тэтгэмж авдаг. Энэ тэтгэмжийг сүүлийн үед зогсооно гэсэн ийм гадуур цуу яриа ч гэх юм уу, ийм яриа яваад байна. Тэгэхээр энэ дээр та зогсоох уу, зогсоохгүй юу гэдгээ бас Ерөнхий сайдын хувьд бодит үнэн хариултыг өгнө үү гэдгийг нэгдүгээрт Ерөнхий Ерөнхий сайдаас асууя.

Дараагийн асуулт мэдээж салбарын сайд Наранбаяр сайдаас асууна. Улс орны хөгжлийн тэргүүлэх салбар 1 сая гаруй хүүхэд сурдаг, 100 гаруй мянган хүн ажиллаж байгаа энэ том салбарыг манай Наранбаяр сайд тэргүүтэй ХҮН намын нөхдүүд маань самарлаа сүүлийн 1 жил. Энэ Боловсролын багц хууль 2023 оны 7 сарын 7-ны өдөр батлагдсан. Энэ боловсролын багц хуулиар бол боловсролын салбарт 6 реформын шинжтэй 6 өөрчлөлт явагдаж байсан Энх-Амгалан сайдын үед боловсролын засаглал, боловсролын хөтөлбөр, боловсролын санхүүжилт, багшийн хөгжил, боловсролын үнэлгээ, цахим шилжилт гээд ингээд 6 чиглэлээр.

Харамсалтай нь эд нар энэ 6-аа зогсох нь зогсоод, ухрах нь ухраад, дампуурах нь дампуурсан гэж салбарын экспертүүд, мэргэжилтнүүд, багш нар хэлж байна. Энийг би хэлээгүй. Засаглал дээр Боловсролын судалгааны үндэсний төв, Боловсролын үнэлгээний төв, зээлийн сангийн энэ байгууллага дээрээ мэргэжлийн бус улс төржсөн томилгоог хийсэн гэдгийг танай боловсролын салбарынхан чинь над руу бас хэлдэг юм шүү дээ Наранбаяр сайдаа. Би зохиогоод яриад байгаа юм биш ерөөсөө. Ийм байдлаар энэ засаглалын шинэчлэлийг танай намынхан устгасан Наранбаяр сайд тэргүүтэй ХҮН намынхан. ЕБС-ийн сургууль бага ангид хэрэгжиж эхлэх гэж байсан сургалтын хөтөлбөрийн шинэчлэл зогссон. Энэ шинэчлэлийг хийнэ гэж та нар вакум сургалт гэж хэчнээн зуун сая төгрөгийг салхинд хийсгэж хаясан.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Ц.Мөнхтуяа: Сурах бичиг, цэцэрлэг, сургуулийн өмнөх боловсрол, бага сургуулийн хөтөлбөрийг шинэчлэх гээд ингээд шинэчлэл яригдаж байсан боловч ирэх хичээлийн жилд зөвхөн сургуулийн өмнөх боловсрол дээр л энэ шинэчлэл явагдах нь тодорхой болж байна. Сургууль, бага сургууль дээр байхгүй болсон. Сурах бичгээ хийгээгүй. Хэрвээ хийсэн бол намар сурах бичиггүй хичээл эхлэх гэж байна.

Гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг дээр яриад байх юм байхгүй. Бүх багш нар энийг чинь болохгүй ээ, бүтэхгүй ээ, үндсэн цалиндаа оруул энэ мөнгөө ингэж салхинд хийсгээд хэрэггүй ээ ийм ажил хийсэн нэртэй ийм хачин юм битгий хийгээч ээ гэж гуйгаад байна. Боловсролын санхүүжилт яаж дампуурсныг эхлээд сайд сайн судлаарай. Ер нь хэдэн төгрөгийн өр, авлага үүсгэсэн бол гэхээс айдас төрж байна. Үүн дээр нарийн аудит оруулж байж цаашаа явахгүй бол толгой цустах юмнууд хийсэн. Сургуулийн менежмент гээд

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Ер нь багш нарын тэтгэвэр, тэтгэмжийг зогсоох хасах биш, харин илүү шударга, тогтвортой, үр дүнд тулгуурласан тогтолцоог бүрдүүлэх зорилгоор судалгаа, үнэлгээнд суурилсан шинэчлэл хийх санал дэвшүүлсэн. Нийт багш нарын эрх ашгийг хамгаалах тэгш хүртээмжтэй шийдэлд л ч энэ бодлого, шинэчлэлд чиглэнэ. Тийм учраас Мөнхтуяа гишүүнээс хүсэх юм бол цуу ярианд биш судалгаа тооцоо, нотолгоонд үндэслэсэн бас яриаг бид энд ярьж байвал зүгээр. 36 сарын талаар багш нарын талаар тийм яриа би л лав сонсоогүй юм байна.

Гэхдээ нийт төрийн албаны түвшинд 36 сарын тэтгэмжид 270 тэрбум төгрөг жилдээ зарцуулдаг юм. 270 тэрбум төгрөг. Ер нь энэ тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийг оновчтой болгож зорилтот бүлэгт нь чиглүүлэх талаар судалгаа, чиглэл хийхийг холбогдох яам, газарт өгсөн байгаа. Халамж бол эзэндээ зорилт бүлэгтээ хүрдэг. Татвар бол хөдөлмөр эрхэлсэн хүн болгоныг дэмждэг энэ бодлого чиглэлийг хэрэгжүүлж байж энэ бодит ажил, үр дүн болно гэж бодож байна. Нийт том зардлын хувьд манай нийгмийн хамгааллын зардал 8.9 их наяд буюу нийт төсвийн 23 хувь байдаг. Боловсролын салбарын зардлыг бууруулахгүй. Харин нэмэгдүүлэх талаар өмнөх гишүүдийн асуултад бид ярьсан. Хамгийн сайн хөрөнгө оруулалт бол боловсролд оруулж байгаа хөрөнгө оруулалт. Тэр дотроо багшийн хөдөлмөр, багшийг сайн багштай байж байж л боловсрол өөрчилж илүү сайн өөрчлөлтийг, шинэчлэлтийг хийж чадна. Тэгээд боловсролын талаар цогц бодлогыг хөдөлмөрийн ур чадвар эзэмшүүлэх, зайны сургалт энэ тэр гээд олон зүйлийг өмнө нь ярьсан учраас нуршаад яах вэ.

Багш нарын гүйцэтгэлийн үнэлгээг болиулж үндсэн цалинд хамруулах ийм санааг бид ярьж байгаа. Тэгээд бусад асуудлын талаар Наранбаяр сайд тэр салбар дээр юу болоод байгаа талаар өмнө нь ажиллаж байсан учраас илүү дэлгэрэнгүй хариулт өгөх байх. Наранбаяр сайд хариулъя.

Д.Амарбаясгалан: Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүнд микрофон өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр зэрэг энэ ер нь нэг юм дээр санаа нэгдээд байгаа шүү дээ. Тэр гүйцэтгэлийн үнэлгээ өнөөдөр 70 гаран тэрбумыг бид нар яг ингээд яг гүйцэтгэл, үнэлгээ дээр нь үнэлгээ дээр нь суурилад гүйцэтгэл дээр нь цалинг нь ингээд нэмээд өгч байгаа нэмэгдэл хэлбэрээр. Энэ бол анх удаа энэ жил ер нь аймгийн боловсролын газруудаараа дамжаад дээр нь нэмээд ийм цахим хэлбэрээр нэлээн бас оновчтой хэлбэрээр зохион байгуулчихсан. Бүх багш нар энэний эсрэг байгаа гэдэгт би итгэхгүй байгаа шүү. Зүгээр цаашдаа сайжруулах зүйл байгааг хүлээж авна. Тэрийг хүлээж авна. Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн 6 шинэчлэл явагддагаараа явж байна тэр. Ер нь цаашдаа бид олон нэмэгдлүүдийг гүйцэтгэлийн үнэлгээг бид нар зарим хэсгийг нь оруулаад үндсэн цалин руу нь шингээх энэ бодлогыг яриад байгаа юм. Энийг та миний Их Хурлын энэ танхимд хэлсэн үгнээс ч гэсэн олж харсан байх. Тэгэхээр энэ бодлого бол тантай яг адилхан бодолтой, адилхан ийм чиглэл рүү харж байгаа гэдгийг.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: Тийм та өөрөө бас ажигласан байх. Тэгээд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд тэр 6 шинэчлэл, тэр 6 тулгуурт бодлого, багшийн хөгжлийн 3 тулгуурт бодлого, бусад хөтөлбөрийн шинэчлэл эд нар бүх юм явдгаараа явж байгаа шүү дээ. Хаана нь дампуурчхаад юу яагаад би тэрийг би сайн ойлгохгүй байна. Явж байгаа. Ялангуяа энэ СӨБ-ын болоод бага сургуулийн хөтөлбөр нь шинэчлэгдээд одоо

Сурах бичгийнх нь тендер юмнууд ингээд зохиох энэ ажлууд нь хуулийн дагуу мэргэжлийн зөвлөлөө ажиллуулаад ингээд явж байгаа. Тэгэхээр энэ чинь бас тодорхой хэмжээнд цаг шаарддаг, хугацаа шаарддаг ийм ажлууд. Тэгээд энэ ажил нь ингээд төлөвлөгдсөнөөрөө хийгээд явах юм. Юуны хувьд бол цахим шилжилтийн асуудал ч гэсэн бид нар өнөөдөр ингээд үргэлжлүүлээд явж байгаа. Тэгэхээр энэ дээр бидний хийгээд байгаа ажлууд тасралтгүй байх, төрийн албаны тогтвортой зарчмыг баримтлах, бодлогын залгамж чанарыг хадгалах гээд ийм зарчмаараа явж байгаа шүү Мөнхтуяа гишүүнээ. Тэгэхээр бид яг энэ боловсролын салбарт.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Би зохиогоод байгаа юм биш ээ гүйцэтгэлийн үнэлгээ чинь фэйлд/failed/-чихсэн бүгдээрээ хэлж байна за юу. Тэрийг багш нараасаа та өөрөө очоод сонсоорой. Монголын боловсрол түүхэндээ анх удаа өнгөрсөн хичээлийн жилд багшийн хөгжлийн нэгдсэн сургалтаа зохион байгуулж чадаагүй ийм ичгэвтэр байдалд орсон шүү таны үед. Эцсийн эцэст хичээлийн жилийн бүтэц, төлөвлөгөө олигтойхон зохиож чадахгүй 3 улирал гэж самраад энэ хичээлийн жилд маш олон багш нар, хүүхдүүд, багш нар ядарсан. Тэгээд хамгийн чухал салбарыг элгээр нь хэвтүүлчхээд ямар нүүрээрээ дахиад сайд хийнэ ээ гээд ороод ирж байгаа юм. Ямар эрх ашиг байгаа юм. Би ичээд эргэж ирж чадахгүй. Салбараараа таныг хүлээн зөвшөөрөхгүй байна. Намар бүгдээрээ ажил хаялт зохион байгуулна манайх танд хэлчихье.

Д.Амарбаясгалан: Наранбаяр гишүүн нэмж хариулъя.

П.Наранбаяр: Энэ үндсэн сургалт, энэ нэгдсэн сургалтаа хийчихсэн шүү дээ. Энэ чинь хийгдээд, явагдаад дууссан. Тэгээд Боловсролын ерөнхий газраас 5 жил тутам хамрагддаг энэ үндсэн сургалтаа зохион байгуулсан гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Д.Ганбат: Ямар ч байсан Ерөнхий сайдтай, Засгийн газартай болж байх шиг байна. Ямар ч байсан сайн тал руугаа л явж байна гэж ойлгож байна. Манай Ерөнхий сайд маань энэ давхрынхаа энэ зургаа өлгүүлэх болчхож байна. Баянхонгор аймгаас бас анхны Ерөнхий сайд гарч ирж байна. Энд бас бүгдээрээ хүчин зүтгэлээ тийм. Тэгээд яах вэ юу билээ нөгөө морин дээрээсээ дэлхийг эзлэх амархан. Мориноосоо буугаад дэлхийг төвхнүүлэх хэцүү гэж байгаа. Одоо яг энэ юм чинь эхэлж байна л даа. Ер нь яг ямар Засгийн газар хүлээж авч байв? Ямар Монгол Улсыг хүлээж авч байна Ерөнхий сайд өнөөдөр? Яагаад дангаараа засгийн газраа байгуулсангүй вэ? Та нар чинь 68 суудалтай нам шүү дээ. Энийг нэг асуумаар байх юм. Ямар утга учир байна? Яах вэ Засгийн газар боломжийг нь бүрдчихжээ гэж ойлгож байна. Хашрууд ч байна, шонхрууд ч тэгээд үзэх гээд л

буцаад л ороод ирсэн байна. Нөгөө Ардын намын алт шиг хүмүүсээс хагас нь ороод ирж, хагас нь үлдсэн байна.

Би түрүүний Засгийн газраас 2 сайдыг их сайн ажиллалаа дажгүй байлаа гэж хэлэх гээд байгаа юм. 1 нь манай Батцэцэг сайд. Энэ айн тийм 2 хөрштэйгөө харьцах харьцаа, гуравдагч хөршийн бодлого энэ тэрийг их сайн барилаа.

2 дахь сайд нь манай Учрал сайд. Орано-гийн гэрээг хийчихлээ. Энэ маань нээрээ юу болж байгаа вэ? Яг явж байна уу яаж байна тээ? Тэрийг бас лавлацихъя. Бид хэд энэ дотор ярьж байхдаа бүгдээрээ л сайхан болчихсон юм шиг, сайхан болж байгаа юм шиг ингээд бууж байгаа сайдууд нь ч гэсэн ийм зөндөө олон юм хийчихсэн юм шиг үнэхээр маш сайхан байгаа юм шиг яриад байх юм. Ард түмэн бол арай өөр байна л даа. Ард түмэн тэгж байна шүү дээ, амьдралд хэцүү байна, хүнд байна, энэ Засгийн газар солигдоод бас арай дээрддэг юм болов уу гэсэн ийм хүлээлттэй байна л даа.

Гэхдээ энэ байдлыг сүүлийн арваад жил Ардын намынхан та нар хийлээ. Улсын ДНБ-ий 30, 40 хувийг төсөв дээр аваачаад овоолчихдог. Тэгээд улсаасаа илүү баян тарган яам, сайд нар төрж байдаг. Ийм л авлига ихэсчихсэн ийм юм руу шилжүүлчихлээ. Энийгээ яаж багасгах гэж байна? Ардчилсан нам уул нь яг тийм ийм гээд ажил хийчихдэг юм. Жишээлбэл, малыг хувьчилдаг, орон сууцыг хувьчилдаг, тэгээд иргэдэд наалддаг байхгүй юу. Таны Засгийн газар яг юу хийх вэ?

Д.Амарбаясгалан: Ганбат гишүүнд 1 минут нэмж өгье.

Д.Ганбат: Иймэрхүү ажлууд байна. Татвар их нэмэгдэж байна. амьдрахад туйлын хүнд байна. Одоо энэ эрчим хүчин дээрээ онц байдал зарла. Тэгэхгүй бол цаашдаа яах юм? Үнээ нэмсэн. Ямар ч тийм баталгаатай, найдвартай эх үүсвэр ард түмэн эрчим хүчээр хангагдаж чадахгүй байна. Энийгээ шийд. Ер нь нөгөө Ленин багш ч хэлж байсан шүү дээ Коммунистууд цахилгаанжуулалт дээр зөвлөлт засгийн нэмбэл коммунизм, социализм болно гэж байсан. Одоо энэ цахилгаанжуулалт дээрээ шүүх засаглалаа сайжруулчихвал арай дээрдэнэ. Засаг орох их юманд ороод байх шаардлагагүй. Аль болохоор бага юманд оролцож байж хувийн хэвшил, хувийн өмчийг сайн явуулмаар байна. Өөрсдөөр нь хийх ажлыг нь хийлгэмээр байна, саад болмооргүй байна. Байнга л хувийн хэвшлээ дээрэлхэж, доромжилж байх юм. Өмнө нь тэгдэг л.../минут дуусав./

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Г.Занданшатар: Өнөөдөр ингээд манай Засгийн газар албан ёсоор бүрдэх гэж байна. Энэ Засгийн газар өнөөдөр улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хувьд гадаад шок, төсвийн алдагдал, үнийн өсөлтөөс шалтгаалсан иргэдийн амьжиргааны дарамт нэмэгдсэн, хувийн хэвшлийн орон зай харьцангуй шахагдсан гэсэн шүүмжлэлийн дор хүнд нөхцөлд улс орны эдийн засаг, нийгмийн байдлыг хүлээж авч байна гэж бодож байна. Ийм учраас шийдвэртэй уялдаа бүхий бодлого шаардлагатай. Ийм учраас би 1 л зарчим барьж байгаа. Ярьдаг биш, хийдэг байгаач ээ энэ сайд нар. Тийм учраас би ярьдаг, попордог гэхээсээ илүү ажил хийдэг сайд нарыг ажил гэж, уламжлал,, шинэчлэлийг хослуулж, дан

шинээр бүрдээд цаашаа бүхнийг суралцаад явах цаг хугацаа алга. Дан хуучнаараа явах бололцоо алга.

Ийм учраас үнэн л байх ийм зарчимтай Засгийн газрыг бүрдүүлэхийг зорьж байна. Ажил хийдэг байх хамгийн гол нь ажлын үр дүн байх. Хувийн хэвшлээ дэмждэг, таны энэ санал, санаачилгууд дээр тулгуурласан энэ зах зээлийн нийгэм, ардчиллын үнэт зүйлд тулгуурласан ийм л Засгийн газар байхыг үзэж байна. Янз бүрийн шошго наагаад л, гоё гоё нэр, гоё гоё Пи Ар үгээр би яримааргүй. Үр дүн гарахгүй бол бидэнд үнэхээр эдийн засгийн байдал маань ямар хүнд байгааг муу хувилбараар 3.2 их наяд, сайн суурь хувилбараар 2.3 их наядын алдагдалтай төсөв, ханшийн дарамт, валютын нөөцийн цэвэр нөөц -1.8 тэрбум доллартой яг өнөөгийн нөхцөл байдал.

Монгол Ардын нам дангаараа засгаа байгуулах боломж байсан. Монгол Ардын намын бага хурлаас олон ургалч үзлийг хүндэтгэж, нийгмийн итгэл, тогтвортой байдалд тулгуурласан, эв нэгдэл, ойлголцлыг эрхэмлэсэн шийдвэр гаргасан. Тэгэхээр энэ агуулга нь мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд ард түмэнд амлачихсан энэ намуудын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд л чиглэж байгаа. Энэ намуудын мөрийн хөтөлбөр 55.9 хувийн давхцалтай Ардчилсан намын, Ардын Намын мөрийн хөтөлбөрийг нэгтгээд боловсруулчихсан. ХҮН намын мөрийн хөтөлбөрийг оруулчихсан. Ногоон намын мөрийн хөтөлбөр ч гэсэн ногоон бодлого, чиглэл нь тусчихсан ийм мөрийн хөтөлбөр учраас энэ мөрийн хөтөлбөрийг хамтарч хэрэгжүүлье. Гаднаа ийм зөрчилтэй, тэмцэлтэй үед Монгол Улс 1 байя. Эерэг, сөрөг хүчин ч гэсэн болохгүйг нь шүүмжилдэг, бодлогыг нь дэмждэг ийм парламентын соёлоо хүндэтгэе. Ийм зорилгоор бид илүү хариуцлагатай, илүү өргөн суурьтай, тогтвортой засаглалыг бүрдүүлэх зорилгоор л бусад намуудтайгаа хамтарч өнөөдрийн Засгийн газрыг бүрдүүлэх санал гаргаж хамтарч ажиллаж байна. Өргөн суурьтай ойлголцолтой засаг байгуулах нь тогтвортой байдал легитим байдлыг хангах суурь сонголт болно гэж үзэж байна.

Тэгээд манай Дашдондогийн Ганбат гишүүн маань бас харьцангуй чөлөөт үзэлтэй, эдийн засгийн либералчлал, хувийн хэвшлийг дэмжих бодлого дээр тууштай явдаг хүний хувьд одоо бас энэ төрийн өмчийн компаниудын менежментийн засаглалыг сайжруулах, засаглалыг сайжруулах, хувьчлал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх гээд тодорхой асуудлуудаар, авлигын суурь үндсийг арилгахад чиглэгдсэн энэ асуудлуудаар бас санаачилгатай хамтарч ажиллахыг урьж байна. Заавал засагт орохоороо л хамтардаг юм биш. Монгол Улсын эрх ашгийн төлөө Монгол Улсынхаа төлөө тангараг өргөсөн гишүүн бүр хамтарч ажиллах ёстой гэж. Харин бурууг нь шүүмжилж засаж байх ёстой. Энэ бол манай парламентын ардчиллын суурь зарчим гэж ойлгож байна. Таныг ингэж дэмжиж ажиллаж байгаад талархаж байна.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Бид нар чинь бас гадна дотнын хэвлэл мэдээллээс юм хумаа мэддэг болчихсон байна. Та нарын тэр доторх нарийн ширийн юмыг мэдэхгүй юм байна. Тэр Таймс дээр юу гарсан юм бэ? Тэр юм үнэн юм уу, худлаа юм уу? Энэ чинь Монгол Улсын нэр хүндэд нэлээн нөлөөлөхөөр юм байна шүү дээ. Үгүй ээ мэдэхгүй хэн нь мэддэг юм байгаа юм? Асуумаар байгаа байхгүй юу бас. Тэгээд Монгол Улсын Ерөнхийлөгч бас хуулиар хамгаалагдсан нэр хүндтэй л дээ. Тэгээд

гадна, дотно бид нар хэлхээ холбоо энэ нөхцөл байдалд ийм байж байдаг, тэгээд хэвлэл мэдээллээр гаднын хэвлэлээр ингээд ийм юм гараад байдаг. Энэ ямар учиртай юм бэ, энэ чинь ганцхан Монгол Ардын намынхан гэхгүй шүү дээ. Монгол Улс л гэж ярина шүү дээ. Энийгээ тайлбарлачих уу?

Д.Амарбаясгалан: Энэ ч гаднын хэвлэл дээр гарсан нийтлэлийн талаар энэ танхимд тайлбар хийх эрхтэй хүн байхгүй шүү дээ.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Засгийн газрын гишүүдийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцлоо.

Одоо ингээд Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдийг томилж, захирамжаа гардуулна. Үүний дараа Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд Тангараг өргөх ёслолын ажиллагаатай байгаа. 30 минутын хугацаагаар түр завсарлалаа.

23.38 цаг

Лхагва гараг 18 Зургаадугаар сар 2025

Төрийн ордон “Их хуралдай” танхим 00 цаг 15 минут

Д.Амарбаясгалан: Чуулганы хуралдаанаа үргэлжлүүлье. Хэлэлцэх асуудал хоёр.

Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Засгийн газрын гишүүнээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын гишүүнээр томилох тухай захирамж гаргаж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаар Ням-Осорын Учралыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар Сайнбуянгийн Амарсайханыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар Тогмидын Доржхандыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Сандагийн Бямбацогтыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдаар Батмөнхийн Батцэцэгийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар Болдын Жавхланг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Лхагвын Мөнхбаатарыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаар Гонгорын Дамдиннямыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар Дамбын Батлутыг, Монгол Улсын

Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар Батын Батбаатарыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсролын сайдаар Пүрэвсүрэнгийн Наранбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар Тилеуханы Аубакирыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайдаар Борхүүгийн Дэлгэрсайханыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаар Чинбатын Ундрамыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаар Энхтайваны Бат-Амгаланг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Жадамбын Бат-Эрдэнийг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаар Энхбаярын Батшугарыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар Жадамбын Энхбаярыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдаар Энхбаярын Батшугарыг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайдаар Баттогтохын Чойжилсүрэнг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдаар Жигжидсүрэнгийн Чинбүрэнг тус тус томиллоо.

Манай Засгийн газар нийт 19 гишүүний бүрэлдэхүүнтэй. Үүнээс Монгол Ардын намаас 16 сайд хүн, намаас 2 сайд, Иргэний зориг ногоон намаас 1 сайд тус тус томилогдсон байна.

Засгийн газрын гишүүдийн 50 хувь нь өмнө нь Засгийн газрын бүрэлдэхүүнд ажиллаж байсан туршлагатай бол Засгийн газрын үлдсэн 50 хувь гишүүн нь анх удаа томилогдсон байна.

Засгийн газрын гишүүдийг Улсын Их Хурлын өмнө өргөсөн тангарагтаа үнэнч байж, хууль дээдлэн, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид, хариуцсан ажил, албан үүрэгтээ эзэн болж, мэдлэг, ур чадвараа бүрэн дайчилж танхимын зарчмыг чанд сахиж ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Шинэ Засгийн газар бүрдэж, бүрэн эрхээ цаг алдалгүй хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлж өгсөн Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүддээ баярлалаа.

Цаашдаа Засгийн газар үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг төлөвшүүлж, хүний хөгжлийн цогц шийдэл, үндэсний аюулгүй байдал, Монгол хүний эрх ашигт нийцүүлэн тулгамдаж байгаа асуудлуудыг эрэмбэ, шат дараатай шийдвэрлэх, төрийн хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, ил тод байдал, нээлттэй нэгдмэл байдлыг чанд сахиж, хариуцлагын тогтолцоог чангатгах, татвар, нийгмийн даатгалын сангийн цогц реформ, Үндэсний баялгийн баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр санаачилгатай, шуурхай ажиллаж, үр дүнгээ Улсын Их Хуралд тухай бүрд нь тайлагнах болно.

“Нэг бодлого нэг зүтгэл” уриаг хэрэгжүүлж, шударга ёс, эв нэгдлийг хангаж ажиллана гэдгээ дахин илэрхийлье. Сэргэн мандсан хүчирхэг Монголын төлөө хамтран зүтгэхийг уриалж байна. Мөнх хөх тэнгэрийн дор Монгол Улс мандан бадрах болтугай.

Д.Амарбаясгалан: Одоо Засгийн газрын гишүүд тангараг өргөх ёслолын ажиллагааг эхэлье. Нэгдсэн хуралдааны танхимын голд Засгийн газрын

гишүүдийн тангараг өргөх байрлалыг бэлдсэн байгаа. Гишүүд байрлалаа эзлэхийг хүсье.

Засгийн газрын гишүүд тангаргийг хамтаар өргөх бөгөөд насаар хамгийн ахмад гишүүн тангаргийг уншиж бусад гишүүд давтан хэлнэ. Та бүхнийг тангаргаа өргөж эхлэхийг хүсэж байна. Тангаргаа эхлүүлье.

Б.Дэлгэрсайхан: Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн төрт ёс, Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хуулийг биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсынхаа Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая.

Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын гишүүд төрийн сүлдэнд мэхийн ёсолж хүндэтгэл үзүүлнэ.

Одоо Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд заасан дарааллын дагуу гишүүдийг нэг нэгээр нь дуудаж, төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурахыг урих тул та бүхэн суудлаа түр эзэлье.

Төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурах дарааллаар гишүүдийг урья.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Тогмидын Доржханд таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан таныг төрийн далбаанаасаа адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд, Батмөнхийн Батцэцэг таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Лхагвын Мөнхбаатар таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Гонгорын Дамдинням таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Дамбын Батлут таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Батын Батбаатар таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсролын сайд Пүрэвсүрэнгийн Наранбаяр таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд Тилехуаны Аубакир таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн сайд Борхүүгийн Дэлгэрсайхан таныг төрийн далбааны сайдаас авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл спорт, аялал жуулчлал залуучуудын сайд Чинбатын Ундрэм таныг төрийн далбааны сайдаас авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Энхтайваны Бат-Амгалан таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр таныг төрийн далбаанаасаа адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Энхбаярын Батшугар таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн таныг төрийн далбаанаасаа адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Жигжидсүрэнгийн Чинбүрэн таныг төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсгээ зурна уу хэмээн урьж байна.

Монгол Улсын Засгийн газрын шинээр томилогдсон гишүүдэд хандаж үг хэлье.

Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Их Хурлын гишүүд ээ,

Өнөөдөр Монгол Улсын Засгийн газрын шинэ бүрэлдэхүүнийг баталж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх шинэ баг үүрэгт ажилдаа орж буй түүхэн мөч тохиож байна. Энэ бол зөвхөн улс төрийн шинэчлэл биш харин иргэдийн итгэлийг хүлээж, шинэ хөгжлийн гарцыг нээх хариуцлагатай цаг үе юм.

Монгол төрийн туйлын зорилго бол ард иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлж, шударга ёсыг тогтоож, үндэсний хөгжлийг урагшлуулахад оршдог.

Тиймээс өнөөдөр томилогдож буй шинэ сайд, яамдын удирдлагууд үүрэг хариуцлага, хүлээлт өндөр цаг үед албан тушаалдаа томилогдож байна. Шинээр томилогдсон салбарын сайдуудад амжилт хүсэхийн ялдамд анхааруулах зүйлсийг товч танилцуулъя.

Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд гадаад худалдааны бодлогыг Засгийн газрын түвшинд онцгой анхаарч, яамд хоорондын ажлын уялдаа холбоог нягт зохицуулж, урсгал данс, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, валютын нөөцийг нэмэгдүүлэх, төгрөгийн ханшийг тогтворжуулах шат дараатай бодлогын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Өнөөдрийн үүсээд байгаа асуудлуудыг шийдэхийн хажуугаар нүүрс дээр тогтож байгаа өнөөгийн бүтцийг халж, илүү төрөлжсөн олон тулгуурт эдийн засагтай болох ажилд ач холбогдол өгч, илүү хурдавчлуулах шаардлага байгааг өнөөдрийн нөхцөл байдал бидэнд сануулж байна.

Хөрөнгө оруулалт, худалдааны газрын үр дүнд чиглэсэн гадаадын хөрөнгө оруулалтын урсгалыг татахад шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх, болохгүй байгаа зүйлсийг цаг алдалгүй сайжруулж, өөрчлөх саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх нь үүссэн байгаа энэ орчинд хамгийн чухал болоод байна.

Эдийн засгийн хөгжлийн яамны дэргэд судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдийг төвлөрүүлж, нэг дээвэр доор хоорондын уялдаа холбоог хангасан нэгдсэн бодлого явуулах боломжийг судалж үзэхийг Ерөнхий сайдаас хүсэж байна.

Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга төрийн албаны дунд, урт хугацааны хөгжлийн зураглалыг бүрэн тодорхойлж, процессын дахин инженерчлэл хийж, үр ашиггүй зардлыг бууруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлд үйл ажиллагаагаа эрчимжүүлэх нэн шаардлагатай байна.

Тэр дундаа төрийн байгууллагын давхардсан чиг үүргийг цэгцлэх, чадавхын зарчимд суурилж төрийн албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрүүдийг нэвтрүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. Энэ хүрээнд Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад холбогдох талууд, Төрийн албаны зөвлөл Улсын Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, намрын чуулганд багтаан хуулийн төслийг оруулж ирэх нь зүйтэй байна.

Ялангуяа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар салбар дундын уялдааг хангах, хүний нөөцийн бодлогоо зангидах, ойрын ирээдүйд үүсэх үүсэх ажиллах хүчний хомсдол, технологиос хамааралтай ажлын байрны шилжилт зэрэг хүний нөөцөө бодлогоор бэлтгэхэд анхаарах ёстой. Төрөөс үзүүлэх үйлчилгээг төр, хувийн хэвшил болон төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг илүү нэмэгдүүлэх. Мөн төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтыг шинэчлэн сайжруулж, үйл ажиллагааны үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлж зардал бууруулах, компаниудыг хувьчлах ажлаа эрчимжүүлэх шаардлагатай.

Сангийн сайд үүссэн байгаа нөхцөл байдалд зөв үнэлэлт, дүгнэлт өгч, хөрөнгө оруулалтын эрэмбэ, дэс дарааллын эргэж харсан мега төслүүдийг эдийн засагт дарамт болохгүйгээр хэрэгжүүлэх шийдэл гаргасан төсвийн тодотгол оруулж ирэх шаардлагатай.

Төсвийн үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлэх, шаардлагагүй тэвчиж болох зардлыг танахаас гадна юуны түрүүнд эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажилд шаардлагатай хөрөнгө мөнгийг цаг алдалгүй хурдан шуурхай шийдвэрлэх хэрэгтэй. Эрүүл мэнд, боловсролын салбарыг хөндөхгүйгээр дунд, урт хугацаанд улс орны өрсөлдөх чадвар, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын төслүүдийг хөндөхгүйгээр төрийн албыг илүү чадварлаг, бүтээмжтэй болгох явцад эдийн засгийн идэвхжил, эрэлтийг анхаарч, эдийн засгийн өсөлтийг агшаахгүй байх тийм тэнцвэрийг олсон шийдвэр гаргах ёстой.

Эрүүл өрсөлдөөнтэй эдийн засгийн орчныг бий болгохын тулд иргэд, аж ахуйн нэгжүүдэд ээлтэй татварын цогц реформ хэрэгжүүлэхийг ард иргэд хүсэж байна. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд тулгарч байгаа хүндрэл, гарч байгаа асуудлыг хандлагаа өөрчилж, жижиг, том гэж ялгахгүй шийдвэрлэх нь эдгээр эдийн засгийн идэвхжилд эерэг нөлөө үзүүлэх юм.

Хууль ба журмын зохист харилцааг хангах, хуулиас давсан журмуудыг цэгцлэх хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг парламент энэ өдрүүдэд хэлэлцэж байгаа. Хууль батлагдсаны дараа энэ хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлууд өрнөх учиртай.

Мөн хуулийн хэрэгжилтийг хангаж, одоо хүчин төгөлдөр байгаа хуулиуд дахь журам батлах, холбоотой заалтуудыг хуульд нийцүүлж өөрчлөх шаардлага бий. Үүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам тухайлан анхаарч ажиллах ёстой.

Манай улс 1998 онд Улсын Их Хурлаас тогтоол гарган эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр баталж, эрх зүйн шинэтгэлийн 7 чиглэлээр системтэй цогц

иж бүрэн байдлаар хийж байсан удаатай. Энэ хөтөлбөр хэрэгжиж дууссан. Одоо эрх зүйн шинэтгэлийн 2 дахь шатыг эхлүүлэх шаардлага бий. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эрх зүйн шинэтгэл 2 хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэхээр заасан боловч жил тойрч байхад энэ хөтөлбөр Улсын Их Хуралд орж ирээгүй байна. Хууль зүй, дотоод хэргийн яам үүн дээр даруй анхаарч, намрын чуулганаар өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулах хэрэгтэй.

Ингэхдээ төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах, хувийн салбарын бизнес, үйлдвэрлэл, худалдаа, арилжаа, шударга өрсөлдөөнийг дэмжих эрх зүйн цогц бөгөөд системтэй логик уялдаатай шинэтгэлийн бодлогыг боловсруулах шаардлагатай байна.

Төрийн бизнес данхайдаг биш харин иргэдийн бизнес цэцэглэдэг тийм эрх зүйн шинэтгэлийн бодлого боловсруулж, шуурхай оруулж ирэх хэрэгтэй.

Уул уурхайн салбарт гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг өндөр байлгахад нэн чухал ач холбогдолтой Ашигт малтмалын хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Компанийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль зэрэг хуулиудын шинэтгэл, нэмэлт, өөрчлөлтийн уялдаа холбоог сайжруулах зэрэг нэн тэргүүнд анхаарах асуудлууд бий.

Ялангуяа энэ салбарын гол хууль болох Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулж, хуулийн хэрэгжилтэд хөрөнгө оруулагчийн итгэлцлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Нөгөө талаараа байгалийн баялаг болж шахагддаг баялаг. Иймд тогтвортой, хариуцлагатай, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл бий болгох, хайгуул, олборлолтод ногоон технологи нэвтрүүлэх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлд ахиц дэвшил гаргаж ажиллаарай.

Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенцын талуудын бага хурал буюу КОП-17 хурлыг зохион байгуулах ач холбогдол. Түүнээс Монгол Улсын байгаль хамгаалалд гадаад улсуудаас оруулах хөрөнгө оруулалтыг өндөр хэмжээнд хүргэн ажиллахад онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой.

Нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг яриад л байдаг. Өнөөдрийг хүртэл оновчтой боловсруулсан, цаг үедээ нийцсэн, хуулийн төсөл өргөн мэдүүлээгүй байгааг онцгой анхаарч ажиллах хэрэгтэй.

Боловсролын салбарын хувьд боловсролын гол хөдөлгөгч хүч багш. Гэвч манайд багш мэргэжлээр төгсөгчдийн зөвхөн 33 хувь нь багшилж, тэдний 60 орчим хувь эхний 5-8 жилдээ ажлаа орхиж байна. Учир нь залуу багш нарын цалин бага, нийгмийн баталгаа хангалтгүй, орон сууц, эрүүл мэнд, гэр бүлийн дэмжлэг хомс байна. Тиймээс багшийн нийгмийн баталгааг сайжруулж, орон сууц, эрүүл мэнд зэрэгт чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Сургалтын хөтөлбөр нь 2012-14 онд боловсруулсан тул өнөөдрийн технологи цаг үетэйгээ нийцэхгүй байна. Ирэх хичээлийн жилээс шинэчилсэн ирээдүйн ур чадварт чиглэсэн хөтөлбөрүүдийг боловсруулж, багш нарын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Гуравдугаарт хот, хөдөөгийн эдийн засгийн ялгаанаас үүдэлтэй боловсролын тэгш бус байдал улам гаарсаар байна. Алслагдсан орон нутгийн хүүхдүүд хотын хүүхдүүдээс 7 жилийн хоцролттой байна гэсэн судалгаа гарчээ.

Иймд боловсролын хүртээмжийг тэгшитгэх, цахим сургалтын дэд бүтцийг сайжруулах, үдийн цай хөтөлбөрийг бүх дунд, ахлах ангийн сурагчдад хамруулах, багшийн хангамжийг нэмэгдүүлэх, бодлого хэрэгжүүлэх шаардлага өнөөдрийг хүртэл хүлээсээр байна. Эдгээр чиглэлүүд дээр шуурхай ажиллах нь Монголын боловсролын чанарыг сайжруулж, ирээдүйн тогтвортой хөгжлийн үндэс болно гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсад 2024 оны байдлаар нийгмийн халамжийн үйлчилгээ нь жилдээ 2.3 их наяд төгрөг зарцуулж байна. Цаашид нийгмийн халамжийн зорилтот бүлгийг сонгохдоо өрхийн амьжиргааны түвшинд суурилах тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримтлах шаардлагатай. Бид халамжаас хөдөлмөрт гэж олон жил ярьж байгаа. Монгол Улсын ажиллах хүч буюу хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 62 хүн нь хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож байна. Тиймээс хөдөлмөрийн зах зээлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

Иймд Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудыг өөрчилж, хөдөлмөрийн зах зээлийг либералчилж, хөдөлмөр эрхлэх сонирхолтой хүн болгоныг дэмжих бодлогыг баримталж ажиллах ёстой. Мөн хувийн хэвшилд НДШ, бусад татвар, хураамж маш хүнд дарамт болж байна. Татвар төлөөгүй, нийгмийн даатгалын өглөгтэй гэсэн шалтгаанаар аж ахуйн нэгжүүдийн дансыг хаадаг явдал их гарч байна.

Тиймээс тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хэвийн явуулах, орлого олж, төлбөр хураамж, ашиг олох боломжийг олгодог болох хэрэгтэй.

Нөгөө талаар Нийгмийн даатгалын сан жилдээ хэдэн зуун тэрбумаар, цаашдаа хэдэн их наядаар улсын төсвөөс татаас авахаар тооцоолол гарч байна. Иймд энэ сангийн тогтолцоог сайжруулж, улс төрөөс хараат бус болгох, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд дарамт болж байгаа шинэтгэлийг цэгцлэх асуудалд онцгой анхаарч ажиллах шаардлагатай.

Зам, тээврийн салбарын хувьд төмөр замын бүтээн байгуулалтыг хугацаандаа ашиглалтад оруулахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай. Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын төв төмөр замыг шинэчлэх, тээврийн уялдааг холбоог сайжруулж, логистикийн төвүүдийг хөгжүүлэх, төрийн өмчит төмөр замын компаниудын бүтцийн давхцалыг арилгаж, менежментийг сайжруулах. Мөн тээврийн аюулгүй байдал, стандарт, хяналтын тогтолцоог шинэчлэх нь бидний өмнө тулгамдаж буй зорилтууд тул эдгээрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд салбарын сайдын манлайлал, олон улсын хамтын ажиллагаа болон хувийн хэвшлийн идэвхтэй оролцоо нэн шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд соёл, аялал жуулчлалын салбарт ихээхэн ач холбогдол өгч үндэсний, бүс нутгийн, олон улсын хэмжээний тодорхой ахиц гаргаж ажиллаж чадсан. Цаашид энэ салбарыг өөрөө өөрийгөө тэтгэдэг, эдийн засагт бодит хувь,

нэмрээ оруулдаг салбар болгон хөгжүүлэхэд шинэ сайд анхаарч ажиллах хэрэгтэй.

Энэ чиглэлд чадавхаа бэхжүүлэхэд илүү анхаарах, үндэсний өв уламжлал, соёл өв тээгчдийг бодлогоор дэмжих, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягт залуус, хүүхдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, дадал хэвшлийг тогтооход анхаарч ажиллах хэрэгтэй.

Барилга, орон сууцжуулалтын салбарт хот, суурин газрын төлөвлөлтийг тэнцвэртэй төвлөрлийг сааруулах иргэдийн орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулж, шинэ суурьшлын бүсийг хөгжүүлэхдээ барилгын стандарт, хяналтыг олон улсын жишигт нийцүүлж, дэд бүтцийг оновчтой, хүртээмжтэй төлөвлөж хэрэгжүүлж ажиллах нэн шаардлагатай.

Мөн Улсын Их Хурал дээр хот, суурин газрыг орон сууцжуулах, ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, иргэний шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангах зорилгоор хот дахин төлөвлөлттэй холбоотой ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байгаа. Энэ ажлын хэсгүүд өргөн хүрээнд ажиллаж, судалгаа, шинжилгээ, хэлэлцүүлгүүдийг хийсэн бөгөөд ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцаж, анхаарч, дэмжиж, хамтарч ажиллах хэрэгтэй.

Сүүлийн жилүүдэд хөдөө, аж ахуйн салбарт Атрын 4 дүгээр аян, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Чинээлэг малчин зэрэг бодлогын хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлснээр хөдөө, аж ахуйн бүтцийн шинэчлэл бодит ахиц гарч, орон нутгийн эдийн засгийн идэвх сэргэж, хүнсний хангамжийн тогтвортой байдал сайжрах нөхцөл бүрдэж буйг онцлон тэмдэглэж хэлэх нь зүйтэй. Эдгээр хөтөлбөр нь хүнсний үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгож, иргэдийн эрүүл мэндийн баталгааг хангах үндэс суурь болж байгаа бөгөөд цаашид тогтвортой үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, санхүүжилтийг тогтвортой байлгах үр дүнд суурилсан дэмжлэгийн тогтолцоог төгөлдөржүүлэх шаардлага урган гарч байна.

Энэ хүрээнд салбарын бодлого хэрэгжилтийг улам бүүр боловсронгуй болгох, нэгдмэл чиг хандлагатай уялдуулахад холбогдох байгууллагуудын дэмжлэг, оролцоо чухал ач холбогдолтой юм.

2024 оны эхний 9 сарын урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын ДНБ-д хөдөө, аж ахуйн салбарын эзлэх хувь нь 8.8 хувь байгааг ойрын жилүүдэд 20 хувьд хүргэхийг зорьж, хөдөө, аж ахуйн сэргэлт бий болгох ёстой шүү.

Мөн Улсын Их Хурал дээр байгуулагдсан ажлын хэсгээс Хүнсний тухай, Хүнсний аюулгүй байдлын тухай, хөдөө, аж ахуйн тухай шинэчилсэн болон анхдагч хуулиудын төслийг боловсруулж хэлэлцүүлэгт бэлэн болсон.

Эдгээр хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн амьжиргаа сайжирч, үндэсний үйлдвэрлэл хөгжих, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал бодитой хангагдах нөхцөл нь бүрдэнэ. Мөн хүн амын хүнсний эрүүл, тогтвортой байдалд суурь өөрчлөлт гарч, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн урт хугацааны үндэс тавигдаж, хотоос хөдөө рүү чиглэсэн хүн ам, эдийн засгийн урсгал бодитой бий болж чадна.

Иймд дээрх хуулийн төслүүдийг хэлэлцүүлэх батлуулахад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбараас идэвхтэй оролцож, зохих дэмжлэгийг үзүүлж, нягт ажиллах нь зүйтэй. Улмаар хуулийг хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах энэ чиглэлд иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

Саяхан НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс Монгол Улсын хиймэл оюунд бэлэн байдлын үнэлгээг хийж 5-аас 3 буюу системчлэгдэх үе шатдаа ахиц дэвшил алгуур байгааг онцолсон байна. Иймд хиймэл оюун ухаан, их өгөгдлийн бодлого, стратегия батлуулах ажлаа эрчимжүүлж, гол сорилт болох хөдөө, орон нутгийн дэд бүтцийн асуудал, төрийн албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэн ажиллах чиглэлд дорвитой алхам хийхийг цахим хөгжил хариуцсан сайдад анхааруулж хэлье.

Хиймэл оюун ухааны хөгжүүлэлт, ашиглалт, хэрэглээг нэвтрүүлэх, дэмжих, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан тогтолцоог яаралтай бүрдүүлж, бодит ажил хэрэг болгохгүй бол улс, орнуудын хөгжлийн ялгаатай байдал ихсэх, дижитал эдийн засгийн хөгжлөөс хоцрох эрсдэл бийг анхааралдаа авч ажиллах нь зүйтэй.

Эрчим хүчний салбарт нэн анхаарч ажиллах шаардлагатай. Цаг алдалгүй шийдвэрлэх шаардлагатай дэд бүтцийн бүтээн байгуулалт, сэргээн засварлалт, найдвартай ажиллагаанд бэлдэж, нэн тэргүүнд 3- дугаар цахилгаан станцын гэмтлийн асуудлыг нарийн тодорхойлж, өвлийн улирлаас өмнө хэвийн байдалд шилжүүлэх, шаардлагатай бол Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд асуудлаа яаралтай танилцуулж ажиллах шаардлагатай.

Улсын Их Хурал дээр Эрчим хүч, дулааны хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг ажиллаж, хэлэлцүүлэг өрнөж эхэлсэн. Тус хуулийн төслүүдийг өргөн хүрээнд хэлэлцүүлэх, салбарын хуулиудыг жишиг байдлаар батлуулахад идэвхтэй хамтран ажиллах нь салбарын сайдаас ихээхэн шалтгаалах зүйл юм.

Энэ салбарын хууль, эрх зүйн орчныг дорвитой сайжруулж, эрчим хүчний либерал бодлого барих, эрчим хүчний дутагдлаа ойрын хугацаанд арилгах зорилго хангагдах боломж бүрдэх юм. Мөн сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг илүү дэлгэрүүлэх, баруун бүсийг сэргээгдэх эрчим хүчээр хангах тал дээр ач холбогдол өгөх, байгальд ээлтэй шинэ технологи нэвтрүүлэх, тогтвортой байдлыг хангах чиглэлд арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайдаас хүсэж байна.

Эрүүл мэндийн тулгамдаж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ЭМД-ын тогтолцоог оновчтой болгох, хүнс, эмийн хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр Улсын Их Хурал дээр 3 ажлын хэсэг байгуулагдан ажиллаж дүгнэлтээ гаргаж байгааг Эрүүл мэндийн сайдаар шинээр сонгогдсон Чинбүрэн гишүүн мэдэж байгаа. Энэ ажлын хэсгүүд өргөн хүрээнд ажиллаж, судалгаа, шинжилгээ, хэлэлцүүлгүүдийг хийсэн, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Тухайлбал, эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлж буй тохиолдлын 30-40 хувь нь хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагагүй, амбулаториор тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой тохиолдлууд гэж дүгнэсэн байна. Энэ мэт нөхцөл байдал нь эрүүл мэндийн тогтолцооны санхүүжилтийг хянах, зардлын үр өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

Одоо мөрдөгдөж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийн арга нь тоо хэмжээнд тулгуурласан, тэр хэрээр эмнэлгүүдэд эдийн засгийн сонирхол төрүүлж байгааг эрс өөрчилж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт үндэслэн санхүүжилт олгох загварыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улс ЭМД-ын хураамжийн хувь, хэмжээгээр хамгийн бага улсуудын хэвээр байгаа нөхцөлд санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг хүн амын өргөн хүрээний тусламж, үйлчилгээнд яаж оновчтой хуваарилах вэ гэдэг асуудал өнөөдөр эрүүл мэндийн салбарт тулгамдаж байна.

Үүний тулд бодлогын шинэ санаачилга, шийдэл гарган ажиллаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хот, хөдөөгийн ялгааг арилгах, тусламж, үйлчилгээний зардлын давхардлыг шийдвэрлэх хэрэгтэй. Хүнд нь цаг алдалгүй хүргэдэг байх тийм санхүүжилтийн загвар хийх эрх зүйн орчин бүрдүүлэх санаачилгыг Улсын Их Хурал дэмжиж ажиллана.

Монгол Улсын 34 дэх Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар болон шинээр томилогдсон Засгийн газрын гишүүд, сайд нарт ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Монгол Улс хөгжин цэцэглэх болтугай.

Баярлалаа.

Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөлөө.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

00.53 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

